



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ БА ҮЙЛДЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

ЭМНЭЛЗҮЙН ГАРЫН АВЛАГА



УЛААНБААТАР ХОТ
2019 ОН



ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ БА ҮЙЛДЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ БА ҮЙЛДЭГЧДЭД ҮЗҮҮЛЭХ СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

ЭМНЭЛЗҮЙН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2020 он

Энэхүү гарын авлагыг боловсруулахад эрдэм мэдлэг, үнэт цагаа Зарцуулан өөрийн мэдлэг оюунаа бусдад түгээх харамгүй сэтгэлээр ажигласан эмч, багш, судлаач Ш.А бүхэндээ талархаж байгаагаа илэрхийлэхийн Зэргээ санхүүгийн дэмжлэг үзүүлсэн НҮБ-ын Хүн амын сангийн хамт олонд ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

Энд илэрхийлсэн үзэл санаа нь зохиогчдынх бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй.

Энэхүү гарын авлагыг НҮБ-ын Хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр НҮБ-ын Хүн амын сан, Монгол улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн хүрээнд хэвлэв.

Боловсруулсан:	В.БАЯРМАА	<i>Анагаах ухааны доктор, тэргүүлэх зэргийн эмч</i>
	Б.ЖАРГАЛ	<i>Анагаах ухааны доктор, ахлах зэргийн эмч</i>
	Д.БАЙГАЛМАА	<i>Удирдахуйн ухааны магистр, жендэрийн үндэсний хорооны дэргэдэх төвийн сургагч багш</i>
	Ж.НАРАНЧИМЭГ	<i>Нийгмийн эрүүл мэндийн магистр, зөвлөх</i>
	К.ЕЛЕНА	<i>Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч</i>
	Д.ОДОНЧИМЭГ	<i>Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч</i>
	Н.ЭРДЭНЭТУУЛ	<i>Тэргүүлэх зэргийн эмч</i>
	Э.МӨНХ	<i>Анагаах ухааны магистр</i>
Хянасан:	Л.НАСАНЦЭНГЭЛ	<i>Анагаах ухааны доктор, профессор, зөвлөх зэргийн эмч</i>
	Я.БУЯНЖАРГАЛ	<i>Анагаах ухааны магистр, Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламжийн газрын дарга</i>
	Т.ЭНХЗАЯА	<i>Эрүүл мэндийн яамны нийгмийн эрүүл мэндийн газрын дарга</i>
	Н.ТУЯА	<i>Анагаах ухааны магистр, дэд профессор</i>

Тоонотпринт ХХК-д хэвлэв
Утас: 70187616, 99093235
И-мэйл: toonot98@yahoo.com

ГАРЧИГ

Өмнөх үг	4
Өмнөх үг	5
I БҮЛЭГ	
Хүний эрх, жендерийн тухай ерөнхий ойлголт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	6-44
II БҮЛЭГ	
Хүчирхийллийн хохирогч хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх нь	45-101
III БҮЛЭГ	
Хүчирхийллийн хохирогч насанд хүрэгчдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх нь	102-156
IV БҮЛЭГ	
Хүчирхийлэл үйлдэгч хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх нь	157-176
V БҮЛЭГ	
Хүчирхийлэл үйлдэгч насанд хүрэгчдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх нь	177-205

ӨМНӨХ ҮГ

Хүний эрх, эрх чөлөө нь олон улсын хэм хэмжээ, хуулиар хамгаалагдсан ч гэр бүлийн хүчирхийлэл нь дэлхий нийтэд тулгамдсан асуудал хэвээр байна. Хүчирхийлэлд гол төлөв эмэгтэй хүн, хүүхэд, ахмад настангууд өртдөг. Эмэгтэйчүүдийн 70% нь амьдралынхаа явцад ямар нэг төрлийн хүчирхийлэлд өртөж байгааг НҮБ-ын судалгаагаар тогтоожээ. ДЭМБ-ын 2000-2017 онд хийгдсэн хүчирхийллийн судалгааны тайланд 10 эмэгтэй тутмын 1 нь 15 наснаас өмнө хүүхэд байхдаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн, 15 наснаас хойш 17.3% нь амьдралдаа бэлгийн хүчирхийлэлд өртөж, хүнд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 10.2% нь цагдаад мэдэгдсэн байна.

Дэлхийн дахинд сэтгэл түгшээсэн тоон мэдээлэлтэй төстэй зураглал Монгол улсад ч байсаар байна. Үндэсний статистикийн хорооноос хийсэн 2009 оны “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа”-нд оролцсон 9106 хүний 73.6% нь хүчирхийллийн ямар нэг харилцаатай гэр бүлийг мэдэхээ илэрхийлж, уг судалгаанд хамрагдсан 5 эмэгтэй тутмын 1 нь нөхөр, хамтран амьдрагчийн зүгээс үйлдсэн бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна.

2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг баталж, 2007 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чухал алхам болсон. Энэ хууль батлагдсанаар хуулийн хүрээнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага тооцох эрх зүйн үндэслэл бүрдсэн. Уг хуулиар цагдаа, нийгмийн ажилтан, сум, багийн засаг дарга, эмнэлгийн ажилтан болон бусад мэргэжилтнүүдийн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үүрэг, хариуцлагыг хуульчилж өгсөн. Манай улсад тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийг бэлтгэх, давтан сургах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх мэргэжлийн аргагүйгээр хангах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх нэн чухал юм.

Энэхүү чухал цаг үед “Хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчдэд үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ” гарын авлагыг боловсруулж, хянан тохиолдуулсан эмч, эрдэмтэд болон ивээн тэтгэсэн Монгол улс дахь НҮБ-ийн Хүн амын сангийн хамт олонд талархал илэрхийлье.

НОМЫН ҮР ШИМ ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ!

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД



Д. САРАНГЭРЭЛ


ӨМНӨХ ҮГ

Гэр бүлийн хүчирхийлэл нь олон талын сөрөг үр дагаврыг хохирогч, гэр бүлийн бусад гишүүдэд авчирдаг тул хүчирхийллийг даван туулахад цогц үйлчилгээ, тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгч нарт тусламж үйлчилгээ үзүүлэхдээ гэр бүлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хувь хүнийг нийгэмшүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах, тухайн асуудалд тохирсон оновчтой тусламж, дэмжлэгийг гэр бүлийн гишүүдийн нас, хүйс, сэтгэл зүйн онцлогийг харгалзан мэргэжлийн түвшинд үзүүлэх хэрэгтэй юм.

Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв нь хүчирхийлэл болон бусад сэтгэл зүйн тулгамдсан асуудалд хүртээмжтэй, тасралтгүй, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, нууцлалыг хадгалан, хувьчилсан зөвлөгөө өгөх үүднээс 2019 оноос сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 24 цагийн мэдээлэл өгөх 1800-2000 утсыг нээж, Улаанбаатар хотын төвд “Үнэ төлбөргүй, нэр хаяггүй сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв”, “Хүүхэд хамгааллын 108 утас” дээр сэтгэцийн эмч нараа нэмэлтээр ажиллуулж байна. Хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгч нарт үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгч бүрийн нэр төр, эрхэм чанарт хүндэтгэлтэй хандаж, хүүхэд, насанд хүрэгчдэд ялгаатай сэтгэл зүйн зөвлөгөө, тусламжийг үзүүлэх арга аргачлалын эзэмшүүлэх шаардлагатай билээ.

Энэхүү гарын авлагын 1-р бүлэг нь хүний эрх, жендэрийн тухай ерөнхий ойлголт, 2-р бүлэг нь хүчирхийллийн хохирогч хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх нь, 3-р бүлэг нь хүчирхийллийн хохирогч насанд хүрэгчдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх нь, 4-р бүлэг нь хүчирхийлэл үйлдэгч хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх нь, 5-р бүлэг нь хүчирхийлэл үйлдэгч насанд хүрэгчдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх нь гэсэн 5 бүлэгтэй. Мөн гарын авлагын хамт хүчирхийллийн хохирогч /хүүхэд, насанд хүрэгчид/, хүчирхийлэл үйлдэгч /хүүхэд, насанд хүрэгчид/-д сэтгэл зүйн тусламж үзүүлэх нь баримтын цомгийг боловсруулж, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулан гаргалаа. Энэ гарын авлага, баримтын цомгийг боловсруулан эмхлэн гаргахад мэдлэг, оюун ухаан, сэтгэл санаа, үнэт цаг, эрч хүчээ харамгүй зориулсан бүх хүмүүст чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье.

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ, АНАГААХ УХААНЫ
ДОКТОР, ПРОФЕССОР



Л.НАСАНЦЭНГЭЛ

I БҮЛЭГ

ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЭРИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ, ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ

1.1 ХҮНИЙ ЭРХЭМ ЧАНАР БА ХҮНИЙ ЭРХ

Хүний эрхэм чанар гэж юу вэ?


Хүн болж төрсний хувьд хүн бүр ижил үнэ цэнэ, адил хүндэтгэлийг эдлэх төрөлхөөс заяасан эрхтэй. Хэн байхаас нь үл хамааран хүн бүрийн эрхэм чанарыг хүндлэх ёстой. Хүн бүрт эрхэм чанар бий гэдэг нь хүн бүрийн амьдрал адилхан үнэ цэнэтэй гэсэн үг бөгөөд үүнээс хүндлэлийн тухай ойлголт гарч ирдэг. Өөрөөр хэлбэл, хүнийг хүндлэх гэж юу вэ гэсэн асуултанд хариулах шаардлагатай болно. Хүндлэлийг ерөнхийд нь хоёр хувааж болно: ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ хүндлэл ба ҮНЭЛЭХ хүндлэл. Бид хүмүүсийг зан чанар, бүтээсэн зүйлийг нь үнэлж хүндэлдэг. Харамсалтай нь, зарим хүн ийм хүндлэл огт хүлээдэггүй. Гэхдээ энэ нь бид хүлээн зөвшөөрөх хүндлэлийг алдсан гэсэн үг биш.

Хүлээн зөвшөөрөх хүндлэл нь хүнийг хүнийх нь хувьд хүндлэх тухай норматив ойлголт юм. Энэ нь хүний эрхэм чанар гэх ойлголтын цөм утгыг илэрхийлдэг. Хүлээн зөвшөөрөх хүндлэл гэдэг бол хүн бүрийг хэн байхаас нь үл хамааран хүнийх нь хувьд хүндлэх буюу хүний эрхэм чанартай гэдгийг нь хүлээн зөвшөөрч хүндлэх тухай юм. Жишээлбэл, 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалын оршлын хамгийн эхэнд «Хүн төрөлхтөний гэр бүлийн бүх гишүүдийн төрөлх эрхэм чанар болон салшгүй эрхүүдийг хүлээн зөвшөөрөх нь дэлхий дээрх эрх чөлөө, шударга ёс, энх тайвны үндэс...» гэж бичсэн байдаг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын оршил мөн адилхан өгүүлбэрээр эхэлдэг.

Хүний эрхийн тухай олон улсын гэрээнүүд болон ардчилсан улсуудын үндсэн хуулиудад хүнийг хүнийх нь хувьд хүлээн зөвшөөрсний үндсэн дээр хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, эвлэлдэн нэгдэх, хувийн амьдрал халдашгүй байх зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх талаар зааж, хамгаалах механизмыг тогтоосон байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулинд ч ялгаагүй хүн бүр халдашгүй, чөлөөтэй байх эрхтэйг тунхаглаж, хэнд боловч хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглосон.

Хүний эрхэм чанар /human dignity/



Хүний эрхэм чанарын үндсэн шинжүүд

Хүний эрхэм чанар нь дараах 4 үндсэн шинжтэй:

1. Заяамал: Хүн болж төрснийх нь хувьд угаас заяагдсан төрөлх чанар болохоос хэн нэгний, аль нэг институци,

байгууллагын олж тогтоосон эсвэл олгодог, зөвшөөрдөг зүйл биш.

2. Түгээмэл: Хүний эрхэм чанар нь үндэс угсаа, нийгмийн гарал, нас, хэл, хүйс, боловсрол, гэр бүлийн байдал, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, итгэл үнэмшил, хөрөнгө чинээ, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл зэрэг төрөлхийн болон бусад байдлаас үл хамааран хүн бүрт адил.

3. Салшгүй: Хүний оршихуйгаас урган гардаг тул хэзээ ч, ямар ч тохиолдолд салгаж, бас халдаж болдоггүй. Хэнд ч хүнлэг бус, хэрцгий хандаж, зодож, тарчлааж болохгүй.

4. Хэмжигдэшгүй: Хүн бүр “хүн” учраас адил үнэ цэнэтэй. Олон, цөөн, баян, ядуу, олонхийн санаа бодол, сайн муугийн үнэлэмж зэрэг ямар ч үзүүлэлтээр үл хэмжигдэнэ.

Хүний эрхэм чанар бол хүний эрх, эрх чөлөөний үндэс юм. **Хүний эрхэм чанар хөндөгдөж байвал бид бүрэн утгаараа хүн шиг амьдарч чадахгүй.** Тиймээс хүний эрхийг эдлэх цорын ганц нөхцөл нь хүн байх явдал болно. Хүний эрхийг эдлүүлэхгүй байх нь хүн гэдгийг нь үгүйсгэж байгаа хэрэг мөн.

Хүний эрх, түүний суурь зарчмууд

Хүн бүр үндсэн эрх, эрх чөлөөг эдэлнэ. **Хүний эрх нь ямар нэг давуу эрх, онцгой ямбыг илэрхийлсэн ухагдахуун биш.**

Хүний эрх нь:

- Хүнд угаас заяагдсан эрхэм чанарыг илэрхийлсэн ойлголт;
- Хүн бүрийг эрхэм чанараа хадгалан, нэр төртэй, үнэ цэнэтэйгээр амьдрахад зайлшгүй шаардлагатай наад захын стандарт;
- Хүний эрхэм чанарыг олон улсын болон үндэсний түвшинд баталгаажуулсан хуулийн баталгаа;

Хүний эрхийн суурь зарчмууд

Бүх эрх хоорондоо салшгүй холбоотой, хуваагдашгүй, цогц, харилцан хамааралтай. Нэг эрх зөрчигдөхөд л бусад эрх хөндөгддөг тул эрэмбэ, шатлалгүй. Жишээлбэл: Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд аюулгүй амьдрах эрх зөрчигдөхийн зэрэгцээ ажил хөдөлмөр эрхлэх, өөрийн гэсэн орлоготой байх зэрэг бусад нийгэм, эдийн засгийн эрх хөндөгддөг.



Хүний эрхийн суурь зарчмууд

Заяамал: Хүний эрх нь төрөлх, заяамал шинжтэй. **Бүх хүн нас, хүйс, яс үндэс, гарал үүсэл, арьсны өнгө, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл, хэл, шашин шүтлэг, боломж чадвар, нийгэмд эзлэх байр суурь, иргэний харъяалал болон улс төрийн үзэл бодол зэргээс үл хамааран ижил хүндлэл хүлээнэ.**

Түгээмэл: Хүний эрх нь хүн бүрт хамаатай. Хүний эрх түгээмэл байна гэдэг нь хэн нэгний төрөлх болон бусад байдлаас үл шалтгаалан бүх хүнд хамаатай байна гэсэн утга агуулна.

Салшгүй: Хүн оршин байсан цагт эрхийг хүнээс тусгаарлах, салгах боломжгүй. Эрхийг ямар ч нөхцөл, шалтгаанаар хүнээс ангид гэж үзэж болохгүй. Хэн ч өөрийн эрхийг алдах учиргүй. Зөвхөн хүний эрхүүд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд түүнийг хязгаарлаж болно. Онцгой нөхцөл байдалд хуулиар хязгаарласан болон гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсоноос бусад тохиолдолд тухайн хүнээс булааж үл болох салшгүй шинжтэй. Энэ тохиолдолд ч хүний салшгүй эрх болох амьд явах, халдашгүй амьдрах, эрх чөлөөтэй байх эрхийг хөндөж үл болно.



ХҮНИЙ ЭРХ

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Парис хотноо батлагдсан. Энэхүү тунхаглал нь Дэлхийн II дайны үр дагавраас үүдэж "ХҮН БҮРТ ЗАЯАМАЛ ЭРХ БИЙ" гэсэн санааг дэлхийн түвшинд анх удаа тунхаглажээ.

Хүн бүр амьд явах эрхтэй	Хүн бүр ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй	Хүн бүр сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй
Хүн бүр өв залгамжлах эрхтэй	Хүн бүр тайван жагсаал хийх эрхтэй	Бусад хууль бусаар учруулсан хохирлыг нохон толүүлэх эрхтэй
Хүн бүр өмчлөх эрхтэй	Хүн бүр халдашгүй чөлөөтэй байх эрхтэй	Хүн бүр үгээ боллоо илэрхийлэх эрхтэй
Хүн бүр соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагааг явуулах, бүтээх тусрах эрхтэй	Хүн бүр өргөдөл, гомдол гаргах эрхтэй	Хүн бүр мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй
Хүн бүр гадаадад явах, оршин суух эрхтэй	Хүн бүр шашин шүтэх, эс шүтэх эрхтэй	Хүн бүр хувийн аж ахуй эрхлэх эрхтэй
Хүн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй	Хүн бүр сонгох, сонгогдох эрхтэй	Хүн бүр хууль зүйн туслалцаа авах эрхтэй
Хүн бүр эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй	Хүн бүр эд, мөнгөний тусламж авах эрхтэй	Хүн бүр төрнийг удирдах хэрэгт оролцох эрхтэй
Хүн бүр сурч боловсрох эрхтэй	Хүн бүр улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй торчих эрхтэй	Хүн бүр өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхтэй
Хүн бүр улс төр, шийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд гэгш эрхтэй	Хүн бүр шударга шүүхээр шүүгдэх эрхтэй	Хүн бүр түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхтэй

ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛД ЗААСАН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ЗӨРЧИХ, ҮГҮЙСГЭХ ЭРХ ХЭНД Ч БАЙХГҮЙ.

Хуваагдашгүй, шатлалгүй: Хүний бүх эрх ижил үнэ цэнэтэй. Нэг эрх нь нөгөө эрхээс чухалд тооцогдох, дээгүүр тавигдах ёсгүй. Нэг эрхийг давууд үзэх нь бусад эрхийг үгүйсгэх нөхцлийг бүрдүүлдэг. Бүх эрхүүд нь ижил ач холбогдолтой, адил тэнцүү шинж чанартай учраас ижил түвшинд хамгаалагдах, хангагдах ёстой.

Харилцан уялдаатай: Хүний эрхүүд нийлээд нэг цөм болж байдаг. Тэдгээр нь өөр хоорондоо харилцан хамааралтай, уялдаа холбоотой. Хүний эрх нь орон гэр, сургууль, ажлын байр, зах зэрэг газар бүрт, амьдралын бүх хүрээнд хамаардаг. Хүний эрхийн зөрчлүүд нь харилцан холбогдсон байдаг тул нэг эрхийг зөрчигдсөнөөр бусад эрх мөн хязгаарлагддаг. Үүнтэй адил хүний аль нэг эрхийг хангах нь хүний бусад эрхийг хангахад мөн дэмжлэг болж байдаг.

Үл ялгаварлах: Хүн бүр арьсны өнгө, яс үндэс, нас, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, гэрлэлтийн болон бусад байдлаас үл хамааран ямар ч ялгаварлалгүйгээр эрхээ эдлэх ёстой.

Эрх чөлөө ба хариуцлага, эрх чөлөө ба дур зорго

Эрх чөлөө нь хүн оршин тогтнолоо хангах үндсэн нөхцөл юм. Өөрөөр хэлбэл, бусдын оролцоо, хяналт, дарамт, саад, хавчлага, хязгаарлалтгүйгээр сонголтоо хийх, шийдвэр гаргах боломж юм.

Гэхдээ эрхээ эдэлнэ, эрх чөлөөтэй байна гэдэг нь дураар авирлахын нэр биш. Хэрэв ингэвэл эрх чөлөөг буруугаар ашиглаж, дураар авирласан хэрэг болно. Бусдын эрхэнд саад болсон эрх чөлөө байх учиргүй. Эрх чөлөөг зоргоор авирлахтай адилтгаж болохгүй.

Хувь хүн бусдад хор хөнөөл учруулаагүй л бол түүний эрх чөлөөг хязгаарлах өөр үндэслэл, шалтаг, шалтгаан байх ёсгүй. Хувь хүний эрх чөлөөнд нэг л хязгаарлалт байна. Тэр нь бусад хүнд байгаа мөн тийм эрх чөлөө юм. Иймээс хүний эрх, эрх чөлөөг нийгмийн дэг журам, ёс суртахуун, эрүүл мэнд, аюулгүй байдлын үүднээс хязгаарлана. Гэхдээ ямар ч тохиолдолд хязгаарлаж болдоггүй эрх гэж бий. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлана. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.

Эрх чөлөө ба хариуцлага


Эрх чөлөөний цаана зайлшгүй хариуцлага байдаг. Хариуцлага нь эрх чөлөөний нөгөө тал. Хариуцлага нь бусдын эрхийг зөрчихгүйгээр, өөрийн эрхийн хүрээнд ухамсартай сонголт хийх чадвар, бас хийсэн сонголтынхоо үр дагаврыг хариуцах чадвар юм. **Хийсэн сонголтынхоо төлөө хариуцлага хүлээнэ.** Өөрөөр хэлбэл сонголтынхоо үр дагавартай

нүүр тулна, нүдээ анихгүй, нуугдахгүй. Үр дагавар нь сайн ч байсан, муу ч байсан, таалагдсан ч, таалагдаагүй ч түүнийг хүлээнэ. Хэдий хэцүү байсан ч үр дагавраа амсана.

Хүний эрхийг хангах төрийн үүрэг

Хүний эрхийг баталгаатай хангахын тулд хүндэтгэл, хамгаалал, дэмжлэг, хангамж зайлшгүй шаардлагатай болдог. Төрөөс хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах хариуцлага хүлээдэг.

Төрийн үүрэг хариуцлага



Хүний эрхийг хангах төрийн үүрэг хариуцлага

Гэр бүлийн хүчирхийлэл хүний эрхийн зөрчил болох нь: Аливаа хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалтаас ангид, хэнээс ч хараат бус, халдашгүй амьдрах эрх нь хүн бүрийн эдлэх салшгүй эрх юм. Ялгаварлан гадуурхалт, доромжлол, дарамт, хүчирхийлэл нь хүний эрхэм чанарт халддаг, хүний эрхийн зөрчил юм.

Гэр бүлийн хүчирхийлэл нь бусдаас хараат бус, аюулгүй, халдашгүй амьдрах эрхэнд халддаг хүний эрхийн ноцтой зөрчил юм. Гэр бүлийн хүчирхийллийг гэр бүлийн дотоод асуудал гэж үзэх хандлага манай улсад түгээмэл байсан ч сүүлийн жилүүдэд батлагдан гарсан бодлого, хуулийн дагуу хүний эрхийн зөрчил төдийгүй зарим үйлдлийг нь зөрчил, гэмт хэрэг гэж үздэг болоод удаагүй байна.

Иймд гэр бүлийн бүрэн бүтэн байдлыг хадгалах зорилгоор, эсвэл гэр бүл, ойр дотны харилцаатай хүмүүс хоорондоо шийдэх асуудал гэсэн байгаа хүнийг хамгаалахгүйгээр, үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэхгүйгээр орхиж болохгүй.

Хүн бүрийн эрхэм чанарыг нь хүлээн зөвшөөрч, хүндэтгэхийн зэрэгцээ тэдний аюулгүй, хараат бус, халдашгүй амьдрах эрхийг тэргүүн зэрэгт үзэж чухалчилсан, хэрэгцээнд нь мэдрэмжтэй хандсан үйлчилгээг шуурхай хүргэх шаардлагатай.

Шигтгээ 1. Хүний түгээмэл эрхүүд хаанаас эхэлдэг вэ?

“Хүний түгээмэл эрхүүд хаанаас эхэлдэг вэ?”

Жижиг, жижиг, гэрт ойр газраас-дэлхийн аль ч газрын зурган дээр харагдахааргүй тийм ойрхон, тийм жижигхэн газраас. Эрэгтэй, эмэгтэй хүн бүр, хүүхэд бүр аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр, тэгш ёс, тэгш боломж, тэгш үнэ цэнийг эрэлхийлж буй газрууд ийм л байдаг. Хүний эрх ийм газруудад утга учиртай байж чадахгүй бол, хаана ч утга учиртай байж чадахгүй”

*Элеанор Рузвельт, Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан
НҮБ-ын хорооны дарга*

Хуулийн байгууллагын ажилтнууд, үйлчилгээ үзүүлэгчид бүгд хүний эрхийн хамгаалагчид юм. Гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл өгөх явдал ч бас ялгаагүй хүний эрхийг хамгаалж байгаа нэг хэлбэр билээ.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тусгагдсан хүний эрх, эрх чөлөө

1. Хүн бүр эрх чөлөөтэй; хүн бүрт адил тэгш хандах ёстой
2. Арьсны өнгө, хүйс, шашин, хэл зэргээрээ ялгаатай ч, хүн бүр тэгш эрхтэй
3. Хүн бүр амьд явах; эрх чөлөөтэй, аюулгүй амьдрах эрхтэй
4. Хүнийг боол мэт үзэж, харьцах эрх хэнд ч байхгүй
5. Хүнд гэм учруулж, тамлан зовоох эрх хэнд ч байхгүй
6. Хүн бүр хаана ч байсан хуулийн этгээд байх эрхтэй
7. Хууль хүн бүрийн хувьд адил, хуулийг хүн бүрт адил тэгш хэрэгжүүлэх ёстой
8. Эрх нь зөрчигдсөн тохиолдолд хүн бүр эрх зүйн туслалцаа авах эрхтэй
9. Хүнийг шударга бусаар хорих, улс орноос нь хөөн зайлуулах эрх хэнд ч байхгүй
10. Хүн бүр нээлттэй шүүхээр шударгаар шүүлгэх эрхтэй
11. Хүн бүр гэм буруутай нь нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй
12. Хүн бүр аюул заналхийллээс хамгаалуулах эрхтэй, гэвч хангалттай үндэслэлгүйгээр гэрт тань дайрч орох, захидлыг тань нээх, гэр бүлийнхнийг тань шалгаах эрх хэнд ч байхгүй
13. Хүн бүр дураараа аялан зорчих эрхтэй
14. Хэлмэгдсэн буюу хэлмэгдэх аюулд өртсөн тохиолдолд хүн бүр өөр оронд очиж хамгаалал хүсэх эрхтэй
15. Хүн бүр аль нэг орны иргэн байх эрхтэй, хүслээрээ өөр орны иргэн болоход тань саад хийх эрх хэнд ч байхгүй

16. Хүн бүр гэрлэх, гэр бүл үүсгэх эрхтэй; гэрлэгсэд гэр бүл болох, хамтран амьдрах, гэр бүл салахад тэгш эрхтэй
17. Хүн бүр өмч, хөрөнгөтэй байх эрхтэй
18. Хүн бүр шашин шүтэх, шашны зан үйлээ гүйцэтгэх, хүсвэл өөр шашинд орох эрхтэй
19. Хүн бүр санал бодлоо илэрхийлэх, мэдээлэл өгөх, авах эрхтэй
20. Хүн бүр тайван замаар хуран цугларах, эвлэлдэн нэгдэх эрхтэй
21. Хүн бүр улсынхаа удирдлагыг сонгох, улс орноо удирдахад оролцох, төрийн үйлчилгээнээс тэгш хүртэх эрхтэй
22. Хүн бүр нийгмийн хамгаалалтай байх, өөрийгөө чөлөөтэй хөгжүүлэх, “хүн шиг” амьдрах боломжтой байх эрхтэй
23. Хүн бүр аюулгүй орчинд шударга цалинтай ажиллах, үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхтэй
24. Хүн бүр амрах, өөрийн гэсэн чөлөөт цагтай байх эрхтэй
25. Хүн бүр эрүүл, гачигдалгүй амьдрах бололцоотой байх эрхтэй
26. Хүн бүр сурч боловсрох эрхтэй
27. Хүн бүр нийгэм, хамт олныхоо соёлын амьдралд оролцох эрхтэй
28. Хүн бүр энэ бүх эрхийг эдлэх боломжийг хангахуйц “нийгмийн дэг журмыг” сахих үүрэгтэй
29. Хүн бүр бусдын эрх, хамт олон, нийтийн өмчийг хүндэтгэх үүрэгтэй
30. Энэ тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг зөрчих, үгүйсгэх эрх хэнд ч байхгүй

*Эх сурвалж: Simplified version of UDHR, <http://www.hrea.org>
Орчуулга: МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ, 2012 он*

1.2 ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Хүйс ба жендэр

Хүйс ба жендэрийг заримдаа адилтгаж үзэх эсвэл зөвхөн эмэгтэй хүнд хамаатуулах зэргээр ташаа ойлгодог.

Хүйс нь байгалиас заяасан, үл өөрчлөгдөх биологийн ялгааг илэрхийлдэг. Хүйсийн ялгаа нь генээр тодорхойлогддог, түгээмэл, нийтлэг зүй тогтолтой, үл өөрчлөгдөх чанар юм.

Жендэр нь хүмүүсийн хүлээсэн үүрэг хариуцлага, тулгарч буй саад бэрхшээл, хүртэж буй боломж бололцоог нь дүгнэн шинжлэх нийгэм, эдийн засаг, улс төрийн шинжтэй хувьсах хэмжигдэхүүн бөгөөд нийгмийн анги давхраа, нас, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, газарзүйн байршил, эдийн засаг, улс төр, соёлын орчин гэхчлэн олон үзүүлэлттэй харилцан хамааралтай байдаг.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн биологийн ялгаа ба нийгмийн үүргийг ялган салгаж ойлгохын тулд жендэр гэдэг нэр томъёог хэрэглэх болсон.

Хүйс ба жендэрийн ялгаа

Хүйс	Жендэр
Биологийн ялгааг илэрхийлдэг	Үүрэг хариуцлага, байр суурийн ялгаатай байдлыг илэрхийлдэг
Үл өөрчлөгдөх чанар	Цаг хугацааны явцад хувиран өөрчлөгддөг
Түгээмэл, бүх улс оронд адил	Нийгэм, соёл бүрт харилцан адилгүй
Ижил хүйсийн хүмүүсийн хувьд адил	Ижил хүйсийн хүмүүсийн дунд ч ялгаа байдаг

Жендэрийн хэвшмэл ойлголт ба жендэрийн үүрэг

Жендэрийн хэвшмэл ойлголт

Жендэрийн ялгаатай үнэлэмж нь эрэгтэй, эмэгтэй, охин, хөвгүүн болон тодорхой бүлгийн хүмүүсийн үүрэг, хариуцлага, тэдний хувьд “зөв”, “зүйтэй” хэмээн тооцогдох зан үйл, хийж болох болон болохгүйн хязгаарлалтыг тодорхойлдог. Жишээ нь: эрэгтэй хүн эмэгтэйд оройн хоолонд урих, хоолны төлбөрийн тасалбарыг эрэгтэйд өгөх, эрэгтэй хүн онгоцны буудал дээр хүүхдийнхээ живхийг солих болоход ийм өрөөнүүд зөвхөн эмэгтэй бие засах өрөөнд л байдаг гэх мэт.

Жендэрийн ялгаатай үнэлэмж нь нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтоос үүдэлтэй. Нийгэмд түгээмэл байгаа хэвшмэл ойлголт нь хүмүүсийн зан үйл буюу хэрхэн бодох, биеэ яаж авч явах, ямар сонголт хийх, ямар шийдвэр гаргахад нөлөөлдөг. Ингэснээр хүмүүс хоорондын харилцаанд нөлөөлж, хүмүүсийг баригдмал загварт оруулдаг. Мөн эрх мэдлийн, хөрөнгө нөөцийн, нийгэмд эзлэх байр суурийн ялгавартай байдлыг үүсгэх хөрс суурь нь болдог.

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, тодорхой бүлгийн хүмүүсийг нийгэмд уламжлагдан тогтсон хандлага, хүлээлтэд нийцүүлэн зан үйл, биеэ авч явах байдлыг багаас нь зааж хэвшүүлдэг ба “эрэгтэйлэг”, “эмэгтэйлэг” шинж байдлын талаарх итгэл үнэмшлийг суулгадаг. Тухайлбал, эрэгтэйчүүд олон таван үггүй, уйлдаггүй, гэр бүлээ тэжээгч, харин эмэгтэйчүүдийг уян хатан, дуулгавартай, асран халамжлагч гэж үзэх үнэлэмж, нийгмийн хүлээлт давамгайлж, энэ нь хүмүүсийн харилцаанд нөлөөлдөг.

Жендэрийн үүрэг

Жендэрийн үүрэг нь тухайн нийгэм, соёлд эрэгтэй, эмэгтэй хүнийг юу хийх, ямар үүрэг гүйцэтгэхийг тодорхойлсон ойлголт. Энэ нь 1. эрэгтэй эмэгтэй хүмүүсийн нийгэмд эзэлдэг буюу эзлэх ёстой байр суурь, 2. тэдний дагаж мөрдвөл зохих зан үйл, хийх үйлдлийн тухай дүрэм журам, 3. эрэгтэй

эмэгтэй хүмүүсийн гүйцэтгэдэг үүргийг илэрхийлсэн 3 талт ойлголт юм.

[Жендэрийн үүрэг нь хүйсийн онцлогоосоо үүдэн амьдралын тодорхой үе шатанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг ялгаатай ажил үүрэг төдийгүй “эмэгтэйлэг” “эрэгтэйлэг” байх талаар тухайн нийгэм, соёлд хэрхэн авч үздэгээс үүдэн эмэгтэй эрэгтэй хүмүүст нийгмийн зүгээс оноож буй “зохиомол” үүрэг юм. Эдгээр нь хамтдаа тэдний гадаад дүр төрх, зан авир, нийгэмд эзлэх байр суурийг хэм хэмжээ болгон тодорхойлдог].

Жендэрийн үүрэг нь тухайн нийгэм, олон нийт, нийгмийн бүлэг дотор эмэгтэй эрэгтэй, тодорхой бүлгийн хүмүүсийн хувьд зөв зохистой хэмээн тооцогддог дүр төрх, үнэлэмж, байр суурийн талаар харилцан адилгүй хүлээлт үүсгэж, тодорхой дүр /эмэгтэйлэг болон эрэгтэйлэг байдал/, үнэлэмжийг тулгадаг. Жендэрийн үүрэгт нас, анги давхраа, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, газарзүй, эдийн засаг, улс төр, соёл, технологийн орчин нөлөөлдөг.

Тэдгээр дүр төрх, үнэлэмж, үүрэг, хариуцлага, байр суурь, хүлээлт нь олон хүчин зүйлээс шалтгаалан хувьсан өөрчлөгддөг ба нийгэм, соёл бүрт харилцан адилгүй. Хүүхэд хөхүүлэх зэрэг зарим үүрэг хариуцлага нь биологийн хувьд тодорхойлогдсон учраас өөрчлөгдөх боломжгүй. Гэвч асран халамжлах зэрэг зарим үүрэг хариуцлага нь нийгмээс зохиогдсон учир өөрчлөгдөж болно.

Жендэрийн үүргийг 3 төрөлд ангилдаг:

1. Үйлдвэрлэлийн үүрэг: Энэ нь бүтээгдэхүүн боловсруулах, бараа үйлчилгээ үйлдвэрлэх зэргээр орлого олох үйл ажиллагаа ба хөлстэй хөдөлмөрт тооцогдоно.

2. Нөхөн үржихүй, асаргааны үүрэг: Энэ нь хүүхэд тээж төрүүлэх, асрах болон хүүхдийн боловсрол, эрүүл мэндэд анхаарал, халамж тавих, өрхийн гишүүдээ асран халамжлах, ахмад настан, өвчтэй хүний асаргаа, ус авах, хоол унд бэлтгэх зэрэг үйл ажиллагаа ба голдуу хөлсгүй хөдөлмөрт тооцогддог.

3. Олон нийтийн үүрэг: Тухайн хамт олон, бүлэгт байгаа хүмүүсийн төлөө гүйцэтгэх үүрэг юм. Голдуу үнэлгээгүй, хийгээд л байдаг хэрнээ шагнал, урамшуулал авдаггүй ажил байдаг.

Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хэн хэн нь нийгэмдээ үйлдвэрлэлийн, нөхөн үйлдвэрлэлийн болон орон нутгийн менежментийн үүргүүдийг гүйцэтгэдэг боловч өрх гэрээ тэжээгч хэмээн тооцогддог эрэгтэйчүүд үйлдвэрлэлийн үүргээ гүйцэтгэхэд цагаа илүү зарцуулах боломжтойгоос гадна үүгээрээ тэд нэгэн дор олон талын үүргээ биелүүлж чаддаг. Харин эмэгтэйчүүдийг хоёрдогч цалин хөлс ологч гэж үзэх нь түгээмэл бөгөөд тэд олон ажлыг амжуулан хийж, хязгаарлагдмал хугацаанд бүгдийг тэнцвэртэй гүйцэтгэх хэрэгтэй болдог. Тиймээс ажлын цагаа зохицуулах болон уян хатан байлгах нь эмэгтэйчүүдэд илүү чухал бөгөөд тэд энэ хүрээнд илүү их асуудалтай

тулгардаг. Эмэгтэй эрэгтэй хүмүүс эрт дээр үеэс нийгэмд ялгаатай үүрэг гүйцэтгэж ирсэн учраас тэдэнд тулгарах соёл, институцийн, биет болон эдийн засгийн саад бэрхшээл харилцан адилгүй бөгөөд олонхи нь тогтолцооны ялгаварлал, өрөөсгөл хандлагаас эхтэй байдаг.

Жендэрийн үүрэг, түүнээс үүдсэн жендэрийн харилцаа нь хөрөнгө нөөц, эд баялагийг хэн хүртэж, өмчилж, захиран зарцуулж, хянахыг тодорхойлдог ба эрх мэдэл, гэр бүл, нийгэмд эзлэх байр суурийн ялгаатай байдлыг үүсгэх хөрс суурь нь болдог.

Жендэрийн тэгш байдал ба жендэрийн мэдрэмж

Жендэрийн ялгаварлан гадуурхалт: Энэ нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд болон бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсээр нь ялган хязгаарлах буюу үгүйсгэхийг хэлнэ.

Жендэрийн ялгаварлан гадуурхалт нь 3 хэлбэрээр илэрдэг. Үүнд:

1. Шууд ялгаварлан гадуурхалт
2. Шууд бус ялгаварлан гадуурхалт
3. Тогтолцооны ялгаварлан гадуурхалт

Шууд ялгаварлан гадуурхалт нь хүйсээр ялгаварлаж, адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон, хамааралт байдалд оруулсан буюу оруулахыг завдсан үйлдлээр илэрдэг. Нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаас нь шалтгаалан залуу эмэгтэйчүүдийг ажилд авахаас татгалзах нь шууд ялгаварлан гадуурхалтын нэг жишээ юм.

Шууд бус ялгаварлан гадуурхалт нь нэг хүйсэд хамаарахгүй аливаа стандарт, хэм хэмжээ, үйлдэл нь хүнийг эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэхийг хэлнэ. Мөн хүйсийн шинжтэй аливаа зааг, ялгаа агуулаагүй мөртлөө адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс нь дорой байдалд ороход хүргэдэг байдлыг хэлнэ.

Жишээлбэл: эмэгтэй эрэгтэй хүний амьдралын хэв маяг өөр өөр байдгаас хамаарч ихэнхдээ эрэгтэйчүүд байгууллагадаа тогтвортой ажилладаг бол эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэхдээ орж, гарч хөдөлгөөнтэй ажилладаг. Гэр бүлийн үүрэг хариуцлагыг анхаарч тооцдоггүй цагийн хуваарь нь шууд бус ялгаварлалын шинжийг агуулдаг.

Тогтолцооны ялгаварлан гадуурхалт гэж хүлээн зөвшөөрөгдөхүйц мэт ойлгогдох хэрнээ тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэхэд хүргэсэн хандлага, журам, хууль тогтоомжийн улмаас хүн амын аль нэг хэсгийн эрх ашгийг хөндөж, үр дагавар нь тодорхой хугацаанд үргэлжилсэн байдлаар илэрдэг үгүйсгэл, хязгаарлалт, ялгаварлалыг хэлнэ. 1990-ээд оны эхээр олон хүүхэдтэй эхчүүдийг эрт тэтгэвэрт гаргасны улмаас эмэгтэйчүүд 35 настайдаа хүртэл тэтгэвэрт гарч, өнөөг хүртэл хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч олон жил хохирч байгаа нь тогтолцооны ялгаварлан гадуурхалын тод жишээ юм.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгч тус бүрийн бие даасан байдал, хувийн онцлог, соёлын өвөрмөц байдал, ялгаатай хэрэгцээг харгалзана. Хохирогчийг нас хүйс, гарал үүсэл, нийгмийн статус, бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гэрлэлтийн байдал, шашин, улс төрийн үзэл бодол, санхүүгийн боломж зэргээр ялгаварлан гадуурхахыг хориглодог. Ялгаварлан гадуурхалт нь эдгээр хүчин зүйлээр үл хязгаарлагдана.

Зарим хохирогч ялгаварлан гадуурхалтын олон хэлбэрт өртөж, энэ нь тэднийг улам эмзэг болгон, хүчирхийллийг даван туулах боломжийг нь бууруулдаг. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн илэрхийллээр ялгаварлан гадуурхах нь үүний нэг жишээ юм. Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл болол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж, эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол ялгаварлан гадуурхах гэмт хэрэг үйлдсэнд тооцогдоно.

Жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт нь жендэрт суурилсан хүчирхийлэлд нөлөөлөгч хүчин зүйлсийн нэг юм.

Жендэрийн тэгш байдал

Жендэрийн тэгш байдлыг хүмүүс янз бүрээр ойлгож, төөрөлддөг. Тухайлбал, эрэгтэй эмэгтэй хүмүүст нэгэн адил байдлаар хандах, эсвэл ялгаагүй болох ёстой гэж өрөөсгөл ойлгодог. Мөн тодорхой салбар, байгууллагад эрэгтэй эмэгтэй хүмүүс тэнцүү тоогоор байх явдал гэж үзэх нь түгээмэл.

Жендэрийн тэгш байдал нь эрэгтэй эмэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байна гэсэн үг юм. Эрэгтэй эмэгтэй хүмүүс ижилхэн байх бус, харин тэдний эдлэх боломж, бололцоо нь тэгш, нийгэм, гэр бүлдээ эзлэх байр суурь, эрх үүрэг нь адил байх тухай ойлголт юм.

Ялангуяа жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэхдээ эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн хооронд үүссэн эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг харгалзах зайлшгүй шаардлагатай.

Жендэрт суурилсан хүчирхийллийн тухай ойлголт

Жендэрт суурилсан хүчирхийллийн онцлог

Жендэрийн тэгш бус байдал, эрх мэдлийн тэгш бус харилцааг тогтоох, бэхжүүлэх, хадгалахад ашигладаг аливаа хэлбэрийн хүчирхийллийг жендэрт суурилсан хүчирхийлэлд тооцдог.

Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуульд тодорхойлсноор жендэрт суурилсан хүчирхийлэл нь /уг гарын авлагад цаашид ЖСХ гэж товчлон хэрэглэгдэнэ/ ЖСХ нь жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын,

бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэл юм.

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд хүйсээс нь шалтгаалан нийгмээс оноосон, хуваарилсан үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурийн талаарх хүлээлт, шахалтад үндэслэн үйлдэгддэг. Хянах, эрх мэдлээ мэдрэхийн тулд хэн нэгнийг үгүйсгэх, хязгаарлах, хянах, дарамт шахалт үзүүлэх, заналхийлэх зэрэг ямар ч аргаар үйлдэгдэж болох ба зовиур шаналал, хор хохирол учруулах буюу учруулж болзошгүй санаатай үйлдэл, эс үйлдэл юм.

ЖСХ нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба бусад төрлийн хүчирхийлэлтэй холбоотой /эрэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй гэх мэт/.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэж “жендэрт суурилсан хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүдэд бие махбодын, бэлгийн болон сэтгэл зүйн дарамт учруулсан болон учруулахыг завдах үйлдлийг хэлнэ. Үүнд: хувийн болон олон нийтийн орчинд ийм үйлдэл хийхээр заналхийлэх, хүний эрх чөлөөг хязгаарлах хүч хэрэглэсэн эсвэл шаардсан үйлдлийг багтаана”.

ЖСХ нь хувийн харилцаанд, гэр бүлд, ажлын байранд, сургуулийн орчинд, гудамж талбай зэрэг нийгмийн бүхий л хүрээнд, үйлдэгдэж, нийгмийн бүх анги, давхаргын дунд тохиолддог.

Жендэрт суурилсан хүчирхийлэлд хэн ч өртөж болох ч ихэвчлэн охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж, гэр бүл, хамт олон, нийгэмд далд, нуугдмал байдлаар оршин байна.

Жендэрт суурилсан гэж тодотгохын учир

Жендэр нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид, хөвгүүдэд нийгмээс оноосон үнэлэмж, үүрэг хариуцлага, байр суурь, хүлээлтийг тодорхойлж, тэдний хувьд "зөв", "зүйтэй" хэмээн тооцогдох зан үйл, юу хийж болох, болохгүйг тулгаж, хүлээлт, шахалт үүсгэдэг ба үндэслэн үйлдэгддэг учраас жендэрт суурилсан хүчирхийлэл гэж нэрлэгддэг. Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалд үндэслэгдсэн байдаг ба суурь шалтгаан нь жендэрээс үүдэлтэй эрх мэдлийн тэнцвэргүй байдал юм.

ЖСХ нь хувийн, ойр дотны харилцаанд, гэр бүлд, ажлын байранд, боловсролын орчинд, гудамж талбайд, ер нь нийгмийн бүхий л хүрээнд үйлдэгддэг. Эрх мэдлийн тэнцвэргүй харилцаа суурь шалтгаан нь учраас ихэвчлэн эмэгтэйчүүд, охидын эсрэг үйлдэгддэг. Нийгэмд хэвийн үзэгдэл болтлоо хүлээн зөвшөөрөгдөж, нийгэмд тогтсон хэм хэмжээ, хүмүүсийн үзэл хандлагаар дэмжигдэж байдаг.

ЖСХ-д олон хүчин зүйл нөлөөлдөг, тэдгээр хүчин зүйлс нь давхцдаг, өөр, өөр нөхцөлд янз бүрээр илэрдэг, олон талт асуудал юм. Энэ нь амьдралын турш тохиолдож болох ба амьдралын аль мөчлөгт тохиолдож болохоос шалтгаалан өөр өөр байдаг ч хоорондоо холбоотой.

Жендэрт суурилсан хүчирхийллийн төрлүүд

Манай улсад жендэрт суурилсан хүчирхийллийн дараах төрлүүд түгээмэл үйлдэгддэг:

Гэр бүлийн хүчирхийлэл

Бэлгийн хүчирхийлэл /Гудамж, талбайд үйлдэгдэх хүчин, болзооны хүчин, ураг төрлийн хүчин, гэрлэгсдийн хүчин, бэлгийн халдлага зэрэг/

Хүн худалдаалах

Бэлгийн дарамт /Энэ нь боловсролын орчинд, бас ажлын байранд голчлон үйлдэгддэг/



Хүчирхийллийн эдгээр хэлбэр давхцдаг. Дангаар байх нь ховор. Сэтгэл санааны дарамт нь хүчирхийллийн бусад хэлбэртэй хавсардгаараа нийтлэг ч нүдэнд харагддаггүй. Харин шинж, тэмдгүүд нүдэнд ил байдаг учраас хүмүүс бие махбодын хүчирхийллийг илүү мэддэг.

Хүчирхийллийн төрлүүд, түүний илрэх үйлдлүүдийг мэдсэнээр хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэхээс гадна бусдад цаг алдахгүй тусалж чадна.

Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх төөрөгдөл ба бодит байдал

Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх өрөөсгөл ойлголт олон байдгаас олон нийт төдийгүй хохирогчид хүртэл төөрөлддөг. Энэ нь жендэрийн хэвшмэл ойлголттой холбоотой байдаг. Эдгээрээс зарим өрөөсгөл ойлголтыг тодруулж тайлбарлавал:

Төөрөгдөл 1: Манай уламжлалын нэг хэсэг гэж үзэх

Бодит байдал: Уламжлалыг хэрхэн ойлгодог бид эргэн харах шаардлагатай. Уламжлал нь тухайн улс орон, нийгмийн хувьд олон

жилийн туршид шүүн тунгаагдсан, дараа үедээ өвлүүлэн үлдээх үнэт зүйл байдаг. Харин хүчирхийлэл нь хүнд айдас, түгшүүр төрүүлж, зовоон шаналгадаг. Хэн нэгнийг ялгаварлаж, зовиур, шаналал авчрах нь манай уламжлал яавч биш.

Төөрөгдөл 2. Хүчирхийлэл нь санамсаргүй үйлдэл

Бодит байдал: Хүчирхийлэл хэзээ ч санамсаргүй байдаггүй. Эрх мэдлийн давамгайл байдлаа ашиглан, хяналтаа тогтоож, хохирогчийг хамааралд, дуулгавартай байдалд оруулах зорилгоор үйлдэгддэг, шууд санаатай үйлдэл, эс үйлдэл юм.

Төөрөгдөл 3. Хохирогчоос өөрөөс нь болсон гэж буруутгах

Бодит байдал: Хүчирхийлэлд ямар ч зөвтгөл, хүлээн зөвшөөрөгдөх түвшин байх учиргүй. Үзэл бодлоо илэрхийлэх, санал нийлэхгүй байх нь хүчирхийлэлд өртөх шалтгаан биш. Буруутай байлаа ч хүчирхийлэл, дарамт үйлдэх аргаар зөрчил, асуудлыг шийдвэрлэж болохгүй.

Төөрөгдөл 4. Эрчүүд ч гэсэн хүчирхийлэлд өртдөг байтал эмэгтэйчүүдийг түлхүү ярих юм.

Бодит байдал: Жендэрт суурилсан хүчирхийлэлд хэн ч, амьдралынхаа аль ч хугацаанд, хаана ч өртөж болно. Гэмт хэрэг, зөрчлийн статистикаас харахад дийлэнх нь охид, эмэгтэйчүүд хохирч байна.

Төөрөгдөл 5. Эрчүүд төрөлхөөсөө л түрэмгий зан ааштай.

Бодит байдал: Бүх эрчүүд хүчирхийлэл үйлдэгч биш. Хүчирхийлэл нь сонголт, сурсан зан үйл юм.

Төөрөгдөл 6. Хүчингийн хэргийн хохирогч нь зөвхөн эмэгтэйчүүд л байдаг.

Бодит байдал: Цөөн тохиолдолд хөвгүүд, эрэгтэй хүн ч ялгаагүй хүчингийн хэргийн хохирогч болдог.

Төөрөгдөл 7. Хүчиндэгч нь танихгүй хүмүүс байдаг.

Бодит байдал: Харамсалтай нь ихэнх тохиолдолд хүчиндэгч нь хохирогчийн сайн таньдаг хүн, хөрш, хамаатан садан, дотны хүн нь байдаг. Тэр ч байтугай найз залуу, төрсөн болон хойд эцэг байх тохиолдлууд гардаг.

Төөрөгдөл 8. Нэг ажлын газрын хүмүүсийн хооронд тоглоом, наргиа байж л байдаг. Энэ үедээ биед нь хүрч, тэвэрч болно шүү дээ.

Бодит байдал: Хүсээгүй үед бэлгийн сэдэлтэй санал тавих, биед хүрэх нь бэлгийн дарамт болно.

Төөрөгдөл 9. Зөвхөн гадаадад худалдаалагдсан хүн л хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болно.

Бодит байдал: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь зөвхөн гадаадад худалдаагддаггүй. Биеийг нь үнэлүүлж, ашиг олох зорилгоор хил дамжуулахгүйгээр дотооддоо хүнийг худалддаг зохион байгуулалттай бүлгүүд байдаг.

1.3 ЭРХ МЭДЭЛ БА ХҮЧИРХИЙЛЛИЙН УЯЛДАА ХОЛБОО

Эрх мэдэл ба түүний төрлүүд

Эрх мэдэл бидний амьдралын салшгүй нэг хэсэг. Эрх мэдэл нь бидний шийдвэр, сонголтонд байнга нөлөөлж байдаг ч бид эрх мэдлийн тухай бараг боддоггүй.

Эрх мэдэл нь өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй байх, шийдвэрээ өөрөө гаргах, сонголт хийх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, амьдралаа өөрийнхөөрөө бүтээх хүч, чадамж юм.

Эрх мэдлийн доорх 4 төрөл бий.

1. Дотоод хүч, эрх мэдэл
 2. Хамтын хүч, эрх мэдэл
 3. Өөрчлөлт хийх, үйл хэрэг болгох эрх мэдэл
 4. Бусдыг хянах, дарамтлах эрх мэдэл
- Эдгээр эрх мэдлийг дэлгэрүүлж тодорхойлъё.

Дотоод хүч, эрх мэдэл: Амьдралдаа болон эргэн тойрондоо эерэгээр нөлөөлөх чадвартай гэдгээ ухаарахад бидний дотроос ундрэн гардаг хүч. Бид өөрт буй энэ эерэг эрх мэдлээ нээснээр эргэн тойронд, хамт олны дунд шударга бус байдалд хүргэж байгаа эрх мэдлийн сөрөг хэрэглээг зогсоох эрмэлзэлтэй болдог.

Хамтын хүч, эрх мэдэл: Ганц, ганцаараа хийж чадахгүй зүйлээ хоёр буюу түүнээс дээш хүмүүс нийлж хийхэд мэдрэгддэг эрх мэдэл.


Өөрчлөлт хийх, үйл хэрэг болгох эрх мэдэл: Хувь хүмүүс, бүлгүүдийн эерэг өөрчлөлт авчрах чадамж буюу тэдний итгэл үнэмшил, эрч хүч, үйл ажиллагаа юм.

Бусдыг хянах, дарамтлах эрх мэдэл: Хэн нэгэн хүн буюу бүлэг хүмүүс өөр хүнийг эсвэл өөр нэгэн бүлгийг хянах, эрхийг нь хязгаарлаж, дарамтлахад ашигладаг эрх мэдэл. Хэн нэгэн эрх мэдлээ бусдыг хянах, эрхийг нь хязгаарлах хэлбэрээр ашиглах нь хүчирхийлэл мөн. Эрх мэдлийн тэгш бус байдал нь айдас, түгшүүр, дарамт, хүчирхийллийг төрүүлж байдаг.

Эрх мэдэл ба хүчирхийллийн уялдаа холбоо

Эрх мэдэл нь хязгаарлагдмал зүйл огт биш. Хүн бүрт эрх мэдэл бий. Аль ч хүйсийн хүнд нөгөө хүйсийн хүнээс дээгүүр эрх мэдэл байхгүй. Хэн нэгэн эрх мэдэлтэй байхын тулд бусдаас эрх мэдлийг нь авах шаардлагагүй.

Хүмүүс эрх мэдлээ ихэнхдээ эерэгээр ашигладаг бол, харамсалтай нь зарим хүн сөргөөр хэрэглэдэг. Дотоод хүч чадлаа нээн, бусадтай хүчээ нэгтгэн, эргэн тойрноо өөрчлөх чадамжаа мэдэрч байгаа бол энэ нь эрх мэдлээ эерэгээр ашиглаж байгаагийн илрэл юм. Харин бусдыг үл хүндэтгэж, эрх чөлөөг нь хянаж байгаа бол энэ нь эрх мэдлээ сөргөөр ашиглаж байгаагийн илрэл юм.



Эрх мэдлийн энэ сөрөг хэрэглээ нь эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг үүсгэдэг ингэснээр дарамт, хүчирхийллийг төрүүлж байдаг. Бид зарим нөхцөл, тохиолдолд өөрсдийгөө эрх мэдэлтэй гэж мэдэрдэг, харин зарим үед эрх мэдэлгүй, хүчин мөхөс байна гэж мэдэрдэг. Эдгээр нөхцөл, тохиолдол нь хүн бүрийн хувьд ялгаатай.

Бид ихэвчлэн хүчирхийллийн үр дагавар болох бэртэл, гэмтэл, сэтгэл санааны цочрол, хямрал, эрүүл мэндийн хохиролын талаар л ярилцдаг. Харин "Яагаад энэ хүчирхийлэл үйлдэгдээд байна?" гэж бараг асуудаггүй. Эрх мэдлээ бусдыг хянах, дарамтлах байдлаар сөргөөр ашигласны улмаас үүссэн эрх мэдлийн тэнцвэргүй байдал нь жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан юм. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү эрх мэдэлтэй байх ёстой гэсэн хүлээлт манай нийгэм, хамт олны дунд давамгайл байдаг тул заримдаа бид дотно харилцаандаа эрх мэдлийн тэгш бус байдалд байгаагаа өөрсдөө ч ухаараагүй байдаг. Зарим хүмүүс эрх мэдлийн тэнцвэргүй байдал байгааг ойлгож байдаг боловч үүнд дасал болсон байдаг учраас өөрчлөхийг оролддоггүй.

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийг хүсч байгаа бол эрх мэдлээ сөргөөр ашиглахыг зөвшөөрөөд байгаа хэм хэмжээг өөрчлөхөд анхаарах шаардлагатай.

Хүмүүс эрх мэдлээ сөргөөр ашиглахаас татгалзсан үед хүчирхийллээс ангид амьдарч чадна.

Хамт олон, олон нийт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг эсэргүүцэж тэгш бус байдлаас татгалзаж, дуу хоолойгоо нэгтгэх тохиолдолд л жендэрт суурилсан хүчирхийлэл эцэс болно.

1.4 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН БУСАД ХЭРГЭЭС ЯЛГАГДАХ ОНЦЛОГ

Гэр бүлийн хүчирхийлэл, түүний хэлбэрүүд

Гэр бүлийн хүчирхийлэл гэж гэр бүлийн гишүүд болон хамаарал бүхий хүний зүгээс бусаддаа хяналтаа тогтоож, эрх мэдлийн тэнцвэргүй байдалд оруулж буй үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

Гэр бүлийн хүчирхийлэл нь жендэрт суурилсан хүчирхийллийн түгээмэл үйлдэгдэж байгаа нэг төрөл ба хүний амьд явах, аюулгүй орчинд амьдрах, халдашгүй, хараат бус байх эрхэд халдсан хүний эрхийн ноцтой зөрчил юм. Гэр бүлийн хүчирхийлэл нь нас, хүйс, хөрөнгө чинээ, нийгэмд эзлэх байр суурь, боловсрол зэргээс үл хамааран төрөл бүрийн хэлбэрээр үйлдэгддэг.

Гэр бүлийн хүчирхийллийг хүмүүс ихэвчлэн гэр бүл дотор эхнэр, нөхрийн хооронд үйлдэгддэг гэж ойлгодог ч бодит байдалд өргөн хүрээг хамардаг. Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчтой нэг гэрт амьдардаг эсэхээс үл хамааран эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүнээс гадна хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа хүн, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа хүн болон тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү зэрэг ойр дотны харилцаатай хүмүүсийн хооронд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгддэг. Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй хүний хооронд үйлдэгдсэн хүчирхийлэл ялгаагүй гэр бүлийн хүчирхийлэлд тооцогдоно.

Гэр бүлийн хүчирхийлэл хэзээ ч санамсаргүй үйлдэгдэхгүй. Биеэ барьж чадаагүй, хяналтаа алдсанаас шалтгаалж үйлдэгддэггүй. Эрх мэдэл, хяналтандаа хохирогчийг оруулах зорилго, сэдэл бүхий шууд, санаатай үйлдэл юм.

Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүд

Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийг хяналтандаа байлгахын тулд янз бүрийн арга, тактик ашигладаг. Үүнээс шалтгаалан гэр бүлийн хүчирхийлэл нь нийтлэг дараах хэлбэрүүдтэй:

- Бие махбодын хүчирхийлэл
- Сэтгэл санааны хүчирхийлэл
- Эдийн засгийн хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл



Бие махбодын хүчирхийлэл

Бие махбодын хүчирхийлэл гэж гэр бүлийн гишүүний хэн нэг нь бусаддаа хяналтаа тогтоон, хамааралд оруулах зорилгоор биед нь халдан өвдөлт авчирч, бэртэл, гэмтэл учруулах болон учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.

Бие махбодын хүчирхийллийн үр дагавар нүдэнд шууд харагдахуйц байдаг тул хүчирхийллийн энэ төрлийг хүн бүр мэддэг. Гэхдээ энэ нь хамгийн их хэрэглэгддэг хүчирхийллийн төрөл биш юм.

Сэтгэл санааны хүчирхийлэл

Гэр бүлийн гишүүний хэн нэг нь бусдынхаа хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, доромжлох, дорд үзэх, айлган сүрдүүлэх, заналхийлэх, нэр төр, алдар хүндийг нь гутаах, гүтгэх, мөрдөн мөшгих, ах дүү, төрөл төрөгсөд, хамт олноос нь тусгаарлах, бусадтай харилцахыг хязгаарлах, эд хөрөнгөө сүйтгэх, гэрийн тэжээмэл амьтанд уур хилэнгээ гаргах болон бусад хэлбэрээр сэтгэл санааны



шаналал үүсгэснийг сэтгэл санааны хүчирхийлэл гэнэ.

Сэтгэл санааны хүчирхийлэл нь хамгийн түгээмэл үйлдэгддэг ч хүмүүс хүчирхийлэл гэж үзэх нь бага. Хохирогч ч бас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж байна гэж анзаарч таньдаггүй тул байнга давтагдаж байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн бусад хэлбэрүүдтэй хавсардаг, нүдэнд илт харагдаж мэдрэгдэхгүй тул үр дагавар, хор уршгийг хэмжих, нотлоход төвөгтэй.

Хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийг дуулгавартай болгож, хамааралдаа оруулахын тулд айдас, түгшүүрт оруулж, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нь үгүй хийдэг.

Эдийн засгийн хүчирхийлэл

Гэр бүлийн гишүүн нөгөө этгээдийнхээ хөдлөх ба үл хөдлөх, түүнчлэн мөнгөн хөрөнгө, цалин хөлсийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль бусаар захиран зарцуулах эрхийг хууль бусаар хязгаарлахыг хэлнэ.



Санхүүгийн нөөцийг хяналтдаа байлгах зорилгоор цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсан аливаа үйлдэл, зан үйл хамаарна.



Бэлгийн хүчирхийлэл

Гэр бүлийн гишүүн, сэтгэл зүйн болон ураг төрлийн хамааралтай хүний эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ. Бэлгийн сэдэлтэй үг хэллэг, онигоо ярих, зураг, кино, дүрс үзүүлэх, үнсэх, илж таалах зэргээр зөвшөөрөлгүй хүрэх, хүсээгүй байхад бэлгийн харьцаанд орохыг албадах, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, зэвсэг, эсвэл өөр бусад зүйлсийг хэрэглэн бэлгийн шинжтэй үйлдэлд албадах, хүчиндэх

болон хүчиндэхээр завдах үйлдлүүд орох ба үүгээр хязгаарлагдахгүй. Дээрх гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүдийг нөхцөл байдлын үнэлгээ хийх, хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд харгалзан үзнэ.


Гэр бүлийн хүчирхийллийн давтамж, даамжирал

Гэр бүлийн хүчирхийлэл нь далд үйлдэгддэг ба давтагдан даамжирч байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэл нь далд үйлдэгддэг.




Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн гишүүдийн нэр төр, хувийн нууцтай холбогддог эмзэг асуудал тул далд, гэрчгүй үйлдэгддэг. Мөн нийгэм, олон нийт “гэр бүлийн дотоод асуудал” гэж үзэх хандлага түгээмэл учраас хохирогчийг буруутгах хандлага хүчтэй хэвээр байгаа үед гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүс хүчирхийллийн эхэн үед бусдаас тусламж, дэмжлэг хүсэх нь ховор.



Далд үйлдэгддэг тул эрт шатанд мэдээлэгдэх, илрэх нь ховор. Ихэвчлэн гэмтэл авсан, эсвэл амь нас хохирсон үед илэрдэг.

Гэр бүлийн хүчирхийлэл нь давтагддаг




Хаалттай хаалганы цаана эрх мэдлийн тэнцвэргүй харилцаа өрнөдөг учраас хүчирхийлэл давтагдаж байдаг. Давтагдах тусмаа даамжирч, үхэл, амьдралын зааг ойртож ирдэг.

Хүчирхийлэл үйлдэгч зан үйлээ эргэн харж, хүчирхийлэл үйлдэхээ зогсоогоогүй цагт хүчирхийлэл давтан үйлдэгдсээр байдаг. Хохирогч дангаараа таслан зогсоох боломжгүй, тэд хүчирхийлэлтэй харилцааг зогсоох гарц хайж, даван туулахыг хичээдэг ч хүчирхийлэл давтагдах тусам итгэл, найдвар нь багасдаг учир хөндлөнгийн оролцоо зайлшгүй шаардлагатай.

Хүчирхийлэлтэй харилцааны тойрог, хохирогч хүчирхийлэлтэй харилцаандаа үлддэг шалтгаанууд

Хүчирхийлэлтэй харилцааны тойрог



Гэр бүлийн хүчирхийлэл нь далд үйлдэгдэж, байнга давтагдан даамжирч байдаг. Энэ давтамж нь мөчлөг хэлбэрээр илрэхийг хүчирхийлэлтэй харилцааны тойрог гэж нэрлэдэг.

Зөрчил хуримтлагдах үе

• Маргаан, зөрчил ихсэж, хүчирхийлэл үйлдэгч бал сарын үед амлаж байсан амлалтаасаа бага багаар няцаж эхэлнэ.

- Хохирогчийн хийж буй үйлдэл бүрийг хянан, буруутгах шалтгааныг хайж, янз бүрийн шалтаг гарган хэрүүл өдөх, эсвэл дуугаа хураан элдэв дарамт шахалт үзүүлж эхэлнэ.
- Хохирогч хүчирхийлэл үйлдэгчийг тайвшруулахын тулд юу ч хамаагүй хийх гэж оролдох ч энэ нь ихэнхдээ амжилтгүй болж дуусна.

Тэсрэлтийн үе

- Хүчирхийллийн тойргийн хамгийн аюултай үе шат юм.
- Эрх мэдэл, хяналтаа бүрэн тогтоохын тулд хүчирхийлэл үйлдэгчээс биеийн болон бэлгийн, эдийн засгийн дарамт, шахалт үзүүлэх нь маш хүчтэй болно.
- Хүчирхийлэл үйлдэгдэж, хэн нэгэн гэмтэж, бэртэж, амь насаа алдах эрсдэл өндөр.

Бал сарын үе

- Хүчирхийлэл үйлдэгчдийн ихэнх нь “хяналтаа алдсан байсан” гэсэн шалтгаанаар уучлал хүсдэг. Зарим нь өөр бусад гадны хүчин зүйлсийг энэ бүхэнд буруутай гэж тайлбарлана.
- “Өөрчлөгдөнө, дахин ийм үйлдэл хийхгүй” гэж амлана. Хохирогчид бэлэг авч өгөх, гэр орны ажлаа хийх зэргээр анхаарал тавихыг хичээнэ. Зарим нь эсрэгээр эвлэрэхгүй бол “ингэнэ, тэгнэ” гэх мэтээр айлган сүрдүүлнэ.
- Хохирогч нь хүчирхийлэгчийн амлалт болон халамж анхааралд нь итгэж уучилдаг.
- Гэр бүлийн гишүүн бүр сэтгэл хангалуун мэт боловч энэ бүхэн удаан үргэлжлэхгүй.
- Хүчирхийллийн эргүүлэг үргэлжилж, ямар нэг шалтгаанаар хүчирхийлэл үйлдэгч бухимдаж, айдас, түгшүүр эхэлнэ.

Хүчирхийлэлтэй харилцааны тойргийн үе шат бүрийг заавал дамждаггүй. Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл өөрчлөгдөөгүй, тэдний харилцаан дахь эрх мэдлийн тэнцвэрт бус байдал хэвээр үед хүчирхийлэл зогсохгүй. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр бал сарын шатыг алгасаж, зөрчил хуримтлагдах байдлаас шууд тэсрэлтийн үе шат руу шилжинэ.

Хохирогч хүчирхийлэлтэй харилцаандаа үлддэг шалтгаанууд

Зодуулдаг эмэгтэйн хам шинж /The syndrome of the battered woman/

Энэ нь сэтгэцийн гэмтлийн дараах стресст эмгэг юм. Удаан хугацаанд үргэлжилсэн, өөрөөр хэлбэл даамжирсан хүчирхийллийн дунд бий болдог. “Зарим эмэгтэй хэт их айсны улмаас эсвэл зугатах ямар ч боломжгүй гэж итгэдэг учраас хүчирхийлэлтэй харилцаандаа үлддэг” гэсэн санааг Ленора Волкео 1979 онд танилцуулсан. Тэрээр гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйн цөхрөх, итгэл найдвараа алдах, тусламж авах боломжгүй гэж итгэх, хүчирхийллийн эргүүлэгт орж түүнээсээ гарч чадахгүй болох, хэвийн бус харилцаанд ээнэгшин дасах энэ бүх шинжийг “зодуулдаг эмэгтэйн хам шинж” гэж нэрлэсэн. Хэдийгээр зугтах боломжтой ч ганцаараа бие даан амьдарч чадна гэж өөртөө итгэхгүй бол хохирогч хүчирхийлэлтэй харилцаагаа орхиж явдаггүй.

Энэ нь эмэгтэйчүүд цагдаад мэдэгдэхгүй байх, эсвэл гэр бүл, найз нөхөддөө өөрийнхөө нөхцөл байдлыг хэлэхээс зайлсхийхэд нөлөөлдөг. Энэ байдлаар далд үйлдэгдэж, давтагдан даамжирсаар зарим тохиолдолд хүчирхийлэл үйлдэгчийнхээ амь насыг хөнөөхөд хүргэдэг.

Энэ хам шинж нь ерөнхийдөө 4 үе шаттай:

1. Үгүйсгэл: Дарамт, хүчирхийлэлд байгаагаа хүлээн зөвшөөрч чадахгүй, эсвэл "нэг л удаагийнх" гэж зөвтгөдөг.

2. Буруутгал: Дарамт, хүчирхийлэлд өөрийгөө буруутай гэж итгэх

3. Олж харах: Энэ үе шатанд хохирогч хүчирхийлэл өөрөөс нь биш, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлээс болж үйлдэгдэж байгааг олж хардаг.

4. Хариуцлага: Хүчирхийлэл үйлдэгч хийсэн үйлдэлдээ хариуцлага хүлээх ёстойг хүлээн зөвшөөрдөг. Ихэнхдээ хүчирхийлэлтэй харилцаанаас гарах гэж хичээж байх үедээ хохирогч үүнийг ойлгодог.

Хүчирхийлэлтэй харилцаандаа байгаа зарим хохирогч эхний хоёр шатанд байх үедээ хүнд гэмтэж, амь насаа алдах тохиолдлууд гардгийг мартаж болохгүй.

Аажмаар шатах хариу үйлдэл /Slow burn reaction/

Энэ нь дарамт, хүчирхийлэлд байгаа эмэгтэй сэтгэл зүйн зарим шалтгаанаар, мөн хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн хоорондох хүч, чадлын тэнцвэргүй харьцааны улмаас хүчирхийлэл үйлдэгдсэн даруй, шууд хариу үйлдэл үзүүлдэггүй хэрнээ хүчирхийлэл дахин үйлдэгдэх гэж байгаа, энэ нь өөрт нь өмнөхөөс илүү аюул авчрах мэт төсөөлөгдөх үед илэрдэг хариу үйлдэл юм. Үүнийг улаан гэрэл байнга асаалттай байхтай

зүйрлэж болно. Өөрөөр хэлбэл тархинд айдас, түгшүүрийн голомт үүсдэг. Зодуулдаг эмэгтэйн хам шинжтэй хохирогч нь хүчирхийлэл үйлдэгдэж байгаа үед тэр даруйд нь хариу үйлдэл үзүүлэхгүй, өөрөөр хэлбэл шууд уурлахгүй тэвчдэг ба тэр нь хуримтлагдаж байгаад гэнэт дэлбэрдэг. Үүнийг хүчирхийлэл үйлдэгчийнхээ амь насыг хөнөөсөн эмэгтэйчүүдийн үйлдсэн хэргээс харж болно.

Тэд хүчирхийллийг зогсоох гэж өөрийн зүгээс хийж чадах бүхий л зүйлийг хийгээд юу ч өөрчлөгдөхгүй байгааг хүчирхийлэлтэй харилцааны явцаас мэдэрсэн байдаг. Мөн өөрийгөө, бас хүүхдүүдээ хамгаалах оролдлого бүрт хүчирхийлэл үйлдэгчийн үйлдэл улам ноцтой, хэрцгий болж байгааг хүчирхийлэлтэй харилцааных нь туршлага мэдрүүлсэн байдаг. Хүчирхийлэл үйлдэгчийг эрүүлд нь ч юмуу эсвэл сэрүүн үед нь дийлэхгүй, яаж ч чадахгүй гэдгийг мэдэрсэн энэ туршлага нь хэзээ нэгэн цагт энэ хүний гарт амь насаа алдаж магадгүй гэсэн айдас, түгшүүртэй давхцан, өөрийгөө, бас хүүхдүүдээ хамгаалах үүднээс хүчирхийлэл үйлдэгчээ унтаж юмуу согтуу байхад нь, эсвэл хүчирхийлэл дахин давтагдах нь гэж үзсэн нөхцөлд түүний амь насыг нь хөнөөдөг. Хохирогч үүнийг хүчирхийллээс ангижрах цорын ганц арга зам гэж итгэхэд хүрсэн байдаг.

Хохирогчийн энэ үйлдэл нь хүчирхийлэл үйлдэгдэж байгаа, довтолгоо эхэлсэн тэр цаг хугацаатай давхцдаггүйгээс хүний амь нас хөнөөсөн шууд санаатай үйлдэлд тооцогддог. Хүчирхийллийн дайралт, хохирогчийн хамгаалалт хоёр давхцдаггүйгээс аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд тооцогддоггүй. Харин шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуулиар /2016/ ийм тохиолдолд хөнгөрүүлж үзэх болсон.

Гэр бүлийн хүчирхийлэл нь бусад хэргээс ялгагдах онцлог

Далд үйлдэгддэг

Гэр бүлийн хүчирхийлэл нь хувь хүний болон гэр бүлийн нэр төртэй холбогддог эмзэг асуудал учир ихэнхдээ далд үйлдэгддэг. Далд үйлдэгддэг учраас ихэнхдээ гэрчгүй, гэр бүлийн бусад гишүүн нь асуудлыг ил гаргахыг хүсдэггүй. Ойр дотны хүмүүсээ байнга хүчирхийлдэг хүмүүс хохирогчийг хамааралдаа оруулсан байдаг тул хүчирхийллийг илчлэх, мэдээлэх гэсэн хүсэл, зоригийг нь хяналтаа ашиглан мохоодог тул эрт шатандаа илрэх нь ховор.

Давамгаалдаг

Зөрчил болон асуудлыг дарамт, хүчирхийллийн аргаар шийдэж сурсан зан үйлээ өөрчлөхийг хүчирхийлэл үйлдэгч хүсээгүй цагт гэр бүл дэх хүчирхийлэл байнга давтагдаж байдаг. Тиймээс хүчирхийлэл үйлдэгдсэн тохиолдол болон үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлыг мэдээлэх, шуурхай таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг тэргүүн ээлжид анхаарах шаардлагатай.

Даамжирдаг

Гэр бүлийн хүчирхийлэл давтагдах тусмаа хоорондын зай нь ойртож, даамжирч байдаг. Давтамжийн хоорондын зай ойртох тусам амь насаа алдах эрсдэлд хүргэдэг тул хүчирхийлэлтэй харилцааны түүхийг судалж, хэн нь илүү давамгайлж, хэн нь илүү айдас, түгшүүртэй байгааг тодорхойлох шаардлагатай. Аюулын зэргийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ тухайн гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцааны түүхийг бүхэлд нь судална.

Ураг төрөл, сэтгэлзүй болон санхүүгийн хамаарал бүхий хүмүүсийн дунд үйлдэгддэг.

Энэ хамаарал нь заавал нэг гэр бүлд байгаа гишүүдийн хүрээгээр хязгаарлагдахгүй. Энэ онцлогийг харгалзан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг дараах 3 хүрээгээр тодорхойлсон. Үүнд:

1. Эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа хүн;
2. Тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү;
3. Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй хүн.

Хохирогч нь хүчирхийлэл үйлдэгчээс хамааралтай байдаг.


Хохирогч нь ихэвчлэн хүчирхийлэл үйлдэгчтэй нэг орчинд амьдардаг. Хохирогч хуулийн байгууллагад хандсан ч өөр очих газаргүйгээс ихэвчлэн хэрэг шийдвэрлэгдтэл хүчирхийлэл үйлдэгчтэй нэг орчинд амьдрах болдог. Ингэснээр хүчирхийлэл үйлдэгчийн амлалт, ятгалга, сүрдүүлэг, заналхийлэл, дарамтад орж, арга буюу гомдол, мэдүүлгээсээ буцахад хүрдэг.

Хүчирхийлэлтэй харилцааны явцад бий болсон айдас, түгшүүр нь хохирогчийн хувьд бодитой байдаг. Хүчирхийлэл үйлдэгч гадны хүний дэргэд гараа зангидах юмуу ганц удаа муухай харахад л энэ нь ямар үр дагавар учруулахыг хохирогч мэднэ.

1.5 ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах тогтолцоо ба түүний оролцогч талууд

Гэр бүлийн хүчирхийлэл нь олон талт, төвөгтэй асуудал тул аюулгүй байдал, хууль, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр, нийгмийн халамж, хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллагуудын нэгдмэл хүчин чармайлт, хамтын ажиллагаа, түншлэл зайлшгүй шаардлагатай. Нэг байгууллага, ганц мэргэжилтэн дангаар ажиллаад энэ асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй.



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нь өргөн хүрээтэй ойлголт ба дараах чиглэлүүдийг өөртөө багтаадаг:

- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
- Илрүүлэх, таслан зогсоох
- Хохирогчийг хамгаалах
- Хохирогч, гэр бүлийн гишүүдэд үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэх
- Хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох, зан үйлд нөлөөлөх.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах тогтолцоо нь дараах бүрдэл хэсэгтэй:
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн байгууллагууд
- Хохирогчийг хамгаалах эрх зүйн орчин, цогц зохицуулалтууд
- Салбар дундын зохицуулалтыг хангах механизм

Хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, мэргэжилтнүүд тогтолцоог бүхэлд нь харж, дангаар болон хамтдаа ямар чиг үүрэг хүлээж, тогтолцооны нэг хэсэг болж байгаага олж харах нь хамтын ажиллагаа, түншлэлийн суурь болно.

Шинэчлэн батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн нэг давуу тал нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог бүхэлд нь тодорхойлж, байгууллага тус бүрийн бүрэн эрх, тэргүүлэн хариуцах чиглэл болон төсвийг тодорхойлон зааж баталгаажуулсан явдал юм.

Хохирогчийг хамгаалах эрх зүйн цогц зохицуулалтууд

2004 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай анхны хууль нь нийгэмд болон хуулийн байгууллагын ажилтнуудад гэр бүлийн хүчирхийллийг нийгмийн асуудал болохыг таниулж, хохирогчдод чиглэсэн олон төрлийн үйлчилгээг үүсгэн, хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээ, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх хөтөлбөр зэрэг механизмыг туршин хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан ч хохирогчийг хэн, яаж, хэрхэн хамгаалах процессийн зохицуулалтууд дутаж байлаа.

Уг хуулийг батлагдахаас өмнө буюу 2002 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль батлагдсан байсан нь хохирогчийг хамгаалах заалтуудыг эдгээр хуульд тусгахад хүндрэл үүсгэсэн. Батлагдаад удаагүй байгаа хуульд нэмэлт өөрчлөлт оруулахгүй гэсэн хандлага хууль тогтоогчдын дунд давамгайлж байснаас арга буюу Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дангаар нь батлуулахаас аргагүйд хүрсэн билээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсаны дараахнаас эрх зүйн цогц шинэчлэлийг бий болгохын төлөөх нөлөөллийн ажлыг Хүчирхийллийн эсрэг үндэсний төв эхлүүлсэн ба 12 жилийн тууштай, стратеги бүхий нөлөөллийн үр дүнд 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль шинэчлэгдсэн батлагдсанаар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах цогц зохицуулалт бүрдсэн билээ.

Гэвч нэгэнт бүрдсэн эрх зүйн цогц зохицуулалтыг ашиглахгүй, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дангаар нь хэрэглэх явдал практикт харагдаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх болон хохирогчийг хамгаалах үзэл баримтлал, суурь зарчмууд, хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох ажиллагаа, хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрлүүд болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо, бүтэц, механизм, энэ хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудын чиг үүрэг зэргийг тодорхойлсон, урьдчилан сэргийлэх агуулгатай суурь хууль юм.

Харин хүчирхийллийн үйлдэл нь зөрчил, гэмт хэрэг, эсвэл иргэний хэрэг эсэхээс хамаарч хохирогчийг хамгаалах нарийвчилсан ажиллагаанууд нь бусад хуулиудад тусгагдсан байдаг. Тухайлбал: Эрүүгийн хууль,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн хамгааллын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэрэг хуулиудаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах зохицуулалтууд болон хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлага нарийвчлан тусгагдсан.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах эрх зүйн цогц орчин



Дээрх хуулийн холбогдох зохицуулалтуудыг сайтар судалж, хохирогч тус бүрийн хэрэгцээнд нийцүүлэн чадмаг ашиглаж чадсан тохиолдолд л хохирогчийн аюулгүй байдал болон амь нас, эрүүл мэнд бүрэн хамгаалагдаж чадна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн үзэл баримтлал, хамрах хүрээ, зарчмууд

Аливаа хуулийн амин сүнс болсон үзэл баримтлал нь тухайн хуулийг уншсан даруйд бүрэн харагддаггүй. Нэг хууль доторхи зүйл, заалтуудын хоорондын уялдаа холбоо, бүр цаашилбал, тодорхой нэг хуульд байгаа заалт холбогдох өөр бусад хуулийн зохицуулалттай хэрхэн нарийн холбогдож байгааг олж харахад төвөгтэй. Иймээс ч бусад улс орнуудад хуулийн эх баригч гол үүрэгтэй байдаг ба хуулийн ажлын хэсгийн гишүүд

тухайн хуулийг батлагдсан цагаас эхлэн хуулийн үзэл баримтлал, агуулгыг хууль хэрэглэгч, хэрэгжүүлэгч нарт сургалтаар дамжуулан нарийвчлан танилцуулдаг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн тухай хуулийн үзэл баримтлал

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь гэр бүлийн хүчирхийллийг эрт шатанд нь илрүүлэх, цаг алдахгүй, шуурхай таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх болон урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь урьдчилан сэргийлэх агуулгатай суурь хууль болохыг дээр дурдсан.



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн агуулга

Уг хуулиар:

1. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бүтэц, механизм
3. Хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудын салбар дундын зохицуулалт
4. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, хугацааг нарийвчлан тодорхойлсон.

Хуулийн үзэл баримтлал ба өмнөх хуулиас шинэчлэгдсэн зарчмын өөрчлөлтүүд

1. Хуулийн зорилго нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхойлоход чиглэгдсэн байсныг өөрчилж, хохирогч, гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгыг шинээр нэмсэн.
2. Хуулийн үйлчлэх хүрээг өргөтгөж, хамгаалалтын гадна үлдэж байсан хохирогчдыг энэ хуулийн зохицуулалтад хамааруулах боломжийг бүрдүүлсэн.
3. Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчаас хамааралтай эмзэг байдлыг харгалзан хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалтыг нэг бүлэг болгон шинээр оруулсан.

4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах байгууллагуудын үйл ажиллагаа салангид, зарим яамны чиг үүрэг орхигдсон байгааг өөрчилж, байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, салбар дундын зохицуулалт, тэргүүлэн гүйцэтгэгч хэн байхыг тодорхой болгосон.
5. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх үүрэг хүлээсэн байгууллагуудын дунд мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож, мэдээлэл, дүн шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргах боломжийг бүрдүүлсэн.
6. Гэр бүлийн хүчирхийллийг маргаан, иргэний хэрэг хэмээн үзэж, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлыг хохирогчийн үүрэг болгож, эрсдэлд оруулахаас гадна хүчирхийлэл дахин давтагдахад хүргэж байгааг өөрчилж, гэр бүлийн хүчирхийллийг зөрчил, гэмт хэрэгт тооцож, хариуцлага гарцаагүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.
7. Байгууллагуудын эрх хэмжээ, оролцоог хэт ерөнхий тунхаглалын шинжтэй хуульчилсныг өөрчилж, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах процедурыг тусгаж, холбогдох хуулиудын зохицуулалтыг нийцүүлэн өөрчилсөн.
8. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зохицуулалт энэ хуулиас гадна Эрүүгийн эрх зүйн тогтолцооны бусад хуулийн зохицуулалтаар давхар хангагдах боломжийг бүрдүүлсэн. Жишээ нь: хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор цагдаагийн ажилтнаас эрх хэмжээгээ хэрэгжүүлэх үндэслэл, журам, хэргийн бодит байдлыг шалган тогтоохтой холбоотой зохицуулалтыг Цагдаагийн албаны тухай хуулиар, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагын төрлийг Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар, шүүхээс оноосон ялыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулиар гэх мэтчилэн цогц байдлаар тусгасан.
9. Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зохицуулалтыг цогц байдлаар хуульчилж, үйлчилгээг мэргэшсэн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, тэдэнд үзүүлэх дэмжлэгийн хэлбэрүүдийг шинээр оруулсан.
10. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг дагаж холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулаагүйгээс өрөөсгөл зохицуулалт үйлчилж байсныг халж, эрх зүйн цогц орчин бүрдүүлсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

Уг хуулийн хамгаалалтад орох хүмүүсийг дараах 3 хүрээнд багтаан хуульчилсан

Нэг гэр бүлд амьдарч байгаа

- эхнэр, нөхөр, гэр бүлийн гишүүн
- хамтран амьдрагч
- асран хамгаалагч, харгалзан дэмжигч
- асран хамгаалалтад байгаа хүн
- тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа хүн

Тусдаа амьдарч байгаа

- Төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд
- Төрсөн, үрчлэн авсан эцэг эх, ах, эгч, дүү

Гэр бүлийн харилцаатай байсан

- Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр
- Хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан хүн
- Дундаасаа хүүхэдтэй хүн

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд баримтлах зарчмууд

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхдээ дараах зарчмуудыг үйл ажиллагаандаа удирдлага болгоно. Үүнд:

1. Хохирогчийн нэр төрийг хүндэтгэх, үл буруутгах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх
2. Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах
3. Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг шуурхай хангах
4. Нууцлалыг хамгаалах
5. Салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, нэгдмэл цогц байх
6. Хүчирхийллийг үл тэвчих

1.6 САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ

Салбар дундын зохицуулалт, түүний ач холбогдол

Гэр бүлийн хүчирхийлэл нь аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгаалалтай холбоотой олон сөрөг үр дагаврыг хохирогч, түүний гэр бүлийн гишүүдэд бий болгодог. Богино хугацаанд, түр арга хэмжээ авах юмуу эсвэл нэг төрлийн үйлчилгээг дагнан үзүүлснээр хохирогчийг бүрэн хамгаалж, нөхөн сэргээж чадахгүй.

- Иймд хохирогч, даван туулагчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл, дарамтанд дахин өртөхөөс сэргийлэх, хэвийн амьдралд эргэн оруулах, нөхөн сэргээх зэрэг олон талт хариу арга хэмжээ авах болон зайлшгүй шаардлагатай үйлчилгээнүүдийг үзүүлэхийн тулд холбон зуучлах, холбогдох байгууллага, мэргэжилтнүүд хамтран ажиллах шаардлага үүсдэг

- Хохирогч, даван туулагчийн эрх, хэрэгцээнд нийцсэн аюулгүй байдлын хамгаалалт, хууль, эрүүл мэнд, нийгмийн ажлын зэрэг зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тасралтгүй, тогтвортой, харилцан уялдаатай, үр дүнтэй хүргэхэд салбар дундын зохицуулалт нэн чухал.

Оролцогч талууд, тэдгээрийн үүрэг хариуцлагын зааг ялгаа

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар УИХ-ын бүрэн эрх

Монгол Улсын Их Хурал нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцооны нэг хэсэг юм. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд зааснаар Монгол Улсын Их Хурал нь төрөөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар баримтлах бодлогыг тодорхойлно. Хууль тогтоох дээд байгууллагын хувьд батлан гаргасан хууль тогтоомжийнхоо хэрэгжилтэд хяналт тавина. Гэр бүлийн хүчирхийллийг тэглэх, хохирогчийг хамгаалах төрийн хүчин чармайлт нь гаргасан хууль тогтоомж, бодлогоо хэрэгжүүлэх төсөв, санхүүжилт гаргаж байгаа эсэхээр тодорхойлогдоно. УИХ нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган батлах үүрэг хүлээсэн.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар Засгийн газрын бүрэн эрх

Засгийн газар нь УИХ-аас баталсан хуулийг хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. Иймд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад Засгийн газар гол үүрэгтэй. Хууль нь төрийн бодлогын гол хүрээ, чиглэлийг тодорхойлох ч бүгдийг хуулиар зохицуулах боломжгүй. Хуулийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах үүднээс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авах үүргийг Засгийн газар хүлээсэн. Энэ бодлогыг төлөвлөхдөө **гэр бүлийн хүчирхийлэлтэй** холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт болон статистик мэдээлэл, дүн шинжилгээ, судалгаанд үндэслэнэ. Иймд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулах бодлогыг нарийвчлан төлөвлөх, улсын төсөвт тусгах тусгах эхлэл цэг болно.

Төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэг

2004 онд батлагдан хэрэгжсэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар ямар чиг үүргийн хүрээнд аль яам нь тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, бүрэн хариуцлага хүлээх тухай тодорхой тусгагдаагүйгээс яамд бодлого, зохицуулалтын шийдэл шаардсан асуудлыг бие бие рүүгээ шилжүүлэх, хариуцах эзэн олдохгүй байх, эсвэл орхигдох явдал цөөнгүй гарч байв. Үүнээс сургамж авч энэ удаад яамдын бүрэн эрх, хүлээх үүргийг яамд тус бүрээр нарийвчлан зааж өгсөн.

Хуулиар үүрэг хүлээсэн байгууллагууд

Улсын Их Хурал	Засгийн газар	Хууль зүйн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага /ХЗДХЯ/	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв /ХНХЯ/
ИТХ /аймаг, нийслэл, сум, дүүргийн/	Бүх шатны Засаг дарга нар	Прокурорын байгууллага	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөл	Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар
Боловсрол урлагийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага /БСШУЯ/	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /ЭМЯ/	Төрийн бус байгууллага	Хамтарсан баг	

Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

Засгийн газрын өмнө хууль зүйн нэгдсэн бодлогыг хариуцдаг, ерөнхий чиг үүргийн яамны хувьд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд голлох чиг үүрэгтэй. Тус яамны харъяа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын салбар дундын зохицуулалтыг үндэсний хэмжээнд хариуцна.

Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

Хохирогчдод үзүүлэх 7 төрлийн үйлчилгээг зохион байгуулах, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий ажилтныг давтан сургах хөтөлбөр, журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг хариуцна. Түүнчлэн түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх ажилтныг бэлтгэх, арга зүйгээр хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх үүрэг хүлээсэн.

Тус яамны харъяа хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээнд холбон зуучлах, хяналт тавих журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих, хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх тусгай утасны үйлчилгээг улсын хэмжээнд зохион байгуулах, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээсэн.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

Анх удаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээх болсон. Тус яам нь хүчирхийллийг гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэхийн тулд зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох агуулгыг бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөр, стандартад тусгахын зэрэгцээ гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх, үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэх ур чадварыг эзэмшүүлэх агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын багш бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрт тусгаж, хяналт тавих үүрэгтэй. Түүнчлэн боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журам баталж, хэрэгжилтэд хяналт тавихаар тусгагдсан ба уг журам батлагдан хэрэгжиж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон гэрч болсон хүүхдүүд ээжийгээ даган хүчирхийллээс дайжин явах, эсвэл түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвд байрлах хугацаанд хичээл тасрах, сургууль завсардах эрсдэлд ордог. Энэ нөхцөл байдлыг зохицуулахын тулд тус яаманд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам батлахыг даалгасан ба уг журам бас батлагдан хэрэгжиж байна.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

Анх удаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээх болсон. Тус яам Нэг цэгийн үйлчилгээ, сэтгэл заслын үйлчилгээний зардлыг санхүүжүүлж, эмнэлэгт ажиллах нэг цэгийн үйлчилгээний төвийг удирдлага, зохион байгуулалтаар хангахад гол үүрэг хүлээнэ. Түүнчлэн нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж байгаа нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлан, мэдээллийн сан бүрдүүлнэ. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сургалтыг зохион байгуулах зэрэг үүргийг бас хүлээсэн.

Соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

Хүний эрх, эрх чөлөө, эрх тэгш байдлыг хүндэтгэсэн, гэр бүлийн тэнцвэрт харилцааг дэмжсэн эерэг зан үйл, хандлагыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих, сурталчлах ажлыг зохион байгуулах үүрэг хүлээсэн. Хүчирхийллийг илэрхийлж, сурталчилсан агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх, хяналт

тавих, хязгаарлалт тогтоох бүрэн эрхийг хуулиар олгосон. Одоо энэ бүрэн эрх БСШУЯ-д хамаарна.

Прокурорын байгууллагын чиг үүрэг

Анх удаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээх болсон. Тус байгууллага нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний амь нас хохирсон тохиолдол бүрийг нарийвчлан судалж дүгнэлт гаргах, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавина. Мөн Улсын ерөнхий прокурор нь хохирогчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран баталж, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Анх удаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээх болсон. Бүх шатны ИТХ нь тухайн орон нутагтаа гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бодлогыг төлөвлөх, хяналт тавихад гол үүрэг гүйцэтгэнэ. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавина. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаархи Засаг даргын тайлан, мэдээллийг хэлэлцэж, чиглэл өгөх ба Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлан, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ. Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах шийдвэрийг ИТХ-аас гаргана. Сум, хороонд хамтарсан баг байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

Бүх шатны Засаг даргын чиг үүрэг

Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахаас гадна орон нутгийн төсөвт үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг тусгуулан батлуулахад гол үүрэг гүйцэтгэнэ. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангах ба тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

Жил бүрийн орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх ба гүйцэтгэлийг тайлагнана. Мөн нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хуулиар хүлээсэн. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Төрийн бус байгууллагын чиг үүрэг /ТББ/

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх тогтолцооны нэг хэсэг ба хохирогчдод үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд мониторинг хийхэд гол үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх болон хохирогчдод үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн аргагүйгээр хангахад дэмжлэг үзүүлэх ТББ-ыг Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас магадлан итгэмжлэнэ. Төрийн энэ чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэж байгаа магадлан итгэмжлэгдсэн ТББ-д нь төрийн энэ чиг үүргийг гэрээлэн гүйцэтгэх ба олгох санхүүжилт, ажилтны цалин, урамшуулал нь адил төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллагынхаас багагүй байх баталгааг хуульчилж өгсөн.

Хохирогчийн хүсэлтээр түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлэх чиг үүрэг ТББ-д хуулиар олгогдсон. Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр төрийн, төрийн бус байгууллага, бусад этгээдтэй харилцах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны талаархи саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох байгууллага, хуулийн этгээд, бусад этгээдээс дэмжлэг хүсэх эрхтэй.

Зайлшгүй шаардлагатай үйлчилгээнүүд

Гэр бүлийн хүчирхийлэл нь олон талт үр дагаврыг хохирогч, гэр бүлийн бусад гишүүдэд авчирдаг тул хүчирхийллийг даван туулахын тулд цогц үйлчилгээ, тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд хохирогчийн хөндөгдсөн эрх, тусгай болон өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэн дараах үйлчилгээний төрлүүдийг анх удаа баталгаажуулан хуульчилсан.

Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгч бүрийн нэр төр, эрхэм чанарт хүндэтгэлтэй хандана. Үйлчлүүлэгч тус бүрийн бие даасан байдал, хувийн онцлог, соёлын өвөрмөц байдал, ялгаатай хэрэгцээг харгалзана.

Хохирогчдод үйлчилгээ үзүүлэхдээ хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн, жирэмсэн эмэгтэй, ахмад настны хэрэгцээ, шаардлагыг харгалзана. Монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид үйлчилгээ үзүүлэхдээ орчуулагч, хэлмэрчийн тусламж авах боломжоор хангана.

Хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрлүүд

1. Аюулгүй байдлын хамгаалалт	<ul style="list-style-type: none"> Түр хамгаалан байрлуулах Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнд хамруулах
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулах Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр нийгмийн ажилтантай хамтран ажиллах, мэргэжлийн дүгнэлт гаргах
Сэтгэл зүйн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Сэтгэл зүйн зөвлөгөө Сэтгэл заслын үйлчилгээ
Нийгмийн халамжийн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний холбогдох төрлүүд / Нийгмийн халамжийн тухай хуулийн 18,1 дэх зүйл/
Хүүхэд хамгааллын үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан үйлчилгээ
Эрх зүйн тусалцаа	<ul style="list-style-type: none"> Эрх зүйн зөвлөгөө Өмгөөллийн үйлчилгээ
Холбон зуучлах үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Нийгмийн ажилтаны хийсэн Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн холбон зуучилна.

Хохирогчид үзүүлэх дээрх 7 төрлийн үйлчилгээг холбогдох байгууллага, албан тушаалтан хамтран үзүүлэх, үйлчилгээний талаарх мэдээллийг солилцох үүрэгтэй. Холбон зуучлах үйлчилгээ болон байгууллага хоорондын мэдээлэл солилцоо нь хохирогч, даван туулагчийн зүгээс өөрт тохиолдсон зүйлээ олон дахин ярих эрсдлийг багасгаж, ингэснээр үйлчлүүлэгч сэтгэл зүйн цочролд дахин өртөхөөс урьдчилан сэргийлдэг. Хохирогчийг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр эмнэлгийн тусламж болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан бусад үйлчилгээг 24 цагийн турш нэг дор үзүүлэх чиг үүрэг бүхий нэгж нь эмнэлэг, төрийн болон төрийн бус байгууллага, цагдаагийн байгууллага ажиллана.

Салбар дундын зохицуулалтыг хангах бүтэц, механизмууд

“Салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, нэгдмэл цогц байх” нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зарчмын нэг юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэхдээ хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах зарчимд нийцүүлэхийг зорьсон.



Шинэчлэн батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог хуульчилж, оролцогч талууд, тэдгээрийн үүрэг хариуцлагыг маш тодорхой ялган зааглаж өгсөн. Өмнө нь хүлээх үүрэг хариуцлага нарийн зааглагдаагүй, гол хариуцлага үүрэгч буюу тэргүүлэн гүйцэтгэгч нь тодорхойлогдоогүйгээс салбарын яамд "манай хариуцах ажил биш" хэмээн өөр хоорондоо шилжүүлэх, эсхүл орхигдуулах явдал түгээмэл байсан.



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, чиглэл өгөх, хяналт тавих чиг үүргийг үндэсний түвшинд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хэрэгжүүлнэ. Орон нутгийн түвшинд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл дээрх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Салбар дундын зохицуулалтыг хангах бүтэц, механизм

Харин засаг захиргааны анхан шатны нэгж болох баг, хороон дээр зайлшгүй шаардлагатай үйлчилгээнүүдийг үзүүлэх үүрэг бүхий Хамтарсан баг ажиллана. Хамтарсан баг нь өрхийн эмч, сум, хороо, сургуулийн, халамжийн, хүүхэд гэр бүлийн хөгжлийн нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагч, энэ чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд тухайн сум, хорооны Засаг дарга ахална.

Мөн Нэг цэгийн үйлчилгээний төв болон Түр хамгаалах байр нь үйлчилгээний түвшинд салбар дундын зохицуулалтыг хангах механизм юм.

НОМ ЗҮЙ

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 www.hrea.org
2. Монгол улсын Үндсэн хууль, 1992 www.legalinfo.mn
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /2016/ болон холбогдох журмууд, www.legalinfo.mn
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2012, www.legalinfo.mn
5. “Амьдрах ухааны чадвар” багц гарын авлага, БСШУЯ, НҮБХАС. Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх модуль, “Хүний эрх” сэдэв, Д.Энхжаргал, 2016
6. “Хүний эрхэм чанар /Human dignity/” нийтлэл, О.Мөнхсайхан, МУИС-ийн Хуульзүйн сургуулийн дэд профессор, хуульзүйн доктор, 2015
7. Хүний эрхийн товч тайлбар, ХЭҮК, 2012
8. Жендэр ба бодлого төлөвлөлт, Жендэрийн үндэсний хороо, Ж.Занаа, О.Оюунцэцэг, Б.Онон, Т.Амгалан, 2018
9. Жендэрийн нэр томъёо, тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь, Жендэрийн Үндэсний Хороо ба ЖҮХ-ны дэргэдэх Жендэрийн консерциум, 2013
10. ХЭҮТ, Д.Энхжаргал ба бусад, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц стратеги”, 2005 он.
11. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт Монгол улс, Хүний эрхийн тайлан, ХЭҮТ, The Advocates for Human Rights 2015

II БҮЛЭГ

ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДЭД СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ

2.1 ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Хүүхэд, өсвөр үеийнхний бие болоод сэтгэл зүй нь тасралтгүй хөгжиж байдаг бөгөөд биологи, танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, нийгмийн хувьд бүрэн төлөвшөөгүй байдаг. Ийм эмзэг үедээ хүүхэд өөрөө хүчирхийлэлд өртөх эсвэл тухайн хүүхдийн гэр бүл, хүрээлэн буй орчинд хүчирхийлэл үйлдэгдэхэд тэдний бие махбод, сэтгэл санаанд өөрчлөлт ороод зогсохгүй, цаашид насан туршид нь хортой үр дагавар үүсч болдог.

Манай улс Швейцарийн хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газрын “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд анх удаа жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтыг тогтоох судалгааг 2017 онд хийсэн. Уг судалгаагаар хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл буюу 15 нас хүрээгүй арван охид тутмын нэг нь өртсөн байна. Хүчирхийлэл үйлдэгчийн 29.5% нь гэр бүлийн гишүүд, 19% нь найз нөхөд, танилууд 18.7% нь танихгүй хүн байжээ.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж нь хэн нэгэн этгээд, өөрийн хүч, эрх мэдэл, давуу талаа ашиглан хүүхдийн халдашгүй дархан байх эрх, эрх чөлөөг зөрчсөн, гэм хор учруулсан, эсвэл учруулахаар завдсан, түүнийг хамгаалах ба урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдлийг хэлдэг. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг нийгэм хүрээлэн буй орчны, хувь хүний буюу хүүхдийн, гэр бүлийн хүчин зүйлс гэж 3 бүлэгт ангилж үздэг.

Хүүхдийн хувьд нас, хүйс, тахир дутуу, хөгжлийн бэрхшээлтэй байх, оюун ухаан сэтгэхүйн хөгжил сул, анхаарал тогтворгүй байх зэрэг асуудлууд нөлөөлдөг бол гэр бүлийн зүгээс хойд эцэг, эхтэй байх, эцэг эхийнхээ нэгэнтэй нь амьдардаг, эцэг эх нь хүүхэд байхдаа хүчирхийлэлд өртсөн, гэр бүлийн тааламжгүй харилцаа, хүүхэд, эцэг эхийн харилцаа ойр дотно биш байх, эцэг эхийн анхаарал халамж сул, олон хүүхэдтэй өрх гэр бүл, өсвөр насандаа хүүхдээ төрүүлсэн ээж, хатуу чанга гарын хүмүүжил, эцэг эхийн хэн нэг нь сэтгэл гутрал буюу сэтгэцийн эмгэгтэй байх, архи мансууруулах бодис хэрэглэдэг зэрэг нь нөлөөлдөг байна. Харин нийгмийн хүчин зүйлст нийгэм эдийн засгийн сул дорой байдал, ажилгүйдэл, ядуурал, олон нийтийн тусламж дэмжлэг дутмаг, хүн амын дунд архи, тамхи, мансууруулах бодис ихээр хэрэглэх, мөн хүчирхийллийг дэмждэг ёс заншил зэрэг зүйлүүд хамрагддаг.

Хүчирхийллийн улмаас хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйл, танин мэдэхүй, нийгэмшилд нь олон сөрөг үр дагавар илэрдэг төдийгүй улс орны нийгэм эдийн засагт ч хор хохирол учруулдаг байна.

Бие махбодын талаас

Бэлгийн хүчирхийллийн улмаас охидод цус алдах, хэвлийн доогуурх архаг өвдөлт, бэлгийн замын халдварт өвчин, ДОХ, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, мэдрэл дотоод шүүрлийн үйл ажиллагаа алдагдах зэрэг өөрчлөлтүүд илэрч болдог.

Сэтгэл зүйн талаас

Хүүхэд насандаа хүчирхийлэлд өртөхөд сэтгэл зүйн талаас сэтгэл гутрах, сэтгэл түгших, архи, мансуурах бодис хэрэглэх, айх, ичих, өөрийгөө бусдаас доогуур үнэлэх, танин мэдэхүйн өөрчлөлт зэрэг шинжүүд илүүтэй тохиолддог бол сэтгэцийн эмгэгүүдээс сэтгэл зүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг, сэтгэл гутрах, сэтгэл түгших, диссоциатив эмгэг, психосоматик өвчин, нойрны болон хооллох дурын эмгэг илүүтэй тохиолддог байна.

Зан үйлийн талаас

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд зожигрох, хэт эмзэг болох, эсэргүүцэн сөргөлдөх, нийгмийн эсрэг янз бүрийн зан үйл гаргах, насанд хүрэгчидтэй адилхан дүр төрх үзүүлэх, гэрээсээ олон хоног сараар дайжих, гадуур тэнэж, дахин хүчирхийлэлд өртөж болно. Мөн архи, мансууруулах бодис хэрэглэх, этгээд бэлгийн зан үйл гаргах ба өөрөө хүчирхийлэгч болж гэмт хэрэгт холбогддог байна.

Танин мэдэхүйн болон нийгмийн талаас

Өөрийгөө үнэлэх үнэлэмж буурсантай холбоотой нийгмийн харилцаанд ороход олон бэрхшээл учирч, сурах чадвар алдагдах, сургууль хамт олон найз нөхдөөсөө хөндийрөх, сурлагандаа муудах, хичээлдээ явахгүй байх, сургууль сольж, шилжих гэх мэт олон асуудлуудтай тулгардаг. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд эцэг эх, асрамжлагчтайгаа айдастай харилцаанд орсноос бусдад итгэл алдарч, томчуудын зааж буй зүйлд сурах сонирхолгүй болдог. Тэд бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох, өөрсдийнхөө сэтгэл хөдлөлийг хянах, зохицуулах чадвар буурснаас үе тэнгийнхэнтэйгээ харилцахад олон бэрхшээл учирдаг.

Эдийн засгийн талаас

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь хүүхдийн сэтгэл санаа, зан үйл, нийгмийн асуудалд нөлөөлөөд зогсохгүй тухайн улс орны хууль зүй, эрүүл мэнд, нийгмийн халамжийн байгууллагуудад зарцуулах өртөг зардлыг нэмэгдүүлдэг байна.

Иймд нийгэм хамт олон, сургууль, гэр бүл хамтдаа хүчирхийлэлд өртсөн хүүхэд өсвөр үеийнхнийг цаашид хэвийн амьдрах, суралцах, нийгмийн харилцаанд амжилттай орох зэрэг өдөр тутмын энгийн хэмнэл рүү нь хөтөлж, сэтгэл зүйн байдал нь дахин сайжрахад бүхий л чадлаараа туслах хэрэгтэй.

2.2 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДЭД СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрт харъяалагдах эрүүл мэндийн болон бусад холбогдох байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүд доорх шаардлагыг хангасан байх хэрэгтэй.

Тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт

Хүчирхийлэлд өртсөн, тэр тусмаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэг дор төвлөрсөн байдлаар, мөн сум, аймаг, дүүрэг, хот хоорондын болон салбар дундын зохицуулалтыг цогцоор үзүүлэхээр төлөвлөж, зохион байгуулах хэрэгтэй. Мөн өөрийгөө хамгаалах чадваргүй бүлэг учраас зөвшөөрөл авахгүйгээр заавал холбогдох байгууллагад, тухайлбал хүүхэд хамгааллын мэргэжилтэнд мэдээлэх ёстой.

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь

Мэргэжлийн хувьд

- Хүний их эмч
- Сэтгэл зүйн зөвлөгөө, тусламжийн талаар зохих мэдлэгтэй
- Зонхилон тохиолдох сэтгэц, зан үйлийн эмгэгийн үеийн тусламж үзүүлэх чадвартай
- Тасралтгүй сургалтанд хамрагддаг, мэргэжил мэдлэгээ байнга дээшлүүлдэг, шаардлагатай үед бусад мэргэжилтнээс зөвлөгөө авч, тэдэнтэй мэдлэг, ур чадвараа харилцан солилцдог байх
- Удирдлага, мэргэжил нэгт нөхөд, сэтгэл засалч эмч, сэтгэл зүйч, сувилагч, нийгмийн ажилтан, цагдаа, сайн дурынхантай хамтран ажиллах, өөрийн мэдлэгээ бүрэн хуваалцах, холбогдох мэдээллийг ойлгомжтой үг, хэллэгээр илэрхийлэх чадвартай
- Орчиндоо дасан зохицох чадвартай
- Ажлаас халшрах хам шинжээс өөрийгөө хамгаалах чадвартай
- Эмпатитай хандах чадвартай
- Хүүхдийн сэтгэл хөдлөлийг мэдэрч, түүнийг зөв үнэлэх чадвартай
- Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр үеийнхэнтэй ажиллаж байсан туршлагатай бол давуу талтай
- Харилцааны ур чадвар эзэмшсэн байх
- Хүндлэг, энэрэнгүй, өрөвч, зөөлөн сэтгэлтэй байх
- Шүүмжлэлгүй хандах чадвартай байх
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэл зүйн хэрэгцээг ойлгох, түүнийг хүндэтгэх чадвартай байх

Бие, сэтгэцийн хувьд

- Бие махбодын хувьд эрүүл чийрэг
- Сэтгэл санааны хувьд тэнцвэртэй /эрүүл сэтгэцтэй/, стресст өртөөгүй байх

Ёс зүйн хувьд

- Тусламж үзүүлэх явцад хүүхэд, түүний гэр бүл, асран хамгаалагчтай хүндэтгэлтэй харилцаж, хор учруулахгүй байх
- Хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/ -өөс тусламж үйлчилгээ үзүүлэх талаар таниулсан зөвшөөрөл бичгээр авах
- Байгууллагын дотоод журам, тусламж үйлчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийг мөрдөж ажиллах
- Хүүхдийн нууцтай холбоотой аливаа мэдээллийг санамсаргүй буюу санаатайгаар хөндлөнгийн хүмүүст болон тэдний дэргэд дэлгэх, шүүмжлэн ярихгүй байх
- Мэргэжил, мэргэшсэн давуу байдлаа ашиглан эмнэлгийн, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэхээс татгалзахгүй байх
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь хүүхдийн бие махбод, сэтгэц, нийгмийн эрүүл мэндтэй холбоотой бичиг, баримтыг хуурамчаар үйлдэх, эсвэл хуурамч бичиг баримтад гарын үсэг зурах, нөхөж бичих, засварлах, устгах, хуудас солихгүй байх.
- Хүүхдийн нууцтай холбоотой бичиг баримтыг түүний зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах буюу ашиглуулахгүй байх
- Шаардлагагүй тусламж үйлчилгээг зааварчлах, үзүүлэхгүй байх
- Хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой байхад хувийн ашиг сонирхлын үүднээс өөр эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхийг албадахгүй байх
- Тусламж, үйлчилгээнээс хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/ татгалзсан тохиолдолд шийдвэрийг бичгээр авах
- Сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд өөртөө болон бусдад аюултай үйлдэл хийх бодол, төлөвлөгөөтэй байгаа тохиолдолд урьдчилан сэргийлэх үүднээс зохих албан тушаалтанд мэдэгдэх
- Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх явцад түүний хувийн орон зайг нь хүндэтгэж харилцах
- Хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгчтэй /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/ харилцах явцад ёс зүйн зөрчил үүсэх эрсдэл тулгарвал тусламж, үйлчилгээ үзүүлэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд татгалзах болсон үндэслэлээ хүүхэд, түүний хууль ёсны төлөөлөгч, өөрийн байгууллагын удирдлагад бичгээр мэдэгдэх бөгөөд дараагийн эмнэлгийн мэргэжилтэн тусламж үйлчилгээг бүрэн

хариуцан авах хүртэл үүрэгт ажлаа үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

- Сэтгэл зүйн тусламж үзүүлж буй эмнэлгийн мэргэжилтэн өөрийн сэтгэл хөдлөлийн асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд хүүхэдтэй харилцахыг хориглоно.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлж байхдаа хүүхдийг өвтгөж, эмзэглүүлэх үйлдэл гаргахгүй, мөн зохисгүй үгээр таагүй сэтгэгдэл төрүүлж болохгүй.
- Шүүхийн баримт нотолгоог хамгаалалт сайтай газар шилжүүлэн хадгалах.
- Хүчирхийлэлд өртсөн болон хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхдийн талаарх мэдээллийг цагдаагийн албан хаагч, хамтарсан баг, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагад өгнө
- Хүчирхийлэлд өртсөн болон хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа талаар хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн гишүүдэд тайлбарлан таниулна.
- Хүүхдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг стандарт, зааврын дагуу үзүүлэн баримтжуулна.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд яаралтай болон бусад эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлсний дараа тусгай хамгаалалтаар хангах эрх бүхий байгууллагын албан хаагчид дахин мэдэгдэж, хүлээлгэн өгнө.

Бусад

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн тухайн орон нутгийн ёс заншил, хэл соёлын талаар ойлголттой байж, хүүхдийн сэтгэл зүйн онцлог, шашин шүтлэгийг нь хүндэтгэн, анхаарал болгоомжтой хандана.

Хүүхэд сэтгэл зүйн сорил бөглөх боломжгүй эсвэл сорилын хариугаар анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх боломжгүй бол эмч, эмнэлгийн мэргэжилтэн үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн тусламж руу шилжүүлнэ.

Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх өрөө

Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх өрөө нь аюулгүй, гадны дуу чимээнээс бүрэн тусгаарлагдсан, өрөөний гэрэлтүүлэг хэт тод биш, хувийн орон зайнд халдахааргүй, таатай сэтгэгдэл төрүүлэхүйц, нас, сэтгэхүйн онцлогт нь тохирсон байна.



Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх өрөөний загвар

Сэтгэл зүйн тусламж үйлчилгээг ямар хугацаанд үзүүлэх вэ?

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ хоногийн 24 цаг, 7 хоногийн бүх өдөр боломжтой байхаар зохицуулж, нэг удаагийн уулзалтыг 30-60 минут, шаардлагатай тохиолдолд 90 минут хүртэл хугацаанд үргэлжлүүлэх хэрэгтэй.

Сэтгэл зүйн тусламж үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний хувцаслалт

- Зөв, цэвэр хувцаслах
- Ажлын үнэмлэх, энгэрийн тэмдэг зүүх
- Хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч буй тохиолдолд хүүхдийн нас сэтгэхүйн онцлогоос шалтгаалан эмчийн дүрэмт хувцсыг өөрөөр, энгийнээр орлуулж болно.

Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх үед хэрэглэхээс зайлсхийх үг хэллэгүүд

- Чи ингэж бодож болохгүй.
- Надад итгээрэй, би яг одоо чиний юу мэдэрч байгааг мэдэж байна.
- Өдий зэрэгтэй байгаа нь азтай шүү.
- Бүх юм сайхан болно.
- Азаар бүх зүйл сүйрчихээгүй байна.
- Амьдрах сайхан.
- Бид бүгдээрээ үүнийг даваад гарна.
- Цаг хугацаа бүхнийг илааршуулна.
- Өөр сэдвээр ярилцацгаая.

Хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэгч эмч, эмнэлгийн мэргэжилтэн өөрийгөө хамгаалах

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх явцдаа хүчирхийллийн гэрч болох, тухайн үйл явдлаас хүчтэй цочрол авч, сэтгэл зүйн дарамтанд орсны улмаас цаашид тусламж үйлчилгээг үзүүлэх боломжгүй нөхцөл үүсч болдог. Үүний хожмын үр

дагавар нь эмч, эмнэлгийн мэргэжилтний сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, ажлаа орхих, таагүй мэдрэмж, сэтгэлийн түгшүүр насан туршид нь үргэлжилж ч болзошгүй. Иймд эрүүл мэндийн байгууллага тухайн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллахаас өмнө болон дараа сэтгэл зүйн байдлыг нь тодорхойлж, хүчирхийлэл хүний оюун санаанд яаж нөлөөлдөг болох сэтгэлзүйгээ хэрхэн хамгаалах талаар сургалтанд хамруулах хэрэгтэй. Хэрвээ сэтгэл зүйн үнэлгээгээр цаашид хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй үргэлжлүүлэн ажиллах боломжгүй нөхцөл үүссэн бол ажлыг нь зогсоох хүртэл арга хэмжээ авна.

2.3 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙ

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр үеийнхэнтэй харилцахад юуны өмнө тэдний дотоод сэтгэл юу мэдэрч байгааг мэдрэх нь чухал бөгөөд тэдэнд өөрийнх нь аюулгүй байдлыг хангасан тодорхой орон зай шаардагддаг. Хүүхэд хүчирхийллийн үйл явдлыг эргэн санах, таагүй дурсамжтай төстэй үйл явдал тохиолдоход сэтгэл нь түгшиж, айдаст автах ба өөрийн сэтгэл зүйг хамгаалахын тулд хэт их идэх, компьютер тоглох, зурагт үзэх, архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх зэрэг сөрөг үйлдлүүдийг хийдэг. Эдгээр үйлдлүүд нь тэр таагүй дурсамжийг санахгүй гэж хичээх, уурлаж, үзэн ядсан мэдрэмжээ гаргахгүй тэвчих үед улам ихээр хийгддэг. Хүчирхийлэлд өртсөн хүүхэд бүхэн сэтгэл зүйн гэмтэлтэй болдоггүй бөгөөд тухайн үйл явдалд дасан зохицож чадаагүй тохиолдолд гэмтэл үүсч цаашилбал сэтгэцийн эмгэгтэй болдог. Сэтгэл зүйн гэмтэл үүсэхэд дараах хүчин зүйлс нөлөөлдөг.

- Биологийн онцлог байдал
- Нийгмийн дарамт шахалт
- Хүүхдийн сэтгэл зүйн онцлог байдал
- Хүүхдийн зан төлөвийн онцлог
- Хүүхдийн нас
- Хэн хор хохирол учруулж байгаагаас
- Гэмтээгч үйл явдлын хүч гэх мэт.

Хүүхэд эцэг эхийн зүгээс үл хайхрах болон бусад хэлбэрийн хүчирхийлэлд хэрхэн өртдөг болохыг илрүүлэх зорилгоор бага насны хүүхдүүдийг танихгүй хүнтэй хамт нэг өрөөнд байлгажээ. Хэсэг хугацаанд хүүхдүүд нөгөө хүнтэй хэрхэн харьцаж, ямар зан үйл гаргахыг ажиглахад нэг их онцын үйлдэл үзүүлэхгүй тоглоомоо үргэжлүүлэн тоглосоор байв. Дараа нь нөгөө хүнийг гаргаад ээжийг нь өрөөнд оруулахад Эхний хүүхэд ээж рүүгээ гүйн очиж тэвэрснээ буцаж тоглоомоо үргэжлүүлэн тоглож байв. Энэ нь ээждээ итгэдэг бөгөөд аюулгүй байдалд байдгийн илрэл юм.

- Зарим хүүхэд ээжийгээ орж ирэхийг огт тоохгүй байв. Ээж нь хүүхдээ хэт халамжилж, бүх зүйлд нь санаа тавьж байнга дагадаг тул хүүхэд хэсэгхэн хугацаанд өөрийнхөөрөө байж, түүнийгээ хадгалахыг хүсч байгаа байдал.
- Ээжийгээ орж ирэнгүүт хүүхэд нэг хэсэг уйлав. Ээж нь хүүхдээ тэр бүр хайхардаггүй бөгөөд хүүхэд ээжийнхээ анхаарлыг татах зорилгоор ямар нэг үйлдэл хийхийг хүсэж байна.
- Үлдсэн хүүхдүүд ээж рүүгээ гүйснээ зогтусаад уйлж байв. Энэ нь хүүхэд хүчирхийлэлд өртдөгийн илрэл байлаа.

1 ой 6 сар хүртэл хүүхэд эхийнхээ хайр халамжид байх ба эх нь түүнийг хэрхэн асарч, халамжилж байгаагаас хамаарч орчноо мэдрэх мэдрэмж бүрэлдэн тогтодог болохыг судлаачид илрүүлжээ. Хүүхэд өөр өөрийгөө тайвшруулж чадахгүй учраас ээж нь түүнийг тайвшруулах ёстой. Энэ хугацаанд хайр энэрэлээр дутаагүй, аюулгүйн хэрэгцээ нь сайн хангагдсан хүүхэд аажимдаа ээжээсээ холдож эхэлдэг. Мөн хүүхдэд таагүй зүйл тохиолдоод уйлахад ээж нь түүнийг аргадаж, тайвшруулснаар хожим хүүхэд сэтгэл хөдлөлөө эерэгээр илэрхийлж, хүн уйлж болдог юм байна гэсэн ойлголтыг эндээс суралцдаг. Харин ээж нь хайхардаггүй, тоодоггүй, тайвшруулдаггүй бол сэтгэл хөдлөлөө хянаж чадахгүй, байнга ээжийгээ хайж, түүнээс салахаас айдаг байна.

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд өөрийн дотоод мөн чанарт анхаарал тавихаа больж, бусад хүмүүс, эргэн тойрныхондоо түлхүү анхаардаг. Жишээлбэл, архины асуудалтай гэр бүлд өсөж байгаа хүүхдэд өөрийн бодол байдаггүй ба бусдад өөрийн үнэ цэнийг харуулахын тулд онц сурдаг ч өөрийн гэсэн бодолгүй байх нь бий.

Охидууд хөвгүүдийг бодвол илүү эмгэг хариу үйлдэл хийдэг бол бол хөвгүүд түрэмгий авирладаг. Охид найз нөхөд, гэр бүл, ангийн хамт олноос тусдаа салангид, ганцаардмал байх юм уу эсрэгээр тэднээс тусдаа байх үедээ айж, түгших хандлагатай болдог.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд илрэх түгээмэл шинжүүд

- Насандаа зохицохгүй зан ааш гаргах
- Хуруугаа хөхөх зэрэг хөгжил ухрах шинжүүд илрэх
- Ээрэх, оройтож хэлд орох, хэл ярианы хөгжил муудах
- Орондоо шээх эсвэл баах
- Тайван бус байх
- Сэтгэл түгших
- Өөрийгөө буруутгах
- Горьдлого тасрах
- Маш их айх
- Анхаарал төвлөрөхгүй байх
- Байнга хөдөлгөөнтэй байх
- Бусадтай муудалцах, түрэмгий, дээрэлхүү хандах

- Үе тэнгийн хүүхдүүдтэй харьцуулахад сурлагаар хоцрох
- Гэрээсээ зугатаах, юм хулгайлах
- Зожиг, бусад хүүхэдтэй хамт тоглодоггүй, харилцдаггүй байх
- Худлаа ярих, хулгай хийх
- Сургууль хамт олны үйл ажиллагаанд идэвхигүй байх
- Аливаад хүйтэн хөндий хандах, уйтгартай байх
- Бусдад итгэлгүй болох
- Амьдралын сайн сайхан зүйлээс таашаал авахад хэцүү санагдах
- Өмнөхөөсөө илүү насанд хүрэгчидтэй дотносох
- Амиа егүүтгэх оролдлого хийх
- Тодорхой шалтгаангүйгээр өөрийнхөө гэр бүл дэх насанд хүрэгчдээс айх

Согтууруулах болон мансууруулах бодис хэрэглэх гэх мэт Мөн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд дараах сэтгэцийн өвөрмөц шинжүүд илэрч болдог. Үүнд:

- Нэрээр нь дуудах, ямар нэгэн юм хий /хувцасаа тайл, эд зүйлээ хая/ гэсэн захиран тушаах хэлбэрийн хий зүйл сонсогдох
- Ямар нэгэн үндэслэлгүйгээр эргэн тойронд байгаа хүмүүс өөрийг нь дээрэмдэх, амь насыг нь хохироох гэж байна гэсэн итгэл үнэмшилд автан, айдастай байх
- Эргэн тойронд болж буй үйл явдал тодорхойгүй, бодит биш, зүүд юм шиг, эсвэл өөрийн мэдэлгүй аймшигтай газар луу явж буй мэт мэдрэмж төрөх
- Хүчирхийлэлтэй холбоотой ямар нэгэн мэдээ, мэдээлэл сонсоход гашуудах, нулимс мэлмэрүүлэх, тайван бус болох гэх мэт.

Эдгээр шинжүүд тухайн үйл явдал болж өнгөрснөөс хойш 48-72 цагийн дараа багасч, 30 хоногийн дараа намждаг.

Дээрх асуудлыг зөв зохистой шийдвэрлэж чадахгүй бол хичээл сурлагандаа муудах, сургууль завсардах, эрт жирэмслэх, архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх, гэмт хэрэгт холбогдох цаашилбал нийгмээс гадуурхагдаж, ажилгүй, гэр оронгүй юмуу нийгэмд дасан зохицох чадваргүй хүн болж хувирдаг.

Мөн сэтгэл зүйн гэмтэл авсан хүүхдүүд аливаа зүйлийг ялангуяа хэн нэгний тавьсан шаардлага, хүсэлт, сургамж, шүүмжлэлийг бодит байдлаас нь хэтрүүлэн томруулдаг шилээр харж буй мэтээр үнэлэх, буруугаар ойлгох, хүлээн авах хандлагатай байдаг тул ийм хүүхдүүдтэй ажиллахад маш их тэвчээр шаардагддаг. Хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өөрийн бодол санаа, үзэл бодол, сэтгэлгээг өөрчилж, тэвчээртэй, хүнлэг хандах хэрэгтэй. Мөн эмч өөрийн бодол санаа, шийдвэрээ хүүхдэд шууд тулгаж болохгүй бөгөөд ийм тохиолдол илрэхэд хүүхэд өөрийгөө хамгаалах сэтгэл зүйн байдалд орж, мэдрэмж, сэтгэл хөдлөлөө чөлөөтэй нээж чаддаггүй.

2.4 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН БАЙДАЛД ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Яагаад үнэлгээ хийдэг вэ?

Амьдрал дээр хүчирхийллийн тохиолдол, тухайн нөхцөл байдал, хохирогч буюу хүүхдийн сэтгэл зүйн хариу урвалууд өөр өөр байдаг. Ноцтой хор хохирол тохиолдсоны хирээр стрессийн хариу урвалууд хүчтэй байна. Хүчирхийллээс шалтгаалсан хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэл зүйн хариу урвалыг цаг тухайд нь зөв үнэлснээр үзүүлэх тусламж үйлчилгээ төдий чинээ үр дүнтэй, цаашид сэтгэл зүйн байдал, дасан зохицол нь хэвийн болоход сайнаар нөлөөлдөг.


Хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй хир сайн харилцаа тогтоож чадна тэр нь цаашаа сэтгэл зүйн тусламж амжилттай явагдахын үндэс болдог бөгөөд сэтгэл зүйн байдалд үнэлгээ хийхээр анх удаа уулзаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн тэрхүү суурийг тавьдаг билээ.

Үнэлгээ хийх алхмууд

Тухайн нөхцөл байдалтай уялдуулан үнэлгээ хийх дэс дараалал бий. Хүүхдэд сэтгэл зүйн үнэлгээ хийхийн тулд өмнө нь олон удаа туршсан, бодит байдалд тулгуурласан, үнэн зөв илрүүлэгтэй үнэлгээний хурдавчилсан асуумжуудыг өргөнөөр хэрэглэдэг. Үүнийг бид хавсралт хэсэгт багтаасан бөгөөд үнэлгээг хийхээс өмнө дадлагажих хэрэгтэй.

Шаардлагатай үед **MINI**-Mini International Neuropsychiatric Interview-энэхүү оношлогооны асуумжийг зөвхөн сэтгэцийн эмч хөтөлнө.

Үнэлгээ хийх алхмууд



Үнэлгээ хийхэд анхаарах зүйлс

Үнэлгээний өмнө

- Үзэг, бал, тэмдэглэлийн дэвтэр, цаас, хэвлэж бэлдсэн асуумжууд, эрүүл мэндийн боловсролын болон сурталчилгааны материалууд, ус, амны цаас зэргийг бэлдэх ба эмч, эмнэлгийн мэргэжилтэн зохистой хувцаслаж, ажлын үнэмлэх, энгэрийн тэмдэгээ зүүнэ. Хүүхдийн нууцыг хадгалах үүднээс тусдаа чимээгүй өрөөнд үнэлгээг хийнэ
- Өөрийгөө танилцуулна. Жишээ нь: “Сайн уу, би эмнэлгийн эмч, байна. Би чамд болон танай гэр бүлд бага ч болов тусалж чадах болов уу гэж найдаж байна.
- Үнэлгээг танилцуулж, үнэлгээний зорилгоо хэлээд чиний нууцыг чандлан хадгална гэдгээ ойлгуулах ба эцэг эх асран хамгаалагчаас таниулсан зөвшөөрлийг авсны дараа үнэлгээг хийж эхэлнэ. Хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагч, багшийг хамт байлгаж ч болдог.
- Үнэлгээ хийх явцад хүүхэд эргэлзэж, асуулт асуувал түүнийг нь тодруулан хэлж өгөх хэрэгтэй.
- Хэлний бэрхшээл, нутгийн аялга ойлгомжгүй үед туслалцаа авч болно.
- Үнэлгээ хийх үед аюулгүй байдлыг ханган, хурц үзүүртэй эд зүйлсийг далд хийж, урьдчилан сэргийлэх хэрэгтэй.

Үнэлгээ хийх үйл явц

- Хүүхэдтэй үнэлгээ хийх үеэс эхлэн аюулгүй, итгэлтэй харилцааг бий болгох хэрэгтэй. Үнэлгээний явцад хүүхдийн эмзэг асуудлыг хөндөж болзошгүй тул эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд зөв асуулт, зөв үг хэллэг сонгож ярилцах нь чухал.
- Үндсэн мэдээллийг цуглуулснаар хүүхдийн ерөнхий сэтгэл зүйн байдлыг таньж, шаардлагатай тусламж дэмжлэгийг үзүүлнэ. Асуумж авч байхдаа зарим эргэж санах, цээжлэх зүйлийг товчхон тэмдэглэж аваад асуумжаа дараа нь бөглөж болно.
- Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан ойлгомжтой, энгийн үг хэллэгийг сонгон ярилцах бөгөөд эмч биеэ зүй зохистойгоор авч явах хэрэгтэй. Хүүхэдтэй ижил түвшинд, шаардлагатай үед өвдгөн дээрээ ч сууж болдог. Асуумжийг гартаа бариад унших байдлаар биш, энгийнээр ярилцаж асуух нь зүйтэй. Ярьж, хэлэх үгийн агуулга хэт урт бол таниулсан зөвшөөрөл авсны дараа бичлэг, тэмдэглэл хийж болно. Жишээлбэл: Хэрвээ чамайг зөвшөөрвөл, зарим зүйлийг илүү сайн ойлгож, эргэж санахын тулд тэмдэглэл хөтлөх гэсэн юм гэх мэт.
- Сэтгэл зүйн гэмтэл үүсгэсэн таагүй дурсамжийг хэт нарийвчлан асуух хэрэггүй. Гол ярилцлагын агуулга нь хүүхдэд ямар боломж байгааг олж илрүүлэх, байдал сайжирна гэсэн итгэл үнэмшил бий болгоход чиглэгдэнэ.
- Хүүхдэд илрэх сэтгэл зүйн хариу урвал нь тодорхой байвал үнэлгээгээ зогсоон, зохих тусламжийг үзүүлэх хэрэгтэй.

- Үнэлгээ хийх явцад сэтгэл санааны хямрал хүчтэй илэрвэл үнэлгээг зогсоон зохих арга хэмжээг авах нь зүйтэй.
- Хүчирхийллийн дараа хүүхэд, эцэг эх, ойр дотны хүмүүс ердийнхөөс илүүтэй бухимдах, уурлах, буруутай мэт мэдрэмжтэй байх нь түгээмэл учраас тэдэнд мэдээллийг хэт их тайлбарлаж зөвлөгөө өгсөнөөс илүүтэйгээр сайн сонсох хэрэгтэй.
- Хүүхдийн үнэлгээ голдуу насанд хүрэгчдийн мэдээлэл дээр тулгуурладаг. Гэтэл насанд хүрэгчид хүүхдийн сэтгэл зүйн байдлыг анзаарахгүй, дутуу юмуу буруу үнэлж болзошгүйг анхаарах нь чухал.
- Хүүхдийн гол асран хамгаалагч болох эцэг эх, ялангуяа ээжийн өгүүлэмж маш чухал бөгөөд үнэлгээ, дүгнэлт хийхэд гол нотолгоо болдог. Мөн тухайн хүүхдийн талаар үнэлгээнд оролцож буй насанд хүрэгч нь өөрөө сэтгэцийн хувьд эрүүл гэдгийг магадласан байх ёстой.
- Хүүхдийн үнэлгээнд нийгмийн харилцаа болон зан үйлийн асуултуудыг заавал тусгах хэрэгтэй. Зарим тохиолдолд хамаатан, хөрш, ангийн багш, нийгмийн ажилтан болон баг хороон даргаас үнэлгээний нэмэлт мэдээлэл асууж тодруулах нь зүйтэй.
- Хэвийн биш хариу урвал илэрвэл асран хамгаалагч нь тэр даруй эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэдээлэх бөгөөд цаашид хүүхдийн сэтгэцийн эмч гардан ажиллах нь тохиромжтой. Иймд болзошгүй сэжигтэй тохиолдлыг сайн анхааран хянаж, үнэлэх нь маш чухал билээ.
- Үнэлгээ хийлгэхээс татгалзаж буй тохиолдолд эрүүл мэндийн боловсролтой холбоотой материалыг өгч, шаардлагатай үед хэрхэн эргэж холбогдох талаар зөвлөгөө өгөх ба өөр туслалцаа хэрэгтэй эсэхийг тодруулна.

Үнэлгээний төгсгөлд

Ярилцлага, үнэлгээний төгсгөлд талархал илэрхийлэн, эрүүл мэндийн боловсролтой холбоотой материал өгч, өөр нэмэлт мэдээлэл, туслалцаа хэрэгтэй эсэхийг тодруулна. Тухайн хүүхдэд анхаарал халамж, сэтгэл зүйн болон бусад дэмжлэг туслалцаа хэрэгтэй гэдгийг гэр бүлийнхэн, дүүрэг, хорооны нийгмийн ажилтан зэрэг хүмүүст нь мэдэгдэнэ. Мөн туслалцаа хэрэгтэй үед холбогдох тусламж үзүүлэх байгууллагын байрлал, утасны дугаар, сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг утасны дугаар гэх мэт газруудыг хэлж өгөх хэрэгтэй.

Үнэлгээ хийх үндсэн аргууд

- Хүүхэдтэй ярилцах, тоглох, ажиглах, эцэг эх асран хамгаалагчаас мэдээлэл авах гэх мэт хүүхэд, өсвөр үеийнхнийг үнэлэх аргууд байхаас гадна өөрөөс нь асуумж авч /II бүлгийн хавсралтаас харна уу/ оноогоор үнэлж болно.
- 0–6 насны хүүхэд төдийлөн өөрийгөө зөвөөр илэрхийлэн ярихгүй учраас тоглох, зураг зуруулах, үлгэр ярилцах гэх мэт аргаар үнэлдэг.

- 6–12 насны хүүхдийг сэтгэц, танин мэдэхүйн хөгжлөөс нь хамаарч тоглох, зуруулах, үлгэр яриулах юм уу шууд өөртэй нь ярилцлага хийж, үнэлгээний асуумжаар /II бүлгийн хавсралтаас харна уу/ үнэлж болно
- 12–18 насны өсвөр үеийнхнийг асуумжаар /II бүлгийн хавсралтаас харна уу/ үнэлгээ хийхийн зэрэгцээ бүлгийн сэтгэл зүйн ярилцлага хийж болно
- Зан төлөвийн байдлыг нь эцэг эх, асран хамгаалагч, багш нараас нь тодруулж, асуумж авч болно.
- Илэрхий сэтгэл зүйн гэмтэлтэй боловч мэдрэмжээ илэрхийлэхийг хүсэхгүй байгаа хүүхдэд тоглоом хамтдаа тоглох, үлгэр яриулах зэрэг аргыг ашиглан үнэлгээ хийнэ.
- Бүлгээр ярилцах, бүлгээр тоглох аргаар хүүхдийн хэвийн биш, хэт цочролын хариу урвалуудыг илрүүлэн цаашдын үнэлгээ, оношлогоонд тусгана.
- Хүчирхийллийн улмаас үүссэн айдсаа илэрхийлж чадахгүй байгаа хүүхдэд айдас болон бусад мэдрэмжүүд үүсэх нь хэвийн гэдгийг ойлгоход нь аль болох хялбараар тусалж, чиглүүлж, үнэлгээг хийнэ.

Бусад:

- Энэхүү гарын авлагыг зөвхөн хүчирхийлэлд өртсөний дараа ашиглах бөгөөд цаашид эрдэм шинжилгээ, судалгааны ажилд ашиглах бол ёс зүйн зөвшөөрөл авна.
- Бүх үнэлгээ, гарын авлага нь бодит амьдрал дээр тулгуурласан бөгөөд, үүнийг хэрэгжүүлэх, хэрэглэх эмч, эмнэлгийн мэргэжилтэн өмнө нь сургалтад хамрагдсан байх шаардлагатай.

2.5 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨНИЙ УЛМААС ХҮҮХДЭД ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ СЭТГЭЦИЙН ЭМГЭГҮҮД

Хүүхэд насандаа хүчирхийлэлд өртсөн тохиолдолд эрүүл мэндийн олон асуудал цаашид тулгардаг байна. Тухайлбал, зүрх судас, уушиг, хоол боловсруулах замын архаг өвчнүүд үүсэх нь элбэг байдаг. Үүнийг судлаачид хүчирхийлэлд өртсөний улмаас сэтгэл санаа тогтворгүй болж, сэтгэл түгших, сэтгэл гутрах зэрэг сэтгэцийн байдлаас үүдэн мэдрэл шингэний тохируулга алдагдаж, улмаар дааврын болон дархлаа тогтолцооны тэнцвэр өөрчлөгдсөнтэй холбон тайлбарладаг. Мөн сэтгэцийн дараах эмгэгүүд түгээмэл тохиолддог билээ.

Хүүхдийн сэтгэл түгших эмгэг

Айдас хүрмээр юм уу амь насанд заналхийлсэн нөхцөл байдал тохиолдоход бие махбод, сэтгэл зүйн талаас салганаж чичрэх, зүрх дэлсэх, хөлрөх, айх, сандрах зэрэг шинжүүд илэрдэг. Энэ бол стресст үзүүлж буй сэтгэл

түгшилтийн хэвийн хариу урвал юм. Харин сэтгэл түгших эмгэгийн үед айж түгших тодорхой шалтгаан байхгүй үед тухайн нөхцөл байдалтай тохироогүй хэт их санаа зовиол, айдас, сэтгэл түгшилт илэрч, энэхүү байдал харьцангуй тогтвортой удаан хугацаагаар үргэлжилж, өдөр тутмын үйл ажиллагаанд бэрхшээл тулгарч, үүнээсээ болоод зайлсхийх, зугатаах зан үйл ихэнхдээ гаргадаг.

Хүүхдэд сэтгэл түгших эмгэгийн дараах хэлбэрүүд элбэг тохиолддог. Үүнд:

- Сандрах эмгэг
- Талбайн айдас
- Өвөрмөц айдсууд-амьтнаас айх айдас /6-7 нас/
- Нийгмийн айдас /11-13 нас/
- Улигт бодол албадмал үйлдлийн эмгэг
- Сэтгэл зүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг
- Стресст өгөх цочмог хариу урвал /13-15 нас/
- Салан хагацахаас айх айдас

Талбайн айдас

Талбайн айдас гэдэг нь айдас хүрмээргүй орон зай, талбай, гудамж, олон хүн цугласан газар, ганцаараа байхад өөрийн эрхгүй айдас төрж, вегетатив мэдрэлийн хөөрөлд орохыг хэлдэг. Тухайлбал, хүчирхийлэлд өртсөн газар, дэлгүүрээр ганцаар явах, автобус, галт тэрэг, онгоц, машинаар ганцаар аялах, гэрээс гадагш ганцаар гарахад айдас хүрч зүрх хүчтэй цохилж, амьсгал бачуурч, бөөлжис цутгах, шээс түргэн хүрч, муужирч унах буюу хөлрөх шинжүүд илэрдэг.

Нийгмийн айдас

Нийгмийн айдас гэдэг нь гэр бүлийнхээ гишүүдээс бусад хүмүүстэй, нийгмийн тодорхой нөхцөл байдалд уулзах буюу харилцах үед тухайлбал олны өмнө үг хэлэх, бусдын өмнө ярих, асуулт асуух, идэх, эсрэг хүйсний хүнтэй уулзах, анхаарлын төвд байх, олон нийтийн арга хэмжээнд оролцох үед айж ичих мэдрэмж төрж, зүрх дэлсэж, нүүр улайж, бие салганан чичирч, амьсгаадах зэрэг шинж тэмдэг илэрнэ.

Өвөрмөц айдас

Өвөрмөц айдас гэдэг нь нийгэм, талбай, өвчнөөс айх айдсаас бусад айдсуудыг хэлдэг. Тодорхой амьтанд дөхөн очих, өндөр газар байх, тэнгэр дуугарах, харанхуйд байх, онгоцоор нисэх, битүү орон зай, нийтийн бие засах газар орох, тодорхой хоол идэх, шүдээ эмчлүүлэхээс, цус болон гэмтлийг харах зэрэг маш өвөрмөц нөхцөл байдлуудаас айх айдсууд багтдаг.

Сандрах дайралт

Сандрах дайралт нь гэнэт, хүчтэй айдас, сэтгэл түгшилтийн байдалд ордог. Үхчих вий, галзуурчих вий, хяналтаа алдах вий гэж айснаас цээж бачуурч, хөндүүрлэх, амьсгал давчдах, бүгчимдэх, зүрх дэлсэх, дагжин чичрэх, гар хөл бадайрч чимчигнэх, дотор харанхуйлах, хөлрөх, нүүр

халах, улайх, дотор муухайрах, толгой эргэх зэрэг симпатик хөөрлийн шинжүүд тод ажиглагдана. Сандрах дайралт нь тухайн хүүхдийн эргэн тойронд болж буй үйл явдлаас шалтгаалдаггүй, хэсэг хугацааны дараа хэвийн байдалдаа эргэн ордог.

Улигт бодол, албадмал үйлдлийн эмгэг

Ямар нэгэн бодол, дурсамж хар аяндаа үүсч, сэтгэлийг маш хүчтэй түгшээж, энэ бодлоосоо салж, сэтгэл түгшилтээ намжаахын тулд дараах албадмал үйлдлүүдийг хийдэг. Гараа угаах, мөргөл үйлдэх, тоо тоолох, хуруугаа хөхөх, хумсаа мэрэх, нүдээ цавчлах, хий хоосон ханиах, нусаа татах, юм тогших гэх мэт үйлдлийг өөрийн эрхгүйгээр байн байн давтан үйлдэхэд бие сэтгэл тайвширдаг ба утгагүй үйлдэл хийж байна гэдгээ шүүмжлэн, түүнээс салах идэвхитэй тэмцэл хийх тусам сэтгэл улам түгшдэг.

Салан хагацахаас айх айдас

Эцэг эх, гэр бүлийн гишүүдээс хол байх, ганцаараа байх үед айдас төрж, симпатик мэдрэлийн хөөрлийн шинж тод илэрдэг. Энэ үед хүүхэд ганцаараа унтаж чадахгүй, гэртээ үлдэх, гадагшаа ганцаараа гарахаас айна. Салан хагацах тухай аймшигтай зүүд зүүдлэнэ. Эцэг эхээсээ холдох үед шууд толгой өвдөх, гэдэс базлах, огиулах, бөөлжих, уйлах, сэтгэл санаа тавгүй болох, сэтгэл зовинох, ганцаардах зэрэг шинжүүд илэрнэ. Айснаас болоод сургууль, цэцэрлэгтээ явахгүй.

Сэтгэл түгших эмгэг илэрсэн хүүхэд, эцэг эхэд өгөх мэдээлэл, зөвлөгөө

Сэтгэл түгшилтийн үед илэрдэг шинж тэмдэгүүд түр зуурын бөгөөд айдас сандралтай холбоотой үүсдэг гэдгийг эцэг эхэд ойлгуулах.

Хүүхэдтэйгээ түүний мэдрэмжийн талаар ярилцаж, хамгийн их санааг нь зовоож байгаа зүйлийн талаар энгийнээр, шулуухан асуухыг оролдоорой. Илэн далангүй, тодорхой байх нь хүүхдийнхээ айдас болон мэдрэмжийг мэдэхэд туслах ба ярилцаж байх үедээ түүнд итгэдэг, түүний буруу бодол болон айдсын мэдрэмжүүдийг чин сэтгэлээсээ ойлгож байгаагаа харуулах хэрэгтэй. Та тайван байснаар хүүхэд тань тайван байж чаддаг.

- “Битгий санаа зов, тайвшир” гэх мэт үгсийг хэрэглэснээр хүүхэд тайвширдаггүй болохыг анхаараарай.
- Хүүхэд хүчтэй цочролд ороход гүнзгий, хурдан амьсгалснаар цусанд хүчил, нүүрсхүчлийн хэмжээ буурч, бие махбод, тархинд хүчилтөрөгчийн хэмжээ багассанаар сэтгэл түгшилтийн шинжүүдийг үүсгэдэг.

Эдгээр шинжүүдэд толгой эргэх, амьсгал давчдах, сэтгэл цочирдоноос үүсэх сөрөг мэдрэмж, зүрх хүчтэй цохилох, салгалж чичрэх гэх мэт шинжүүд дахиад л үүснэ. Ийм учраас хүчтэй стресст өртсөн хүүхдийг “Цаасан уут” руу амьсгалуулж нүүрсхүчлийн хийн хэмжээг цусанд буцааж ихэсгэснээр хэт амьсгалах шинжийг бууруулдаг юм.



*Хэт амьсгалах шинжийн үед
авах арга хэмжээ*

Хүчтэй стресс буюу хүчирхийлэлд өртсний дараах сэтгэл зүйн хариу урвалуудыг дараах эмнэлзүйн хэлбэрүүдэд хуваан авч үздэг бөгөөд доорх эмгэгүүдийг III бүлгээс судлаарай.

Үүнд:

F43.0-Стресст үзүүлэх цочмог хариу урвал

F43.2-Дасан зохицохын эмгэг

F43.7-Хүчтэй стресст үзүүлэх бусад хариу урвал

F43.8-Хүчтэй стресст үзүүлэх хариу урвал тодорхойгүй

Сэтгэл зүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг

Хүчирхийлэлд өртсний дараа цочмог хариу урвал хэдэн цагаас хэдэн өдөр үргэлжлээд алга болдог бол зарим хүүхдэд дараах шинж тэмдэг хэдэн сар жилээр үргэлжилдэг.

Гэмтлийн дараах стрессийн эмгэг нь хүчирхийлэл, аюул занал, айлган сүрдүүлэхийг тухайн цаг мөчид нүдээрээ харж, сэтгэлээрээ мэдэрч, биеэрээ туулж өнгөрөөсөн хүүхдүүдэд үүсдэг. Энэ нь гэмтлийн дараах хожим өгөх сэтгэл зүйн хариу урвал бөгөөд аймшигтай үйл явдлын тухай дурсамжууд, таагүй үзэгдлүүд гэнэт нүдэнд харагдах, шөнө нь хар дарж зүүдлэх зэргээр хар аяндаа, дахин дахин орж ирэн, тэдний сэтгэлийг зовоон, тарчлаах шинжээр илэрдэг эмгэг юм.

Илрэх шинж тэмдэг

Хүчирхийлэлд өртсний дараа 6 сарын дотор доорх 3 бүлэг шинж тэмдгүүд илэрдэг.

1. Сэтгэл зүйн гэмтэл дахин мэдрэгдэх шинж

Хүчтэй стресст өртөх үед сонссон харсан, үнэртсэн, мэдэрсэн аймшигтай, тааламжгүй сэтгэгдэл төрүүлсэн тийм зүйлсийн тухай таагүй дурсамж, таагүй үзэгдэл, хар дарсан зүүд өөрийн эрхгүй, хар аяндаа байн байн үүсэж, нүдэнд гэнэт харагдах, шөнө нь хар дарж зүүдлэх маягаар сэтгэлийг зовоон, тарчлаах шинжээр илэрнэ.

2. Зайлсхийж, зугатаах шинж

Сэтгэл зүйн гэмтлийг сануулагч зүйлсээс эсвэл түүнтэй холбоотой бүхий л зүйлээс зайлсхийнэ. Тухайлбал хүн, газар орчин, тэр тухай ярилцлага хийх, хоол хүнс, хувцас, цаг агаарын байдал, ямар нэгэн үйл ажиллагаа, нөхцлүүд, бодол санаа, мэдрэмжүүд гэх мэт. Түүнчлэн урьд өмнө нь сэтгэлийн таашаал авч байсан зүйлээсээ одоо сэтгэлийн таашаал авахаа

болин, ямар нэгэн зүйлд идэвх сонирхолгүй болж, сэтгэлийн хөдөлгөөнгүй болсон мэт санагдана.

3.Хэт цочромтгой болох шинж

Нойрны хямрал буюу нойр хулжих, огт нойр хүрэхгүй байх, дүрсхийж уурлах, бухимдаж цухалдах, хэт сонор сэрэмжтэй болох, анхаарал тогтворгүй, аливаа зүйлд хэт их цочих хариу урвал өгнө.

Хэрвээ дээрх шинж тэмдгүүд хүүхдэд 6 сараас дээш хугацаагаар илэрвэл эцэг, эх, багш, асран хамгаалагчид сэтгэцийн болон сэтгэл засалч эмчид хандах хэрэгтэй.

Сэтгэл зүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг илэрсэн хүүхдэд өгөх зөвлөгөө, мэдээлэл

Өөрийн итгэдэг хэн нэгэн хүн, мэргэжлийн сэтгэлзүйч, сэтгэл засалч эмч, насанд хүрэгчдэд хандаж, өөрийн мэдрэмжээ илэрхийлж, дэмжлэг, туслалцаа авах хэрэгтэйг зөвлөх

Болж өнгөрсөн таагүй үйл явдалд үзүүлж буй хариу урвалын талаар бусадтай ярилцах нь эдгэрэх үйл явцын нэг чухал хэсэг бөгөөд юу болж өнгөрснийг хүлээн зөвшөөрөхөд тань туслах болно.

Сэтгэл зүйн гэмтлийг эерэгээр даван туулах дараах чадваруудыг эзэмших хэрэгтэй.

- Хэрэгтэй зүйлдээ анхаарлаа хурдан төвлөрүүлэх чадвартай байх
- Шийдвэр гаргах
- Таагүй сэтгэл хөдлөл, мэдрэмжээ зөв тайлах, хүлээн зөвшөөрөх
- Гарч болох эрсдлийг зөв тооцох, зохицуулах, шийдвэрлэх бэлтгэлтэй байх
- Бусдын туслалцааг авах, бусдаас тусламж хүсэх
- Гэнэтийн үйлдлүүдийг хүч хэрэглэхгүйгээр зогсоож сурах
- Орчин тойронд байгаа маргаантай асуудлуудыг шийдвэрлэх, тэдгээрийн ашигтай талыг таньж мэдэх
- Сэтгэл түгшилтийг намжаах аргуудыг хэрэглэж сурах /амьсгалын дасгал, хошигнох чадвар, цагаа зохицуулах, булчин сулруулах аргууд гэх мэт/

Сэтгэл зүйн гэмтлийг сөргөөр даван туулах дараах шинжүүдээс зайлсхийх

- Зожигрох, хэт үгүйсгэх, олон хүнтэй газраас зугатах, зохиомол, худал зүйл ярих
- Түрэмгий авирлах
- Өөрөөсөө сул дорой хүнд уураа гаргах
- Бусдаас халамж хүсч байгаагаа мэдрүүлэх, дэмжлэг тусламж ашиглах чадваргүй байх
- Бусдаас хамааралтай байхыг эрмэлзэх
- Сэтгэл хөдлөл, мэдрэмжээ дарах, зорилгогүй ямар нэгэн зүйлийг давтан хийх

- Амархан ядрах, амралтын дэглэм алдагдах
- Архи, тамхи, нойрсуулах, тайвшруулах эм хэрэглэх

Анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг

Анхаарал төвлөрүүлэх чадваргүй хийгээд хэт хөдөлгөөнтөх шинжүүдээр илэрдэг хүүхдийн сэтгэцийн эмгэгийг анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг гэнэ.

Анхаарал дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй хүүхдүүдийг өвчний улмаас ингэж байна гэж хүмүүс мэддэггүй.

Илрэх шинж тэмдэг

1. Тогтвортой сууж чадахгүй
2. Хэт хөдөлгөөнтэй байдлаасаа болоод найз нөхөдгүй байх
3. Чалчаа. Янз бүрийн зүйл ярьж хүмүүст саад болно
4. Гэнэт ухасхийн хөдлөнө
5. Бодлогогүй үйлдэл хийнэ
6. Өөрийн эргэн тойронд байгаа эд юмсаар оролдоно, тэдгээрийг хөдөлгөнө
7. Анхаарал нь тогтворгүй хийгээд сарниун байна
8. Анхаарал шаардсан ажлыг гүйцэтгэж чадахгүй байна
9. Нэг ажлыг дуусгалгүй нөгөө ажлыг хийдэг
10. Гэрийн даалгавраа дуусгадаггүй
11. Ажил хийхдээ тууштай биш
12. Үймүүлдэг, үгэнд орохгүй, хүүхдүүд шоглодог
13. Өөрийгөө хянах чадваргүй байна
14. Хөдөлгөөнтэй учраас найз нөхөдгүй байдаг
15. Ажлаа зохион байгуулж чаддаггүй
16. Багаар ажиллаж чадахгүй байна
17. Түргэн зантай, бодож төлөвлөхгүй юмыг шууд гэнэт хийдэг
18. Эмх цэгцтэй биш
19. Сурлагандаа муу

Анхаарал дутмагшил хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй хүүхдийн эцэг эхэд өгөх зөвлөгөө, мэдээлэл

- Хүүхдийг гэртээ байхад нь анхаарал халамж тавих
- Ямар нэгэн шийтгэл үзүүлэхээс зайлсхийх
- Хэрвээ хүүхэд зөв зүйл хийвэл сайн магтан урамшуулж байх
- Нэг зэрэг олон үүрэг даалгавар бүү өг. Яагаад гэвэл түүнээс хүсч байгаа зүйлийг тэр биелүүлж чадахгүй. Хэт олон тоглоом өгөөд хэрэггүй.
- Хүүхдийн илүүдэл энергийг спорт, биеийн хүчний хөнгөн хялбар ажил хийхэд нь зарцуулах
- Анхаарал төвлөрүүлэх сонирхолтой дасгал хийлгэх
- Хүүхдэд зориулсан тогтмол цагийн хуваарийг хийж, нэг өдөрт хийж гүйцэтгэх ажлыг нь төлөвлө
- Хүүхдийн санаа бодлыг сайн сонс

- Хүүхдийг гадуур дагуулан явахдаа хараа хяналт сайн тавих, болж өгвөл олон хүнтэй газар бага дагуулан явах

Хүүхдийн зан үйлийн эмгэг

Хүүхэд өөр өөрийн нас сэтгэхүйн онцлог, биеийн хөгжилтэй уялдан гэр бүлийн орчин, тухайн нийгэмдээ дасан зохицож амьдардаг. Аливаа хүн амьдралынхаа турш нийгэм, хамт олон, гэр бүлийнхээ хүрээнд баримталж буй ёс зүй, зан заншил, хүмүүс хоорондын харилцаа, хуулийн хэм хэмжээг даган мөрдөж биеэ зөв авч явж байх ёстой байдаг бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хууль, дүрэм, ёс зүй, зан заншил, эрх зүйг гажуудуулан зөрчихийг зан үйлийн асуудал гэнэ.

Илрэх шинж тэмдэг

1. Ихэвчлэн хүүхэд ууртай, хэрцгий догшин шазруун харилцаа байнга гаргана.
2. Орон гэрээсээ дайжих
3. Гадуур ямарч зорилгогүй дэмий тэнэх /тэнэх дон/
4. Бусад хүмүүс ба амьтадтай хэрцгий хандах
5. Эд зүйлсийг шалтгаангүй эвдлэн сүйтгэх, галдан шатаах
6. Худал хэлэх
7. Хичээлээ олон цагаар таслах
8. Хулгай хийх
9. Нийгмийн сөрөг үзэгдэлийг даган дуурайх /архидах, тамхи татах, биеэ үнэлэх, мансуурах/
10. Өөртөө гэмтэл учруулах /судсаа ханах, хийгээр хордох, эм их хэмжээгээр уух, өөрийгөө боймлох/
11. Өөртэйгээ адил хүүхдүүдтэй эвсэлдэн нэгдэж ёс зүйн болон нийгмийн хэв журам зөрчих улмаар гэмт хэрэгт холбогдох
12. Том хүний үг сонсохгүй эсэргүүцэх
13. Биеэ хянах чадваргүй
14. Уурласан үед нүүр улайх, гар хөл салгалах, зүрх хүчтэй дэлсэх зэрэг шинжүүд илэрнэ.

Зан үйлийн эмгэгтэй хүүхдийн эцэг эхэд өгөх зөвлөгөө, мэдээлэл

- Хүүхдэд нөлөөлсөн нөхцөл байдлуудад аль болох анхаарлаа хандуулах нь зөв
- Эцэг эхчүүд хүүхдийнхээ зан үйлийн сайн чанаруудыг илрүүлж, эерэг талыг нь дэмжиж байх
- Эцэг эхчүүд өөрсдөө сахилга батыг тогтвортой баримтлах хэрэгтэй
- Эцэг эхчүүд зан үйлийн муу чанарыг хязгаарласан дүрэм, журам тогтоох, энэ хязгаарлалтын давуу тал үр дүнг хүүхэддээ тайлбарлах
- Багш нартай нь сахилга батын талаар ярилцах
- Хүүхдэд үүссэн будлианыг эерэгээр шийдвэрлэх

- Хэрвээ амиа хорлох оролдлого хийхийг завдвал яаралтай эмчид хандах
- Биеийн шийтгэлээс зайлсхийх
- Хүүхдээ ямар хүүхдүүдтэй нөхөрлөж байгааг мэдэж байх
- Чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж сургах
- Гэр бүлийн эерэг нөхөрсөг харилцааг бүрдүүлэх шаардлагатай

Хүүхдийн сэтгэл гутрах эмгэг

Хүүхэд, өсвөр үеийнхэн уйтгарлаж гунигласан мэдрэмжээ илэрхийлэхдээ сэтгэл гутрал гэдэг үгийг хэрэглэдэг. Эдгээр мэдрэмжүүд нь хэдэн цагаас, хэдэн өдөр үргэлжлээд арилдаг бөгөөд энэ үедээ өдөр тутам хийдэг ажлаа хэвийн явуулах чадвартай байдаг. Харин сэтгэл гутрах эмгэг нь түр зуурын уйтгарлаж гуних мэдрэмжээс ялгаатай юм.

Сэтгэл гутрах эмгэгийн үед уйтгар гуниг маш хүчтэй мэдрэгдэж, хоёр долоо хоногоос дээш хугацаагаар үргэлжилж, өдөр тутмын идэвхитэй үйл ажиллагаагаа явуулахад хүндрэл учирдаг.

Илрэх шинж тэмдэг:

1. Сэтгэл санаагаар унах
2. Уйтгар, гунигтай болох
3. Идэвхи сонирхолгүй, баяр баясгалангүй болох
4. Ирээдүйд итгэлгүй болж, горьдлого тасрах
5. Өөрийгөө царай муутай, мэдлэг боловсролгүй гэж муугаар бодох
6. Анхаарал төвлөрөлт муудах
7. Амьдрал утга учиргүй мэт санагдах
8. Үхэх тухай бодох, төлөвлөх
9. Нойр муудах
10. Хоолны дуршил буурах
11. Толгой өвдөх бусад зовиур шаналгаанууд
12. Цочромтгой болох
13. Ядарч эрч хүчээ алдах
14. Үлбэгэр, сул дорой байх

Нярайн сэтгэл гутралын үед /эцэг эхээс нь салгах/ нүүрэнд нь сэтгэл хөдлөлийн илрэл байхгүй, уйтгар гунигтай царайны илрэл, харж асарч байгаа хүндээ хариу урвал үзүүлдэггүй.

Сургуулийн өмнөх насны хүүхдэд хамгийн элбэг тохиолдох шинж нь ямар ч баяр баясгаланг мэдрэхгүй, идэвхи сонирхолгүй байдаг. Долоогоос бага насанд хүүхэд сөрөг сэтгэл хөдлөл, сөрөг бодлоо бусдад ойлгуулж, өөрийгөө чөлөөтэй үг яриагаараа илэрхийлж чаддаггүй учраас сэтгэл гутралын шинж нь биеийн энд тэнд, толгой, ходоод гэдэс орчим өвдөх зэргээр илэрдэг. Мөн сэтгэл түгшилт, салан хагацахаас айх айдас хавсран тохиолдох нь түгээмэл. Уйтгар гунигтай байгаа сөрөг сэтгэл хөдлөл нь уур уцаараар илэрдэг.

Сэтгэл гутрах эмгэгтэй хүүхдийн эцэг эхэд өгөх мэдээлэл, зөвлөгөө

- Сэтгэл гутрах эмгэг үүсэх шалтгаан олон янз байдаг
- Сэтгэл гутрах эмгэг хүн амын дунд элбэг тохиолддог эмгэг
- Шаардлагатай үед эмчилгээ хийхэд эмчилгээ сайн авдаг
- Өвчин дахиж болно.
- Энэ бол залхуурал, сул дорой байдал биш
- Хүүхдийн хийх дуртай зүйлсийн жагсаалтыг хамт гаргаж, өдөр бүр дуртай зүйлээ хийж байхад нь туслах
- Хийж буй ажлыг нь дэмжиж, сайшааж урамшуулж байх
- Хүүхдийг байнга хараа хяналттай байлгах
- Сайн ажиглаж, ярилцаж байх
- Хүүхдийг шүүмжлэх буюу зэмлэхгүй байх
- Хүүхэдтэйгээ илүү цагийг өнгөрөөж, тоглож байх
- Биеийн тамир спортоор хичээллэхэд нь туслах
- Гутранги сөрөг бодлоос салахад нь туслах

Өсвөр үеийнхэнд өгөх зөвлөгөө

- Стрессээ бусад найз нөхөд, гэр бүл, багш гэх мэт бусад хүмүүстэй хуваалц. Бүү ич.
- Сөрөг мэдрэмжтэй байгаа үедээ өөрийгөө завгүй байлгах
- Гэр бүлийн болон бусад найз нөхөдтэйгээ хамт байхыг хичээх
- Ажлаа сонирхолтой хийхийн тулд өөртөө өдөр бүр зорилго тавьж бага багаар биелүүлэх
- 7 хоног бүр хийх ажлын төлөвлөгөө гаргаж, дуртай зүйлсээ хийж байх
- Биеийн тамир спортоор хичээллэх

Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх эмгэг

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд архи, тамхи, мансууруулах бодисыг хааяа нэг хэрэглэж байснаа, яваандаа донтох эмгэгээр өвдөх эрсдэлтэй болдог.

Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэж буйг илтгэх шинжүүд

1. Харахад уйтгартай, сэтгэл нь түгшүүртэй байх
2. Хүүхэд урьд өмнө нь хичээл сурлагадаа сайн байсан боловч ялимгүй шалтгаанаар хичээлдээ явахгүй болох
3. Хичээл сурлагадаа муудаж, олон нийтийн ажилд оролцохгүй болох
4. Хэрэг төвөгт орооцолдох
5. Хүүхдийн өмссөн хувцасны халаасанд чүдэнз, тамхины цаас, ахуйн газ, тугалган цаас, өвс гэх мэт зүйлсийн тасархай үлдэгдэл зэрэг байх
6. Хуруу, шүд нь шаралсан, хувцас болон үснээс тамхи үнэртэж байх
7. Архи үнэртэх, гэртээ согтуу, мансуурсан байдалтай орж ирэх гэх мэт

Өсвөр үеийнхэнд өгөх зөвлөгөө

- Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэж буй хүүхэд, насанд хүрэгчдээс хол байх

- “Үгүй” гэж хэлж сурах
- Гэр бүлийнхэн, найз нөхөдтэйгөө цагийг хамтдаа өнгөрүүлэх
- Өөрийн дуртай, сонирхдог зүйлсээ хийх

Гар утас, компьютерт донтох эмгэг

Сэтгэл зүйн гэмтэлтэй хүүхэд айдас, зөрчил будлиан, уур уцаар, бухимдал, түгшүүр, уйтгартай байдлаасаа гарч тайвшрах, эсвэл хэн нэгэнд илэрхийлж чаддаггүй таагүй дурсамж мэдрэмжээсээ салах, бодит ертөнцөөс зугтах гэсэндээ гар утас, компьютерийг хэрэглэсээр донтдог.

Илрэх шинж тэмдэг

1. Хүүхдүүд урьд нь сонирхож хийдэг байсан зүйлээ орхих, найз нөхөдтэйгөө уулзах, спортын ямар нэг төрлөөр хичээллэхээ болих
2. Хичээлдээ анхаарах нь багасаж сурлагандаа муудах, зөвхөн компьютер, гар утсаараа тоглосноос цаг хугацааг анзаарахгүй байх, аажмаар найз нөхөд болон гэр бүлийнхнээсээ хөндийрч ганцаардах
3. Мэдрэлийн ядаргаанд орж анхаарал төвлөрөлт муудах
4. Идэвх сонирхолгүй, тэмүүлэлгүй болох
5. Яарч тэвдсэн биеэ барьсан байдалтай байх
6. Ууртай бухимдуу, гомдомхой болох зэрэг зан аашийн өөрчлөлт
7. Аймхай цочимтгой болж сэтгэл нь түгших
8. Нойрондоо муудах, хар дарж зүүдлэх заримдаа хий хоосон зүйл харах сонсох, дэмийрэх зэрэг солиорлын шинж илрэх
9. Зан ааш нь хардалт, үл итгэх, дайсагнал, түрэмгий хандлагатай болох, хулгай хийх, худал хэлэх гэх мэт бие хүний доройтлын шинжээс илрэх
10. Бодит амьдрал дээр амьдралын асуудлуудыг даван туулах боломжгүй болох
11. Бие махбодын хэвийн хөгжил идэвхтэй хөдөлгөөн алдагдан жин нэмэх, хөдөлгөөний дутагдалд орж хүзүү хөшиж хөдөлгөөн нь хязгаарлагдаж хүзүү нурууны яс шохойжих
12. Биеийн эсэргүүцэл муудаж ханиад хүрэх гэх мэт өвчлөмтгий болох
13. Нүдний хараа муудах, бие нь бүхэлдээ эсвэл хэсэг газар нь өвдөх гэх мэт

Гар утас, компьютерт донтох эмгэгтэй хүүхдийн эцэг эхэд өгөх мэдээлэл, зөвлөгөө

- Хүүхдэдтэйгээ хамт цагийг өнгөрүүлэх
- Салхинд гарах
- Гэрээрээ хамтдаа хөгжөөнт тоглоом тоглох
- Спорт, дугуйланд хамруулах
- Өөрөө компьютер, гар утасны хэрэглээгээ хянаж, үлгэрлэх
- Гэртээ зохистой хугацаагаар хэрэглэх дадал бий болгох

Мэдрэлийн гаралтай хоолноос татгалзах эмгэг

Сэтгэл зүйн гэмтэлтэй холбоотой хүүхдүүд өөрийгөө “махлаг тарган, муухай галбир”-тай гэсэн улигт бодлоосоо болж турах хүсэл эрмэлзэлд

бүрэн автаж, хоолоо сойж, тураах янз бүрийн аргуудыг хэрэглэснээр биеийн жингээ хэт хасаж, тураалд хүрснээр бодисын солилцооны гүнзгий алдагдалд ордог эмгэг.

3 үе шатаар явагдана

1. Эхлэл буюу далд үе /Дисморфофоби/
2. Хоолноос татгалзах буюу бөөлжих /Анорексийн/ үе
3. Тураалын үе

Дисморфофоби: Энэ үед өөрт нь ямар нэгэн “өөтэй, гажигтай, согогтой” шинж бий гэсэн алдаатай бодол мэдрэмж, итгэл үнэмшилтэй болох ба улмаар тухайн “өөтэй, гажигтай, согогтой” шинжээсээ ичин бусад хүүхдүүд түүнийг нь анзаарч шоолох вий гэсэн байнгын айдаст автана. Хоолны дур хэвийн байдаг тул өлсдөг. Гэвч бүдүүн болчих, бусдын элэг доог болох, биеийн хэлбэрээ алдах, хүмүүс намайг тоохоо болих вий гэж айж, түгшиж, сэтгэлээр унаж, гутардаг.

Хоолноос татгалзах буюу бөөлжих үе

Биеийн жингээ хасах зорилгоор идсэн зүйлээ бөөлжиж гаргах, хоолны хатуу дэглэм барих, клизм тавих, хоолны дур бууруулах, шээлгэх, туулгах эм, бэлдмэлүүд ихээр хэрэглэх, хүнд дасгалуудыг олон цагаар хийх зэрэг өөртөө зовиуртай үйлдлүүдийг хийдэг. Энэ үед биеийн жингээ 20-50% алдаж, дотоод шүүрлийн өөрчлөлтүүд илэрч, сарын тэмдэг багасах буюу алга болох зэрэг онцлог шинжүүд илэрнэ.

Тураалын үе

Биеийн жингээ 50 ба түүнээс дээш хувиар алдаж, хоол идэх дур үгүй болж, бодисын солилцооны алдагдал ихээр явагдана.

Мэдрэлийн хомхой

Мэдрэлийн хомхой эмгэгтэй хүүхэд их хэмжээний хоол хүнс хэрэглэдэг бөгөөд идсэнийхээ дараа хэт их биеийн хүчний ажил хийх, бургуй тавих, шээх, туулгах эм хэрэглэх, бөөлжих зэргээр биеийн илүүдэл калорио гадагшлуулдаг.

Илрэх шинж тэмдэг

1. Ижил нөхцөл, адил хугацаанд бусад хүмүүсийг бодвол их хэмжээгээр хоол идэх
2. Хоол идэх мэдрэмжээ хянаж чадахгүй болох
3. Хэт хурдан идэх
4. Өөрийгөө албаар бөөлжүүлэх гэж оролдох
5. Хэт их дасгал сургуулилалт хийх
6. Туулгах болон бусад эмийн тунг хэтрүүлэх
7. Сэтгэлээр унах
8. Донтох

Булчин татваганах эмгэг

Биеийн аль нэг хэсгийн булчин өөрийн мэдэлгүй таталдахыг булчин татваганах эмгэг гэнэ. Дуу авианы болон хөдөлгөөний гэж 2 ангилдаг. Хүүхдүүдэд ихэвчлэн аль нэг нь тохиолдох боловч зарим үед хавсран илрэх нь бий. Хэрвээ хавсран тохиолдвол үүнийг “Туреттийн хам шинж” гэдэг.

Илрэх шинж тэмдэг:

1. Нүдээ цавчлах. Хүүхэд өөрөө хүчтэй намжаах оролдлого хийсэн тохиолдолд түр хугацаагаар намжих боловч сүүлд энэ үзэгдэл дахин бүр хүчтэйгээр тохиолдох нь бий. Нүд цавчлах, нүүр таталдах, хамар сартаганах, амаа ангайх зэргээр илэрнэ.
2. Хоолойгоо засах
3. Нусаа татах гэх мэт

2.6 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСНИЙ ДАРААХ ЭРСДЭЛ

Хүчирхийллийг дагалдаад эрсдэл зайлшгүй үүсдэг.

Өндөр эрсдэлт бүлэг

Амьдралд нь аюул занал учирсан, хэцүү явдлын гэрч болсон, урд нь хүчирхийлэлд өртсөн юмуу эсвэл сэтгэл зүйн гэмтэлтэй байсан, эмэгтэй, өвчтэй юмуу хөгжлийн бэрхшээлтэй, оюуны хомсдолтой, гэр бүлд нь сэтгэцийн өвчтэй хүн байдаг, эцэг эх, асран хамгаалагч, ойр дотно найз нөхдөө алдсан, эцэг эхтэйгээ холбоо харилцаа тасарсан, эцэг эх нь эм, архи, тамхи, мансууруулах бодист донтсон, эцэг эх нь бие махбодын хүнд өвчтэй хүүхэд энэ бүлэгт ордог учраас онцгойлон анхаарах хэрэгтэй.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үүсэх сэтгэл зүйн хариу урвалын эрсдэл

- Хүүхдийн аюулгүй байдлын мэдрэмж алдагдаж, хүүхэд учраа олохгүй, сөрөг сэтгэл хөдлөл үүсч, үүнийг давж гарч чадахгүй мэт /**амиа егүүтгэх**/ санагдаж болзошгүй.
- Хүчирхийллийн улмаас хүүхэд, өсвөр үеийнхэнд өөрсдөд нь үүсэх сэтгэл зүйн хариу урвалууд: стрессийн шинж тэмдэг, биеийн болон сэтгэл зүйн хөгжил саатах, хөгжил ухрах, сэтгэл гутрал, түгшилт, уйтгар, сурах бэрхшээл, хичээлдээ сонирхолгүй болох, өөрийн үнэлэмж буурах, үнэ цэнэгүй болох, өөрийгөө арчлахгүй болох, бусад хүүхдүүдтэй нийгмийн харилцаанд ороход бэрхшээл тулгарах гэх мэт сэтгэл хөдлөлийн болон сэтгэл зүйн хариу урвал илрэх
- Хүчирхийллийн улмаас хүүхэд, өсвөр үеийнхэнд гэр бүлийн хүрээнд нөлөөлөх хүчин зүйлс: хүйс, нас, мэдрэмтгий байдал, даван туулах чадвар хэр зэрэг болох, эцэг эх, хүүхдийн хоорондын харилцаа, бусад дэмжих тогтолцоо, тохиолдсон хүчирхийллийн нөхцөл байдал, хүчирхийллийн өмнөх болон дараах нөхцөл байдал, хүрээлэн буй орчин,

хүчирхийллийн өмнө болон дараах гэр бүлийн зөрчил будлиан, эцэг эхээсээ харилцаагаа тасалсан, эцэг эх нь архи, тамхи, мансууруулах эм бодист донтсон, асран хамгаалагч нь сэтгэлийн шаналалаа даван гарах чадвар дутуу байх

- Хүчирхийллийн улмаас хүүхэд, өсвөр үеийнхэнд нийгэм хамт олны зүгээс нөлөөлөх хүчин зүйлс: зөвхөн сэтгэл зүйн сөрөг хариу урвал төдийгүй сэтгэл зүйн гэмтэл, уй гашуугаас шалтгаалсан цөхрөл, өөрийн ухамсар болон зан үйлийн хөгжлийн доголдол, сэтгэл зүйн хүлээлт, дасан зохицол муутай байх, ажил амьдралын ирээдүйн төлөвлөгөө, чиг баримжаагаа өөрчлөх, засаг захиргаа, олон нийтийн халамж үйлчилгээнд найдах гэх мэт маш өргөн хүрээний эрсдэл үүснэ.

Хамгийн хүнд эрсдэл буюу хүчирхийлэлд өртсөний дараа амиа хорлохоос сэргийлэх нь

Хүчирхийллийн улмаас өсвөр үеийнхэнд үүсэх сэтгэлийн хямрал болон стрессийн хариу урвалуудаас хамгийн хэцүү эрсдэлт байдал нь амиа хорлох бодол болон амиа хорлох оролдлого хийх үйлдэх юм.

Хүчирхийллийн дараа амиа хорлох эрсдлийг нэмэгдүүлэх хүчин зүйл

- Дотны хүнээ алдсан
- Эдийн засгийн том хохирол
- Сэтгэцийн тулгамдсан асуудалд орох
- Урьд нь амиа хорлох оролдлого хийж байсан
- Удамд нь амиа хорлох, донтох болон сэтгэцийн эмгэгтэй хүн байсан
- Бие махбодын хавсарсан өвчтэй
- Гэр оронгүй болсон, ганцаардсан

Амиа хорлох шинж тэмдэг

Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн амиа хорлох шинж тэмдэг адилхан байх магадлал ихтэй. Энэ шинж тэмдгийг сэтгэцийн эмч, сэтгэл засалч эмч мэдсэнээр амиа хорлох үйлдлээс хүүхдийг сэргийлэх боломжтой байдаг.

- Үхлийн тухай болон амиа хорлох тухай байнга ярьдаг
- Амиа хорлох аргын тухай сонирхдог
- Зүсэх багаж хэрэгслийг цуглуулдаг
- Бусдын төлөө санаа зовдог
- Хувийн дуртай зүйлээ хаях, оршуулга зохион байгуулах
- Ганцаараа үлдэх дуртай
- Сэтгэл гутралтай, өөрийгөө буруутгасан
- Зарим үед шалтгаангүй чанга инээдэг
- Амьдралын тодорхой зорилгогүй

Амиа хорлох байдлыг илрүүлэх сорилууд

- Амиа хорлох оролдлогыг илрүүлэх богино хэмжээний сорил /I/ бүлгийн хавсралтаас харна уу/
- Сэтгэл гутралыг үнэлэх Бекийн сорил /II бүлгийн хавсралтаас харна уу/

Амиа хорлох тухай буруу ойлголтууд

- Амиа хорлох тухай хүүхэдтэй ярих нь тэр хүүхдийг амиа хорлох оролдлого хийхэд түлхдэг.
- Амиа хорлох үйлдэл хийхээр илт заналхийлж байгаа хүн амиа хорлодоггүй.
- Амиа хорлох оролдлого хийсэн л бол амиа хорлолтын эрсдлийг нэмэгдүүлдэг.

Амиа хорлохоос урьдчилан сэргийлэх ба шийдвэрлэх

Хүчирхийллийн дараа амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх

Гурван үе шаттай

- Эхний үе шатанд амиа хорлох бодлыг нь өөрчлөх
- Хоёрдагч үе шатанд сэтгэцийн тулгамдсан асуудлыг болон амиа хорлох зан үйлийг илрүүлэх
- Гуравдагч урьдчилан сэргийлэх үе шатанд амиа хорлох түвшинг буруулах ба оролдлого хийсэн хүүхдийг дахин амиа хорлохоос сэргийлэх

Хүчирхийлэлд өртсөн амиа хорлох бодол бүхий өсвөр үеийнхэнд зөвлөгөө өгөх

Хамгийн эхэнд аюулгүй байдлыг хангаж, амиа хорлох эрсдэл өндөртэй хүүхдийг сэтгэцийн эмнэлэгт эмчилгээнд хамруулах, хавсарсан сэтгэцийн эмгэг байвал эмчлэх

Дараах аргуудыг хэрэглэнэ:

Мэдрэмж хуваалцах

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, хүүхэд хоёрын дунд итгэлтэй харилцааны үндсэн дээр эмпацийн тусламжтай холбоо тогтооно. Амьсгалын болон булчин сулруулах дасгалыг хэрэглэж мэдрэмжийг гаргана. Мэдрэмжээ хуваалцах дургүй тохиолдолд өөрийнх нь тухай яриулна. Эмпатигаа илэрхийлж, хүүхдийн мэдрэмж, бодлыг хүлээж авна.

Амиа хорлох байдал, үхлийн тухай ойлголт өгөх

Амиа хорлох оролдлого хийх үеийн мэдрэмж, нөхцөл, бодол болон биеийн урвалын тухай ярилцах, амьдрал болон үхлийн тухай ойлголтыг асуух.

Өөрийгөө таньж мэдэх

Хүүхдээс өөрийгөө хэрхэн үнэлдэгийг асуух. Үүнд: өөрийгөө чадваржуулах, хүлээн зөвшөөрөх, хянах чадвар, стрессийг даван туулах, бусадтай харилцах чадварыг нь олж мэдэх. Энэ аргаар хүүхдийн нөөц бололцоог илрүүлнэ, мөн бодит байдлыг тодорхойлно.

Эерэг нөөцийг хуримтлуулах

Нийгмийн харилцаанд, хүрээлэн байгаа бүх нөөц бололцоог ашиглан хуримтлуулах, нийгэмд өөртөө туслах бүлгийг зохион байгуулах, бусад хүмүүстэй найзын харилцааг тогтоох.

Амьдралд итгэх итгэлийг сэргээх

Стрессыг даван туулах ур чадвартай болгох, амьдралд итгэх итгэлийг

нь сэргээх, дуртай сонирхолтой үйл ажиллагааг нь сэргээх, шинэ найз нөхдүүдтэй болгох

Эрсдэлийг үнэлэх асуумж

Энэ асуумжийг зөвхөн эмч болон өсвөр насны хүүхэд хэрэглэнэ.

Хэрэг болсны дараах судалгаанаас үзэхэд хүчирхийлэлд өртсөн охид эмэгтэйчүүд болон хүчирхийлэл үйлдэгч нартай холбоотой хэд хэдэн эрсдэлт хүчин зүйлүүд байдаг байна. Бид хүчирхийллийн үед юу болохыг таамаглаж чадахгүй ч хүчирхийллийн улмаас маш аюултай нөхцөл байдал, амиа алдах эрсдлээс сэрэмжлүүлж чадна.

"Хохирогч өөртөө тохиолдож болох эрсдэлийг үнэлэх асуумж"-д /II бүлгийн хавсралтаас харна уу/ хариулж чиний хувьд амиа алдах эрсдэл хэр их байгааг олж хараарай.

Аюулгүйн байдлын төлөвлөгөө

- Хэрвээ чи аюулд байгаа эсвэл хэн нэгэн чамайг гэмтээж буй үед **102, 103** эсвэл **108** руу залгана уу.
- Хэрвээ танай гэрээс сэжигтэй чимээ гарах үед сонсож, чиний өмнөөс **102, 103, 108** руу залгаж өгдөг хөрш болон найзтай болох
- Чи өөрөөсөө бага дүү нартаа утсаар цагдаа дуудахыг зааж өгөх
- Хүчирхийллийн үед чи дүүдээ аюулгүй газар луу явахыг зааж өгөх. Жишээ нь: Унтлагын өрөө эсвэл хөршийнх рүү гэх мэт.

2.7 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Сэтгэл зүйн анхны тусламж нь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хамгийн түрүүнд үзүүлэх тусламжийг хэлнэ. Энэ тусламжийг шуурхай зөв үзүүлсэн тохиолдолд хүүхдийн дасан зохицох, ээнэгшлийг сайжруулахад төдий чинээ нөлөөлдөг учир цаг алдалгүй, аль болох богино хугацаанд үзүүлбэл зохилтой.

Хүчирхийллийн улмаас учирсан гэмтлийн хор хохирлыг багасгах сэтгэл зүйн дэмжлэг зохицуулга хийхдээ үг яриа, харилцаа холбоо, түүнчлэн хоёрдогчоор сэтгэл зүйн гэмтэл нэмж үүсгэхгүй байхад анхаарна. Сэтгэл зүйн дэмжлэгийн ганцаарчилсан болон бүлгээр дэмжих арга бий.

Сэтгэл зүйн тусламж дэмжлэгийн талаарх ойлголт /наснаас нь хамаарна/

Хүчирхийллийн дараах сэтгэл зүйн хариу урвалыг ойлгох нь

Хир хүнд хор хохирол учирсны хирээр хүүхдийн сэтгэл зүйн хариу урвал төдий их байдаг. Мэдрэмжээ, хүчирхийллийн улмаас үүссэн айдсаа илэрхийлж чадахгүй байгаа хүүхдэд айдас болон бусад мэдрэмжүүд үүсэх нь хэвийн гэдгийг нь ойлгоход нь туслах ба чиглүүлэх хэрэгтэй.

Хүүхдэд гэр бүлийн нөхөн сэргээх дэмжлэгийн систем бий болго

Сэтгэл зүйн хямралыг даван туулах эхэн үед гэр бүлийн гишүүдийг

бүгдийг хамруулахыг хичээх ба нөхөн сэргээх төлөвлөгөөг хэрхэн яаж хэрэгжүүлэхийг зааварлаж, ямар нэгэн хориг саадгүй амьдарч суралцах, орчин нөхцөлийг аль болох сайнаар нь бүрдүүлнэ.

Олон нийтийн дэмжлэгийн сүлжээ

Гэр бүлийнхэнтэйгээ, найз нөхөдтэйгээ, олон нийтийн дунд, засаг захиргааны байгууллагад гэх мэт хаана хэнтэй байвал нөхөн сэргээхэд тустай байж болох бүх боломжит нөөц бололцоог эрэлхийл, харилцан туслалцах бүлэг, бүлгийн эмчилгээ гэх мэтээр анхны байдалдаа эргэн ирэх боломжийг нь урамшуулан зоригжуул.

Хүүхдийн өөрийнх нь боломжийг хөгжүүлэхэд тусал

Бусад хүмүүсийн сэтгэл зүйн дэмжлэгийг хүлээж авч сурах, учирч буй бэрхшээлийг аль болох даван гарах, тохиолдсон зүйлийн улмаас чи бусдаас өөр болоогүй, бусадтай ижил төстэй гэдгийг нь ойлгоход нь тусал.

Сэтгэл гутрал, өөрийгөө доогуур үнэлэх гэх мэт асуудал тулгарахаас урьдчилан сэргийлэх

Өөрийн хамт олны байр сууриа хадгалах, өөрөө өөртөө туслах чадвар зэргийг нь хөгжүүл, дээшлүүл. Эмнэлгийн ажилтануудтай аль болох сайн холбоотой байж, идэвхгүй, ууртай, эсэргүүцэх зэрэг зан байдлыг нь таслан зогсоохыг хичээ.

Эерэг хандлагад суралц

Өөрт нь байгаа боломжийг улам бэхжүүлж хүчирхэгжүүлэх, эерэг хандлагатай, бэрхшээлийг зөвөөр даван туулж чадсан хүүхдүүдийг бүлэгт байлган, тэднээс суралцах урамших, хүүхдийн өөрийгөө хянах, дасан зохицох чадварыг дээшлүүлэх.

Амьдралын зорилгоо эерэгээр тодорхойлох

Хүүхдийн нас, хүйс, суурь нөхцөл байдал, учирсан хохирлын хүнд хөнгөний зэргийг харгалзан зөв жишээ, үлгэр дуурайлал бий болго.

Хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөхдөө наснаас нь хамаарах

Зураг зурах, үлгэр ярих, бичих, тоглох гэх мэт уян хатан хэлбэрийг сонгоно.

Хүүхэд үгүйсгэлтэй эсвэл сэтгэл гутралтай байгаа үед

Сонс, тайлбарла, чиглүүл, боломжит аргуудыг санал болго, хүүхдийн сэтгэл хүнд хэцүү байгааг ойлгож байгаагаа чин сэтгэлээсээ илэрхийл, тэднийг хүндэтгэж байгаагаа харуул.

Сэтгэл зүйн гэмтлийн дараах стрессийн хариу урвалын эмчилгээнд маш сайн анхаар

Цаашид уг эмгэг хүндрэх, түүнчлэн сэтгэл гутрал, амиа егүүтгэх байдал ч гарч болзошгүй тул мэргэжлийн туслалцааг цаг тухай бүрт нь үзүүлнэ.

Сургуульдаа эргэж орсны дараа

Хүүхдийг орхилгүй, сэтгэцийн эмч, сэтгэл зүйчтэй тогтмол харилцаатай байлгаж, ялангуяа хүчтэй сэтгэл зүйн гэмтэлтэй хүүхдүүдийг бүр илүү анхаар.

Сэтгэл зүйн өвөрмөц тулгамдсан асуудал бүхий хүүхэд, өсвөр үеийнхэнтэй ажиллах нь

Сэтгэл зүйн гэмтэл, хүчирхийлэл, уй гашуу хэнд ч тохиолдсон маш хүнд хэцүү сорилт болдог бөгөөд, тэр тусмаа хүүхэд өсвөр үеийнхэнд маш хүндээр тусдаг. Тэдний зарим нь гэр бүл ойр дотныхноо, зарим нь сайн найзаа алдсан эсвэл биеийн гэмтэл авах зэрэг нь амьдралын хүнд сорилттой нүүр тулгарч байгаа хэрэг бөгөөд ихэнхдээ сэтгэл зүйн гэмтэл дагуулдаг.

Хүчирхийллийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон хүүхдийн сэтгэлзүйд тулгамддаг өвөрмөц асуудал

Хүчирхийлэлд өртсөн хүүхэд өсвөр үеийнхэн хамгийн түрүүнд сэтгэл зүйн тусламж үзүүлэх ёстой эгнээнд эрэмбэлэгдэх бөгөөд бие эрхтэний гэмтэл учирсан бол сэтгэл зүйн тусламжийн зэрэгцээгээр нөхөн сэргээх, амьдралын чанарыг алдагдуулахгүй байх тусламжыг хамтад нь үзүүлэх хэрэгтэй.

Сэтгэл зүйн тусламжийг дараах 3 чиглэлээр үзүүлнэ. Үүнд: эцэг эх, хүүхдэд зөвлөгөө өгөх, дэмжих тогтолцоог бий болгох

Эцэг эхэд нь зөвлөгөө өгөх

Хүүхэд нь гэмтсэн эцэг эхийн стрессийн түвшинг үнэлж, сөрөг сэтгэл хөдлөлийг нь илрүүлж, засаж залруулах хэрэгтэй. Мөн тулгарсан нөхцөл байдлыг хүлээн авахад нь туслах ба эцэг эхэд нь бодит байдлыг ойлгуулан зоригжуулж, хүүхдэд нь юу хэрэгтэй болох, яавал сайжрах талаар төлөвлөгөө гаргахдаа хамтран оролцуулж, боломжит бүх нөөц бололцоог ашигла.

Хүчирхийллийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон хүүхэд өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх нь

Хүчирхийллийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон хүүхэд өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөхдөө тулгараад буй таагүй, хөгжлийн бэрхшээлийн улмаас үүссэн тухгүй нөхцөл байдлыг аль болох эерэг байдлаар даван туулахад нь туслана. Өөрийгөө үнэлэх үнэлэмж нь буурах, хэт их санаа зовох, нийгмийн дасан зохицол буурах зэргийн эсрэг ажиллах хэрэгтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэхэд анхаарах зүйлс

Нүд, харц

Сонирхож, хачирхаж харах, биеийнх нь бэрхшээл бүхий хэсэг рүү нь ширтэж, өрөвдөж харж болохгүй, энгийн хэвийн байх.

Хэл яриа

Хөгжлийн бэрхшээл рүү чиглэсэн агуулгатай үг яриа бус, энгийн сайхан харилцаж ярих, бие махбодын согог гажигтай холбоотой үг хэлэхээс зайлсхийх.

Үнэлгээ

Хөдөлгөөн нь хязгаарлагдсан хүүхэд зөвхөн тэд өөрсдөө зөвшөөрсөн үед хөдлөхөд нь туслах.

Дэмжлэгийн тогтолцоог бий болгох бусад тусламж

Хүчирхийллийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон хүүхэд өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч буй мэргэжилтэн нь гэр бүл, найз нөхөд, сургууль, олон нийтийн хүрээлэл гэх мэт гол дэмжигчидтэй нь холбоо тогтоон ажиллана.

Хүчирхийллийн улмаас салан тусгаарлагдаж, өнчрөх асуудалтай болсон хүүхэд, өсвөр үеийнхэн

Хүчирхийлэлд өртсний улмаас өнчирсэн хүүхэд өсвөр үеийнхэн бол сэтгэл зүйн тусламжийн нэгдүгээр эрэмбийнхэн.

Гэр бүлийнхээ талаар одоогоор ямар нэг мэдээлэлгүй байгаа хүүхэд өсвөр үеийнхэн

- Мэдээллийг тодруулахын төлөө ажиллана, гэхдээ гэрийнхэн чинь нас барсан байж магадгүй гэсэн урьдчилсан таамаглал хийж болохгүй.
- Хүүхэд, өсвөр үеийнхний асууж болзошгүй асуултуудад хариулахдаа асуудлаас зайлсхийхгүй ч амьдралд нь ойр байж, учир зүйг үнэнээр нь өгүүлэхдээ итгэж найдах зүйлийг нь ул мөргүй үгүйсгэж болохгүй.
- Үг яриа, биеийн хэл, дохио зангаагаа ч хүртэл тухайн ярилцагч хүүхдийн нас, сэтгэхүйд нь тохирсон, ойлгомжтой байлгах хэрэгтэй.

Хүчирхийллийн улмаас эцэг эх, ойр дотны хэн нэгэн нь амь үрэгдсэн тухай мэдээллийг хүүхдэд хэрхэн мэдээлэх вэ?

- Юуны түрүүнд хэлэх гэж байгаа мэдээлэл батлагдсан, үнэн гэдэгт та өөрөө итгэлтэй байх.
- Хаана, ямар өнгө аясаар хэлэх, уг асуудалтай холбоотой яаралтай нөхцөл байдал тулгарвал ямар арга хэмжээ авах, аюулгүй байдлаа хангах зэргээр урьдчилан сайн бэлдэх.
- Яг батлагдсан мэдээллээ дамжуулах бөгөөд аль сайнаараа дэмжиж туслах.
- Муу мэдээ дамжуулахдаа та хүүхдийн сэтгэл зүйн хариу урвалыг сайн анхаарах.
- Муу мэдээ дамжуулахын өмнө болон дараа нь тухайн хүүхдийг асран хамгаалж байгаа хүн аль болох солигдохгүй, удаан хугацаанд хамт байгаа хүн нь үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэх.

Хүүхэд өсвөр үеийнхний уй гашууг тайлах

- Нас барсан хүнийхээ оршуулгад оролцох, эсвэл оршуулсан газар дээр нь очих зэргийг хорихгүй, аль болох мэдрэмжийг нь гадагшлуулах.
- Талийгаачаа санан дурсах, ой буюу нас барсан өдрийг нь өөрийнхөөрөө ёслохыг хориглохгүй байх.

Хүүхэд өөрөө дасан зохицоход нь тусал

- Уй гашуугаа даван туулж дасан зохицох буюу аль болох эрт нийгмийн харилцаанд эргэн орох, нийгмийн дэмжлэг авах, сэтгэл зүйн зөвлөгөө авахад нь туслах.
- Дүрд тоглох хэлбэрээр өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлэх.
- Хүүхдэд хар аяндаа үүсч байгаа сөрөг бодол, өөрийгөө шийтгэх зэрэг үйлдлээс сэрэмжлэн аль болох сэтгэл зүйн эерэг байдлаар уй гашуугаа даван туулахад нь чиглүүлэх.

Үрчлэн авалтын тухайд анхаарах зүйл

- Хүүхэд үрчлэх асуудлын тухайд хамгийн түрүүнд хүүхдийн хүсэл, сэтгэл ямар байгааг чухалчлан, өөрөө сонгох эрхийг нь хүндэтгэн үзэх хэрэгтэй. Үрчлэн авах гэж байгаа эцэг эхийн асрамжлагч байх чадварыг нь холбогдох засаг захиргааны байгууллагууд үнэлнэ.
- Үрчлэн авж буй тал /асран өсгөх байр, байгууллага, хувь хүн/ доорх шаардлагуудыг хангасан байх хэрэгтэй. Эцэг эх хоёр хамт байх, халуун дулаан сэтгэлтэй, асран хамгаалах зан төлөвтэй, тухайн гэр бүлд ямар нэг хүчирхийлэл бэлгийн дарамтын эрсдэлгүй, гэр бүлийн зөв уур амьсгалтай, үрчлэн авч буй хүүхэдтэй ойролцоо насны хүүхэдтэй бол бүр сайн.

Анхаар

- Өдөр тутмын амьдралдаа тухайн хүүхдийг анхаарч, мэдэрч, найрсаг дулаан орчин бүрдүүлэх.
- Хүүхдийн хоромхон зуурын ааш аягийг зөв ойлгож харилцах
- Хүүхдийн сэтгэл зүйн байдлыг тогтмол анзаарах

2.8 ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙНХЭНД СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ТҮГЭЭМЭЛ ТЕХНИКҮҮД

Бүх насны хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөхдөө

0-6 нас буюу сургуулийн өмнөх насны хүүхэд

Тэврэх, илэх гэх мэт биед нь хүрэхээс гадна, өрөөнд хангалттай тоглоомыг байлгаж, 3-аас дээш насны хүүхдээр зураг зуруулах, тоглоом тоглуулах нь үр дүнтэй.

6-12 нас

Өрөөнд зураг зурж болдог ханыг байрлуулж, хүүхдээр сонин уншуулах, зураг зуруулах ба хүүхдүүдийн дунд бүлгийн ярилцлага явуулах.

12-18 нас

Үе тэнгийн хүүхдүүдийн дунд бүлгийн ярилцлага, урлагийн сэтгэл засал, танин мэдэхүй-зан үйлийн сэтгэл засал явуулах.

Танилцах буюу нүүр хагарах үе

Нүүр хагарах техник нь хүүхдэд сэтгэл зүйн үнэлгээ болон сэтгэл засал хийх

зуураа таатай бөгөөд баталгаатай сайн харилцаа тогтоохын эхлэл юм. Нүүр хагарах техникийг хэрэгжүүлж байхдаа итгэлтэй, нууцыг хадгалах, хүндэтгэлтэй, хор хохирол учруулахгүй байх зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай байдаг.

Итгэлтэй байх буюу нууцыг хадгалах зарчим

- Аюулгүй орчин, хамгаалагдсан мэт мэдрэмж үүсгэх тохитой газрыг сонгоно.
- Сэтгэл зүйн тусламж үзүүлж буй хүүхэд болон түүний асран хамгаалагчийн үнэлгээний асуултуудад хариулсан байдал, зөвлөгөө өгөхөд хөтөлж тэмдэглэж байгаа баримт, материалуудын нууцлалыг чандлан хадгална.
- Аюулгүй байдалтай холбоотой асуудал үүсэж болзошгүй учир зөвхөн сонгогдсон байрандаа л ярилцлагаа хийнэ.

Хүндэтгэлтэй байх зарчим

- Боломжит бүхий л мэдээллийг цуглуулахын зэрэгцээ үйлчлүүлэгчийнхээ /цаашид үйлчлүүлэгч гэж хүүхэд болон хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хамааруулан ойлгоно/ шашин шүтлэг, ёс заншлыг хүндэтгэнэ.
- Хүүхэд бүрийн ялгаатай тал болон бусдаас үл хамаарах бие даасан байдал, үнэт зүйлийг нь хүндэтгэн үзэж, тэвчээртэй, хүндэтгэлтэйгээр хандаж, ойлгон хүлээн авч, шүүн хэлэлцэхгүй байх хэрэгтэй.
- Өөр хэл соёл, шашинтай газраас ирсэн үйлчлүүлэгчдэд сэтгэл засал хийхдээ үр дүнд нь яарч болохгүй. Жишээ нь: Бурхан болоочийнхоо араас их уйлж болохгүй, тэгвэл эргэж төрдөггүй гэсэн итгэл үнэмшилтэй хүнийг сэтгэл засалч нь чи уйлж болно гэх мэтээр туслахыг оролдох нь ямар ч нэмэргүй байдаг.

Хор хөнөөлгүй байх зарчим

- Аливаа сэтгэл зүйн хямралыг зохицуулах явцад нэмэлтээр юмуу хоёрдогчоор дахин сэтгэл зүйн гэмтэл үүсгэж болохгүй. Нүүр хагарах техниктээ оролцуулахаар зориудаар болон зориуд бусаар хүчилж хэрхэвч болохгүй.

Нүүр хагарахын өмнөх бэлтгэл үе

Мэдээлэл цуглуулахдаа ёс зүйтэй, ойлгомжтой бай

Мэдээлэл цуглуулах журмыг доор үзүүлэв

- Хувь хүний үндсэн мэдээлэл: Нас, хүйс, цэцэрлэг, сургууль, авьяас сонирхол гэх мэт
- Хүчирхийллийн нөхцөл байдал: Гэр бүлийн гишүүдээс нь хүчирхийлэлд өртсөн үү, үгүй юу, өөрөө гэмтсэн үү, эдгэрэлт хир зэрэг байгаа, одоо байгаа нөөц боломж юу байна вэ гэдгийг тодорхойлох
- Гэр бүлийн байдал: Орлого, амьдралын нөхцөл, гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн байдал, гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцааны

шинж чанар, боломжит дэмжлэг хэр зэрэг байгааг үнэлэх Үйлчлүүлэгчид аятай тухтай, хамгаалагдсан мэдрэмж төрүүлэх бэлтгэл Халуун цай, кофе, салфетка, чихэр, тоглоом, цаас харандаа гэх мэт зүйлсийг бэлтгэх

Нүүр хагарах техник

Ганцаарчилсан ярилцлагад нүүр хагарах

Эхний уулзалт

- Хүүхдэд өөрийгөө танилцуулах, нэр, хаана ажилладаг, ямар зорилгоор уулзаж байгаагаа хэлж, өөрийгөө “Эмч-туслах гэж байгаа хүн” гэдгээ ойлгуулах.
- Эсвэл таныг хүүхдийг урд нь таньдаг хүн танилцуулж болно, ингэсэн тохиолдолд илүү итгэл төрдөг.
- Чагнуур, даралтын аппарат, цусны сахар хэмжигч гэх мэт эмч хүний өдөр тутамд хэрэглэгддэг багаж хэрэгслүүдийг биедээ авч явах ба эхний удаад биеийн ерөнхий үзлэг хийж, шаардагдах зөвлөгөө өгөх зуураа хүүхэдтэй аль болох насанд нь тохируулан харилцах хэрэгтэй. Ерөнхий биеийн эрүүл мэндийн байдлыг асуухаас эхлэн зугуухнаар, өөр зовиур шаналгаа рүү шилжиж ялангуяа өндөр эрсдэлт бүлэгт хамаарах хүүхдэд биеийн үзлэг хийх үедээ сэтгэл зүйн үнэлгээг эхэлж болно.
- Хүүхдийг чихрээр дайлах, бага насны хүүхдэд бичих зурах хэрэгсэл өгөх, хамт тоглох, өсвөр насны хүүхдүүдтэй чөлөөтэй энгийн харилцах /цаг агаар гэх мэт энгийн сэдвээр ярилцах/.

Үгийн бус харилцаа

Судалгаануудаас харахад хүмүүс хоорондын харилцааны 80% нь үгээр илэрхийлэгддэггүй. Эмч тухайн хүүхдийн нүүр царайны илэрхийлэл, дууны өнгө, биеийн хэл, дохио зангаа зэргийг сайн ойлгож анзаарах хэрэгтэй.

- Нүдээрээ аль болох дулаахан харилцаа үүсгэх
Хүүхдийн нүд рүү харж, найрсаг байж, харин хүүхдийг тухгүй байдалд ортол ширтээд байж болохгүй. Гэхдээ нүдээрээ сайн холбогдох тусам төдий чинээ сайн харилцаа үүсдэг. Мөн хүүхдийн нүдний харц, байрлалд өөрийн үйл хөдлөлөө тохируулах хэрэгтэй.
- Шүүн хэлэлцээгүй өнгө аясаар, эерэгээр мэдээллээ дамжуулах ба хүүхдээс илүү чанга ярьж болохгүй, хүүхдийн дуу хоолойны өнгөтэй адилхан юмуу намуухан хоолойны өнгөөр, хурдан ярихгүй байх нь зүйтэй. Хүүхдийн сэтгэл тогтворгүй байгаа бол тайвшруулж, та өөрөө ч тайван байх хэрэгтэй.
- Таны биеийн хэл зохистой байх ёстой бөгөөд та түүнд анхаарал хандуулж байгааг хүүхэд мэдрэх ёстой.

Хүүхэдтэй ярилцаж, тоглох зуураа аажмаар урагшилж, түүнийг маш сайн анхаарч, сонирхож байгаагаа илэрхийлж, ярилцаж байх үедээ тайван байх ба бага насны хүүхэдтэй харилцахдаа хүүхдийн өндрийн түвшинд доош

суух, том хүүхэд бол хүүхэд рүү хандан ялимгүй урагш тонгойж, гараа зөв байрлуулна. Тохиромжгүй дохио зангаа гаргахгүй, нүдээрээ харилцаа үүсгэж, харц бууруулахгүй, чин сэтгэлээсээ харьцаж байгаагаа мэдрүүлэх хэрэгтэй.

Биеэ займчих, хөлөө товших, биеэ сул тавьж суух, гараа элгэндээ зөрүүлэх, үсээ оролдох, амаа таглах, хамраа ухах, нүдээ нухах, ярилцаж байхдаа гартаа юм эргүүлэх юмуу алгандаа эргэлдүүлэх гэх мэт үйлдлийг хориглоно.

Хүүхэд өөрийгөө илэрхийлэх итгэл үүсгэ

Сайн харилцаа, итгэлцэл үүсч байж хүүхэд өөрийгөө илэрхийлдэг. Сэтгэл засалчийн өөрийгөө илэрхийлэх байдал нь хүүхдийн өөрийгөө илэрхийлэх байдалд нөлөөлдөг талтай. Тухайн хүүхэдтэй ижил төстэй байдалд орж байсан эсвэл бүтэлгүйтэж байсан үеийнхээ сөрөг сэтгэл хөдлөлөөсөө хуваалцаж, би ч бас ингэж байсан гэдгээ илэрхийлэх нь эхний уулзалтаас л итгэлтэй амжилттай харилцааны эх суурийг тавихад маш сайн үр нөлөөтэй байдаг.

Үр ашигтайгаар сонсох, итгэлтэй, аятайхан уур амьсгал үүсгэх

Үр ашигтайгаар сонсоно гэдэг нь хүүхдэд итгэл үүсгэн, тухайн хүүхдийг чин сэтгэлээсээ хүндэтгэн сонсож байна гэдгээ мэдрүүлэн, үүний үр дүнд хүүхэд улам нээгдэх буюу ярих хүсэлтэй байхыг хэлнэ.

Үр ашигтай сонсоно гэж юу вэ?

- Мэдэр, сонирх, сэтгэлээсээ сонс
- Ойлгож байгаагаа зөв илэрхийл
- Шүүхгүй, дүгнэхгүй, гайхан цочирдохгүй, цээрлэхгүй, балмагдахгүй, бухимдаж уурлахгүй зүгээр л нөхцөл болзолгүйгээр хүндэтгэн ойлгож хүлээж ав.
- Үнэн сэтгэлээсээ сонс, зөвхөн үг яриаг нь бус, нүүрний илэрхийлэл, биеийн хэл, хөдөлгөөнөөр юу илэрхийлж байна, эсвэл юуг ч юм нуухыг оролдож байна уу гэдгийг анзаарах хэрэгтэй. Хүүхэд өөрийнхөө талаар эсвэл өөр хэн нэгний талаар ярьж байна уу, асуултанд яаж хариулж байна гэдгийг мэдрэх нь чухал.
- Хүүхдэд үгээр болон үгийн бус байдлаар зохих хариу үйлдэл үзүүлэх, тухайлбал толгой дохих, хүүхэдтэй энгийн үгээр ярилцах, тоглох, сонирхож байгаагаа илэрхийлэх, үе үе нүдээрээ холбогдох /харц тулгарах/, зохих үед нь толгой дохих гэх мэтээр илэрхийлэх нь тохиромжтой. Инээмсэглэл бол хамгийн сайн хариу урвал юм.

Доорх, буруу сонсох байдлуудыг бүү гаргаарай:

- **Тохиромжгүй сонсох:** Тухайн хүүхдийн асуудал, хэрэгцээг анхаарахгүй байх, хүүхдэд энэ эмч намайг тоохгүй байна гэсэн сэтгэгдлийг төрүүлж болохгүй, хэрвээ ийм хандлага төрүүлбэл чухал зүйлсээ хэлэхгүй өнгөрөөж, амжилттай харилцаа тогтоох оролдлого нуран унана.

- *Дүгнэж сонсох:* Өөрийн мэдэлгүйгээр хүүхдийг дүгнэх юмуу шүүн хэлэлцэх байдал гаргаж болохгүй, ийм тохиолдолд хүүхдэд шүүгдэж байгаа юм шиг мэдрэмж төрдөг.
- *Сонгож сонсох:* Эмч өөрийн хүлээлт, таамаглалынхаа дагуу сонсоё гэсэн зүйлээ сонсохоор хичээх нь буруу ойлголцож, үнэлгээ бодит биш болдог.
- *Үйл явцад чиглэж сонсох:* Хүүхдийн сэтгэл хөдлөл болон үгийн бус илэрхийллийг хайхралгүй, эмч хүүхдээс “Чи яг яасан бэ?” гэх мэт асуулт асууж ярилцвал хүүхэд танаас зай барих юм уу дарамттай байдлыг мэдэрч, сайн харилцаа тогтоож чадахгүйд хүрнэ.
- *Туршиж сонсох:* Эмч өөрийнхөө асуултанд хүүхэд ингэж хариулах байх, ийм хариу урвал үзүүлэх байх гэж төсөөлж, зөвхөн тэр тал руугаа хэт анхаарвал мөн итгэлтэй харилцаа үүсдэггүй.
- *Симпатитай сонсох:* Мэргэжлийн болон сэтгэл засалчаас бусад эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сайн дурын ажилтан хүүхдийн сэтгэл хөдлөлд хэт автаж, гол чиглэлээ алдаж болзошгүй зохих хэм хэмжээг баримтлах нь зүйтэй.
- *Ярилцах, сонсох, тоглох нь* тухайн хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон байх ёстой.

Хэрэг болохуйц санамжууд

- Хэрэв эсэн мэнд, бүрэн бүтэн үлдэх эсэхдээ санаа нь зовж байгаа бол боломжуудынх нь талаар тусалж, мэдээлэх.
- Хүүхэд сэтгэл зүйн тогтворгүй байдалтай /ялангуяа охид/, яг ухаан алдаж унах нь дээ гэмээр үед мөрөөр нь тэврэх, гараас нь барих зэргээр тайвшруулж болно.
- Хэрэв та ойлгоогүй бол асуу, гэхдээ ярьж байхад нь биш. Хүүхэд яриагаа дуусгаагүй байхад дүгнэлт гаргах гэж яарах хэрэггүй.

Эмпати

Эмпати, мэдрэмж, ямар нэгэн нөхцөл болзолгүй эерэг хандлага 3 бол сайн харилцаа бий болгох зайлшгүй 3 хүчин зүйл юм. Эмпати бол харилцааны хамгийн анхдагч хүчин зүйл, хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сэтгэл зүйн тусламж хийх үйл явцаас ч илүү чухал юм.

Эмпатитай байснаар:

- Хүүхэд аятай тухтай байгааг /өөрийн гутлаа өмссөн юм шиг/ эмч мэдрэх боломжтой болж, мэдээллийг зөв солилцоно.
- Сэтгэл зүйн зөвлөгөө зөв, ойлгомтой явагдаж, аль аль нь сэтгэл хангалуун байж, сайн харилцаа үүсэхэд эерэг нөлөөтэй байдаг.
- Хүүхэд өөрийгөө илэрхийлэх, өөрийгөө нээх, өөрийгөө ойлгох, эмчтэй гүн гүнзгий харилцаа тогтооход ач холбогдолтой.
- Сэтгэл зүйн яаралтай тусламж хэрэгтэй байгаа хэн нэгэнтэй эмпатитай ярилцсанаар эмчилгээний үр нөлөө илэрхий мэдрэгдэж эхэлдэг.

Гэр бүлийн хамт сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлж эхлэх цэг

- Хүүхэдтэй гэр бүлийн хувьд, хүүхдийнх нь сэтгэл зүйн байдал ямар байна, хүүхэд нь хир унтаж байна гэх зэргээр яриаг эхлүүлж, цааш эцэг эхийн анхаарал тавьж буй сэдэв рүү шилжих хэрэгтэй. Хүүхэдтэйгээ хамт оролцож байгаа бол хүүхдийнх нь насанд тохируулан харилцаж, тоглох болон хүүхдэд өгөх жижиг бэлгийн зүйлсийг урьдаас бэлдсэн байвал зохимжтой. Уриалагхан харилцаж эхлэх нь хүүхэд эцэг эх, гэр бүлтэй амархан ойлголцох үндэс болдог.
- Хүүхэд хамгийн анх эмчилгээнд ирэхдээ гэрийнхээ хэн нэгэнтэй хамт ирсэн тохиолдолд гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө өгөхөд дөхөм байдаг.
- Эхлэх цэг нь-эхлээд эмэгтэй рүү эсвэл аль ахмад настай хүн рүү нь хандаж ярих хэрэгтэй.

Хүүхдийн бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө буюу нүүр хагарах техник эхлэх цэг

Бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөөд нүүр хагарах аргыг хэрэглэх нь хурдан бөгөөд үр дүн сайтай байдаг. Насаар ойролцоо бүлэг сонгох нь тохиромжтой бөгөөд тухайн орон нутагт түгээмэл дэлгэрсэн хөгжөөн цэнгээнт тоглоомуудыг нүүр хагарахад хэрэглэх нь үр дүнтэй. Нүүр хагарах техникийн хүүхдэд тохиромжтой байж болох хувилбаруудыг доор өгүүлэв. Үүнд:

Шааран бөмбөлөг дээр гишгэх тоглоом



Бэлдэх зүйл: Шаар, уяа

Заавар: Бүгд 2 хэсэгт хуваагдаад хүүхэд бүр хөлөндөө тус тус 2 ширхэг шаар уяж тогтоох ба дохио өгч эхэлмэгц нөгөө багынхаа өөрийн эсрэг гишүүний хөлд уяатай байгаа шааран дээр гишгэж хагалахыг оролдохын

зэрэгцээ өөрийн шаарыг гишгүүлэхгүй бүтэн авч үлдэхийг хичээнэ. Хамгийн сүүлд бүтэн шаартай үлдсэн хүүхэд ялагч болно.

Хөгжимт бөмбөлөг тоглох

Бэлдэх зүйл: Бөмбөг, бөмбөр болон бусад хэрэгсэл

Заавар: Хүүхдүүд тойрог хэлбэртэй суугаад 1 нь бөмбөрийг авч, нүдээ бооно. Нүдээ боосон хүн бөмбөр цохин дуугаргаж байх зуур бусад нь бөмбөг дамжуулан харилцана. Бөмбөр байхгүй үед хувин, төмпөн гэх мэт дуу чимээ гаргаж болох зүйлсийг орлуулан ашиглана. Бөмбөр зогсоход бөмбөг барьж байсан хүн нь дуулах, бүжиглэх, шүлэг унших, онигоо ярих гэх мэт авьяасаа үзүүлнэ.

Хөгжимт сандал

Бэлдэх зүйл: Хөгжмийн хэрэгсэл, сандал

Заавар: Сандлуудыг оролцож буй хүүхдийн тооноос нэгээр дутуу байхаар тооцож тойрог хэлбэрт оруулж тавиад, хөгжим тоглож байх үед тойрон алхана, хөгжим гэнэт зогсох үед сандал дээр өрсөж сууна. Сандалгүй хоцорсон хүн нь хасагдаж, дараагийн шатанд дахин нэг сандлаа хасаад, дахин тойрч тоглоно. 1 хүн 1 сандал үлдтэл тоглох бөгөөд, удаа бүр хасагдаж байгаа хүүхэд өөрийгөө танилцуулах номер үзүүлнэ.

Зураг зурах, 4-16 нас



Бэлдэх зүйл: Цагаан цаас, өнгийн харандаанууд

Заавар: Зураг зуруулах нь сайн сэтгэл засал болдог, ялангуяа ярьж өөрийгөө илэрхийлж чадахгүй байгаа хүүхдээр зураг зуруулах нь маш үр дүнтэй. Хүүхэд өөрийн төсөөллөөрөө л зурна, зарим тохиолдолд “Зүүд”, “Өнгөрсөн ба ирээдүй”, “Хамгийн сайн найздаа өгөх бэлэг” гэх мэт сэдэв сонгон зуруулж болно.

Анхаар: 15- 20 минутын хугацаанд зураг зуруулж, нэг хүүхдийн зургаар дангаар нь эсвэл, олон хүүхдийн зургуудыг нийлүүлээд ханын үзүүлэн хийж болно.

Бөмбөг барих тоглоом, 7-9 нас



Бэлдэх зүйл: Шаар болон резинэн бөмбөг

Заавар: Хүүхдүүд тойрог хэлбэрт зогсоод, хэн нэг нь бөмбөгөө нөгөөдөө дамжуулахдаа "Сайн уу, намайг Бат гэдэг" гэж хэлнэ. Бөмбөг авсан хүн нь "Сайн уу Батаа" гэж мэндлээд, дараагийн хүнтэй харилцахдаа өөрийгөө танилцуулах байдлаар бөмбөг харилцаж дуусахад бүгд хоорондоо танилцсан байна.

Бөмбөлгөн тулаан, 7-9 нас

Бэлдэх зүйл: Олс, бөмбөлөг

Заавар: Тоглох газраа цэвэрлээд гол хэсэгт нь олсоор хязгаар тогтоож, олсны 2 талд хуваагдан бөмбөлөгөө газар унагаахгүй байхаар харилцаж тоглоно.

Бэлэг задлах, 7-12 нас

Бэлдэх зүйл: Жижигхэн тоглоом, чихэр ч юмуу ямар нэгэн бэлэг сонгоод, уг бэлгийг олон давхарлан бооно. Бэлэгний боолт болгоны дээр “Зүүн талдаа сууж байгаа хүнд сайн уу гэж хэлээрэй”, “Эсрэг талдаа сууж буй хүн рүү инээмсэглээрэй”, “Бэлэггүй сууж буй хэн нэгэнд бэлгээ дамжуулаарай” гэх мэт үгсийг бичнэ. Хамгийн сүүлчийн боолтон дээр “Бэлгээ хуваалцаарай” гэж бичиж болно.

Заавар: Тойрог хэлбэрт сууна, голд нь бэлгийг эхлэн дамжуулах ахлагч суугаад, хөгжим эхлэхэд бэлгээ дамжуулж эхлээд, хөгжим зогсоход бэлгийн боолтын 1 үеийг нь задлаад дээр нь бичээтэй байгаа зааврыг гүйцэтгээд, дараагийн хүнд шилжүүлнэ, хөгжим явж эхлэхээр дамжуулаад, хөгжим зогсохоор задлаад гэх мэт явсаар хамгийн сүүлд бэлгээ хуваалцаарай бичигт хүрнэ.

Анхаар: Оролцсон хүүхэд бүрт жижиг бэлэг хүрэлцэхээр бэлдэж боогоорой. Хөгжим байхгүй тохиолдолд цаасан аяга, саваа мод, жижиг чулуу юугаар чимээ авиа гаргаж болохоор байна түүнийг ашиглаж тогшиж тоглож болно.

Миний хамгийн дуртай зүйл, 7-12 нас

Бэлдэх зүйлс: Бөмбөлөг

Заавар: Бөмбөлөг шааран дээр хүнсний зүйлс, амьтан, хээ, дүрсийг зураад нэг нь нөгөөдөө харилцах байдлаар дамжуулан, гарт баригдсан тал дээр юуны зураг байна түүний дагуу миний хамгийн дуртай өнгө бол, хүнс бол, дүрс бол гэх мэтээр хэлээд, дараагийн хүн рүү шаараа шидэж дамжуулах байдлаар тоглоно.

Шааран дээр нэр, хүсэл, хобби гэх мэт юу ч зурж бичиж болно.

Олсон доогуур явах, 7-15 нас

Бэлдэх зүйл: Урт олс

Заавар: Урт олсны 2 үзүүрийг цээжний түвшинд байрлуулан татаад оролцогчид хойш гэдийж, өвдөг нугалан олсонд биеэ хүргэхгүй, газар гараараа тулахгүйгээр доогуур нь гарна. Хүргэж шүргэлцсэн нь хасагдаад, дараагийн тойрогт олсыг доошлуулж намхан болгоно, 1 хүн үлдтэл тоглоомыг үргэлжлүүлнэ.

Анхаар: Олсны өндрийг хүүхдийн нас, өндөрт харгалзан байрлуулна.

Таавар таах, 7-15 нас

Бэлдэх зүйл: Амьтан, нэр, хээ, дүрс гэх мэт зурагтай картуудыг бэлдэнэ.

Заавар: Эхлээд удирдан тоглож байгаа хүн нь картны зургийг хүүхдэд харуулахгүйгээр үгээр, амны хайрцагаар шивнэн хэлнэ, хүүхэд үг ярьж асуулгүйгээр уг амьтныг биеэрээ, үйлдлээрээ дуурайн үзүүлнэ.

Анхаар: Эхлэхдээ аль болох энгийн дүрслэлээс эхлээд цааш жаахан хүндрэх маягаар явагдана.

Анхааруулах нь

Хүүхдийн бүлэгт нүүр хагарах зорилгоор дээрх хөгжөөнт тоглоомуудыг тоглож эхлэхээсээ өмнө бэлтгэх жижиг хэрэгсэл, жижиг урамшуулал болох чихэр, тоглоом, бяцхан шагнал зэргээ урьдаас хүрэлцээтэй хэмжээгээр бэлдээрэй, хүүхдийг урамгүй гонсгор үлдээхгүйн тулд хэнийг ч орхигдуулалгүй оролцуулж, аль болох хөгжилтэй нээлттэй өрнүүлээрэй.

Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үндсэн технологи

Сэтгэл зүйн хямралыг зохицуулах үндсэн техник нь “Сэтгэл хөдлөлийг тогтворжуулах”, “Тайвшрах дасгал” юм.

“Сэтгэл хөдлөлийг тогтворжуулах” техник

- **Сонсох, ойлгох**
- **Хамгаалалтыг нэмэгдүүлэх:** Хүүхдэд аль болох дасал болсон орчинг үүсгэх ба элдэв хэвлэл мэдээллийг багасгах
- **Сэтгэл хөдлөлөө /мэдрэмжээ/ илэрхийлэх:** Ингэснээр сэтгэл санаа тайвширч, хүчирхийллийн таагүй дурсамжийг хадгалах нь багасна.
- **Хүүхдийн ердийн амьдралын дадал зуршилтай** холбоотой орчин нөхцөлийг аль болох ихээр бүрдүүлэх

- **Дэмжлэгийн системийг /гэр бүл, найз, хамаатан, хамт олон/ бүрдүүлэх.**
- **Сэтгэл зүйн боловсрол олгох:** Адил төстэй тохиолдол, сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг даван гарсан жишээ, түүхийг ярьж өгөх
- Байж болох бусад тусламж үйлчилгээнүүдтэй холбогдох

Тайвшрах дасгалын түлхүүр ойлголт

“Тайвшрах дасгал”-д: Амьсгалын дасгал, булчин суллах дасгал, төсөөлөн дүрсэлж тайвшрах гэх мэт аргууд багтдаг. Хүүхэд ухамсарт ухаан, ой санамжаа хагас болон бүрэн алдсан, сэрүүн биш, биеийн үйл хөдлөлөө хянаж чадахгүй гэх мэт илэрхий тусгаарлагдмал байдалтай бол тайвшрах дасгал төдийлөн зохимжтой бус.

- Амьсгалын дасгал хийх техник. Маш тайван байдалд өөрийгөө оруулахын тулд амьсгалаа хамраараа гүнзгий авахад гэдэс түмбийж, аажуухнаар амаараа гаргахад гэдэс хонхойх ёстой. Энэ дасгалыг 3 удаа хийсний дараа бие чинь ямар байдалтай байгааг маш сайн анзаараарай. Энэ дасгалыг хийх явцад намуухан тайвшруулах хөгжмийн аяыг тавьж болно.

Хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ба ур чадвар

Тоглоомын эмчилгээ

Ихэнхдээ 3-11 насны хүүдүүдийн мэдрэмж, айдас, үзэн ядалт, ганцаардал, азгүйтэл, өөрийгөө буруутгах гэх мэт сэтгэл хөдлөл, тохиолдсон бэрхшээл зэргийг тоглоомоор дамжуулан үнэлнэ. Гэхдээ боломжтой бол томчууд ярилцаад өөрийгөө илэрхийлдэг шиг хүүхэд өөрөө яривал маш сайн байдаг.

Энэхүү эмчилгээ нь хүүхэд өөрийн дотоод сэтгэл түгшилтээ тоглоомоор илэрхийлж, хамт тоглож буй эмч, эмнэлгийн мэргэжилтэнд өөрийгөө, өөрийн сэтгэл хөдлөлөө гаргасанаар цаашид өөрийгөө илүү илэрхийлэх, өөртөө итгэлтэй байх, бэрхшээлийг даван гарах чадвар зэрэг нь нэмэгдэнэ.

Тоглоомын сэтгэл зүйн тусламж үйлчилгээний үндсэн зарчмууд

- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн эхнээс нь найрсаг дулаан харьцаа үүсгэх
- Хүүхдийг байгаагаар нь хүлээж авах
- Хүүхэд сэтгэл хөдлөл, мэдрэмжээ бүрэн илэрхийлтэл тэвчээртэй байх
- Хүүхдийн гаргаж буй ааш авир, хариу урвал зэргийг маш сайн анзаарах
- Тодорхой хугацааны дараа хүүхэд тохиолдож буй бэрхшээлийг тохиромжтой үед нь өөрөө шийдэх чадвартай, гаргасан шийдвэрээ хариуцах бас өөрчлөх чадвартай боллоо гэдэгт итгэлтэй болох
- Тусламж үзүүлж буй ажилтан хүүхдийн алхмуудыг ажиглах боловч, тэдний гаргаж буй үйлдэл, яриаг таслан, чиглүүлэхгүй байх
- Тусламж, үйлчилгээний явцыг яаравчлуулж хурдлуулахгүй байх
- Бодит орчинтой нүүр тулгарсаны дараа харилцаа болон хариуцлагын

тал дээр суралцах хэм хэмжээний талаар буюу болох, болохгүйн хэвшсэн хязгаарлалтыг зааж өгөх

Хүүхдийн дүрслэн ярих эмчилгээ

Хүүхэд болон түүний гэр бүлд тохиолдоод буй бэрхшээлийг хүүхэд өөрөө дүрслэн ярих нь уг асуудлыг давж гарахад тустай байдаг. Энэ нь хүүхдийн дүрслэн бодох, ярих, төвлөрөх чадварыг сайжруулдаг билээ. Янз бүрийн гар урлалын зүйл, хүүхэлдэйн байшин, хүүхэлдэйнүүд, элсээр тоглох, хуруун хүүхэлдэйнүүд ашиглан хүүхэдтэй болон хүүхдийн гэрийнхнийг оролцуулан тоглож байх зуураа үг яриа, үйлдэл хөдөлгөөнөөр тэдний мэдрэмжийг гадагшлуулдаг. Хир сайн итгэл үнэмшил үүсгэж тоглож ярилцах тусам хүүхэд нээгдэнэ.

Урлагийн эмчилгээ

Зураг зурах, баримал бусад урлагийн бүтээл хийх зэргээр эмчилгээг явуулна. Урлагийн бүтээл хийх нь хүүхдэд төдийгүй насанд хүрэгчдэд ч тустай. Таамаглалаа зурах, дарамттай зүйлийг баримлаар илэрхийлэх, өөрийн зургаар цуглуулга хийх, хувь хүний лого зохиох гэх мэт арга бий. Олон төрлийн утга агуулгатай урлагийн бүтээлээр дамжуулан холбогдож, тэдний оюун санааны ертөнцөд гүн нэвтрэх ба хүүхэд үгээр илэрхийлж чадахгүй байгаа ганцаардал, стресс бүхий дотоод мэдрэмжээ урлагаар дамжуулан илэрхийлэх боломжтой болдог. Будаг, зургийн болон баримлын хэрэгсэл, цуглуулга хийх зүйлс гэх мэт материалаар хангана, энэхүү эмчилгээг хөтөлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь хялбар ойлгомжтойгоор, өдөр өдрөөр эмчилгээний төлөвлөгөөг гаргана.

Хоосон сандлын арга

Энэ аргыг зан үйлийн эмчилгээнд ч хэрэглэдэг боловч уй гашууг тайлахад өргөн хэрэглэдэг. Жишээ нь: Хүүхэд, өсвөр үеийнхэн эцэг эхээ, гэр бүлийн ойр дотны хүнээ, найз нөхдөө алдаж, маш их шаналалыг мэдэрч байхдаа яаж түүнийг илэрхийлэх аргаа олохгүй байх нь бий.

Энэ эмчилгээнд зөвхөн сандал л хэрэгтэй. Өөдөөс нь харуулан нэг сандал байрлуулаад, түүн дээр талийгаачаа сууж байна гэж төсөөлөөд бодож төсөөлж байгаагаа, хэлье гээд хэлж чадаагүй бүхнээ хэлж дотроо онгойлгох буюу тайвшрах арга юм.

Хоосон сандлын аргаар эмчилгээ хийх алхмууд

- Танилцуулга: Чиний ... хүчирхийллийн улмаас насан өөд болжээ, чамд гунигтай хэцүү, зүрх зүсэгдэж байвч яахаа мэдэхгүй байгаа. Би чиний сэтгэлийг маш сайн ойлгож байна, чамд тус болох арга бол чи өөрийн дотор буй уйтгар гуниг, мэдрэмжээ илэрхийлэх гаргах хэрэгтэй. Үүний тулд чи энэ сандал дээр талийгаачийг сууж байна гэж төсөөлөөд түүнтэй зүрхнийхээ үгийг ярилцаарай.
- Сандал сонгох: 2 ижил сандал байвал сайн. Хүүхэд өөрөө өөрийнхөө

суух сандлаа эхлээд сонгоно, ямар байрлалд, ямар зайд тавихаа хүүхэд өөрөө шийдэх хэрэгтэй.

- Тайвшраад, төсөөлөн бодож эхлэх: Нүдээ аниад, өөртөө аль болох тухтайгаар суугаарай, өөрийн амьсгалдаа анхаарлаа төвлөрүүлж, удаан гүнзгий амьсгал аваад удаанаар гаргаарай, бүх биеэ сулла, талийгаачтайгаа юу ярьмаар байна түүнийгээ бодож төсөөл, бэлэн боллоо гэсэн үедээ ярьж эхлээрэй гэдгийг хэлэх.
- Сандал руу хандан ярьж эхлэх: Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хүүхэд хэрхэн гүйцэтгэж байгааг шууд бусаар ажиглана, яриаг нь тасалж, саад болж болохгүй.
- Дууссаны дараа ярилцах: Хэлсэн ярьсан үг бүрийг хэлэлцэхгүй, харин үүнийг хийсний дараа чамд юу бодогдож байна? ямар мэдрэмжтэй байв? хэлэхийг хүссэнээ хэлж чадсан уу? гэх зэргийг асууж болно.

Хүүхэд асрахад зайлшгүй шаардагдах чадвар

Хүүхэд бие махбод, сэтгэл зүйн хувьд үргэлж хөгжиж байдаг, энэ хөгжиж буй бие махбод, оюун санаа нь олон хүчин зүйлийн улмаас тэр дундаа хүчирхийллийн улмаас хөгжил нь саатаж нурна. Хүчирхийллийн дараа хүүхдэд болон хүүхдийн үзүүлж буй хариу урвалд илүү их анхаарал тавих нь зүйн хэрэг. Хүүхдийн аюулгүй байдалд асран хамгаалагч, түүний сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал нь тухайн хүүхдийн сэтгэлийн шаналал илааршихад маш чухал нөлөөтэй. Иймд хүүхдэд үр ашигтай асран хамгаалах тусламж үзүүлье гэвэл асран хамгаалж буй хүмүүс хүүхэд асрах талаар зайлшгүй мэдвэл зохих зүйлүүдийг мэдсэн, энэ талаар тодорхой сургалтад хамрагдсан байх нь зүйтэй, нөгөөтэйгүүр асран хамгаалагч нар өөрсдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлаа бас хамгаалж байх хэрэгтэй.

Хүүхэд асран хамгаалагч өөртөө анхаарал тавих буюу хүүхэд асран хамгаалагчийн өөрийгөө арчлах чадвар

- Биеийн болон сэтгэцийн хувьд эрүүл байх
- Тайвшрах техник /амьсгалын болон булчин суллах дасгал/ эзэмшсэн байх
- Өөртөө үйлчлэх /тогтмол хооллолт, хангалттай унтах, бие биедээ туслах/
- Найз нөхөд, гэр бүлийн дэмжлэг, урамшуулалыг бэхжүүлэх, санаачлах, харилцаа холбоотой байх
- Сэтгэцийн эмчийн тусламж гэх мэт мэргэжлийн тусламж үйлчилгээг тухай бүр авч чаддаг, мэдээлдэг, холбогддог байх

Анхаар

- Асран хамгаалагчийн сэтгэл санааны байдал хүүхдэд нөлөөлдөг учир өөрийн айдас түгшилтээ хянаж, хүүхдийн дэргэд тохиромжгүй сэтгэл хөдлөл үзүүлэхгүй байх
- Хүүхдэд тусламж үзүүлж байхдаа хайхрамжгүй байж эсвэл хэт

бөөцийлөн асран хамгаалж, хүүхдийн хийж буй идэвхитэй үйлдлийг тасалж болохгүй. Харин аль чадахаараа эерэгээр нөлөөлөх хэрэгтэй.

- Хүүхдийн янз бүрийн хариу урвалыг ойлгон хүлээн авч, хэвлэл мэдээллээс хол байлгаж, зөв чиглүүлэх хэрэгтэй.

2.9 ХАВСРАЛТУУД

ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙНХНИЙГ ҮНЭЛЭХ ХУРДАВЧИЛСАН АСУУМЖУУД

/Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулав/

Энэхүү асуумжуудад янз бүрийн насны хүүхдүүдэд хүчирхийллийн дараа илрэх өртөмтгий байдлын шинж тэмдгүүдийг тусгасан. Эцэг эхчүүд өөрийн хүүхдэд сүүлийн 7 хоногийн турш ажиглагдаж буй шинж тэмдгүүдийг харгалзан үнэлнэ. Зөв, буруу хариулт гэж байхгүй.

Нярай болон бага нас /0-3 нас/

Д/д	Сүүлийн 7 хоногт тулгамдаж буй асуудлууд	Үгүй	Тийм
1	Унтах болон баах нь асуудалтай байна уу	0	1
2	Чанга болон хэвийн биш чимээ, доргионд уйлж байна уу	0	1
3	Биеэ хураан чангалж, хөдлөхгүй хөшүүн болж байна уу	0	1
4	Шалтгаангүйгээр уйлж байна уу	0	1
5	Үг яриа, үйлдэл хөдөлгөөнийг даган дуурайх нь буурсан уу	0	1
6	Ганцаараа байхаас айж, аав ээжээсээ салахгүй наалдаж байна уу	0	1
7	Хүчирхийлэлтэй төстэй нөхцөл байдалд зугтаах юмуу сэрэмжлүүлэх үйл хөдлөл хийж байна уу	0	1

Тайлбар ба үнэлгээний үр дүн: Оноог доош нэмж, нийт оноог гаргана.

Нийт оноо	Авах арга хэмжээ
1-2	Анхаарал тавь, амраа, 7 хоногийн дараа дахин үнэл
3-4	Тусламж хэрэгтэй, сэтгэл засалч болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс тусламж ав
5-7	Яаралтай тусламж хэрэгтэй, сэтгэл засалч болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс нэн даруй тусламж ав, цаашдын оношлогоо эмчилгээнд шилжүүл

Бага насны болон сургуулийн бага ангийн хүүхэд /3-10 нас/

Д/д	Сүүлийн 7 хоногт тулгамдаж буй асуудлууд	Үгүй	Тийм
1	Хүчирхийллийн үед тохиолдсон сэтгэл зүйн гэмтлийн улмаас үүссэн шинжүүдийг давтах үйлдэл хийж байна уу?	0	1
2	Илэрхий айж түгшсэн байдалтай байна уу?	0	1
3	Хүчирхийлэлтэй холбоотой тодорхой нэг үйл явдлаас айж байна уу?	0	1
4	Хүчирхийлэл дахих вий гэж айж байна уу?	0	1
5	Хүчирхийллийн үеийн дүр зураг, мэдрэмжээс гарч чадахгүй дахин дахин санаад байна уу?	0	1
6	Хичээл сурлагадаа муудах, анхаарал амархан сарниж байна уу?	0	1
7	Зан үйл нь өөрчлөгдөх, нялхамсах шинж ажиглагдаж байна уу?	0	1
8	Дуугайрах, зожигрох, хэвийн биш учир нь олдохгүй аашлах, дуулгаваргүй болж байна уу?	0	1
9	Дуртай зүйлдээ дургүйцэж байна уу?	0	1
10	Хар дарах, зүүдэндээ явах, унтахгүй байх зэрэг шинжүүд илэрч байна уу?	0	1
11	Шалтгаангүйгээр ямар нэг өвчний шинж тэмдгийг тоочих, зовиурлаж байна уу?	0	1
12	Хүчирхийлэл тохиолдсон өдрийг эргэн санах, гонгинох, тохиромжгүй ааш гаргаж байна уу?	0	1

Тайлбар ба үнэлгээний үр дүн: Оноог доош нэмж, нийт оноог гаргана.

Нийт оноо	Авах арга хэмжээ
1-3	Анхаарал тавь, амраа, 7 хоногийн дараа дахин үнэл
4-6	Тусламж хэрэгтэй, сэтгэл засалч болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс тусламж ав
7-12	Яаралтай тусламж хэрэгтэй, сэтгэл засалч болон сэтгэцийн Эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс нэн даруй тусламж ав, цаашдын оношлогоо эмчилгээнд шилжүүл

Өсвөр үеийнхэн /11-18 нас/

Д/д	Сүүлийн 7 хоногт тулгамдаж буй асуудлууд	Үгүй	Тийм
1	Хүчирхийлэлтэй холбоотойгоор хяналтгүй аашилж авирлаж байна уу? /Хүчирхийллийн голомт руу эргэн очиж бусдыг аврах гэж зүтгэх зэрэг аюултай эрсдэлтэй үйлдэл хийх/	0	1
2	Гашуудах, буруутай мэт мэдрэх, ичих зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийг ил гаргахгүй, мэдэгдүүлэхгүй байхыг хичээж байна уу?	0	1
3	Дотоод шаналалтайгаа нүүр тулахаас зайлсхийх, зугатах, биеийн хүч шаардсан үйлдэл илүү хийхийг эрмэлзэж байна уу?	0	1
4	Осол гэмтэлд амархан өртчих гээд байна уу?	0	1
5	Нойр, хоолонд нь өөрчлөлт орж байна уу?	0	1
6	Хүчирхийллийг мартаж чадахгүй, байн байн эргэн санаж, уур уцаартай болж байна уу?	0	1
7	Сэтгэлээр унах, бусдаас хамааралтай болох, хорвоо ертөнцийг сөргөөр хардаг болж байна уу?	0	1
8	Зан ааш нь өөрчлөгдөх, эцэг эх, төрөл садантайгаа харилцах харилцаанд өөрчлөлт орсон уу?	0	1
9	Хүчирхийллийн тухай дурсамжаасаа ангижрахын тулд насанд хүрсэн хүн шиг байхыг хүсэж байна уу? /Гэрлэх, жирэмслэх, сургуулиа хаях, хуучин нөхдөөсөө холбоо таслах гэх мэт/	0	1
10	Өсөж том болохоос айх, гэр бүлийнхнээсээ илүү их анхаарал халамж шаардаж байна уу?	0	1

Тайлбар ба үнэлгээний үр дүн: Оноог доош нэмж, нийт оноог гаргана.

Нийт оноо	Авах арга хэмжээ
1-3	Анхаарал тавь, амраа, 7 хоногийн дараа дахин үнэл
4-6	Тусламж хэрэгтэй, сэтгэл засалч болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс тусламж ав
7-10	Яаралтай тусламж хэрэгтэй, сэтгэл засалч болон сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага, мэргэжилтнээс нэн даруй тусламж ав, цаашдын оношлогоо эмчилгээнд анхаар

Жич: Энэхүү илрүүлэг нь янз бүрийн насны хүүхэд хүчирхийлэлд өртсөний дараах бие болон сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг нь үнэлэх товч үнэлгээ бөгөөд энэ үнэлгээний үр дүн эмнэл зүйн оношид нөлөөлөхгүй байж болно.

ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ИЛРҮҮЛГИЙН АСУУМЖ

Сэтгэл зүйн гэмтэл үүсгэх үйл явдлын улмаас

хүүхдэд учрах хор нөлөөг илрүүлэх асуумж

/CRIES-Children's Impact of Event Scale/

Амьдралд нь стресстэй үйл явдал тохиолдсоны дараа доорх жагсаалтаар үнэлгээ хийнэ. Сүүлийн 2 долоо хоногийн хугацаанд аль хир олон давтамжтай тохиолдож буйгаар нь хариултаа сонгоорой. Зөв, буруу хариулт гэж байхгүй бөгөөд яг өөрийнхөө нөхцөл байдлаар хариулаарай.

Д/д	Сүүлийн 2 долоо хоногт	Ердөө ч үгүй	Ховор хон	Хааяа	Дандаа
1	Энэ тухай дурсаа ч үгүй байхад хар аяндаа бодогдоод байна уу?	0	1	3	5
2	Чи үүнийг ой санамжаасаа бүрмөсөн авч хаяхаар оролддог уу?	0	1	3	5
3	Анхаарал төвлөрөхөд хэцүү болсон уу?	0	1	3	5
4	Энэ тухай мэдрэмж үе үе хүчтэй орж ирдэг үү?	0	1	3	5
5	Энэ явдал тохиолдсоны дараа илүү амархан цочиж, их бухимдаж байна уу?	0	1	3	5
6	Уг явдлыг санагдуулах газар орон, нөхцөл байдлаас зайлсхийж байна уу?	0	1	3	5
7	Энэ талаар ярихгүй байхыг хичээдэг үү?	0	1	3	5
8	Чи энэ талаар өөрийн оюун санаандаа дүрслэн боддог уу?	0	1	3	5
9	Бусад юмс чамайг энэ талаар бодсоор байхад хүргээд байна уу?	0	1	3	5

10	Чи энэ талаар бодохгүй байхыг хичээдэг үү?	0	1	3	5
11	Чи амархан бухимдаж, цухалддаг болсон уу?	0	1	3	5
12	Онцын хэрэгцээгүй үед сэрэмжлээд болгоомжлоод байна уу?	0	1	3	5
13	Нойрны хямрал байна уу ?	0	1	3	5

Үнэлгээ: Сорилыг 8-аас дээш настай, өөрөө уншиж чаддаг хүүхдээс авах бөгөөд тохирох хариултын дагуу оноог сонгоод доош нь нэмж хариуг гаргана. Сорил нь 0-65 хүртэл оноотой байх ба босго оноо 30, оноо өндөр байх тусам сэтгэл зүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг хүнд байна гэсэн үг.

Сэтгэл гутралыг хүүхэд өөрөө үнэлэх нь
/DSRSC-Depression Self Rating Scale for Children/

Чамд илүү сайн туслахын тулд бид өнгөрсөн 7 хоногийн турш чиний сэтгэл санаа, мэдрэмж ямар байсан талаар мэдэх хэрэгтэй байна. Энд зөв, буруу хариулт гэж байхгүй бөгөөд өөрийн нөхцөл байдалд хамгийн ойролцоо хариултаа сонгоно уу.

Д/д	Өнгөрсөн 7 хоногт	Дандаа	Заримдаа	Ердөө ч үгүй
1	Би өмнөх шигээ урагшаа тэмүүлж байхыг хичээж байна	0	1	2
2	Би сайн унтдаг	0	1	2
3	Би үе үе гэнэт уйлмаар санагддаг	2	1	0
4	Би гадаа тоглох дуртай	0	1	2
5	Би ямар нэг юмнаас зугтаад байгаа юм шиг санагддаг	2	1	0
6	Миний гэдэс өвддөг	2	1	0
7	Би их эрч хүчтэй	0	1	2
8	Би хоолондоо дуртай	0	1	2
9	Би өөрийнхөө төлөө бат бөх зогсож чадна	0	1	2
10	Амьдрал утгагүй юм шиг санагддаг	2	1	0
11	Би хийж байгаа зүйлдээ өөрийгөө сайн, чадварлаг гэж боддог	0	1	2
12	Би хийж байгаа зүйлдээ өмнө нь ч, одоо ч сэтгэл хангалуун хэвээр байгаа	0	1	2

13	Би гэр бүлийнхэнтэйгээ ярилцах дуртай	0	1	2
14	Би муухай зүүд зүүдэлдэг	2	1	0
15	Би их ганцаарддаг	2	1	0
16	Миний сэтгэл амархан сэргэдэг	0	1	2
17	Би их уйтгартай байдаг ба өдрийг арай гэж тэсэж өнгөрүүлдэг	2	1	0
18	Би их уйддаг	2	1	0

Үнэлгээ: Сорил нь 8-13 насны хүүхдэд зориулагдсан ба /зарим судлаач нар 8-16 насанд тохиромжтой гэж үздэг/ 18 асуулттай. Тохирох хариултын дагуу оноог сонгон доош нэмж хариуг гаргана. Босго оноо 15. Өндөр оноо сэтгэл гутралыг илтгэнэ, оноо өндөрсөх тусам сэтгэл гутрал төдий чинээ гүнзгий гэсэн үг.

Хүүхдийн сэтгэл түгшилттэй холбоотой эмгэгийг
хүүхэд өөрөө үнэлэх

/SCARED-Screen for Child Anxiety Related Disorders/

Сүүлийн 3 сарын туршид өөрт илэрч байсан нөхцөл байдлаа бодож асуултанд хариулаарай. Энд зөв, буруу хариулт гэж байхгүй.

Д/д	Сүүлийн 3 сард	Ердөө ч үгүй	Заримдаа	Дандаа
1	Айж сандарсан үедээ амьсгалахад хэцүү болдог	0	1	2
2	Сургуульдаа явахаар толгой өвдөөд байдаг	0	1	2
3	Сайн мэдэхгүй хүмүүстэй хамт байх дургүй	0	1	2
4	Гэрээсээ өөр газар хонохоор айдаг	0	1	2
5	Бусад хүмүүс надтай хэт дотно байх вий гэж санаа зовдог	0	1	2
6	Би үхэх вий гэхээс айдаг	0	1	2
7	Би бухимддаг	0	1	2
8	Ээжийгээ юмуу аавыгаа хаа явсан газар нь дагадаг	0	1	2
9	Хүмүүс намайг “Чи бухимдсан харагдаж байна” гэж хэлдэг	0	1	2

10	Сайн мэдэхгүй хүмүүстэй хамт байхаар бухимдаж эхэлдэг	0	1	2
11	Сургууль дээр ходоод өвддөг	0	1	2
12	Айсан үед галзуурах гэж байгаа юм шиг санагддаг	0	1	2
13	Ганцаараа унтахаар санаа зовнидог	0	1	2
14	Бусад хүүхдүүд шиг “Сайн” байх юмсан гэж санаа зовдог	0	1	2
15	Айсан үед юмс бодит биш юм шиг санагддаг	0	1	2
16	Ээж аавд минь муу юм тохиолдож байна гэж хар дарж зүүдэлдэг	0	1	2
17	Сургуульдаа явахаас санаа зовдог	0	1	2
18	Айсан үед зүрх түргэн түргэн цохилдог	0	1	2
19	Би салгалдаг болсон	0	1	2
20	Надад муу юм тохиолдож байна гэж хар дарж зүүдэлдэг	0	1	2
21	Аливаа үйл явдал над руу чиглээд байгаа юм шиг санаа минь зовдог	0	1	2
22	Би айсан үедээ их хөлөрдөг	0	1	2
23	Би ер нь санаа зовомтгой	0	1	2
24	Шалтгаангүйгээр маш их айдаг	0	1	2
25	Би гэртээ ганцаараа байхаас айдаг	0	1	2
26	Сайн мэдэхгүй хүмүүстэй ярилцах хэцүү байдаг	0	1	2
27	Айсан үед миний амьсгал боогддог	0	1	2
28	Хүмүүс намайг хэт их санаа зовох юм гэдэг	0	1	2
29	Би гэр бүлийнхнээсээ хол байх дургүй	0	1	2
30	Сэтгэл түгшилт юмуу сандрах дайрлагад өртөх вий гэж айдаг	0	1	2
31	Эцэг эхэд минь муу юм тохиолдож магад гэж сэтгэл зовдог	0	1	2
32	Сайн мэдэхгүй хүмүүстэй хамт байхаар ичээд байдаг	0	1	2

33	Ирээдүйд юу болох бол гэж санаа зовдог	0	1	2
34	Айсан үед бөөлжих гэж байгаа юм шиг санагддаг	0	1	2
35	Би юмыг аль хир сайн хийж байгаа бол гэж санаа зовдог	0	1	2
36	Сургуульдаа явахаас айдаг	0	1	2
37	Аль хэдийн болоод өнгөрсөн юманд ч санаа зовоод байдаг	0	1	2
38	Айсан үед толгой эргэдэг	0	1	2
39	Би бусад хүүхдүүд болон том хүмүүстэй байхаар бухимддаг бөгөөд, тэд нар намайг хараад байх юм бол ямар нэг юм /чангаар юм унших, ярих, тоглох гэх мэт/ хийх ёстой юм шиг санагддаг	0	1	2
40	Танихгүй хүмүүстэй хамт байх /үдэшлэг бүжиг гэх мэт/ газар очихоор бухимддаг	0	1	2
41	Би ичимхий	0	1	2

Үнэлгээ: Сорил нь 9–18 насныханд тохиромжтой, 41 асуулттай. Нийт оноо ≥ 23 бол сэтгэл түгшилт байна гэж үзнэ. Оноо хэдий чинээ өндөр байна сэтгэл түгшилт төдий чинээ их байна.

Амиа хорлох оролдлогыг илрүүлэх богино хэмжээний сорил

Өнгөрсөн сард чи:		Тийм	Үгүй
1	Сэтгэл зүйн хямралд орсон уу? Үгүй бол 2 бөглөнө үү, тийм бол 1а бөглөнө үү		
1а	Өөрийгөө егүүтгэхээр төлөвлөж байсан уу? Үгүй бол 2 бөглөнө үү, тийм бол 1b бөглөнө үү		
1b	Сэтгэлийн хямралаас болж үхсэн нь дээр гэж санаж байсан уу?		
2	Чи үхсэн нь дээр гэж боддог байсан эсвэл үхэхийг хүсэж байсан уу?	1	0

3	Өөрийгөө егүүтгэх, хор учруулах эсвэл гэмтээхийг хүсэж байсан уу?	2	0
4	Амиа хорлох тухай бодож байсан уу?	6	0

Тийм бол ямар давтамжтай, хэр хүчтэй энэ тухай бодож байсан бэ?			
Давамж	Хүч		
Хааяа нэг <input type="checkbox"/>	Бага <input type="checkbox"/>	Дээрх үйл ажиллагааг өөрийн хяналтанд байлгаж чадах уу?	0
Ойр ойрхон <input type="checkbox"/>	Дунд <input type="checkbox"/>		
Байнга <input type="checkbox"/>	Их <input type="checkbox"/>		

Өнгөрсөн сард чи:			
5	Амиа хорлох төлөвлөгөө байна уу?	8	0
6	Үхэхийн тулд амиа хорлох аргыг сонгож байсан уу?	9	0
7	Өөрийгөө егүүтгэхгүй мөртлөө өөртөө гэмтэл учруулж байсан уу?	4	0
8	Амиа хорлох оролдлого хийж байсан уу? Амьд үлдэж магадгүй гэсэн бодолтой <input type="checkbox"/> Үхнэ гэсэн бодолтой <input type="checkbox"/>	10	0

Чи өөрийнхөө өнгөрсөн амьдралд:			
9	Амиа хорлох оролдлого хийж байсан уу?	4	0
Нэг удаа “Тийм” гэж хариулсан тохиолдолд	Амиа хорлох эрсдэлтэй		
“Тийм” гэж 1-9 асуултанд хариулсан үед	1-8 оноо	Бага	
Амиа хорлолттой холбоотой өөр мэдээллийг бичиж болно	9-16 оноо	Дунд	
	17 болон түүнээс дээш	Өндөр	

Сэтгэл гутралыг илрүүлэх Бекийн сорил

Чи энэ асуултанд өнгөрсөн долоо хоног болон өнөөдрийн байдлаа бодож хариулна уу. Бүлэг бүрт буй 4 хариултын зөвхөн нэгийг сонгоорой.

Д/д	Хариулт	Оноо
1	Би уйтгарладаггүй	0
	Би заримдаа уйтгарладаг	1
	Би дандаа уйтгартай байдаг, тайвширч чаддаггүй	2
	Би маш их уйтгартай, аз жаргалгүй учир би үүнийг тэсвэрлэж чадахгүй байна	3

2	Би ирээдүйгээ өчүүхэн ч муугаар боддоггүй, итгэлтэй байдаг	0
	Би ирээдүйдээ сэтгэл зовнидог	1
	Би ирээдүйдээ урагшаа тэмүүлэх зүйл юу ч мэдэрдэггүй	2
3	Би ирээдүйдээ итгэлгүй, юу ч дээрдэж чадахгүй гэж боддог	3
	Би өөрийгөө бүтэлгүй хүн гэж боддоггүй	0
	Надад бусад хүмүүсээс илүү бүтэлгүй зүйл тохиолддог гэж боддог	1
	Би өөрийнхөө амьдралыг эргэж харахад бүтэлгүй зүйл маш их байсан	2
4	Би өөрийгөө бүтэлгүй хүн гэж боддог	3
	Би өөрийнхөө хийж буй зүйлд маш их сэтгэл хангалуун байдаг	0
	Би өөрийнхөө хийж буй зүйлд сэтгэл хангалуун байдаггүй	1
	Би юунаас ч жинхэнэ сэтгэл ханамжийг авч чаддаггүй	2
5	Бүх юманд сэтгэл ханамжгүй, уйтгартай, залхмаар байна	3
	Би өөрийгөө ямар нэгэн юманд өчүүхэн ч буруутай гэж боддоггүй	0
	Би өөрийгөө зарим нэгэн юманд буруутай гэж боддог	1
	Би өөрийгөө ихэнх юманд буруутай гэж боддог	2
6	Би өөрийгөө бүх л юманд буруутай гэж боддог	3
	Би өөрийгөө шийтгэгдэх ёстой гэж боддоггүй	0
	Би өөрийгөө шийтгэгдэж болох юм гэж боддог	1
	Би өөрийгөө шийтгэгдэнэ гэж боддог	2
7	Би өөрийгөө шийтгэгдэж байгаа гэж боддог	3
	Би өөртөө сэтгэл гонсгор байдаггүй	0
	Би өөртөө сэтгэл дундуур байдаг	1
	Би өөрийгөө жигшдэг	2
8	Би өөрийгөө үзэн яддаг	3
	Би өөрийгөө бусдаас муу хүн гэж боддоггүй	0
	Би өөрийнхөө сул тал, алдаандаа шүүмжлэлтэй ханддаг	1
	Би өөрийнхөө бүх алдааг буруушаадаг	2
9	Муу юм тохиолдох болгонд өөрийгөө буруушаадаг	3
	Би өөрийнхөө амийг хорлох тухай боддоггүй	0
	Би өөрийнхөө амийг хорлох тухай боддог ч, би үүнийг хийж чадахгүй	1
	Би амиа хорломоор санагддаг	2
	Би боломж олдвол амиа хорлоно	3

10	Би урьдынхаасаа илүү уйлаагүй	0
	Би урьдынхаасаа их уйлдаг болж байна	1
	Би сүүлийн үед байнга уйлдаг болоод байна	2
	Би уйлахыг хүсэж байсан ч уйлж чадахгүй байна	3
11	Би урьдынхаасаа илүү уурлаж бухимдахгүй байна	0
	Би урьдынхаасаа илүү уурлаж, бухимддаг болоод байна	1
	Уурлаж бухимдах юм гараагүй байхад ч би уурлаж бухимдаад байна	2
	Би байнга уурлаж, бухимдаж байна	3
12	Бусад хүмүүсийг сонирхох сонирхол хэвээрээ байна	0
	Бусад хүмүүсийг сонирхох сонирхол бага зэрэг буурсан	1
	Бусад хүмүүсийг сонирхох сонирхол нилээд буурсан	2
	Бусад хүмүүсийг сонирхохоо бүр болисон	3
13	Би урьдынх шигээ шийдвэр гаргаж чадаж байна	0
	Би шийдвэр гаргахаас зайлсхийдэг болоод байна	1
	Урьдынх шигээ шийдвэр гаргахад маш хэцүү болоод байна	2
	Би шийдвэр гаргаж чадахгүй байна	3
14	Би өөрийгөө урьдынхаасаа царай муутай болоод байна гэж боддоггүй	0
	Би царай муутай, хөгшин харагдаж байна гэж санаа зовдог	1
	Миний гадаад төрх эргэшгүйгээр өөрчлөгдөж энэ нь муухай харагдуулдаг	2
	Би муухай харагдаж байна гэдэгтээ итгэлтэй байна	3
15	Би урьдынх шигээ сайн ажиллаж чадаж байгаа	0
	Ямар нэг юм хийж эхлэхэд илүү их чармайлт гаргах болсон	1
	Би ямар нэг юм хийхэд маш их хүч, чармайлт гаргах болсон	2
	Би ямар ч ажил хийж чадахаа болиод байна	3
16	Би ердийнх шигээ сайн унтаж чадаж байна	0
	Би ердийнх шигээ сайн унтаж чадахгүй байна	1
	Би ердийнхөөсөө 1-2 цагийн өмнө сэрээд, эргэн унтахад бэрхшээлтэй болоод байна	2
	Би ердийнхөөсөө хэдэн цагийн өмнө сэрээд эргэн унтаж чадахгүй байна	3

17	Би урьдынхаасаа илүү ядрахгүй байна	0
	Би урьдынхаасаа илүү амархан ядардаг болоод байна	1
	Бараг юм хийхгүй байгаа мөртлөө ядардаг болоод байна	2
	Би маш их ядардаг болоод байна	3
18	Миний хоолны дуршил сайн байгаа	0
	Миний хоолны дуршил урьдынхаасаа буурч байна	1
	Миний хоолны дуршил маш муу байна	2
	Би хоол идэх ямар ч хүсэлгүй болсон	3
19	Миний биеийн жин хэвийн байгаа	0
	Би 2 кг-аас илүү турсан	1
	Би 5 кг-аас илүү турсан	2
	Би 7 кг-аас илүү турсан	3
20	Би эрүүл мэнддээ санаа зовохгүй байгаа	0
	Би эрүүл мэнддээ санаа зовж байна. /Надад ходоод гэдэсний зовиур, батга гарах, өтгөн хатах зэрэг асуудал байна./	1
	Би эрүүл мэнддээ маш их санаа зовж байгаа тул өөр юм бодоход хэцүү байна	2
	Би эрүүл мэнддээ маш их санаа зовж байгаа тул өөр юм бодож чадахгүй байна	3
21	Миний бэлгийн дур өөрчлөгдсөн гэж бодохгүй байна	0
	Миний бэлгийн дур хүсэл урьдахаасаа багассан	1
	Миний бэлгийн дур хүсэл маш бага болсон	2
	Миний бэлгийн дур хүсэл огт байхгүй болсон	3

Үнэлгээ:

- 0-10 оноо Сэтгэл гутрал үгүй
- 11-17 оноо Хөнгөн сэтгэл гутралтай
- 18-23 оноо Дунд зэргийн сэтгэл гутралтай
- 24-дээш оноотой бол Гүнзгий сэтгэл гутралтай

Амиа хорлох бодол, хандлага, оролдлого, үйлдэл, зан үйл цухалзсан, илэрсэн л бол нэн даруй бөгөөд заавал сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчилнэ.

Эмнэлгийн мэргэжилтэн эсвэл хохирогч өөртөө тохиолдож болох эрсдэлийг үнэлэх асуумж

Энэхүү асуумж нь тохиолдож болох эрсдэлийг илрүүлнэ. Доорх асуулт бүрт “Тийм”, “Үгүй” хариултыг сонгон тэмдэглэнэ үү. /Тэр гэдэгт таны найз залуу, хойд эцэг, эсвэл таны биеийг гэмтээж буй хэн нэгэн хамаатай/.

Д/д	Асуултууд	Тийм	Үгүй
1	Өнгөрсөн жилүүдийн хугацаанд хүчирхийллийн давтамж ихэссэн үү?		
2	Тэр чиний эсрэг зэвсэг хэрэглэж байсан уу эсвэл зэвсэг ашиглан заналхийлж байсан уу?		
3	Тэр хоолойг чинь боодог уу?		
4	Тэр гар буутай юу?		
5	Тэр чамайг хүсэхгүй байхад хүчээр бэлгийн харилцаанд орохыг оролдож байсан уу?		
6	Тэр эм хэрэглэдэг үү? /Эм гэдэгт сэтгэл хөөрлийн, нойрны эм, нунтаг, мансууруулах бодис/		
7	Тэр чамайг ална гэж сүрдүүлдэг үү? Эсвэл тэр чамайг алах боломжтой гэдэгт чи итгэдэг үү?		
8	Тэр өдрийн цагаар архи уусан байдаг уу?		
9	Тэр чиний өдөр тутмын ихэнх үйл ажиллагааг хянадаг уу? Хэнтэй найз болж болохыг, дэлгүүр явах үед хэр хэмжээний мөнгө авч явах эсвэл хэзээ гадуур явахыг чинь хэлдэг үү? /Тэр тэгэхийг хичээдэг ч, чи тэрүүгээр хянуулдаггүй бол энд тэмдэглэнэ үү/		
10	Чи жирэмсэн байх үедээ түүнд цохиулж байсан уу? /Хэрвээ түүнээс жирэмсэн болж байгаагүй бол энд тэмдэглэнэ үү/		
11	Тэр чамайг харддаг уу? /Хэрвээ би чамтай байж чадахгүй бол өөр хэнтэй ч байж чадахгүй гэж хэлэх/		
12	Чи амиа хорлохыг завдаж, айлган сүрдүүлж байсан уу?		
13	Тэр амиа хорлохыг завдаж, айлган сүрдүүлж байсан уу?		
14	Тэр чиний дүүг, ээжийг... гэмтээнэ гэж заналхийлж байсан уу?		
15	Тэр ажил хийдэггүй юу?		

16	Өнгөрсөн жилийн хугацаанд чи түүнийг орхиж явсан уу? /Хэрвээ түүнтэй огт хамт байгаагүй бол энд тэмдэглэнэ үү/		
18	Тэр чамайг дагах болон мөрддөг эсэх, айлган сүрдүүлсэн зурвас үлдээсэн эсэх, чиний эд зүйлсийг эвдэн сүйтгэдэг эсэх, чамайг хүсэхгүй байх үед дууддаг эсэх		

Үнэлгээ:

“Тийм” гэж хариулсан асуулт бүрийн тоогоор эрсдэлийн тоо тодорхойлогдоно. Олон асуултанд “Тийм” гэж хариулах нь эрсдэл өндөр байгааг илтгэнэ.

НОМ ЗҮЙ

1. <https://www.legalinfo.mn/annex/details/6084?lawid=9583>
2. Guide for Post-disaster Psychological Crisis Intervention Operation Manual and Supporting Toolkits 2013
3. Communication Skills and Cut-in Techniques Psychological Crisis Intervention Operation Manual and Supporting Toolkits 2013
4. Volunteer Management and Training-Psychological Crisis Intervention Operation Manual and Supporting Toolkits 2013
5. Assessment of Psychological Status-Psychological Crisis Intervention Operation Manual and Supporting Toolkits 2013
6. Psychological Support for the Victims-Psychological Crisis Intervention Operation Manual and Supporting Toolkits 2013
7. Psychological Support for Children, Adolescents and Caregivers-Psychological Crisis Intervention Operation Manual and Supporting Toolkits 2013
8. Дэмжих бүлгийн үйл ажиллагаа зохион байгуулах арга зүйн гарын авлага. Улаанбаатар 2010 он.
9. Rozen, Barkins. -5-minute emergency medicine consult Psychobehavioral Emergencies. 2007; x. 83-85
10. Clinical Management of Rape Survivors
11. Medical Protocol/Guidelines for Management of Victims of Gender Based Violence /including sexual violence/. WHO 2014
12. Guidelines for medico-legal care for victims of sexual violence. World Health Organization 2003
13. Health care for women subjected to intimate partner violence or sexual violence, A clinical handbook. 2014

III БҮЛЭГ

ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ НАСАНД ХҮРЭГЧДЭД СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ

3.1 СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

Хэн нэгэн хүчирхийлэлд өртөхөд тухайн нутаг дэвсгэрт тусламж үйлчилгээг чанартай түвшинд хүргэх мэргэжлийн зохицуулга шаардагддаг. Тухайн орчин нөхцөлд ажиллаж байгаа сэтгэл зүйн тусламж үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн чанарын шаардлага хангахуйц үйлчилгээ үзүүлэхийн тулд мэргэжил, арга зүйгээр хангагдсан байх шаардлагатай.

Сэтгэл зүйн зөвлөгөө

Хүчирхийлэлд өртсөн насанд хүрэгчдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх нь хүчирхийллээс үүдэлтэй бие махбод, сэтгэл хөдлөл, нийгэм, оюун санааны болон танин мэдэхүйн хариу урвалыг даван туулахад нь туслах зорилготой сэтгэл зүйн эмчилгээний нэг хэлбэр юм.

Хүчирхийлэлд өртсөн хүнд тохиолдох мэдрэмжийн нэг нь *гашуудлын мэдрэмж* юм. Уй гашууг алхам алхамаар тайлдаг бөгөөд сэтгэл зүйн гэмтлийн шалтгаантай үүссэн тайлж чадаагүй стрессийг даван туулахад туслах хэрэгтэй. Гашуудал нь 4 төрлөөр илэрдэг:

- **Сэтгэл хөдлөлийн хариу урвал:** Уй гашуу, уур уцаар, өөрийгөө буруутгах, түгшүүрлэх, ганцаардах, уйлах, өөрийгөө тусламжгүй үлдсэн гэж мэдрэх, айдас, үгүйсгэл, уйтгарлах
- **Зан үйлийн хариу урвал:** Хоолноос татгалзах, юмнаас зугатаах, хар дарж зүүдлэх, хэт их ачаалалттай ажиллах, ганцаараа үлдэхээс зайлсхийх
- **Физиологийн урвал:** Нойр хямрах, хоолой сөөх, амьсгал давчдах, ядрах, сульдах
- **Танин мэдэхүйн хариу урвал:** Үгүйсгэл, улигт бодолд автагдах, бодит байдлыг ухаарахгүй байх

Зөвлөгөөний зорилго

- Уй гашууг даван туулж өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн үргэлжлэхэд туслах
- Мэдрэмжээ илэрхийлэхэд туслах
- Амьдралын зорилгыг шинээр тодорхойлох

Зөвлөгчийн анхаарах зүйлс

- Амиа хорлолтоос сэргийлэх
- Үе шаттайгаар зөвлөгөөг өгөх
- Хавсарсан эмгэг илэрсэн тохиолдолд эмчилгээний асуудлыг шийдвэрлэх

Хүчирхийлэлд өртсөн насанд хүрэгчдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн үйлчилгээ үзүүлэхдээ мөрдөн ажиллах ёс зүйн дүрэм, тавигдах шаардлагыг II бүлгээс харна уу.

Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ эмнэлзүйн харилцаан дээр тулгуурлан ажиллах ёстой байдаг.


3.2 ЭМНЭЛЗҮЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Эрүүл мэндийн тусламж үзүүлэгч болох эмч, эмнэлгийн мэргэжилтэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авагч болох үйлчлүүлэгч хоёрын хоорондын харилцааг эмнэлзүйн харилцаа гэж нэрлэдэг. Эмнэлгийн мэргэжилтний тоонд эмч, сувилагч, эмнэлзүйн сэтгэл зүйч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан болон эрүүл мэндийн тусламж үзүүлж байгаа эмнэлгийн бусад хүмүүс хамаарагддаг.


Эмнэлзүйн харилцааны загвар

- Эмнэлзүйн харилцаанд дараах загваруудыг баримталдаг.
- Харилцааны шугаман загвар
- Эцгийн эрхт ёсны харилцаа
- Харилцааны эргэлтийн загвар
- Харилцааны түншлэлийн загвар
- Гэрээ байгуулж харилцах загвар
- Харилцааны нөхөрлөлийн загвар
- Үйлчлүүлэгч төвтэй харилцааны загвар

Харилцааны шугаман загвар



Эмнэлзүйн харилцаанд оролцож байгаа хор талын хэн нэг, тухайлбал эмнэлгийн ажилтан ноёрхож өөрийн үзэл бодлыг нөгөөдөө буюу үйлчлүүлэгчид тулган хүлээлгэдэг, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн асуудлыг харилцан ойлголцож шийдвэр гаргадаггүй, үйлчлэгч нь үйлчлүүлэгчээсээ зөвшөөрөл авалгүй, түүний хүсэлтийг харгалзан үзэлгүй, түүнтэй тохиролцолгүй, дур зоргоороо эмчилгээ үйлчилгээний заалт гаргах буюу үйлдэл хийдэг, шийдвэр гаргах эрх нь зөвхөн үйлчлүүлэгч хүнд байсаар атал түүний өмнөөс ямар нэг шийдвэр гаргадаг, харилцааны эргэх холбоогүй, нэг чиглэлийн урсгалтай, тэгш бус эрхтэй, ардчилсан бус шинж чанартай, хүнд суртлын харилцааг харилцааны шугаман загвар гэдэг.



Эмнэлзүйн харилцаанд үйлчлэгч, үйлчлүүлэгч хоёр тэнцүү эрхтэй оролцдог, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн асуудлыг харилцан ойлголцож шийдвэр гаргадаг, үйлчлэгчийн санал болгосон эмчилгээ буюу бусад зүйлийг хэрэгжүүлэх эсэх талаар үйлчлүүлэгч өөрөө шийдвэр гаргадаг, үйлчлэгч үйлчлүүлэгч хоёр бие биедээ үзэл бодлоо тулган хүлээлгэдэггүй, харилцан бие биенээ хүндэтгэдэг, харилцааны эргэх холбоотой, хоёр чиглэлийн урсгалтай, ардчилсан шинж чанартай харилцааг харилцааны шугаман загвар гэж нэрлэдэг.

Харилцааны түншлэлийн загвар

Эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч хоёр хоршин ажиллах харилцааны зарчим дээр тулгуурласан эмнэлзүйн харилцаа юм. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг зохистой шийдвэрлэх зорилгоор харилцагч хоёр тал болох эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч нар хоршин идэвхтэй үйл ажиллагаа явуулна. Харилцагч хоёр тал үйл ажиллагаанд хоршин оролцохдоо харилцан ойлголцох, зөвшилцөж шийдвэр гаргах, бие биенээ хүндэтгэх, бие биенийхээ биеэ даасан байдлыг хүндэтгэх, нууц хадгалах зэрэг ёс зүйн болон харилцааны нийтлэг зарчмыг хатуу баримтална.

Гэрээ байгуулж харилцах загвар

Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг зохистой шийдвэрлэх зорилгоор тохиролцогч талууд болох эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч хоёр харилцан үүрэг хүлээж гэрээ байгуулж ажиллана.

Тохиролцогч хоёр тал үйл ажиллагаанд оролцохдоо бие биедээ итгэх, бие даасан байдлыг хүндэтгэх, нууцыг чандлан сахих зэрэг ёс зүйн зарчмыг хатуу баримтална.

Гэрээ байгуулж харилцах загварыг сэтгэл засал эмчилгээнд өргөн ашигладаг.

Харилцааны нөхөрлөлийн загвар

Энэ бол нөхөр журмын харилцааны хувилбар бөгөөд харилцааны эргэлтийн зааврын нэг хэлбэр юм. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг зохистой шийдвэрлэх зорилгоор харилцагч хоёр тал эмнэлзүйн харилцаанд тэнцүү эрхтэй оролцоно. Энэ загварыг бүлгийн сэтгэл засал, мэдрэмж нээх сэтгэл засал зэрэг үйл ажиллагаанд өргөн хэрэглэдэг.

Үйлчлүүлэгч төвтэй харилцааны загвар

Энэ бол үйлчлүүлэгчийг дээдлэх харилцаа юм. Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг зохистой шийдвэрлэх зорилгоор эмнэлзүйн харилцаанд оролцогч хоёр тал харилцан ойлголцох зарчмыг баримтална. Шийдвэрийг үйлчлүүлэгч өөрөө гаргана. Үйлчлэгч ямар үйлчилгээ, ямар үйлдэл хийх талаар саналаа хэлнэ. Тухайн үйлдлийг зөвхөн үйлчлүүлэгч өөрөө гаргана. Үйлчлүүлэгч төвтэй харилцааны загварын нэг хувилбар

бол үйлчлүүлэгчээс таниулсан зөвшөөрөл авах харилцаа юм. Үйлчлүүлэгч төвтэй харилцааны өөр нэг харилцааны хувилбар бол “Рожерсийн үйлчлүүлэгч төвтэй сэтгэл засал” юм.

Рожерсийн үйлчлүүлэгч төвтэй сэтгэл засал

Үйлчлүүлэгчийн буюу өвчтөний сэтгэлийг засахдаа эмч дараах гурван зарчмыг баримталж харилцана.

- Үйлчлүүлэгчийн байдлыг сэтгэл зүрхээрээ мэдэрч харилцах
- Үйлчлүүлэгчийн талд орж түүний байдлыг үнэлж харилцах
- Үйлчлүүлэгч өөрийгөө буюу өөрийнхөө байдлыг илэрхийлэхдээ үгсийн харилцаагаар биш, харин бэлэг тэмдгээр, дохионы хэлээр, далд утгаар илэрхийлж харьцахыг хүлээн зөвшөөрөх

Эмч, үйлчлүүлэгч хоёрын эмнэлзүйн харилцаа

Эмч, үйлчлүүлэгч хоёрын эмнэлзүйн харилцаа бол мэдээ, эргэх холбоо, эмнэлзүйн харилцааны хэл, эмнэлзүйн ярилцлага, анамнез цуглуулах зэрэг зүйлийг багтаасан өвөрмөц харилцаа юм.

Мэдээ

Үйлчлүүлэгч ихэнх тохиолдолд зовиур шаналгаа, эрүүл мэндийн тулгамдсан асуудлаа буюу өвчин эмгэгтэй холбоотой бусад зүйлийг мэдээлнэ.

Эргэх холбоо

Эмнэлзүйн харилцааны явцад ялангуяа ярилцлагын төгсгөлд эмч, үйлчлүүлэгчийн зовиур шаналгаа, эрэлт хүсэлт буюу түүний эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг хэрхэн хүлээж авч, ямар онош тавьж, ямар шинжилгээ хийлгэх, ямар эмчилгээ хийлгэх шаардлагатай байгаа зэрэг зүйлийг эргэх холбоогоор дамжуулж мэдээлнэ.

Тэрчлэн ярилцлага өгөгчийн анхаарал төвлөрүүлэх, хариулт сэдвээсээ хазайхад саад тавих, ярилцлагын сэдэлтийг идэвхжүүлэх, ярилцлагыг өөрийн хяналтанд барих зэрэг олон зорилтын үүднээс эргэх холбоо тогтоож болно.

Яаж эргэх холбоо тогтоох вэ? Асуулт тавих, хариу мэдээлэл өгөх зэрэг олон аргаар эргэх холбоо тогтоож болно. Ямар зорилтын үүднээс эргэх холбоо тогтоох гэж байна вэ гэдгээс хамааран тавих асуулт янз үр байдаг. Жишээ нь: Хариулт сэдвээсээ хазайхад саад тавих зорилтын үүднээс дараах асуултыг тавьдаг. Үүнд:

- Надад өөр асуулт байна. Эхлээд хоёулаа энэ талаар ярилцах уу?
- Хэрэв та одоо ярьж байгаа зүйлийнхээ талаар дэлгэрэнгүй ярих хүсэлтэй байгаа бол энэ ярилцлагын дараа дуртайяа сонсох болно.

Богино, урт гэсэн хоёр хэлбэрийн эргэх холбоо байна.

Богино эргэх холбоо

Хаалттай асуулт тавих үед голдуу богино эргэх холбоо тогтоодог. Хаалттай асуултанд өгөх ярилцлага өгөгчийн хариултыг хүндэтгэж богино эргэх

холбоо тогтоож болно. Богино эргэх холбоо тогтооход дараах үг хэллэгийг олонтоо хэрэглэдэг. Үүнд: “Баярлалаа”, “Би ойлгож байна”.

Урт эргэх холбоо

Нээлттэй асуулт тавигдах үед ярилцлага өгөгчийн анхаарлын төвлөрөлтийг ихэсгэх, ярилцлагын сэдэлтийг улам ихэсгэх зэрэг зорилтын үүднээс урт эргэх холбоо тогтоож болно. Урт эргэх холбооны жишээ өгүүлбэрүүд: “Энэ хэрэгтэй мэдээ байна”, “Та надад үүнийг тэмдэглэж авахыг зөвшөөрнө үү”.

Эмнэлзүйн харилцааны ангилал

Эмнэлзүйн харилцааны хэл, хэлбэр, илрэл ба суваг гэсэн ойлголтууд бий. Үүнийг харгалзан эмнэлзүйн харилцааг дараах хэлбэр, төрлүүдэд хуваадаг. Үүнд:

Эмнэлзүйн харилцааны хэл

Үйлчлүүлэгч мэдээг эмнэлзүйн харилцааны ямар хэлээр дамжуулж байгааг харгалзан үгсийн хэл, үгсийн бус хэл гэж хуваан авч үздэг.

Эмнэлзүйн харилцааны хэлбэр

Үгсийн харилцаа, үгсийн бус харилцаа гэсэн хоёр хэлбэртэй байдаг.

Мэдээний илрэл

Үйлчлүүлэгч мэдээгээ үгээр дамжуулж болно, бас дохиогоор илэрхийлж болно. Үүнийг харгалзан мэдээний илрэлийг үгсийн мэдээ, үгсийн бус мэдээ гэж 2 төрөлд хуваадаг. Үгсийн мэдээг дотор нь:

- Амаар хэлэх мэдээ
- Бичгээр өгүүлэх мэдээ гэж хуваана.

Мэдээний суваг

Үйлчлүүлэгчийн мэдээг дамжуулж байгаа сувгийг харгалзан үгсийн суваг, үгсийн бус суваг гэж 2 сувагт хуваадаг.

Эмнэлзүйн харилцааны хэл

Хэл бол харилцааны хэрэгсэл юм. Үйлчлүүлэгчийн мэдээ, мэдээллийг дамжуулж байгаа арга хэрэгслийг эмнэлзүйн харилцааны хэл гэдэг. Үйлчлүүлэгч зовиур шаналгаа, эрүүл мэндийн тулгамдсан асуудал, өвчинтэй холбоотой үүсэж байгаа бодол санаа сэрэл мэдрэмж, сэтгэл хөдлөлөө болон бусад асуудлаа харилцааны хэрэгслээр дамжуулан мэдээлдэг буюу илэрхийлдэг. Шинж тэмдгүүдийг мэдээлдэг, дамжуулдаг, илэрхийлдэг болон зуучилдаг эмнэлзүйн дараах 5 хэл бий.

1. Үйлдэл хөдөлгөөний хэл
2. Биеийн хэл
3. Тэмдгийн хэл
4. Объектийн хэл
5. Үгсийн хэл

Дээр дурдсан эмнэлзүйн 5 хэлбэрүүдээс эхний 4 хэлийг хураангуйлан биеийн хэл /Body language/ буюу үгсийн бус хэл гэж нэрлэдэг. Үйлчлүүлэгч зовиур шаналал, тулгамдсан асуудлаа хөдөлгөөнөөр, тэмдгийн хэлээр,

объектийн хэлээр болон “автомат” мэдрэлээр дамжуулж илэрхийлдэг. Ийм хэлийг биеийн хэл гэдэг.

Үйлдэл хөдөлгөөний хэл /Action Language/

Үйлчлүүлэгчийн нүүрний хөдөлгөөний илрэл, бие, гарын хөдөлгөөн, дохио зангаа, нүдний хөдөлгөөн буюу харц, дууны өнгө зэрэг үйлдэл хөдөлгөөнүүд тухайн хүний дотоод шинжийг мэдээлдэг дохионы хэл юм. Эдгээр мэдээ дохиог төв мэдрэлийн систем /TMC/ дамжуулдаг. Ийм хөдөлгөөний хэлийг зуучлагч нь TMC юм. Өөрөөр хэлбэл төв мэдрэлийн системийн дамжуулж буюу зуучилж байгаа хөдөлгөөний дохиог хөдөлгөөний хэл гэдэг.

Биеийн хэл /Somatic Language/

Вегетатив мэдрэлийн хөөрлийн үед үйлчлүүлэгчийн гар салганан чирэх, санаа алдах, нүүр цайх буюу улайх, алга хөлрөх, хүүхэн хараа өргөсөх буюу нарийсах зэрэг маш олон тооны эмнэлзүйн дохио үйлчлүүлэгчийн бие махбод, дотор эрхтнүүдийн талаас илэрдэг. Эдгээр дохионуудыг автомат мэдрэлийн тогтолцоо дамжуулдаг.

Тэмдгийн хэл /Sign Language/

Бусдын яриаг ойлгодог боловч өөрийн зовиур шаналгаа, эрүүл мэндийн тулгамдсан асуудал, бодол санааг гадагш, бусад хүмүүст үгээр илэрхийлж чаддаггүй хүмүүс байдаг. Ийм хүмүүст “Хаалттай асуулт” тавьж нүдээр нь буюу бэлэг тэмдгийн хэлээр дамжуулж мэдээг хүлээж авч болно.

Объектийн хэл /Object Language/

Зарим үйлчлүүлэгчийн хэрэглэж байгаа зүйлс, биедээ авч яваа эд юмс, шивсэн хээ буюу бусад зүйлс тэдний талаар тодорхой мэдээнүүдийг дамжуулж болно. Ийм дохиог объектийн хэл гэдэг.

Эмнэлзүйн харилцааны үгсийн бус мэдээ /Nonverbal clinical message/

Ийм мэдээг үгсийн бус хэл болох дохио буюу биеийн хэл дамжуулна. Дараах хэлбэрүүдээр илэрдэг.

- Нүүрний хөдөлгөөний илрэл /Facial expression/
- Дохио зангаа /Gestures/
- Биеийн хөдөлгөөн /Body movements/
- Гарын дохио /Hand gesture/
- Нүдний хөдөлгөөн /Eye movement/
- Биеийн хэл /Somatic language/
- Дууны дохио /Vocal cues/
- Бусад дохио

Эмнэлзүйн үгсийн бус мэдээ нь үйлчлүүлэгчийн сэтгэлийн хөдөлгөөн, үйл хөдлөлийг танин мэдэхэд ач холбогдолтой мэдээллийг эмчид дамжуулдаг. Зарим үйлчлүүлэгч тулгамдсан асуудлаа үгээр илэрхийлэхээс татгалзаж, ярьдаггүй. Жишээ нь: Айж түгшиж, ичиж зовж байгаа үйлчлүүлэгч энэхүү зовиур шаналгаагаа үгээр илэрхийлж ярихгүй байгаа атлаа гар нь салганан чичирдэг.

Эмнэлзүйн үгсийн бус харилцаа /Nonverbal clinical communication/

Судалгаануудаас харахад хүмүүсийн хоорондын харилцааны 80% нь үгээр илэрхийлэгддэггүй. Эмч тухайн хүнийхээ нүүр царайны илэрхийлэл, дууны өнгө, биеийн хэл, дохио зангаа зэргийг сайн ойлгож анзаарах хэрэгтэй. Үйлчлүүлэгчтэй нүдээрээ, харцаараа харилцаа тогтоох аргууд болон түүнд өөрийгөө илэрхийлэх итгэлтэй байдлыг үүсгэх, үр дүнтэй сонсох, итгэлтэй уур амьсгал үүсгэх, эмпатитай хандах талаар II бүлгээс харна уу.

3.3 ЭМНЭЛЗҮЙН ЯРИЛЦЛАГА АВАХ АРГА ТЕХНИК

Эмнэлзүйн ярилцлага /The clinical interview/

Тодорхойлолт: Үйлчлүүлэгчээр түүний тулгамдсан асуудлыг амаар нь хэлүүлэх ярилцлагыг эмнэлзүйн ярилцлага гэнэ.

Ярилцлага авахын гол зорилго болон зорилт

Дараах зорилго болон зорилтуудыг дэвшүүлнэ.

1. Онош тогтоох
2. Ярилцлага өгөгчийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг тогтоох
3. Зохих зөвлөгөө өгөх
4. Шаардлагатай эмчилгээний заалт гаргах
5. Ярилцлага өгөгчийн сэтгэлийг ариусгах буюу сэтгэлийн дарамтаас чөлөөлөх

Эмнэлзүйн ярилцлага авах арга техник

Эмнэлзүйн ярилцлага дараах 3 үе шатыг дамжин явагдана.

1. Танилцах үе шат
2. Гол үе шат
3. Төгсгөлийн үе шат

Эмнэлзүйн ярилцлагын нэгдүгээр үе шат буюу танилцах үе шат

Үүнийг өөрөөр сэтгэл зүйн бэлтгэл хийх үе шат гэдэг. Энэ шатанд дараах 5 үйл ажиллагаа явуулна.

1. Ярилцлага авагч /эмч/ өөрийгөө танилцуулж мэндлэх
2. Ярилцлага өгөгч өөрийгөө танилцуулах
3. Суудал эзлэх
4. Ярилцлагын зорилгыг танилцуулах. Танд тулгамдаад байгаа асуудлыг тантай бас гэр бүлтэй хамтран зохистой шийдвэрлэх нэгэн зорилтын үүднээс бид ярилцах гэсэн юм. Иймд харилцан ойлголцож ярилцахыг хоёр талаас хичээе гэсэн утгатай үг хэлнэ.
5. Ярилцлагын талаар үйлчлүүлэгчид дараах зөвлөгөө, санамж өгнө. Үүнд: Би танд туслах гэсэн юм. Та надад итгээрэй. Би нууцыг хадгалж чадна. Ярилцлагын явцад айж, ичиж, эмээж, биеэ барих хэрэггүй. Аль болохуйц тайван сууж, биеэ барилгүйгээр чөлөөтэй ярилцахыг хичээгээрэй гэсэн зөвлөгөө өгнө.

Суудал: Эмч дараах хоёр суудлын аль нэгийг нь эзэлж сууна.

Эмч үйлчлүүлэгчийн орны дэргэд суух. Дараах журмыг баримтална.

- Эмч үйлчлүүлэгчийн баруун гар талд сууна.
- Эмч үйлчлүүлэгчээс 1 метр зайд сууна.
- Эмч үйлчлүүлэгч хоёрын харц дээр, доор биш, нэг ижил түвшинд байхаар суудалд /Сандалд/ эмч сууна.
- Дээр тодорхойлсон дүр төрхөөр эмч сууж, үйлчлүүлэгч орондоо хэвтэж байх нь эмчид түүнийг ажиглах, үйлчлүүлэгч эмчээс харцаа төвөггүй холдуулах боломжийг олгоно.
- Эмч үйлчлүүлэгчийн дэргэд тэмдэглэл хөтөлнө. Эмч зогсож ярилцлага авахад дараах 3 алдаа ажиглагдана:
 - Эмч үйлчлүүлэгчээс дэндүү хол зайд байдаг.
 - Эмч үйлчлүүлэгч хоёр нүүр нүүр рүүгээ, өөд өөдөөс харц тулж харилцдаг.
 - Эмч доошоо үйлчлүүлэгч рүү тонгойж ярьдаг.

Эмч бичгийн ширээний ар талд суух суудал.

Эмч ихэнх үйлчлүүлэгчтэй бичгийн ширээний ар талд сууж эмнэлзүйн ярилцлага авдаг. Дараах журмыг баримтална.

1. Ярилцлагын үед үйлчлүүлэгчийн яриаг тэмдэглэж хөтлөх боломжтой байхаар бичгийн ширээний ар талд сууна.
2. Үйлчлүүлэгчийн яриаг хожим тэмдэглэхээр цээжлэх буюу тогтоох оролдлого хийх хэрэггүй. Хожим тэмдэглэл хөтлөх нь хоёр асуудалд хүргэнэ.
 - Цаг алдана.
 - Үйлчлүүлэгчийн яриаг яг зөв тусгаж чадахгүй.
3. Тэмдэглэж байгаа зүйлд үйлчлүүлэгчийн анхаарлыг татахгүй байхын тулд хэрэвзээ эмч баруун гараар бичдэг бол түүнийг зүүн гар талдаа ширээний тайрдас талд суулгана.
4. Дээр дурдсан суудал албадмал бус уур амьсгалыг бүрдүүлэхийн сацуу үйлчлүүлэгчийг чөлөөтэй ажиглах, үүнтэй нэгэн зэрэг тэмдэглэл хөтлөх боломжийг олгоно.

Эмнэлзүйн ярилцлагын хоёрдугаар үе шат буюу гол үе шат

Энэ үе шатанд дараах үйл ажиллагааг явуулна.

1. “Нээлттэй асуулт”, “Тодруулах асуулт”, “Хаалттай асуулт” зэрэг асуултанд хариулт авах, үгсийн бус дохиог ажиглах, асуулгын хуудас таглуулах зэрэг хэлбэрээр ярилцлагыг явуулна.
2. Эмнэлзүйн ярилцлагыг эхлэх олон хувилбарын асуулт бий.
 - “Бид юунаас эхэлж ярилцах вэ?”
 - “Та юунаас эхэлж ярилцмаар байна вэ?” гэсэн асуултыг тавина.
3. Мэдээлж байгаа мэдээнүүдийг нээлттэй асуултаар тодруулж асуух.

/Үгээр илэрхийлж буй зовиур шаналгааг тодруулан асуух/

4. Үйлчлүүлэгчийн мэдээлж буй бүх сувгуудыг “нээж” үзэх. /Дохионууд байгаа эсэхийг ажиглах/
5. Үйлчлүүлэгчийн зовиур шаналгаануудыг илэрхийлж байгаа ярианы бус дохионуудыг ажиглах.
6. Нээлттэй асуултанд чөлөөтэй хариулах цагийн боломж олгох.
7. Үйлчлүүлэгчийн асуултанд хариулах хандлагыг тогтоох /бодитой, татгалзах, үгүйсгэх, нуух зэрэг олон хариулт бий/
8. Ярилцлагын гол үе шатны төгсгөлд хаалттай асуулт тавих, асуултын хуудас /анкет/ бөглүүлэх болно.

Эмнэлзүйн асуултууд

Эмнэлзүйн ярилцлагын болон анамнез цуглуулахын үр дүн нь асуултыг хэр оновчтой хийгээд зөв тавьж чадсан эсэхээс хамаарна. Эмнэлзүйн асуултуудыг дотор нь:

1. Нээлттэй асуулт
2. Хаалттай асуулт
3. Хөтлөх асуулт
4. Тодруулах асуулт
5. Лавлах асуулт
6. Асуултын хуудас гэж ялгана.

Дурдсан асуулт бүр тодорхой зорилготой байдаг.

Нээлттэй асуулт /Open questions/: Үйлчлүүлэгч тулгамдсан асуудал, бодол санаа, сэтгэл хөдлөл, сэрэл мэдрэмжээ чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгосон асуулт тавихыг нээлттэй асуулт гэдэг.

Хаалттай асуулт /Closed questions/: Үйлчлүүлэгчдэд тулгамдсан асуудлаа бүрэн гүйцэд, чөлөөтэй илэрхийлэх боломжийг олголгүй зөвхөн “тийм”, “үгүй” хариултын аль нэгээр хариулахыг шаардсан түгжээтэй асуулт тавихыг хаалттай асуулт гэдэг.

Хөтлөх асуулт /Leading questions/: Энэ бол хариулахад санаа авахуулсан битүү дохио буюу ёгт сануулгыг дотроо багтаасан асуулт юм. Санаа авахуулах асуулт нь хаалттай асуулттай төстэй.

Тодруулах асуулт /Clarifying questions/: Гол зүйл рүү, учрыг олох гэж байгаа зүйл рүү асуултыг төвлөрүүлж, байцааж, тодруулж, шалгааж асууна.

Лавлах асуулт /Questions/: Энэ бол тодруулах асуултын нэг хувилбар юм. Лавлах асуултыг хэрхэн тавихыг дараах 3 жишээгээр тодруулан авч үзье. Ярилцлагын явцад ярилцлага авагч, ярилцлага өгөгч хоёрын хэн хэн нь дутуу ойлгосон зүйлийг, бас хоёрдмол утгаар ойлгосон юмыг буюу эргэлзсэн зүйлийг нэг мөр болгож ойлгох зорилгоор лавлах асуулт тавьдаг.

Асуултын хуудас /Questionnaire/: Бодож боловсруулсан, олон тооны асуулт бүхий хуудсыг бөглүүлэх буюу анкет таглуулна. Дараах төрлийн асуултыг ашиглан асуултын хуудсыг боловсруулдаг.

1. “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн хариулт бүхий стандарт асуулт
2. Хариулт өгөгдөөгүй асуулт
3. Олон дэд асуултаас тогтсон “Тийм” эсвэл “Үгүй” альтернатив хариулт бүхий асуулт
4. Олон сонголттой хариултаас нэгийг нь сонгох хариулт бүхий асуулт
5. Хариултын хуваарь бүхий асуулт
6. Олон дэд асуултаас тогтсон, олон хуваарьт хариулт бүхий асуулт
7. Бусад төрлийн асуулт

“Тийм” эсвэл “Үгүй” гэсэн хариулт бүхий стандарт асуулт: Энэ бол хаалттай асуултын нэг хувилбар юм. Ихэнх асуултын хуудас “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн хоёр хариултын аль нэгийг сонгож хариулах альтернатив асуулттай байдаг. Гэвч дээр дурдсан хоёр хариултын аль нэгээр хариулахад эргэлзээ төрөх, мэдэхгүй байх тохиолдолд “эргэлзэж байна”, “хэлж мэдэхгүй байна” гэсэн хоёр хариултын аль нэгийг сонгоно.

Хариулт өгөгдөөгүй асуулт: Энэ бол нээлттэй асуултын нэгэн хувилбар юм. Асуултын хуудсанд хариулт өгөгдөөгүй асуултуудыг тусгаж хариултын талбайг хоосон байлгана. Энэхүү хоосон талбайд /зайд/ ярилцлага өгөгч хариултаа бичнэ.

Олон дэд асуултаас тогтсон, “Тийм”, “Үгүй” альтернатив хариулт бүхий асуулт: Энэ бол тодруулах асуулт, хаалттай асуулт хоёроос тогтсон нийлмэл асуулт юм. Асуултын хуудсын нэрсийн жагсаалтанд орсон аль нэг асуултыг олон дэд асуултаар тодруулан асуудаг. Энэ утгаар авч үзвэл олон дэд асуултаас тогтсон асуулт бол угтаа тодруулах асуулт юм. Дэд асуулт нэг бүрт “Тийм”, “Үгүй” гэсэн хоёр хариултын аль нэгийг нь сонгож хариулт өгнө.

Олон сонголттой хариултаас нэгийг нь сонгох хариулт бүхий асуулт: Энэ бол тодруулах асуултын нэгэн хувилбар юм. Санал асуултын хуудсанд орсон асуултуудын нэг асуултанд хариулж болох бүх хариултыг жагсаан бичнэ. Эдгээр жагсаасан хариултуудаас нэгийг сонгож хариулт өгнө.

Хариултын хуваарь бүхий асуулт: Энэ бол тодруулах асуултын өөр нэгэн хувилбар юм. Асуултанд олон хуваарьт хариултаас нэгийг сонгож хариулт өгнө. Хичнээн ч онооны хуваарь байж болох авч ихэнх тохиолдолд 5 онооны хуваарийг хэрэглэдэг.

Олон дэд асуултаас тогтсон, олон хуваарьт хариулт бүхий асуулт: Асуултын хуудсанд жагсаасан нэг буюу хэд хэдэн асуултыг хэд хэдэн дэд асуултаар тодруулан асууж дэд асуулт нэг бүрт олон хуваарьт хариултаас нэгийг сонгон хариулт өгнө.

Эмнэлзүйн ярилцлагын гуравдугаар үе шат буюу төгсгөлийн үе шат

Энэ бол ярилцлагын үр дүнг дүгнэх үе шат юм. Дараах үйл ажиллагаа явуулна.

1. Үйлчлүүлэгчид чөлөөтэй ярих боломж олгоно. Эмч үйлчлүүлэгчид хандан “Би таныг асуултаараа саатуулаад хүссэнийг тань яриулаагүй байж болно. Иймд та өөр ярих зүйл байвал ярина уу?” гэсэн асуулт тавьж хариулт авна.
2. Эмч үйлчлүүлэгчийн тулгамдсан асуудлыг зөв ойлгосон эсэхийг баталгаажуулна. Эл зорилгоор үйлчлүүлэгчийн тулгамдсан асуудлыг түүний ярьсан үгээр түүнд буцааж хэлж өгөөд би таныг ийм ийм асуудалтай хүн гэж ойлголоо. Би таныг зөв ойлгож байна уу, буруу ойлгож байна уу гэж лавлан асууна.
3. Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийнхэнд зохих зөвлөгөө өгнө.
4. Ямар тулгамдсан асуудалтай болохыг үйлчлүүлэгчид хэлж өгнө.
5. Үйлчлүүлэгчийг хэрхэн асарч сувилах арга барилыг зааж өгнө.
6. Баримтлах ёстой бусад дэг журмыг хэлж өгнө.

Эмнэл зүйн ярилцлагын үед үйлчлүүлэгчтэй харилцахдаа баримтлах зарчим

Эмч дараах зарчмыг баримтална.

- Эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхдээ үйлчлүүлэгчийн /хувь хүний/ бие, сэтгэц, нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг нэгдэлтэй авч үзэх иж бүрэн буюу интеграц хандлагыг баримтлах
- Үйлчлүүлэгч бүрт хувьчлан хандаж сэтгэл зүйн хувийн онцлогт тохируулан харилцах
- Үйлчлүүлэгчийн өвчиндөө өгч байгаа сэтгэл зүйн хариу урвалыг бодолцож харилцах
- Үйлчлүүлэгчийг сэтгэл зүрхээрээ мэдэрч ухаанаараа ойлгож харилцах
- Эмч үйлчлүүлэгч хоёрын хооронд сэтгэл зүйн халуун бүлээн уур амьсгал буюу сэтгэл зүйн холбоо /раппорт/ тогтоож харилцах
- Эмчийн ёс зүйг баримталж харилцах
- Эмчийн деонтологийн хэм хэмжээг баримталж харилцах
- “Хор бүү хүргэ” зарчмыг тууштай баримтлах
- “Эмчээс шалтгаант өвчин” үүсэхээс сэргийлэн харилцах
- Эмнэлгийн ажилтны зан төлөв эвдрэхээс сэргийлж харилцах
- Үйлчлүүлэгчийн итгэлийг хүлээж харилцах
- Үйлчлүүлэгчийг доромжлох, ад шоо үзэх, ялгаварлах, нэр хоч өгөх, нэрийг гутаах, нэр хүндгүй болгох хандлага хэрхэвч гаргахгүй байх зарчмыг хатуу баримтлах

Эмнэлзүйн ярилцлагын үеийн зарим алдаанууд

- Өөрийгөө танилцуулахаа мартаж
- Ярилцлагын зорилгыг тайлбарлахаа мартаж
- Дэндүү их, бас дэндүү түргэн ярьдаг эмч нар үйлчлүүлэгчид ярих боломжийг бага олгодог.
- Үйлчлүүлэгч дуугүй байхыг /дуугүй болохыг/ тэвчдэггүй.

- Эмч хувь хүн талаас нь үйлчлүүлэгчийг сонирхдоггүй.
- Ярилцлагыг нээлттэй асуултаар эхлэхийн оронд шууд хаалттай, түргэн асуулт тавьж товч хариулт өгөхийг хүлээдэг.
- Ярилцлагын гол сэдэв болох эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг тогтоох /илрүүлэх/ ярилцлагыг тууштай мөрдлөг болгохгүй, түүний оронд хоёрдугаар зэргийн ач холбогдолтой асуудлыг ярилцдаг /сэдвээс хазайдаг/.
- Ярилцлага авах ба анамнез цуглуулахад цаг бага зарцуулдаг.
- Асуулт тавих боломжийг үйлчлүүлэгчид олгодоггүй.
- Ярилцлагыг дүгнэдэггүй, тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх гэж байгаа арга замыг зөвлөсөн зөвлөгөөг хэлж өгдөггүй.

3.4 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСНИЙ УЛМААС НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОНХИЛОН ТОХИОЛДОХ СЭТГЭЦИЙН ЭМГЭГҮҮД

Хүчирхийлэлд буюу сэтгэлийн хүчтэй стрессорт өгөх сэтгэл зүйн хариу урвал

Хүчирхийллийн буюу сэтгэлийн хүчтэй стрессорын нөлөөгөөр тухайн хүндээ учруулж байгаа аюул занал хийгээд нүдээрээ харж, чихээрээ сонсож, тааламжгүй үнэрийг үнэртэж, хүчирхийлсэн доромжлолыг бие сэтгэлээрээ мэдэрч, хүчирхийлэлд өртсөн хүн бүрт сэтгэлийн өвөрмөц хариу урвал илэрдэг. Хүчирхийлэлд өртсөн хүмүүст хүчтэй айдсаар, сэтгэл түгшилтээр, сэтгэл гутралаар, зан үйлийн өөрчлөлтөөр, ичиж зовох мэдрэмжээр, гэмшлээр, уур омогоор, тааламжгүй сэтгэл хөдлөлөөр, дасан зохицолтын хямралаар гэм мэт янз бүрийн хариу урвал өгнө. Хүчирхийлэлд өгч буй хариу урвалыг бүхэлд нь стресст өгөх хариу урвал гэж үздэг ба өвчний олон улсын 10-р ангилалын дагуу дараах бүлгүүдэд хуваадаг. Үүнд:

1. F43.0-Стресст үзүүлэх цочмог хариу урвал
2. F43.1-Гэмтлийн дараах стрессийн эмгэг
3. F43.2-Дасан зохицохын эмгэг
4. F43.7-Хүчтэй стресст үзүүлэх бусад хариу урвал
5. F43.8-Хүчтэй стресст үзүүлэх хариу урвал, тодорхойгүй

Дээрх дасан зохицохуйн эмгэгүүд нь эмнэлзүйн талаасаа солиорлын бус сэтгэцийн эмгэгийн гол шинжийн бүх илрэлүүдийг өөртөө багтаасан байдаг. Дасан зохицохуйн эмгэгийг сэтгэцийн завсрын эмгэгийн тусгай төрөл хэмээн онцолж ялгах нь хүчирхийлэл болж өнгөрсний дараа уг эмгэг үүсэн бий болох хэтийн төлвийг урьдчилан харж тооцоолох, шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, сэргээн засах тусгайлсан хөтөлбөрүүдийг боловсруулахад ач холбогдолтой. Тухайн хүнд дасан зохицохуйн эмгэг бий болох нь хувь хүний эмзэг, өртөмтгий байдлын

урьдчилсан шинж төлвүүд гэж нэрлэгдэх хүчин зүйлсийн харилцан нөлөөллөөс шалтгаалдаг. Үүнд хүчирхийллийн нөлөө, өмнөх амьдралын сөрөг туршлага, аливаа саад тотгорыг гэтлэн давах тал дээр амьдралын явцад хуралдан бий болсон идэвхгүй үлбэгэр байдал, сэтгэцийн болон биеийн өвчнүүд ордог. Дурдсан хүчин зүйлсийн гүйцэтгэх үүргийг ойлгох, илэрч буй дасан зохицохуйн эмгэгийн хүндрэл, тэрчлэн хүчирхийлэлд өртсөн хэмжээ, хувь хүн бүрт үзүүлэх нөлөөний хүндрэлийн хамаарал зэрэг нь эмчилгээ, урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээ шинжлэх ухааны үндэстэй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Голчлон илрэх 3 эмгэгийг тус бүрд нь авч үзвэл:

F43.0-Стресст үзүүлэх цочмог хариу урвал

Эмнэлзүйн шинж тэмдэг

1. Хүчирхийллээс үхтлээ айснаас болж ухаан бүрийтэн балартаж баримжаагаа алдана. Үүний нөлөөгөөр хэт хөдөлгөөнтөх хариу урвал, хөдөлгөөнгүйтэх хариу урвал /хөшил, дуугүй байх, кататони төст байдал/ болон симпатик мэдрэлийн хөөрлийн шинжүүд /зүрх хүчтэй дэлсэх, чичрэх, хөлрөх, судасны цохилт олшрох, нүүр улайх гэх мэт/ илэрнэ.
2. Ухаан саруул болсоны дараа ухаан балартах цаг мөчид юу болж өнгөрснийг санахгүй буюу ойгүйдэл үүснэ.
3. Хүчирхийллээс болж айхын ихээр айж өөрийгөө удирдах хяналтаа алдаж, хүүхэн хараа өргөсөх, зүрх хавиргаа дэлстэл хүчтэй цохилж, амьсгал давчдах /гипервентиляци/, хар хөлс цувах, бүх бие салганан чичирч байгаа газраасаа зугатах зан үйл гаргана.
4. Мөн айдсын хариу урвалын нөлөөгөөр хувь хүний онцлогоос хамааран аль нэг дотор эрхтэний симпатик мэдрэл хүчтэй цочирсноос айсан харцтай, царай цайх, хөдөлгөөн хөших, ам нь ангайх, хоолой сөөнгөтөх, үг гарахаа болих, хамар сарталзах, үс босох, цусны даралт ихсэх, амьсгаа давчцах, амьсгалахад бэрхшээлтэй болох, амьсгалалт зогсох буюу тасалдах, бөөлжис цутгах, гүйлгэх, суулгах, гэдэс дүүрэх, шээс түргэн түргэн хүрэх гэх мэт шинжүүд илэрч болно.

Оношилгоо

- Тус эмгэг нь 1-3 сар хүртэл үргэлжилж болох боловч ихэвчлэн хэдэн цаг буюу өдрийн дотор арилдаг түр зуурын хариу урвал юм. Хүчирхийллийн дараа шууд эхэлж, сар хүрэхгүй хугацааны турш үргэлжилж буй тохиолдолд стресст үзүүлэх цочмог хариу урвал гэж үзэх үндэслэл их байна.
- Хүчирхийлэл буюу сэтгэлийн дарамтанд цочмог хариу урвал үзүүлэх эсэх, хариу урвалын хүнд, хөнгөний зэрэгт хувь хүний сэтгэлийн эмзэг чанар нөлөөлдөг.
- Илэрч буй шинж тэмдэг нь холимог, байнга өөрчлөгдөж байдаг бөгөөд

эхэн үедээ ухамсрын ба анхаарлын хүрээ нарийсах, цочролыг ойлгох чадваргүй болох, баримжаа алдагдах зэргээр илэрнэ.

- Дээрх байдал даамжирч, нөхцөл байдлаас тасран холдох /Диссоциатив ступор хүртэл-F44.2/ эсвэл хөөрөлд орох шинж илэрнэ.
- Сандрах, сэтгэл түгшилтийн шинж тэмдэг /судасны лугшилт түргэсэх, хөлрөх, нүүр улайх гэх мэт/ голчлон илэрнэ.
- Дээрх шинж тэмдэг нь хүчирхийлэлийн дараа хэдэн минутын дотор үүсч, холимог хувьсамтгай солигдмол шинж тэмдэгүүд богино хугацаанд буюу 2-3 өдөр /ихэнхдээ хэдэн цаг/-ийн дотор арилдаг.
- Тухайн хүчирхийллийн үеийн үйл явдлыг хагас буюу бүрэн санахгүй /F44.0/ байж болно.
- Хэрэв дээрх шинж тэмдэг арилахгүй тогтвортой байвал оношийг өөрчилнө.

F43.1-Гэмтлийн дараах стрессийн эмгэг

Үүнийг II бүлгээс судлаарай.

F43.2-Дасан зохицохуйн эмгэг

Эмнэлзүйн шинж тэмдэг

1. Сэтгэл гутрал болон айдас түгшилт илрэнэ. Гуниглах, гутрах, сэтгэлээр унах, сэтгэл дундуур болох, сэтгэл тавгүйтэх, сэтгэл зовинох, сэтгэл шаналах, айх, түгших зэрэг илрэл бүхий сөрөг сэтгэл хөдлөл үүснэ.
2. Сэтгэл гутарсантай холбоотойгоор зовхи нь буусан, дух нь үрчлээтсэн, царай нь гунисан байдалтай харагдана.
3. Хүрээлэн байгаа юмс үзэгдэл бүр сөрөг сэтгэл, гутранги үзлийг төрүүлж, тааламжгүй өнгө аясаар мэдэрдэг.
4. Удаан сэтгэж, нам дуугаар цөөн үгээр ярина. Асуусан асуултанд давтан асуусны дараа “Тийм”, “Үгүй” гэх мэт ганц нэг үгээр хариулна.
5. Үйлдэл хөдөлгөөн нь удааширна. Өөрөө санаачлан ямар ч ажил хийхгүй, өдрийн ихэнх цагийг хэвтэж өнгөрүүлнэ.
6. Хоолны дуршил буурч, хоол унднаас татгалзана.
7. Байн байн санаа алдна, нулимастай уйлна.
8. Өөрийгөө голно, чамлана, дорд үзнэ.
9. Симпатик мэдрэлийн хүчдэл ихсэж, хүүхэн хараа өргөсөх, өтгөн хатах, зүрх хүчтэй цохилох, цусны даралт ихсэх, ам хатах, амьсгаа давчдах, алга хөлрөх, хоолойд юм тээглэх шиг мэдрэмж үүсэх зэрэг шинжүүд илрэнэ.
10. Үхэх, амиа егүүтгэх талаар бодол үүснэ. Хүмүүст мэдэгдэлгүйгээр амиа егүүтгэх оролдлого гэнэт хийдэг. Энэ байдлаа нууна.
11. Ажиллах, сурах гэх мэтээс татгалзаж, таслах, хоцрох, байн байн чөлөө авах, гарах оролдлого хийнэ.
12. Архи, тамхи буюу бусад мансууруулах бодист татагдана.
13. Уур уцаар ихтэй, бухимдангүй, түрэмгий авир их гаргана.

Оношилгоо

- Амьдралын нөхцөл байдлын томоохон өөрчлөлт буюу сэтгэлийн дарамт үүсгэсэн нөхцөл байдалд дасан зохицох явцад үүсч, нийгэмд гүйцэтгэх үүргээ биелүүлэхэд бэрхшээл учруулдаг бие хүний сэтгэлийн хямрал зовинол юм.
- Дээрх нөхцөл байдал нь хувь хүний нийгмийн харилцаа холбоо /хүнд гарз хохирол, хагацал/, эсвэл нийгмийн дэмжлэгийн сүлжээ /шилжих хөдөлгөөн, дүрвэх/ зэргийг эвдэж, эсвэл амьдралын өөр томоохон өөрчлөлт /сургуульд элсэх, эцэг эх болох, тавьсан зорилгодоо хүрэхэд азгүйтэх, ажлаасаа огцрох/-д хүргэдэг.
- Хувийн зан чанар, сэтгэлийн эмзэг байдал зэрэг нь дасан зохицолтын эмгэг үүсэх эрсдэл, хэлбэрт нь нөлөөлж болох боловч сэтгэлийн дарамт үүсгэх хүчин зүйл үгүй байсан ч энэхүү эмгэг нь үүсч болно.
- Илрэл нь янз бүр байх ба сэтгэл санаа гутранги байх, сэтгэл түгших буюу зовох, эсэргүүцэх, урагшлах чадваргүй мэт санагдах, өдөр тутмын алба ажлаа гүйцэтгэх чадвар буурах зэргээр илэрнэ.
- Зонхилон гарах шинж тэмдэг нь богино буюу удаан үргэжлэх сэтгэл гутрах урвал буюу бусад сэтгэл хөдлөл ба зан үйлийн хямрал юм.
- Онош нь хэлбэр, агуулга, зовиур шаналгааны хүнд хөнгөн, бие хүний шинж төлөв, дарамт үзүүлэгч үйл явдал, амьдралын хямрал зэргээс ихээхэн хамаарна.
- Хойшилсон эхлэл бүхий гэмтлийн дараах стрессийн эмгэг /гэмтлийн нөлөө өгч буй үйл явдалын дараа 6 сараас доошгүй хугацаанд онцлог шинж тэмдэгүүд илрэн гарч ирэх/ гэсэн 3 хувилбарт хуваана.

Дасан зохицохуйн эмгэгийн үеийн эмчилгээний ерөнхий зарчим

1. Хүчирхийлэлтэй орчноос тусгаарлана.
2. Хүчирхийллийн хэлбэр, үргэлжилсэн хугацаа, эмнэлзүйн шинжүүдээс хамааран эмчилгээг төлөвлөнө.
3. Стресст өгөх цочмог хариу урвалын хөнгөн үед эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх шаардлагагүй, эмнэлзүйн ярилцлагыг 3 үе шаттайгаар хийнэ.
4. Үйлчлүүлэгч өөрөө ярилцах боломжтой бол сөрөг мэдрэмжийг нь хуваалцана, өөрөөр нь яриулна.
5. Үйлчлүүлэгчид амьсгал давхцах хам шинж /Гипервентиляци/ илэрч байвал цаасан уут уруу амьсгалуулна.
6. Стресст үзүүлэх цочмог хариу урвалын улмаас хэт хөдөлгөөнтөх болон хөдөлгөөгүйтэх хариу урвалын шинж тэмдэг илэрч байвал үндсэн шатлалын эмнэлгийн сэтгэцийн тасаг болон төрөлжсөн тусламжийн сэтгэцийн эмнэлэгт богино хугацаагаар хэвтүүлэн эмчилж болно.
7. Нойрны хямрал, айдас, сэтгэл түгшилт, гутрал зэрэг шинжүүд илэрвэл шаардлагатай гэж үзвэл зохих эмийн эмчилгээг хийнэ /Жороор олгогдох эмийг сэтгэцийн эмч бичнэ/.

8. Сатааруулах буюу анхаарлыг нь стрессээс нь өөр зүйлд хандуулах эмчилгээ /сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээ/.
9. Ганцаарчилсан сэтгэл засал эмчилгээ /Төрөлжсөн тусламжийн сэтгэцийн эмнэлэгт сэтгэл засалч эмч хийнэ/.
10. Харилцан нөлөөлөх бүлгийн сэтгэл засал эмчилгээ хийх. /Лавлагаа шатлалын тусламжид хийнэ./
11. Сэтгэц танин мэдэхүйн сэтгэл засал эмчилгээ хийх.
12. Хүчтэй стрессийн улмаас саатал үүссэн бол кальцийн цохилт эмчилгээ хийх /Лавлагаа, төрөлжсөн тусламжийн сэтгэцийн эмнэлэгт сэтгэцийн эмч, сэтгэл засалч эмч хийнэ/.
13. Булчин сулруулах, сэтгэлээ ариусгах, өөрөөс гаралтай дасгал эмчилгээ хийнэ /Төрөлжсөн тусламжийн сэтгэцийн эмнэлэгт сэтгэл засалч эмч хийнэ/.
14. Үйлчлүүлэгчид илэрч буй сэтгэц эмгэгийн шинж тэмдэг, хам шинжээс хамааран шинж тэмдэгийн эмчилгээ хийнэ.
15. Хүчтэй стресст өртсөний улмаас сэтгэлээр гутрах, амиа егүүтгэх оролдлого хийх, егүүтгэх үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч тухай бүрт нь тохирсон эмчилгээг хийх.
16. Үйлчлүүлэгч, ар гэрийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгнө.
17. Ерөнхий биеийн эсэргүүцэл сайжруулах эмчилгээ хийнэ.

Дасан зохицохуйн хямрал бүхий өвчтөн, түүний ар гэрийнхэнд өгөх мэдээлэл, зөвлөгөө

Мэдээлэл:

- Уг хариу урвал нь хүчирхийллийн улмаас үүсдэг.
- Хүчирхийлэл нь хүчтэй сэтгэл зүйн гэмтэлд хамаарна.
- Хүчирхийлэл төдийгүй сэтгэл зүйн таагүй байдлаас үүсдэг учир ямар ч хүнд тохиолдох боломжтой.
- Сэтгэл санаа удаан хугацаагаар тааламжгүй байдалтай байвал хувь хүний өдөр тутмын амьдралд сөргөөр нөлөөлдөг.
- Эмчлэгдэх боломжтой.
- Эмчийн үзлэгт тулгуурлах эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагатай бол богино хугацаагаар хэвтүүлэн эмчилнэ.
- Хүчирхийлэлд өртсөн үед шаардлагатай бол төрөлжсөн мэргэжлийн эмчид үзүүлж зөвлөгөө авч болно.
- Хүчирхийлэлд өртсөний улмаас хөдөлмөрийн чадвар алдалт тогтоох шаардлагагүй.

Зөвлөгөө:

- Сэтгэл санааны тааламжгүй байдлаас гарахад гэр бүлийн гишүүд, ойр дотны найз нөхдийн тусламж, дэмжлэг их хэрэгтэй.
- Үйлчлүүлэгч тухайн болсон үйл явдалд өөрийгөө буруутгахгүй, зэмлэхгүй байх, харамсахгүй байхыг хичээх хэрэгтэй.

- Үйлчлүүлэгчид өөрийгөө буруутгах, сэтгэлээр унасны улмаас амиа егүүтгэх бодол төрдөг учир ойр дотны хүмүүс нь ярилцаж байх, санаа бодлыг нь сонсож байх.
- Дасан зохицох хариу урвалын улмаас айдас, түгшүүр төрж тайван бус болох, вегетатив хөөрлийн шинжүүд илэрдэг учир аль болох биеийн шинжүүддээ анхаарлаа хандуулахгүй байвал тайвшрахад эерэгээр нөлөөлнө.
- Үйлчлүүлэгч сэтгэлээр унасны улмаас аливаад идэвхи сонирхолгүй, өөрийгөө арчлахгүй болох хандлагатай учир түүнийг идэвхижүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаанд нь тусалж дэмжих.
- Үйлчлүүлэгч сэтгэл санааны тааламжгүй байдлын улмаас өөрийгөө тайвшруулах гэж тамхи татах, архи уух, мансуурах нь хавсарсан өвчнийг үүсгэж болно.
- Үйлчлүүлэгч болсон үйл явдалд өөрийгөө буруутган ажил, сургуулиа хаях, хамт олноосоо хөндийрөх, ганцаардах, эрх зүйн зөрчил гаргах зэрэг зан үйлийн өөрчлөлт илэрдэг учир сэтгэц зан үйлийн сэтгэл засал эмчилгээнд хамруулна.
- Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн гэмтлээс хамааран ганцаарчилсан, бүлгийн, гэр бүлийн сэтгэл засал эмчилгээний аль тохирохыг сонгон хийх нь үр дүнтэй.
- Сэтгэц эмгэгийн хариу урвал ямар шинжээр илэрч буйгаас хамааран сэтгэцэд нөлөөт эмийн эмчилгээг эмчийн заавраар хийнэ.
- Үйлчлүүлэгч амиа егүүтгэх оролдлого хийсэн, гэрийн нөхцөлд эмийн эмчилгээ үр дүнгүй байгаа тохиолдолд сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчилнэ.
- Стрессээ тайлах аргуудыг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлэх дадалд сургах.
- Шаардлагатай бол төрөлжсөн мэргэжлийн эмчид хандан тусламж авч болно.

Эрүүл мэндийн тусламжийн шатлалын дагуу үзүүлэх тусламж

Анхан шатны тусламжид:

- Хүчирхийлэлд өртсөнийг мэдсэн даруйд тайван орчинд шилжүүлнэ /хүчирхийлэлтэй орчноос тусгаарлах/.
- Үйлчлүүлэгч мэдрэмжээ нээх боломжоор хангах /сандалд суулгах, уух зүйл хийж өгөх, уйлах үед биед нь зөөлөн хүрэх, сальфетка авч өгөх, таныг ойлгож мэдэрч байна гэдгээ зан үйлээр илэрхийлэх зэрэг/.
- Удамд нь сэтгэцийн эмгэгтэй хүн байсан эсэх, өвчин үүсэхэд нөлөөлсөн шалтгааныг тодруулах зорилгоор ар гэрийнхэнээс объектив анамнез авна, эмнэлзүйн ярилцлага хийнэ, тодруулан асууна.
- Үйлчлүүлэгчийг чөлөөтэй яриулах, сөрөг мэдрэмжээ илэрхийлэхэд нь саад болохгүй байх.

- Үйлчлүүлэгч тайван бус, сэтгэц эмгэгийн хурц дошгирол, хөшилтэй байвал үндсэн тусламжийн сэтгэцийн тасаг болон төрөлжсөн тусламжийн сэтгэцийн эмнэлэгт шилжүүлэнэ.
- Үйлчлүүлэгч харьцангуй тайвширсан бол одоогийн сэтгэцийн байдлыг тодорхойлох үзлэг хийнэ.
- Хүчирхийлэлд өртөөд удсан бол одоогийн сэтгэцийн байдлыг тодорхойлох үзлэг хийж хам шинжийн онош тавина, асуумж цуглуулна.
- Үйлчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгнө.
- Сэтгэл зүйн зөвлөгөө засал, стресс тайлах аргаар эмчилнэ.
- Эмийн эмчилгээ хийх шаардлагатай бол эмчилгээг амбулаториор хийнэ.
- Стресс тайлах энгийн аргуудаас зааж өгнө.
- Сэтгэц эмгэгийн шинж тэмдэгт тохирсон сэтгэц нөлөөт эмийн эмчилгээ хийнэ /айдас, сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, амиа егүүтгэх бодол төрөх, нойрны өөрчлөлт, улигт бодол гэх мэт/.
- Өвчин даамжрах хандлагатай, сэтгэц эмгэгийн бусад шинжүүд хавсран илэрч байгаа, сэтгэл засал, эмийн эмчилгээнд үр дүнгүй бол үндсэн мэргэжлийн эмчид илгээнэ.

Лавлагаа шатлалын түвшинд:

- Тухайн үеийн сэтгэцийн байдлыг тодорхойлох үзлэг хийн оношийг тогтооно.
- Хэрэв үйлчлүүлэгчийн өвчин даамжирсан, айдас, сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийн шинжүүд хавсарсан, амиа егүүтгэх бодолтой, амиа егүүтгэх үйлдэл хийсэн байвал хам шинжийн онош, нозологийн оношийг тавьж, төрөлжсөн мэргэжлийн эмчид илгээнэ.

ДИССОЦИАТИВ ЭМГЭГ

Диссоциатив /хуваагдах/ эмгэгийн үед хүний сэтгэцийн нэгдмэл байдал алдагдаж олон тооны саланги хэсгүүдэд хуваагдах нь янз бүрийн хам шинжүүдийн үндсэн шалтгаан юм. Уг эмгэгийн бүх хэвшинж нь ялангуяа сэтгэцийн хүчтэй дарамтын /хүчирхийллийн/ нөлөөгөөр үүссэн бол хэдэн долоо хоног буюу сарын дараа эдгэрэх хандлагатай байдаг. Хэрэв шийдвэрлэшгүй асуудал буюу хүн хоорондын зөрчлийн нөлөөгөөр үүссэн бол нэлээд архаг явцтай, саажих ба мэдээ алдах шинж тэмдэгтэй хавсарч илэрч болно. Диссоциатив эмгэгийн үед үйлчлүүлэгчийн бодол санаанд хурц тод, дүрст байдлууд үүсч хэтэрхий өөрийгөө итгэн үнэмшүүлэх байдалд ордог. Өвчтөний зан үйлд сэтгэцийн гэмтэл өгсөн нөхцөл байдал тодорхой тусгагдсан байдаг. Эмнэлзүйд илэрхий өөрийгөө харуулах гэсэн зан үйл, уйлах, утгагүй хөхрөх, истерийн уналтын шинжүүд тод ажиглагдана. Зарим тохиолдолд ухамсарт ухааны хүрээ нарийсах, истерийн ухаан бүрийтэн балартах үед орон зайн баримжаа алдсан, гажуу

тусгал илэрч болно. Уг эмгэг нь сэтгэцийн шалтгаантай, хүчирхийлэл болон сэтгэлд хүчтэй нөлөөлсөн үйл явдал, шийдвэрлэшгүй ба дааж давшгүй асуудал буюу харилцааны зөрчилтэй холбоотой бөгөөд ихэвчлэн гэнэт үүсдэг. Илэрч буй шинж тэмдэгүүд нь сэтгэцийн өвчин ямар шинж тэмдэгээр илрэх тухай үйлчлүүлэгчийн төсөөлөлтэй нийцнэ. Эмнэлгийн үзлэг ба шинжилгээгээр биеийн буюу мэдрэлийн ямар нэг мэдэгдэх эмгэг илэрдэггүй. Хүчирхийлэл болон сэтгэлийн шалтгаант дарамттай цаг хугацааны хувьд холбоотой байна. Мөн эмчилгээний үр дүнд засрал авдаг бөгөөд хүний ажил, хөдөлмөрт бараг саад тотгор учруулдаггүй. Диссоциатив эмгэгүүдийг /F44/ ӨОУ-ын 10-р ангилалд дараах байдлаар ангилсан байдаг. Үүнд:

- Диссоциатив ойгүйдэл /F44.0/
- Диссоциатив тэнүүчлэлт /F44.1/
- Диссоциатив хөшилт /F44.2/
- Ухаан бүрийтэн балартах эмгэг /F44.3/
- Хөдөлгөөний диссоциатив эмгэг /F44.4/
- Диссоциатив таталт /F44.5/
- Диссоциатив мэдээгүйдэл ба мэдрэх эрхтэний мэдрэх чадвар алдах эмгэг /F44.6/
- Холимог диссоциатив эмгэг /F44.7/,
- Бусад диссоциатив эмгэг /F44.8/
- Диссоциатив эмгэг, тодорхойгүй /F44.9/

F44.0-Диссоциатив ойгүйдэл

Эмнэлзүйн шинж тэмдэг

1. Цочмог эхэлнэ.
2. Хүчирхийлэл буюу сэтгэлийн сэтгэлийн цохилт өгсөн үйл явдлыг сэргэж санах чадваргүй болох хэлбэрийн сонгомол ойгүйдэл давамгайлсан илрэнэ.
3. Истерийн бусад шинжүүд бүдэг илэрч болно.

Оношилгоо

- Гол онцлог нь ойгүйдэх, ихэвчлэн одоо болж буй чухал үйл явдлыг санахгүй болох бөгөөд энэ нь сэтгэцийн органик эмгэгээс болж буй хэрэг биш. Мөн энгийн марталт буюу ядралаар тайлбарлахад хэцүү.
- Ойгүйдэл нь ихэвчлэн хүчирхийлэлийн болон сэтгэлийг хүчтэй гэмтээсэн үйл явдалд төвлөрөхөөс гадна хэсэгчилсэн ба сонгомол байдаг.
- Бүтэн ойгүйдэл маш ховор байх ба ихэвчлэн автоматизмын нэг хэсэг байдаг. Хэрэв ийм бол F44.1 гэж ангилна.
- Уг оношийг тархины органик эмгэг, хордлого, бусад хэт ядаргаа байвал тавьж болохгүй.

F44.1-Диссоциатив тэнүүчлэлт

Эмнэлзүйн шинж тэмдэг

1. Ухаан нь гэнэт балартаж хэдэн минут, цаг, хоногоор өөрийн мэдэлгүй тэнүүчлэх буюу төөрч явна.
2. Тэнүүчлэх үед бүтэн ойгүйдэл үүсч өнгөрсөн амьдралын талаарх бүх мэдээллийг мартана.
3. Хаа нэг газар явж байгаад ухаан гэнэт саруул болно. Гэвч тэнүүчлэх үеийн үйл явдлыг санахгүй. чадна.
4. Тэнүүчлэх явцад шаардагдаж буй үйлдэл хөдөлгөөнийг зөв гүйцэтгэдэг.

Оношилгоо

- Энэ нь сарних ойгүйдлийн бүх онцлогийг агуулахаас гадна жирийн өдөр тутмын замаасаа алс хол зорилготой тэнэхийг хэлнэ.
- Энэ үед үйлчлүүлэгчид ойгүйдэл илрэх боловч үйлчлүүлэгчийн хэлсэн, хийсэн нь хөндлөнгийн хүнд эв эрүүл мэт санагдана.
- Диссоциатив ойгүйдлийн шинж /F44.0/ жирийн өдөр тутмын замаасаа гарч, алс хол зориуд тэнүүчлэн, өөртөө арчаатай, танихгүй хүнтэй хэвийн харьцана.

F44.2-Диссоциатив хөшилт

Эмнэлзүйн шинж тэмдэг

1. Гунигтай царайтай, газар шагайсан харцтай байх
2. Дуугүй, юм ярихгүй. Цөөн асуултанд тийм, үгүй гэх мэт цөөн үгээр хариулна.
3. Ихэнх цагийг хөдөлгөөнгүй хэвтэж өнгөрүүлнэ.
4. Хөшил нь олон долоо хоног, сараар үргэлжилнэ.
5. Аюул занал үгүй болсныг тодорхой мэдсэний дараа хөшил ул мөргүй арилна.
6. Хөшлөөс гарахын өмнө истерийн саа, нялхрах шинж үүсч болно.

Оношилгоо

- Зориудын хөдөлгөөн ба гэрэл, дуу чимээ, хүрэлцэх зэрэг гадны цочролд өгөх хэвийн хариу эрс буурах буюу үгүй болох байдлаар илэрдэг.
- Гэвч үзлэг шинжилгээгээр органик шалтгаан илрэхгүй.
- Сэтгэл санаанд хүчтэй нөлөөлсөн үйл явдал буюу асуудал байсныг нотлох сэтгэцийн шалтгаан байдаг.
- Дээрх хөшилтийг тайлбарлах бие сэтгэцийн эмгэг үгүй. Саяхандаа стресст өртсөн байна.
- Кататоник хөшлөөс ялгана.

F44.3-Ухаан бүрийтэн балартах эмгэг

Эмнэлзүйн шинж тэмдэг

1. Орон зайн баримжаа алдах
2. Гажуу тусгал илрэх

Оношилгоо

- Хүн өөрийгөө бие хүн гэж ухамсралах чадвар түр зуур алдагдах ба орчин тойрноо бүрэн ухамсарлахгүй байдлаар илэрдэг эмгэг.
- Үүнд шашин шүтлэг ба соёлын зан үйлээс ангид тохиолдож буйзориудын бус ухаан алдах байдлуудад орно.
- Энэ ангилалд цочмог ба түр зуурын солиорох эмгэг сэтгэц нөлөөт эм бодистой холбоотой болон шизофренистэй холбоотой байдлууд тус тус хамаарахгүй.

F44.4-Хөдөлгөөний диссоциатив эмгэг

Эмнэлзүйн шинж тэмдэг

1. Үйлчлүүлэгч явж, зогсож чадахгүй болсон гэж өөртөө итгэнэ.
2. Мөчний хөдөлгөөн хийж чадахгүй болох, зогсож, явж чадахгүй тэнцвэр алдана.
3. Үйлчлүүлэгч хэвтэж байхдаа ямар ч хөдөлгөөн хийж чадах авч зогсоо байдалд оронгуут шууд ойчно. Энэ нь үйлчлүүлэгч эмгэгт байдалдаа бусдын анхаарлыг татах истерийн түгээмэл шинжийг харуулж байгаагийн илрэл юм.

Оношилгоо

- Гар хөлөө бүгдийг буюу аль нэгийг нь хөдөлгөх чадвар алдагдах эмгэг орно. Эдгээр нь атакси, апракси, акинези, афони, дизартри, дискинези, уналт буюу саатай маш төстэй байж болно.
- Органик гаралтай өвчний нэгэн адил истерийн үед эмгэгт байдал тогтвортой бус, нойрсох явцад алга болно, сэтгэлийн таагүй нөхцөл байдлын нөлөөн дор хурцадна.
- Истери эмгэгтэй үйлчлүүлэгчийн хөдөлгөөний эмгэгт байдал нь мэдрэлийн өвчлөлтэй холбоотой хөдөлгөөний саатал эмгэгээс зарчмын хувьд ялгаатай.
- Истерийн сааны үед шөрмөсний болон эмгэг рефлекс илрэхгүй.

F44.5-Диссоциатив таталт

Эмнэлзүйн шинж тэмдэг

1. Таталт голдуу чангаар уйлах, хашгирах, инээхээс эхлэн салгалах чичрэх хөдөлгөөнөөр солигдож өрнөнө.
2. Үйлчлүүлэгч татаж унах ба булчин шөрмөс чангарсан, бүх бие гэдрэг нугарч өсгий дагзаараа нум хэлбэрт ордог.
3. Уналт таталт хэдэн минутаас хэдэн цаг хүртэл үргэлжилнэ.
4. Истерийн таталтын оргил үед ухаан санаа нарийсаж, анхаарал огцом буурах ба зарим тохиолдолд түр зуурын ой санамжаа алдана.

Оношилгоо

- Энэ нь хөдөлгөөний байдлаараа эпилепси уналттай маш төстэй байдаг.
- Гэвч хэлээ хазах, унасны улмаас хөхрөлт үүсэх, дороо бие засах зэрэг нь тун ховор
- Ухамсарт ухаан саруул байх бөгөөд эсвэл ступор буюу ухаан бүрийтэн балартах байдлаар солигдоно.
- Истериин уналт таталт нь үйлчлүүлэгч өөрөө унадаг өвчний тухай ямар мэдлэгтэй, түүний шинж тэмдэгийн талаар ямар төсөөлөлтэй байгаатай холбоотой байдаг.

F44.6-Диссоциатив мэдээгүйдэл ба мэдрэх эрхтэний мэдрэх чадвар алдах эмгэг

Эмнэлзүйн шинж тэмдэг

1. Сонсгол, хараа, мэдрэх, үнэрлэх чадвараа алдах эсвэл буурна.
2. Сэтгэл хөдлөл, сандралаас болж үйлчлүүлэгч түр зуур ярих чадвараа алдана.
3. Сэтгэлийн байдал хөдөлмөрийн бүтээмж буурна.
4. Үйлчлүүлэгчийг ажиглахад ямар нэгэн байдлаар анхаарал татсан зан үйлийг хийдэг.

Оношилгоо

- Арьсны мэдээгүй болсон хэсэг нь тодорхой хил хязгаартай байх ба энэ нь биеийн үйл ажиллагааны тухай өвчний төсөөлөлтэй холбоотой байна.
- Энэхүү төсөөлөл нь анагаах ухааны мэдлэгээс өөр байна.
- Мэдрэлийн гэмтлийн улмаас үүсэх боломжгүй мэдрэхүйн алдагдал байдаг.
- Мэдрэхүйн алдагдал нь сэрэл хувирах эмгэгтэй хосолж болно.
- Сарних эмгэгийн үед хараа ба сонсгол бүрэн алдагдах нь тун ховор.

Эрүүл мэндийн тусламжийн шатлалын дагуу үзүүлэх тусламж

Анхан шатны тусламжид

- Үйлчлүүлэгчийн өвчин хөнгөн үед ерөнхий мэргэжлийн эмч оношилж, хянах ба эмчилгээг хийнэ.
- Удамд нь сэтгэцийн эмгэгтэй хүн байсан эсэх, өвчин үүсэхэд нөлөөлсөн шалтгааныг тодруулах зорилгоор ар гэрийнхнээс объектив анамнез авна, эмнэлзүйн ярилцлага хийнэ, тодруулан асууна.
- Үйлчлүүлэгчийн одоогийн сэтгэцийн байдлыг тодорхойлох үзлэг хийнэ.
- Истериин эмгэгийн эмнэлзүйн хэлбэрийг /хувирах, хуваагдах эмгэгийн аль нь болох/ ялган оношлоно.
- Бие махбодын талаас хавсарсан өвчин байж болох тул урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулна /ялангуяа саа, саажил, ухаан балартал, уналт таталтын зовиур өгүүлж буй үед/.

- Үйлчлүүлэгчид итгүүлэх, ятгах, тайлбарлах сэтгэл засал эмчилгээ хийнэ.
- Үйлчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгнө.
- Сэтгэл зүйн зөвлөгөө засал, стресс тайлах аргаар эмчилнэ.
- Эмийн эмчилгээ хийх шаардлагатай бол эмчилгээг амбулаториор хийнэ.
- Стресс тайлах энгийн аргуудаас зааж өгнө.
- Шаардлагатай бол мэдрэлийн, дотрын, эмэгтэйчүүдийн зэрэг үндсэн мэргэжлийн эмчид үзүүлж зөвлөгөө авна.
- Өвчин даамжрах хандлагатай, эмийн эмчилгээнд үр дүнгүй, дахилт олонтой бол үндсэн мэргэжлийн эмчид илгээнэ.

Лавлагаа шатлалын тусламжийн түвшинд

- Тухайн үеийн сэтгэцийн байдлыг тодорхойлох үзлэг хийн оношийг тогтооно.
- Диссоциатив эмгэгийн улмаас шоронгийн солио, хуурамч тэнэгрэл, истериин тэнүүчлэл, ухаан балартал зэрэг сэтгэц эмгэгийн шинжүүд илэрч байгаа бол хам шинжийн онош, нозологийн оношийг тавьж, төрөлжсөн мэргэжлийн эмчид илгээнэ.

Диссоциатив эмгэгтэй үйлчлүүлэгчээс авах асуумж

- Үйлчлүүлэгчийн одоогийн зовиурыг асууна.
- Бага насны хүмүүжлийн хэлбэр, хэнтэй хамт өсч хүмүүжсэн талаар асууна.
- Та бага байхдаа гомдоосон хүнтэйгээ ярихгүй байх, бусдын урдаас хэлээ гаргах, эсэргүүцэх зэрэг байдал гаргаж байсан уу?
- Таны амьдралд сэтгэл санааг тань хүчтэй цочроох үйд явдал болж байсан уу? Та санаж байгаа бол хэзээ, ямар үйл явдал болсон бэ?
- Таны ойр дотны хүмүүсийн дотор, удамд тань сэтгэцийн эмгэгтэй хүн байсан уу? Ялангуяа ухаан алдаж татаж унадаг хүн байсан уу?
- Танд эмнэлгийн үзлэг, шинжилгээгээр оношлогдсон бие махбодын ямар нэг өвчин байдаг уу? /тархины гэмтэл, хавдар, тархины судасны эмгэг гэх мэт/
- Та хэзээнээс эхлэн, ямар шалтгааны улмаас унаж татдаг болсон бэ?
- Та ямар үед, ямар тохиолдолд унаж татаж байна вэ? /бусадтай маргалдсан, сэтгэл санаа тавгүй үед, өөрийн хүссэн зүйл биелэхгүй байгаа тохиолдолд, ямар ч шалтгаангүйгээр хар аяндаа унадаг гэх мэт/
- Жилд, сард, өдөрт хэдэн удаа унаж татдаг вэ?
- Нэг удаа унахдаа хэдий хугацаагаар унаж татдаг вэ? Нэг өдөр олон удаа унаж татдаг уу?
- Унаж татах нь гэдгээ өөрөө мэдэрдэг үү? /толгой эргэх, нүд бүрэлзэх, дотор муухайрах, ямар нэг эвгүй зүйл үнэртэх шиг болох гэх мэт/
- Уналт таталтын улмаас бэртэх буюу түлэгдэж байсан уу?

- Та унах үедээ хэлээ хазах, амнаас хөөс гарах, дороо бие засах зэрэг шинжүүд илэрдэг үү?
- Та унаж татаж байх үедээ гэрт тань, таны байгаа орчинд хэн хэн байгаа тэдгээр хүмүүс ямар үйлдэл хийж байгааг бүгдийг нь мэддэг үү?, заримыг нь мэддэг үү?
- Та хэдийгээр ухаан алдан татаж унахгүй боловч хэсэг хугацаанд ямар үйлдэл хийснээ санахгүй болох тохиолдол байсан уу?
- Сүүлийн үед та ямар нэг зүйлийг тогтоох, цээжлэх, эргэн санах нь муудаж байна уу?
- Та унаж татсаны дараа биед тань ямар зовиур илэрдэг вэ? /хэл завж хөндүүрлэдэг, булчин өвддөг, толгой өвддөг, бэртэж гэмтсэн байдаг, хэсэг хугацаанд яаснаа мэддэггүй, ямар нэг зовиур байдаггүй/
- Та уналтын улмаас эмчид хандан эмчилгээ, шинжилгээ хийлгэж байсан уу?
- Эмч таныг уналт таталтын эсрэг эм уухыг зөвлөж байсан уу? Та уналт таталтын эсрэг эм уудаг уу?

Истериин хувирах болон хуваагдах эмгэгийг илрүүлэх бусад асуумжийг авч эмнэлзүйн хэлбэрийг ялган оношлоно. Нэмэлт мэдээлэл цуглуулна.

Диссоциатив эмгэгтэй үйлчлүүлэгчийн эмчилгээний ерөнхий зарчим

- Диссоциатив эмгэгийн хөнгөн хэлбэрийн үед ерөнхий мэргэжлийн эмч амбулаториор эмчилнэ.
- Үйлчлүүлэгчийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлохын тулд эмнэлзүйн ярилцлага хийнэ.
- Үйлчлүүлэгч мэдрэхүйн болон мэдэрлийн эрхтэн тогтолцооны талаас /хэлгүй, дүлий, сохор, саа саажилт, явж чадахгүй, зогсож чадахгүй, зогсох гэх мэт/ зовиур хэлж буй тохиолдолд шаардлагатай бол төрөлжсөн мэргэжлийн эмчид үзүүлж зөвлөгөө авна.
- Стрессийг даван туулах энгийн аргуудыг ашиглан стресс тайлах эмчилгээ хийх.

Диссоциатив эмгэгтэй үйлчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд өгөх мэдээлэл, зөвлөгөө

Мэдээлэл

- Диссоциатив эмгэг нь эмнэлзүйн олон хэлбэрээр илэрдэг, сэтгэл санааны тааламжгүй байдлаас үүсдэг өвчин.
- Зарим тохиолдолд бие махбодын өвчинтэй андуурагддаг тул заавал эмчид хандан тусламж, зөвлөгөө авах хэрэгтэй.
- Уг эмгэг нь хүн амын дунд элбэг тохиолддог, эмэгтэйчүүд өвчлөх магадлал илүү байдаг.
- Диссоциатив эмгэг нь эмчлэгдэх боломжтой, зарим хэлбэрийн үед сэтгэл засал эмчилгээгээр эмчлэгдэнэ.

- Уг эмгэгийн үүссэн шалтгааныг тогтоож, шалтгааныг нь арилгаж чадвал эмгүйгээр эмчлэгдэх боломжтой.
- Сэтгэл зүйн тааламжгүй байдал давтагдвал өвчний шинжүүд дахин илэрч /өвчин дахих буюу сэдэрч/ болно.
- Стресс бухимдлаа зөв тайлж, асуудлыг зохистой шийдэх нь уг эмгэгээс сэргийлэх аргуудын нэг болно.
- Диссоциатив эмгэгийн үед сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлагагүй тохиолдол байдаг, харин үндсэн мэргэжлийн эмч эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхийг зөвлөсөн үед эмчийн заалтаар хэвтүүлэн эмчилнэ.

Зөвлөгөө

- Диссоциатив эмгэг нь маш олон хэлбэрээр илэрдэг учир төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчид үзүүлж онош тогтоолгох хэрэгтэй.
- Сэтгэлийн тааламжгүй байдлын улмаас биеийн өвчний үед илэрдэг олон шинжүүд илэрдэг тул өөрийгөө өвчтэй боллоо хэмээн айж сандрах хэрэггүй.
- Стрессийн улмаас өөрт илэрч буй бие махбодын зовиуртаа хэт анхаарал хандуулбал өвчний шинж тэмдгүүд улам хүндэрч байгаа юм шиг санагддаг тул тайван байхыг хичээх хэрэгтэй.
- Диссоциатив эмгэгийн үед эмчийн заалтгүйгээр ямар нэг эм уухгүй байх нь зүйтэй.
- Уг өвчний эмнэлзүйн хэлбэрээс хамааран эмч эмчилгээг зөвлөх тул зөвхөн эмчийн заалтаар эмчилгээг хийнэ.
- Уг эмгэгийг үүсгэх шалтгаан нь стресс байдаг тул ойр дотныхоо хүмүүстэй нээлттэй ярилцаж сэтгэлээ ариусгах, бухимдлаа гадагш илэрхийлж сурах нь чухал.
- Үйлчлүүлэгч өөртөө үйлчлэх боломжгүй байгаа бол гардан асаргаа, хяналт шаардлагатай.
- Диссоциатив эмгэг нь хурц байдлаар илэрч байгаа, эмийн бус эмчилгээнд үр дүнгүй байгаа бол сэтгэцийн эмчийн зөвлөгөө авах буюу сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчилж болно.
- Эмнэлгээс гарсан тохиолдолд ерөнхий мэргэжлийн эмч давхар хяналт тавина.

F51-Органик бус нойрны эмгэг

Нойр нь хүний амьдралын чухал хэрэгцээний нэг юм. Хүн хоногт дунджаар 7-8 цаг унтаж амрахад бие сэтгэлийн таашаал авч өдөр тутмын ажлаа хийх эрч хүчийг олж авдаг. Хувь хүний онцлогоос хамааран нойрсох хугацаа харилцан адилгүй байж болно. Тухайн хүний сэтгэл санааны байдал, бие эрхтний өвчин, орчны сөрөг нөлөө зэрэг олон хүчин зүйлийн улмаас хүний нойр өөрчлөгдөхөд хүрдэг. Нойрны өөрчлөлт нь олон шалтгаантай, эмнэлзүйн олон хэлбэрээр илэрдэг, хүн амын дунд хамгийн түгээмэл тохиолддог эмгэг юм. Нойр өөрчлөгдөхөд хүргэх бодит өвчин үгүй ч сэтгэл

санааны тааламжгүй байдлын улмаас нойр хямрахыг органик бус нойрны эмгэг гэнэ.

Эмнэлзүйн шинж тэмдэг

1. Органик бус нойргүйдэл эмгэг /F51.0/-ийн үед:
 - Нойр хулжина
 - Өнгөц нойрсоно
 - Шөнө олон дахин сэрнэ.
 - Унтсан боловч нойр ханаагүй мэдрэмж төрнө.
 - Өглөө эрт сэрнэ.
2. Нойр хэт хүрэх эмгэг /F51.1/-ийн үед:
 - Нойроо дийлэхгүй унтана.
 - Өглөө сэрсний дараа нойр бүрэн сэрэхгүй болно.
 - Шөнийн цагт хангалттай унтсан боловч үе үе тэсвэрлэшгүй их нойр хүрнэ.
3. Унтах болон сэрүүн байх хэмнэл алдагдах эмгэг /F51.2/-ийн үед:
 - Өдрийн цагаар нойр хүрнэ.
 - Шөнө оройн цагаар нойр хүрэхгүй болно.
 - Нойр солигдоно.
 - Нойр хулжсанаас болж өдөр тутмын хэвийн ажиллах чадвар алдагдана.
4. Зүүдэн явалт /F51.3/-ын үед:
 - Унтаж байснаа гэнэт босч явна.
 - Явах үедээ ямар нэг үйлдэл хийнэ.
 - Шөнө босч явснаа огт мэдэхгүй.
5. Шөнийн айдас /F51.4/-ын үед:
 - Шөнө нойрон дунд хүчтэй дуу чимээ сонсож хүчтэй айдас төрнө.
 - Айдсын улмаас орилж хашгирна.
 - Босч сууна.
 - Хүчтэй айдас төрүүлсэн зүйлийн заримыг санана, заримыг нь санахгүй.
6. Хар дарж зүүдлэх /F51.5/-ын үед:
 - Нойрон дундаа аймшигтай, айдас түгшүүртэй зүүд зүүдэлнэ.
 - Зүүд маш тод байна, зүүдээ санана.
 - Сэрсний дараа айж сандарна.

Оношийн шалгуур шинж

- Нойрны хэм өөрчлөгдөнө.
- Нойргүйдлийг үүсгэж буй шалтгаантай байна.
- Нойргүйдлээс өдрийн турш биед зовиуртай, өдөр тутмын үйл ажиллагаанд бэрхшээл учирна.

Нойрны хямралын үед үйлчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд өгөх мэдээлэл

- Бухимдал болон биеийн өвчний үед нойрны өөрчлөлт элбэг тохиолдоно.
- Нойрны өөрчлөлт наснаас хамаарна.
- Нойргүй байна гэж санаа зовох тутам нойр улам хулжина.
- Архи болон бусад сэтгэцэд нөлөөлөх бодис хэтрүүлэн хэрэглэх нь нойргүйдэлд хүргэх шалтгаан болно.
- Өтгөн цай, кофе тогтмол хэрэглэх нь нойргүйдэлд нөлөөлнө.

Үйлчлүүлэгч, түүний гэр бүлд өгөх зөвлөгөө

- Тодорхой нэг цагт унтаж, нэг цагт босч байх
- Орой болгон биеийн булчингаа суллах дасгал хийж сурах
- Урд шөнө нь муу унтсан ч гэсэн унтдаг цагтаа унтаж хэвших
- Унтахад тааламжтай орчныг бүрдүүлэх
- Унтахын өмнө тааламжгүй мэдээлэл сонсохгүй, аймшгийн кино үзэхгүй байх
- Унтахын өмнө архи, кофе хэрэглэхгүй байх
- Унтахын өмнө биеийн тамирын хүнд дасгал хийхгүй байх
- Амралтын өдрүүдэд их унтахгүй байх
- Аль болох тайвшруулах, нойрсуулах эм хэрэглэхгүй байх
- Орондоо орж унтахаар хэвтээд 20 минутын дотор унтахгүй бол босохыг зөвлөнө. Яг нойр хүрсэн үедээ орондоо орж болно.

Эмчилгээ

Анхан шатны тусламжид

- Юуны өмнө нойргүйдэлд хүргэж буй шалтгааныг тодорхойлох
- Нойргүйдэлд хүргэж буй сэтгэцийн ба биеийн эмгэгийг эмчлэх
- Амьсгалын тайвшруулах дасгал, тоо тоолох дасгал хийх

Лавлагаа шатлалын тусламжид

Дээрх аргууд үр дүнгүй үед бензодиазепины бүлгийн эмүүдээс хэрэглэнэ. Нойрсуулах ямар ч эмийг хэрэглэсэн эмийн тунг аажмаар нэмэгдүүлж аажмаар тунг буулгах зарчмыг баримтална. Тухайлбал: Диазепамыг 15-аас 30 мг тунгаар унтахаас өмнө ууж хэрэглэх ба 14 хоногоос дээш хугацаагаар хэрэглэхийг хориглоно.

СЭТГЭЛ ГУТРАЛ

Сэтгэл гутрал гэдэг нь өдөр тутмын ярианд хэрэглэгддэг үг билээ. Ихэнх хүмүүс надад гунигтай байна, би сэтгэл санаагаар уначихаад байна, надад ямар ч урам зориг алга, тамир тэнхэлгүй болчихлоо зэрэг мэдрэмжүүдээр өөрсдийнхөө энэхүү байдлыг сэтгэл гутрал хэмээн илэрхийлдэг. Хэдий тийм боловч эмнэлзүйн практикт “Сэтгэл гутрал” гэдэг энэхүү нэр томъёог өдөр тутамд тохиолддог “Уналт”-аас дараах шинжүүдээр ялгаж ойлгох хэрэгтэй. Үүнд:

- Сэтгэл гутрал нь 2 долоо хоногоос дээш хугацаагаар үргэлжилдэг.
- Сэтгэл гутрал нь хүний өдөр тутмын идэвхитэй үйл ажиллагаанд саад болдог.

Сэтгэл гутралын хам шинж нь мэдрэмж, зан үйлийн цогц шинжүүдийг өөртөө агуулдаг. Магадгүй зарим хүнд сэтгэл гутралын хам шинжээс нэг, хоёр шинж тэмдэг эсвэл бүгд илрэх тохиолдол ч бий. Эдгээр ялгаатай байдал нь тухайн хувь хүний онцлогтой холбоотой байдаг.

Сэтгэл хөдлөл

Сэтгэл гутрал бол сэтгэл хөдлөлийн эмгэг юм. Сэтгэл гутралтай хүнд сэтгэлээр унах шинж тэмдэг 2 долоо хоногоос дээш хугацаагаар илэрдэг. Дунд зэргийн сэтгэл гутралын үед тухайн хүнд бүх л өдрийн турш таагүй мэдрэмж илрэхгүй ч алсуураа нэг л гунигтай, баргар байна. Мөн сэтгэл санаа нь эерэг үйл явдал тохиолдоход сэргэж ирээд дахиад л таагүй байдал руугаа орчихдог. Хүнд зэргийн сэтгэл гутралын үед бүх л өдөржингөө сэтгэл санаа доогуур байх ба таатай үйл явдал тохиолдоход сэтгэл санаа сэргэдэггүй. Сэтгэл гутралтай хүмүүсийн сэтгэл санаа өдөржингөө таагүй байдаг ч ихэнхидээ өглөөгүүр хүнд таагүй байгаад үдээс хойш болохоор сэргээд ирдэг. Үүнийг “Өдрийн хэлбэлзэл” гэх ба сэтгэл гутралын маш түгээмэл хэлбэр нь билээ.

Бодол

Сэтгэл гутралын үед хүний бодол нэг тодорхой жимтэй. Зүйрлэвэл, сөрөг гэрэл асчихсан юм шиг. Тэдний мэдрэмж нь таагүй, бүх л зүйл хүнд хэцүү санагдаж, ирээдүйдээ итгэх итгэл байхгүй болсон байдаг. Сэтгэл гутралтай хүмүүс уй гашууд автаж, бүх л зүйлд өөрийгөө буруутгадаг. Ихэнхдээ тэдэнд өөртөө итгэх итгэл, өөрийгөө хүндлэх байдал маш доогуур байдаг.

Бие махбод

- Сэтгэл гутралын үед зарим хүнд бие махбодын шинжүүд илэрдэг. Үүнд:
- Нойр өөрчлөгдөх. Зарим хүмүүсийн нойрны хэмнэл өөрчлөгддөг. Тухайлбал, өглөө босоход хэцүү байсан бол шөнийн цагаар маш сэргэг, унтаж чадахгүй байх гэх мэт.
- Хоолны дуршил буурсантай холбоотой биеийн жин буурах эсвэл хэвийнээс их хэмжээгээр идсэнээс биеийн жин нэмэгдэх.
- Бэлгийн дур хүсэл буурах
- Тамир тэнхээгүй болох, өдөр тутмын идэвхитэй үйл ажиллагаа, сэдэл тэмүүлэл байхгүй болдог. Сэтгэл гутралтай хүмүүс хүсэл сонирхолгүй, идэвхигүй байдлаасаа болж урьд нь баяр баясгалан мэдэрдэг зүйлээ хийхээ больдог.

Хүмүүстэй харилцах

Сэтгэл гутралтай олон хүн бусадтай харилцах харилцаандаа маш их санаа нь зовдог. Тэд ихэнхидээ аз жаргалгүй, гэр бүлийнхэндээ сэтгэл

дундуур, урам хугарсан байдалтай, бусадтай хаалттай харилцдаг. Тэд магадгүй өөр хүмүүстэй, ялангуяа зарим хүмүүсийн дунд байхдаа ичиж, сэтгэл нь түгшдэг. Мөн ганцаардмал, тусгаарлагдсан байдлыг ихэнхидээ мэдэрдэг ба түүний хийх гэж буй зүйл нь маш их боломжийг түүнд авчрах байсан ч гэсэн түүнийг хийх гэж оролддоггүй.

Сэтгэл гутралын шинж тэмдгүүд

Сэтгэл хөдлөл: Дүнсгэр, гунигтай, итгэл найдвар муутай, уйламтгай, сэтгэл түгшсэн, гэгэлзсэн, уцаарламтгай

Бодол санаа: Сэтгэлгээ удаашрах, анхаарал төвлөрүүлэхэд хэцүү байх, амиа егүүтгэх тухай бодох, өөрийгөө буруутгах

Зан үйл: Үлбэгэр, сул дорой байдал, тодорхой бус биеийн зовиур, санаачлагагүй болох, амархан ядрах, хоолонд дургүй болох, нойр хулжих, амиа егүүтгэхийг завдах

Сэтгэл гутралтай үйлчлүүлэгчтэй харилцах

Сэтгэл гутралтай үйлчлүүлэгчтэй харилцах, ялангуяа өвчний түүхийг тодорхой мэдэж авах, бие махбодын болон сэтгэцийн иж бүрэн үзлэг хийх нь эрүүл мэндийн ажилтнуудад хэцүү байдаг. Энэ нь авах шаардлагатай арга хэмжээний эхний алхмуудыг тодорхойлоход маш их чухал үүрэгтэй. Ялангуяа энэ нь үйлчлүүлэгчийн амь насыг аврахад бүр ч их ач холбогдолтой байдаг. Эдгээр үйлчлүүлэгчийн биеийн өвчнийг илрүүлнээр эмийн эмчилгээг шууд эхлүүлэх шаардлага гарч ирж болно. Эсвэл сэтгэл гутралын байдалд орсон үйлчлүүлэгчээс амиа егүүтгэх бодол санаа байдаг эсэхийг асуух хэрэгтэй. Хэрэв ийм бодол санаа байвал эрүүл мэндийн ажилтан үйлчлүүлэгчийг сэтгэцийн эмч буюу хамгийн ойр байдаг эмнэлэг рүү явуулах хэрэгтэй. Үйлчлүүлэгчийн гэр бүлийн гишүүдэд биеийн өвчний талаар болон амиа егүүтгэх бодолтой байгаа тухай мэдэгдэх хэрэгтэй. Сэтгэл гутралын хажуугаар биеийн өвчин юм уу, амиа егүүтгэх хандлагатай болоогүй л бол тэдэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлдэг ажилтан тусалж болно.

Сэтгэл гутралтай үйлчлүүлэгчтэй ажиллах

Сэтгэл гутралтай үйлчлүүлэгчид туслах хамгийн энгийн бөгөөд анхны арга хэмжээ бол түүнийг анхааралтай сонсох явдал мөн. Эрүүл мэндийн ажилтан нь үйлчлүүлэгчийн мэдрэмж, бодол санаа болон зан үйлийг зохицуулахдаа дараах байдлаар зохицуулж болно. Үүнд:

Үйтгэрлал

Үйлчлүүлэгч сэтгэл гутарсан байдлаас шууд гарах хэрэгтэй буюу түүний гутарсан сэтгэл болон бодол санаа нь зөвхөн түүний толгойд л байгаа гэж хэлж болохгүй. Энэхүү гутарсан сэтгэл болон бодол санаа үйлчлүүлэгчийн хувьд жинхэнэ бөгөөд дарамттай байдаг. Ийм учраас тэднийг энэ тухайгаа чөлөөтэй ярих, бүр уйлж болохыг ч хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Харамсах болон өөрийгөө буруутгах сэтгэл

Үйлчлүүлэгчийг өөртөө харамсах болон өөрийгөө буруутгах мэдрэмжтэй болсон шалтгаан, нөхцөл байдлын тухай яриулж тодруулж авна. Үйлчлүүлэгч өөрийнхөө сэтгэл санааны байдлыг хэт их дэврүүлж байгаагаа ухамсарлаж магадгүй бөгөөд өөрийгөө тийм ч муу хүн биш гэдэгт итгэх болно.

Сэтгэл түгших ба уцаарлах

Энэхүү мэдрэмж нь дарамттай байж болох бөгөөд цаанаа сэтгэл гутралын шинжийг агуулж болох юм. Үйлчлүүлэгч сэтгэл гутрал цаг хугацааны эрхээр өнгөрдөгийг сануулж үйлчлүүлэгчийн сэтгэл санааны байдал сайжрах тутам сэтгэл түгших болон уцаарлах сэтгэл аажимдаа арилна гэдгийг хэлэх хэрэгтэй.

Амиа егүүтгэх бодол

Үйлчлүүлэгчээс амиа егүүтгэх тухай бодож байгаа эсэхийг асууна. Мөн түүний төлөвлөлтийн тухай, тухайлбал хэр олон удаа амиа егүүтгэх тухай боддог, ямар аргаар гүйцэтгэх гэж байгааг тодруулна. Энэхүү мэдээлэл бол амиа егүүтгэх санаа зорилго, амиа егүүтгэхэд бэлэн байгаа байдлыг үнэлэхэд тус болно. Хэрэв эрүүл мэндийн ажилтанд өөрт нь эвгүй биш байвал тэрээр үйлчлүүлэгчээс бурханд залбирах нь түүний зовлонг хэр зэрэг нимгэлж өгч байгааг асууж болно. Энэхүү асуулт бол амиа егүүтгэх санаа бодлыг бурханд мөргөх аргаар хянаж болдогийг үйлчлүүлэгчид шууд бус замаар сануулж байгаа хэрэг юм.

Санаачлагагүй, ядрамтгай байх

Санаачлагагүй, өдрийн турш юу ч хийгээгүй байсан ч ядрах шинэ тэмдгүүдтэй тэмцэхдээ үйлчлүүлэгчийг өдөрт тодорхой зүйл хийх, өөрийнх нь сэтгэл санааг өөдрөг болгох ямар нэг зүйл хийхийг санал болгох зэрэг арга хэмжээ авах нь хамгийн зүйтэй.

Нойр хулжих, хоолны дуршил, биеийн жин буурах

Эдгээр шинж тэмдэг 2 долоо хоногоос дээж үргэлжилбэл сэтгэцийн эмч рүү явуулах хэрэгтэй. Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийг эмч рүү явуулж сэтгэл гутралын эсрэг эм бичүүлнэ.

Сэтгэл гутралын үед авах арга хэмжээ

- Үйлчлүүлэгчийг зовиурыг нь яриулж түүнийг сайтар сонсож ойлгох
- Амиа егүүтгэх бодолтой байгаа эсэхийг асуух. Хэрэв амиа егүүтгэх бодолтой байвал сэтгэцийн эмч рүү илгээх
- Хэрэв шаардлагатай бол эмч рүү илгээж сэтгэл гутралын эсрэг эм бичүүлж авах
- Үйлчлүүлэгчийн гэр бүлтэй ярилцах, үйлчлүүлэгчид туслах яаралтай арга хэмжээний талаар ярилцах
- Нийгэм хамт олноос дэмжлэг авах бололцоог судалж бодитойгоор биелэгдэх арга замыг олох.

Сэтгэл гутрах хам шинжтэй үйлчлүүлэгч, түүний ар гэрийнхэнд өгөх мэдээлэл, зөвлөгөө

Мэдээлэл

- Сэтгэл гутрал нь бие махбодын өвчин, сэтгэцийн өвчний аль алины үед илэрч болно.
- Зарим тохиолдолд сэтгэл гутрал нь тодорхой шалтгаангүйгээр үүсдэг.
- Үйлчлүүлэгчийн сэтгэл санаа гутранги, үйлдэл хөдөлгөөн ердийн байдлаас удаашрах, хэл яриа удаан, болж буй үйл явдалд өөрийгөө буруутгах, зэмлэх, өөрийн буруутай байдлаас болж амьдрах боломжгүй болсон гэх мэт бодит байдалд нийцэмгүй зүйл ярих нь өвчний шинж тэмдэг мөн.
- Сэтгэл гутрал нь эмчлэгдэх боломжтой.
- Сэтгэл гутрал нь дахих хандлагатай.
- Сэтгэл гутрал нь солиорлын шинжүүдтэй хавсран илэрч болно.
- Сэтгэл гутрал нь сэтгэл хөөрөх шинжтэй ээлжлэн солигдох буюу нэгэн зэрэг хавсран илэрч болно.
- Сэтгэл гутрах эмгэгээс урьдчилан сэргийлэх боломжтой байдаг.
- Сэтгэл гутрах эмгэгийн засралын үед ажлаа хийх буюу сургуульдаа суралцах боломжтой байдаг.

Зөвлөгөө

- Үйлчлүүлэгчийн өвчин нь засралын байдалд байгаа, зовиур илрээгүй байсан ч ерөнхий мэргэжлийн эмчийн хяналтанд байх буюу шаардлагатай үед зөвлөгөө авч болно.
- Тодорхой шалтгаангүйгээр сэтгэл санаагаар унах, гуниглах, өөрийгөө хэт буруутгах, үйлдэл хөдөлгөөн ердийнхөөс удаашрах, юм хийх идэвхигүй болох, хоол унднаас татгалзах нь уг өвчний шинж тэмдэг тул эмчид хандах хэрэгтэй.
- Сэтгэл гутрах эмгэгийн гол эмчилгээ нь сэтгэц нөлөөт эмийн /сэтгэл гутралын байдлаас гаргах/ эмчилгээ учир эмчийн заавраар эмчилгээ хийлгэх хэрэгтэй.
- Сэтгэл гутрал нь хөнгөн явцтай, солиорлын шинж тэмдэггүй бол гэрийн нөхцөлд өрхийн эмчийн хяналтанд эмчлүүлж болно.
- Сэтгэл гутрал нь хүнд явцтай, солиоролтой, үхэх тухай бодолтой дошгирлын болон бусад шинжүүд хавсран илэрвэл богино хугацаагаар нийгмээс тусгаарлан эмнэлэгт хэвтүүлэн эмчилнэ.
- Сэтгэц нөлөөт эмийг зөвхөн эмчийн заалтаар хэрэглэх бөгөөд эмнэлгээс гарсан ч дахилтаас сэргийлэх зорилгоор 6 сараас доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн хэрэглэнэ.
- Үйлчлүүлэгч сэтгэл гутралын улмаас өөрийгөө гэмтээх, амиа егүүтгэх оролдлого хийх, гэр бүлийнхэндээ аюултай үйлдэл хийж болзошгүй тул гэр бүлийн гишүүд хяналт тавих хэрэгтэй.

- Өвчний засралын үед үйлчлүүлэгчтэй чөлөөтэй ярилцах, санаа бодлыг нь сонсох, хийж буй ажлыг нь дэмжих, дуртай зүйлийг нь хийлгэх зэргээр идэвхжүүлж байх хэрэгтэй.
- Өвчний засралын үед үйлчлүүлэгч өөрт тохирсон хөдөлмөр эрхлэх, гэр ахуйн хүрээний ажилд оролцох, суралцах бүрэн боломжтой.

3.5 ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН НАСАНД ХҮРЭГЧДЭД БОДИТ ҮЗЛЭГ ХИЙХ

Харж ажиглах

- Үйлчлүүлэгчийн гадаад байдлыг ажиглах /айж түгшсэн, гайхсан, учраа олохгүй мэгдсэн, сэтгэл гутарсан байдалтай эсэх/
- Үйлчлүүлэгчид хөдөлгөөний өөрчлөлт байгаа эсэхийг ажиглах /хөших, сэтгэц хөдөлгөөний хөөрөлд автан хөдөлгөөн ихсэх/
- Үйлчлүүлэгчийн зан үйлийг ажиглах /орилж хашгирах, уйлах, үсээ зулгаах, мэгдэн зугтах, дуугарахгүй байх гэх мэт/
- Бие махбодын ил харагдах хэсгүүдэд шарх, сорви байгаа эсэх

Бодит үзлэг хийх

- Амьсгалыг тоолох
- Артерийн даралт хэмжих
- Судасны лугшилт тоолох
- Симпатик хөөрлийн шинжүүдийг шалгах /хүүхэн хараа өргөсөх, тэнцвэр алдах, чих шуугих, толгой эргэх, чичрэх, хөлрөх, зүрх дэлсэх, шээс хүрэх/
- Хэл ярианы өөрчлөлт байгаа эсэхийг шалгах /хэл яриа түргэсэх, удаашрах эсвэл дуугүй болох/
- Амьсгалын эрхтэн тогтолцооны үзлэг
- Зүрх судасны эрхтэн тогтолцооны үзлэг
- Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны үзлэг
- Шээс ялгаруулах эрхтэн тогтолцооны үзлэг
- Ханиалгах, толгой эргэх, амьсгаадах, амьсгал багтрах гэм мэт амьсгал хэт давчдах шинж илэрч буй эсэхийг шалгах
- Бие махбодод ямар нэг шарх, сорви байгаа эсэхийг шалгах /амиа егүүтгэх оролдлого хийсэн эсэхийг тодруулах зорилгоор хийнэ/
- Бие махбодын өвчнөөс ялган оношлох шаардлагатай бол нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулан шинжилгээ хийх

Сэтгэцийн үзлэг

Сэтгэц эмгэгийн хүрээгээр тухайн үеийн сэтгэцийн байдлыг тодорхойлох үзлэг хийнэ. Хүчтэй стресст үзүүлж буй хариу урвалын эмнэлзүйн хэлбэрийг оношийн шалгуур шинжүүдийн дагуу ялган оношилно.

- Сэтгэл түгшүүрийн түвшин тогтоох Спилберг ханины сорил /III бүлгийн хавсралтаас харна уу/
- Сэтгэл гутралын шинж илэрч буй эсэх, сэтгэл гутралын түвшинг тогтоох Бекийн сорил. /II бүлгийн хавсралтаас харна уу/

Эмнэлзүйн ажиглалтыг дараах байдлаар тэмдэглэнэ

Хүчирхийллийн хэлбэр	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ
Бие махбодын хүчирхийлэл <ul style="list-style-type: none"> • Хазах • Заамдах • Цохих • Түлхэлцэх • Өшиглөх • Алгадах • Буудах • Хутгалах • Эм, эмнэлгийн тусламж, хүнс хоол өгөхөөс татгалзах • Согтууруулах ундаа эсвэл бусад мансууруулах бодис хүчээр хэрэглүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Няцралт /хөхрөх/ • Зүсэгдэх, ихэвчлэн гар, нүүр • Толгойн өвдөлт • Сэтгэл түгшилт • Гипервентиляц • Даралт ихсэлт • Цээж хөндүүрлэх • Архаг өвдөлт • Жирэмслэлтийн явцад • Хэвлий, хөх болон бэлэг эрхтэний гэмтэл • Цус алдах, ихэс ховхрох орно • Умай урагдах • Зулбах/дутуу төрөх • Хугацаанаасаа өмнө төрөх • Гялтан хальс түрүүлээд урагдах • Жирэмсэн үеийн тусламжийг хожуу авах • Үзлэгтээ очилгүй байнга таслах • Жирэмсэн үеийн боловсрол олгох үйлчилгээнд дутуу хамрагдах • Хоол тэжээл муутай байх • Жирэмсэн үедээ тамхи, мансууруулах бодис эсвэл согтууруулах ундаа үргэлжлүүлэн хэрэглэх

<p>Бэлгийн хүчирхийлэл</p> <ul style="list-style-type: none"> Зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн бэлгийн шинжтэй үйлдэл хийхийг албадах эсвэл оролдох Хүчин, бэлгийн гаж үйлдэл төрх, бэлэг эрхтэн орчимд халдах Хамгаалалтгүй бэлгийн хавьтал Хүчээр биеийг нь үнэлүүлэх Хохирогчийг дорд үзэх, сексийн талаар задгай ярих Ил задгай, бэлгийн хавьтлыг харуулсан кино эсвэл зураг авах, үзүүлэх, түүнийг хохирогчийн эсрэг ашиглах Хамтрагчийнхаа бэлгийн харьцааг дорд байдлаар үзэх Бэлгийн ажил, хүсэл сонирхлыг нь шүүмжлэх Араар тавьдаг гэж буруутгах Бэлгийн харилцаанд орохгүй байх 	<ul style="list-style-type: none"> БЗДХ ХДХВ Олон удаа жирэмслэх Жирэмслэлттэй холбоотой гэмтэл, голдуу хэвлий, хөх болон бэлэг эрхтэн орчимд Өөрөө зулбах Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой сэтгэл зүйн гэмтлүүд Сэтгэл гутрал Сэтгэл түгших
<p>Эдийн засгийн хүчирхийлэл</p> <ul style="list-style-type: none"> Хүнийг санхүүгийн хараат болгох эсвэл оролдлого хийх 	<ul style="list-style-type: none"> Сэтгэл гутрал Сэтгэл түгших Мигрень/толгой өвдөх
<p>Сэтгэл санааны хүчирхийлэл</p> <p>Хүний өөрийгөө үнэлэх чадварыг дарах, эсвэл доромжлохыг оролдох</p> <ul style="list-style-type: none"> Байнга шүүмжлэх Доош хийх Доромжлох Гутаах Үл ойшоох, харьцахгүй байх Сэтгэл зүйгээр / сэтгэл хөдлөлөөр тоглох Дахин дахин амлалт өгөх, амлалтаа зөрчих Хамтрагчийнхаа хүүхдээ асран, хүмүүжүүлж буй эсвэл үр хүүхэдтэйгээ харилцаж байгаа байдлыг нь өөчлөх Хүүхдийг нь гэмтээх, алах эсвэл хулгайлна гэж айлган сүрдүүлэх Хүүхэдтэйгээ уулзахаар далимдуулж охилогчийг доромжлох 	<ul style="list-style-type: none"> Сэтгэл гутрал Сэтгэл түгших Даралт ихсэлт Булчингийн архаг чангарал Мансууруулах бодис хэрэглэх Амиа хорлох бодол Аллага хийх бодол Психосоматик өвчин

3.6 СЭТГЭЛ ЗҮЙН ДЭМЖЛЭГИЙН ҮЕИЙН ТҮГЭЭМЭЛ АРГА ТЕХНИК

Амьсгалын дасгал

Насанд хүрсэн хүний мэдрэлийн системийг тайвшруулах аливаа амьсгалын дасгалууд нь тодорхой хэмнэлд суурилдаг. Амьсгалын дасгалын бие махбодод үзүүлэх нөлөө нь амьсгалын хүч чадал, давтамж, тэдгээрийн гүн амьсгалах хугацаа зэргээс хамаарна гэдгийг ойлгох нь чухал юм. Хэрэв хэт их амьсгалж байвал маш бага хэмжээний хүчилтөрөгч уушиг руу орж, тайвшруулах нөлөө үзүүлэхгүй. Түүнээс гадна мэдрэлийн системийг эсрэгээр өдөөх болно, ингэснээр түүний үйл ажиллагаа идэвхижсэнээр тайван биш байдалд орно.

Мэдрэлийн системийг тайвшруулах аливаа амьсгалын дасгал нь хэвтэж эсвэл сууж байх үед хийгдэх ёстой бөгөөд нуруу шулуун байх шаардлагатай.

Дасгалыг нүдээ анин, бясалгаж, сайхан зургууд, дүрсүүдийг төсөөлж хийхэд үр дүнтэй.

Амьсгалах үйл явцад анхаарал бүрэн төвлөрсөн байх ёстой бөгөөд эхний ээлжинд ухамсартайгаар хянах шаардлагатай болно.

Оюун санаа нь аливаа сөрөг бодлуудаас ангижрах ёстой бөгөөд бүх булчингууд бүрэн тайван байх ёстой.

Тайвшруулах дасгалуудыг 5-10 удаа давтах хэрэгтэй. Амьсгалахдаа бие махбод нь хүчилтөрөгчөөр, цэвэр энергиэр дүүрэн байгааг төсөөлөх хэрэгтэй.

Стресс түргэн тайлах Эверлийн амьсгалын дасгал

Энэ дасгалыг стресс түргэн тайлах буюу сэтгэлийн дарамтаас өөрийгөө түргэн чөлөөлөх зорилгоор голдуу ашиглана.

Үйлчлэл:

- Сэтгэл түгшилтийг намжаана.
- Булчингийн хүчдэлийг сулруулна.
- Симпатик мэдрэлийн хөөрлийг номхотгоно.
- Дотор эрхтэний хөөрлийг намжааж зүрхний түргэссэн цохилтыг удаашруулна.

Дасгалыг бүрэн эзэмшсэн хийгээд тогтмол сургуулилт хийдэг хувь хүнд дараах нөлөөг үзүүлнэ. Үүнд:

- Тайван, дөлгөөн зан төлөвтэй болно.
- Стресст өртөх эрсдэл багасна.
- Стресст өртөж гэмээнэ түүнийг хөнгөн давах ур чадвартай болгоно.



Дасгалыг эзэмших арга техник. Дараах 4 шаттай дасгалыг эзэмших сургуулалт хийнэ. Үүнд:

I үе шат. Биеийн байрлал ба төхөл сонгох

II үе шат. Амьсгаа авах

III үе шат. Амьсгаа барих

IV үе шат. Амьсгаа гаргах

I үе шат. Биеийн байрлал ба төхөл сонгох

Дасгалжигч нөхцөл байдалд тохируулан хэвтээ, суугаа, босоо гурван байрлалын аль нэгийг сонгоод зүүн гарын алгаа хэвлий буюу хүйсэн дээрээ тавина. Дараа нь баруун гараа зүүн гар дээр эвтэй байхаар тавина.

II үе шат. Амьсгаа авах

Дасгалжигч хэнхэрцэг болон хэвлийн хөндийг “агаар агуулагч сав” буюу “үлээгээгүй шаар” хэмээн төсөөлөөд хамраараа аажуухан хийгээд гүнзгий амьсгаа авна. Амьсгаа авах агшинд хамраар орсон агаар доош уруудан хэнхэрцэг болон хэвлийд байгаа “шаарыг” дүүргэж байна гэж төсөөлнө. Уушги буюу “шаар” агаараар дүүрэхийн хэрээр хэвлий /шаар/ төмбийж гарыг дээш түлхэж байгааг мэдэр. Амьсгаа гүйцэт авч дуумагц хэвлий болон хэнхэрцэг үлээсэн шаар шиг агаараар дүүрлээ гэж төсөөл. Амьсгаа авах агшинд хэвлийгээс эхэлсэн долгион хэлбэрийн хөдөлгөөн хэнхэрцэгийн дунд ба дээд хэсэг рүү шилжинэ. Амьсгаа авах мөчийн үргэлжлэх хугацаа дасгал сургуулалтын эхний 2 долоо хоногт 2 секунд орчим байвал зохилтой. Цаашид 3 дахь долоо хоногоос хойшхи хугацаанд амьсгаа авах мөчийг 2.5-3 секунд хүртэл уртасгана.

III үе шат. Амьсгаа барих

Амьсгаа авахаа зогсоож уушги буюу “үлээсэн шаар доторхи” агаарыг 2 секундээс илүүгүй хугацаагаар хадгалж энэ мөчид “миний бие тайван байна” гэж дотроо бод.

IV үе шат. Амьсгаа гаргах

“Үлээсэн шаарны” хийг гаргахаар аажууханаар буюу 2 секундээс багагүй хугацаанд амьсгаагаа гаргана. Амьсгаагаа гаргах явцад “Миний бие тайван байна” гэж дотроо бод. Амьсгаа гаргаж байх агшинд түрүү нь төмбийсөн хэвлий хонхойж гар доошоо хөдөлж, бас дээш өргөгдсөн хэнхэрцэг доошилж байгааг мэдэр. Амьсгаа гаргах шатны үргэлжлэх хугацаа дасгал сургуулалтын эхний 2 долоо хоногт 2 секунд, харин гурав дахь долоо хоногоос хойшхи хугацаанд 3 секунд байвал зохимжтой. Дээр дурьдсан 4 шаттай амьсгалын дасгалыг 3-5 удаа дэс дараалан хийнэ. Дасгал сургуулалтын явцад толгой эргэх, ханиалгах 2 шинжийн аль нэг илэрвэл дасгалыг зогсоо.

Дараагийн дасгал сургуулалтын үед толгой эргэх шинж үүсвэл дараах 2 арга хэмжээг авна. Үүнд:

1. Амьсгаа авах шатны хугацааг богиносгох

2. Дөрвөн шатны дасгалын тоог цөөрүүлэх

Дасгалын арга техникийг бүрэн эзэмшихийн тулд, бас үргэлж амар тайван байхын тулд дасгалыг өдөр бүр өглөө, өдөр, оройн цагаар тогтмол хийж байх хэрэгтэй.

Хамрын хоёр нүхээр ээлжлэн амьсгалах дасгал



Энэхүү дасгал нь стресс тайлах нэгэн арга юм. Дасгалжигч эхлээд баруун эрхий хуруугаараа хамрын баруун нүхний хажуу талд дарж хамрын зүүн нүхээрээ тайван, гүнзгий хийгээд удаан амьсгаа авна. Дараа нь баруун эрхий хуруугаа хамрын нүхний баруун хажуугаас холдуулж баруун долоовор хуруугаараа зүүн нүхний хажуу талд дарж хамрын баруун нүхээр амьсгаагаа удаан гаргана.



Үүний дараа амьсгаагаа гаргасан хамрын баруун нүхээр удаан гүнзгий амьсгаа авна. Амьсгаа авч дуумагц долоовор хуруугаа хамрын нүхний зүүн талаас холдуулж баруун эрхий хуруугаараа хамрын баруун нүхний хажуу талд дарж хамрын зүүн нүхээр амьсгаа авах хэлбэрээр хамрын хоёр нүхээр сэлгүүлэн амьсгална.

Булчин сулруулах дасгал

Тайвшруулах дасгалууд нь булчингийн янз бүрийн хэсгийн булчин сулруулахад чиглэгддэг. Тайвшрах болон зүрх судасны үйл явц, даралт хэвийн болж, булчинд цусны урсгал тогтворжиж, тархины үйл ажиллагаа идэвхжиж, мэдрэлийн эсийн тэнцвэрт байдал сэргэж, хүн тайвширснаар эрч хүчээ нэмэгдүүлдэг.

Дасгалыг тав тухтай тайван газарт хийнэ. Гэрэл бүдэг, чимээгүй, тав тухтай өрөөнд хийнэ. Сандал нь тухтай, тайван суух боломжийг хангасан байх ёстой. Эсвэл орон дээр хэвтээд дээшээ харж хэвтэнэ. Хувцас нь биеэ барихгүй байх ёстой. Нүдний шил, контакт линз, цаг, бүс, гутал зэргийг тайлах хэрэгтэй.

Булчин сулруулах дараалал: Гар-толгой-их бие-хөл

Булчин сулруулах дасгалын жишээ:

Өөрөөс гаралтай дасгал /Аутогенная тренировка/

Эхний үе шат: Бэлтгэл хангах үе

Үйлчлүүлэгч өөрөө уг заслын талаар анхны мэдэгдэхүүнтэй байхаас гадна уг дасгалыг тасралтгүй хийх ажил амьдралынхаа боломжийг хангасан байх шаардлагатай. Энэхүү үйл ажиллагаа хангагдсаны дараа дунд үеийн үйл ажиллагаанд шилжинэ.

Дунд үе шат: Өөрийгөө тайвшруулах ба булчин сулруулах үе

Стандарт 6 дасгал үйлдэнэ.

1. Энэ нь гар, хөлд хүндрэх сэрэл үүсгэхэд чиглэгдсэн дасгал

- Эхлээд "Миний баруун гар хүндэрч байна" гэж дотроо 6 удаа давтан хэлнэ. Үүний дараа "Би тайван байна" гэж дотроо 1 удаа хэлнэ.
- Эхлээд "Миний зүүн гар хүндэрч байна" гэж дотроо 6 удаа давтан хэлнэ. Үүний дараа "Би тайван байна" гэж дотроо 1 удаа хэлнэ.
- Үргэлжлүүлээд "Миний 2 гар хүндэрч байна" гэж дотроо 6 удаа хэлнэ. Үүний араас "Би тайван байна" гэж дотроо 1 удаа хэлнэ.
- Дараа нь гар гэдэг үгийн оронд хөл гэдэг үг орлуулж хөлд дасгал хийх бөгөөд дээрх дарааллаар миний баруун хөл хүндэрч байна хэмээх үгийг тус бүр 6 удаа давтан хэлнэ. Төгсгөлд нь би маш тайван байна гэж хэлнэ.
- Дээрх дарааллаар гар хөл хүндэрч байна гэж 6 удаа хэлээд төгсгөлд нь би тайван байна гэж хэлнэ.

2. Энэ нь гар, хөлд халуун оргих сэрэл үүсгэхэд чиглэгдсэн дасгал

- Эхлээд "Миний баруун гар халуун оргиж байна" гэж дотроо 6 удаа давтан хэлнэ. Үүний дараа "Би тайван байна" гэж дотроо 1 удаа хэлнэ.
- Эхлээд "Миний зүүн гар халуун оргиж байна" гэж дотроо 6 удаа давтан хэлнэ. Үүний дараа "Би тайван байна" гэж дотроо 1 удаа хэлнэ.
- Үргэлжлүүлээд "Миний 2 гар халуун оргиж байна" гэж дотроо 6 удаа хэлнэ. Үүний араас "Би тайван байна" гэж дотроо 1 удаа хэлнэ.
- Дараа нь гар гэдэг үгийн оронд хөл гэдэг үг орлуулж хөлд дасгал хийх бөгөөд дээрх дарааллаар миний баруун хөл халуун байна хэмээх үгийг тус бүр 6 удаа давтан хэлнэ. Төгсгөлд нь би маш тайван байна гэж хэлнэ.
- Дээрх дарааллаар гар хөл хүндэрч байна гэж 6 удаа хэлээд төгсгөлд нь би тайван байна гэж хэлнэ.

3. Зүрхний үйл ажиллагаа түүний хэмнэлийг зохицуулахад чиглэгдсэн дасгал

- Миний зүрх хүчтэй жигд цохилж байна гэж 6 удаа хэлнэ. Дараа нь "Би маш тайван байна" гэж 1 удаа хэлнэ.

4. Амьсгалын хэмнэлийг зохицуулахад чиглэгдсэн дасгал

- Би маш тайван амьсгалж байна гэж 6 удаа хэлээд үүний дараа би маш тайван байна гэж 1 удаа хэлнэ.

5. Энэ дасгал нь бидэнд үл захирагдах вегетатив мэдрэлийн төв болох наран сүлжээг захирч сурахад чиглэгддэг.

- Миний аюулхай орчим халуун оргиж байна гэж 6 удаа давтан хэлээд дараа нь би маш тайван байна гэж 1 удаа хэлнэ.

6. Энэ нь мөн л вегетатив мэдрэлээ захирч сурахад чиглэгддэг.

- Миний дух орчим сэрүү оргиж 6 удаа давтан хэлээд үүний дараа би маш тайван байна гэж 1 удаа хэлнэ.

Төгсгөлийн үе шат: Өөртөө ятган итгүүлэх засал явуулах үе

Идэвхгүй булчин сулруулах аргын зорилго нь биеийн гол булчингийн бүлгийг сулруулахад оршино. Энэ аргын давуу тал нь аливаа нөхцөлд бусдын анхаарлыг нь татахгүйгээр хийх боломжтой.

Таны бие нь нарны туягаар дүүргэсэн гэдгийг төсөөлөн бод. Таны бие нь бүлээн, тайвширсан ба таатай байна.

Толгойн булчингууд:

Гүн амьсгалаа ав. Амьсгалахад толгойн бүх булчингууд хэрхэн тайвширдагийг мэдрэх нь дулаан амралтын долгион толгойн орой дээрээс бууж эхэлдэг. Духан дээрх булчинд анхаарлаа төвлөрүүл. Бүх үрчлээг тэнийлгэн нүүрний булчингууд хэрхэн тайвширдагийг мэдэр. Духны булчинд анхаарлаа төвлөрүүл, тайван байх хэрэгтэй. Хар тугалгаар дүүрсэн мэт зовхины булчингууд хэрхэн хүндэрч байгааг мэдэр. Хамрын булчингууд амарч, хүндэрдэг. Тааламжтай дулаан нь дух, зовхи, хамрын бүх булчингуудад тархсан. Амны булчингууд тайвширч, хүндэрдэг. Ам ба эрүүний булчингууд хүнд, тайван болоход анхаарлаа төвлөрүүл. Бүх таагүй бодол алга болж, бүх санаа зовнил, түгшүүр таныг орхисон байна.

Хүзүү ба мөрний булчингууд

Одоо хүзүүний булчинд халуун дулаан амрах долгион мэдрэгдэж эхэлнэ. Бүх хүзүүний булчингууд тайвширч, дулаахан болж, хүнд болж байна. Та амарч, тайвширсан байна. Одоо мөрний булчинд халууны тааламжтай долгион бууж байна. Мөрний бүс дэх булчингууд тайван, хүнд болж байгааг мэдэр. Хүзүүний бүх булчин, мөрний бүслүүрийн булчингууд хүнд, тайвширсан болоход анхаарлаа төвлөрүүл. Сэтгэлийн түгшүүр, ядаргаа мэдрэх нь бие махбодоо орхих болно.

Гарын булчингууд

Тааламжтай дулаан амралтын долгион гарт хүрч бүх булчингуудад тархаж байгааг мэдэр. Бүх булчингууд тайвширч, хүндэрч, хар тугалгаар дүүрсэн юм шиг болно. Үүссэн мэдрэмжийг сайн санаарай.

Цээж, хэвлийн булчингууд

Цээж, хэвлийн булчинд анхаарлаа төвлөрүүл. Цээж, хэвлийн булчинг

сулруулж сэтгэлийн түгшүүрийг алга болсныг мэдэр. Амьсгал нь илүү тайван болсон. Амьсгалах тусам бүх биеийн булчингийн хүчдэл буурсан. Та амарч байна. Та тайван байна.

Хөлний булчингууд

Хөлний булчинд анхаарлаа төвлөрүүл. Амралтын дулаан долгионыг хонго руугаа живж байгааг мэдрээрэй. Гуяны булчингууд нь хар тугалгаар дүүрсэн мэт дулаан, хүнд болж хувирсан. Дулаан нь доошоо бууж, доод хөлийг хамарна. Хөлний булчингууд амарч, хүнд, дулаахан болсон. Хоёр тавхайн булчингууд хэрхэн тайвширсныг мэдэр.

Идэвхгүй булчин сулруулах аргыг унтахынхаа өмнө орой ашиглах бол дасгал хийсний дараа хүн тайван унтах болно.

Хэрэв өдрийн турш идэвхгүй булчин сулруулах аргыг хэрэглэдэг бол дасгалын төгсгөлд дараах томъёог хэрэглэх хэрэгтэй. “Би маш сайн амарч, тайвширсан. Одоо би 1-ээс 5 хүртэл тоолох болно. Би тоолох тусам улам улам сэрүүн болж, бүх бие минь сайжирч байгааг мэдрэх болно. 5 хүртэл тоолоход би шууд нүдээ нээгээд сэрүүн, шинэхэн, эрч хүчээр дүүрсэн мэт, үүргээ сайн гүйцэтгэхэд бэлэн болно. Нэг ! Би илүү идэвхтэй, шинэлэг болсон байна. Хоёр! Миний биеийн бүх булчингууд амарч, хүч чадлаар дүүрэв. Гурав! Би хүчтэй байгаагаа мэдэрч байна. Дөрөв! Би явахад бэлэн байна. Тав! Нүдээ нээ.

Бясалгал

Үйлчлүүлэгчийг “Өөрийн амьдралд тохиолдсон хамгийн аз жаргалтай мөчийг сана” гээд зөвлөнө. Тэр үеийн хараа, сонсгол, амт, үнэр, мэдрэхүй ямар байсныг санаарай гэж зөвлөнө.

А. Амьсгалын дасгал болон булчин сулруулах дасгалын дараа ухамсрын өөрчлөлтийн үе шатанд шилжиж болно.

Б. Эмч нь төсөөлийн талаар тайлбарлана, үйлчлүүлэгч тайлбарсаны дагуу төсөөлнө. Үйлчлүүлэгчийн төсөөлөл зөвлөгчийн дагуу биш байх бол, зөвлөгч нь үйлчлүүлэгчийн төсөөлөл дээр зөвөлгөө өгнө.

В. Үйлчлүүлэгчийн төсөөлөл дээр ажиллаж байгаа тохиолдолд зөвлөгч нь төсөөллийг гүзгийрүүлнэ.

Г. Зөвлөгч нь нарийн дэлгэрэнгүй тайлбарыг үйлчлүүлэгчээс хүсэж болно.

Бясалгалын жишээ

Нүдээ зөөлөн анина. Гүнзгий амьсгалаа аваарай. Амьсгал авах бүрт та тайван болж байна, улам тайван болж байна. Одоо өөрийгөө маш гоё өөрийн хувийн цэцэрлэгт хүрээлэн дээр зогсож байна гэж төсөөлөөрэй. Та амар тайван, амгалан тайвширсан байна. Нарны зөөлөн туяад эргэн тойрон бүх зүйлс шумбаж байна. Олон өнгийн эрвэйхээнүүд агаарт нисэж байна, цэцэгсийн зөөлөн үнэрийг та хамраараа үнэрлэн мэдэрч байна. Та цэцэрлэг дотроо бүх юм тайван, амгалан, үзэсгэлэнтэй байна. Одоо та зүлгэн дээр хэвтэж байна. Нарны туяа таны биеийг бүлээсгэж байна.

Таны бие болон таны бодлууд тайвширсан байна. Одоо энэ гайхалтай тайван байдлыг та зүрхээрээ мэдэрч байна!

Сэтгэл зүйн тусламжийн арга, техникүүдийг

Анхдагч шатлалын түвшинд:

- Тайвшруулах амьсгалын дасгал зааж сургах
- Бухимдал тайлах аргуудыг зааж өгөх
- Сэтгэл түгшилтийн шинжүүд тод илэрч байвал сэтгэл түгшилтийн эсрэг тайвшруулах эм бэлдмэл хэрэглэх

Лавагаа шатлалын түвшинд:

- Өөрийгөө сургах дасгалыг эзэмшүүлэх
- Сэтгэл зүйн дарамтаас чөлөөлөх сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
- Харилцан нөлөөлөх бүлгийн сэтгэл засал эмчилгээ
- Илэрч буй хариу урвалд тохирсон сэтгэц нөлөөт эмэн эмчилгээ хийх

3.7 ХАВСРАЛТУУД

Сэтгэл гутралын түвшинг тодорхойлох Бекийн сорил

/Beck depression inventory, 1961/

II бүлгийн хавсралтаас харна уу.

Эмнэлгийн мэргэжилтэн эсвэл хохирогч өөртөө тохиолдож болох эрсдэлийг үнэлэх асуумж

II бүлгийн хавсралтаас харна уу.

Амиа хорлох оролдлогыг илрүүлэх богино хэмжээний сорил

II бүлгийн хавсралтаас харна уу.

Стрессорын улмаас үүссэн сэтгэл түгшилтийг тодорхойлох

Спилберг-Ханины сорил

Д/д	Бодомж	Үгүй, тийм биш	Бараг л тийм	Тийм	Яг үнэн
1	Миний сэтгэл тайван байна	4	3	2	1
2	Миний хувьд ямар нэгэн аюул заналхийлэл байхгүй байна	4	3	2	1
3	Миний сэтгэл тайван биш байна	1	2	3	4
4	Надад ямар нэгэн өрөвдөх сэтгэл төрөөд байна	1	2	3	4
5	Миний бие чөлөөтэй тэнэгэр байна	4	3	2	1
6	Би сандарчихаад байна	1	2	3	4
7	Ямар нэгэн бүтэлгүй явдал тохиолдож магадгүй гэж би зовж байна	1	2	3	4

8	Би сайхан амарснаа мэдэрч байна	4	3	2	1
9	Би нэг л түгшүүртэй байна	1	2	3	4
10	Миний сэтгэл хангалуун байна	4	3	2	1
11	Би өөртөө итгэлтэй байна	4	3	2	1
12	Би ундууцаж байна	1	2	3	4
13	Би бүр байх суух газраа олохгүй байна	1	2	3	4
14	Сэтгэл минь нэг л дэврүүн байна	1	2	3	4
15	Би биеэ огт бариагүй байна	4	3	2	1
16	Би сэтгэл ханамжтай байна	4	3	2	1
17	Ямар нэгэн зүйлд санаа минь зовоод байна	1	2	3	4
18	Сэтгэл санаа минь хэт цочирсоноос би өөрийн мэдлээ бүр алдаад байна	1	2	3	4
19	Би баяр хөөртэй байна	4	3	2	1
20	Миний сэтгэл тааламжтай байна	4	3	2	1
Нийт оноо					

Үнэлгээ:

- 30 хүртэл оноо Сэтгэл түгшүүрлэл бага
- 31-45 оноо Сэтгэл түгшүүрлэл дунд
- 46-аас дээш оноо Сэтгэл түгшүүрлэл өндөртэй

**Сэтгэл түгшилтийн төрөлхийн байдлыг тодорхойлох
Спилберг-Ханины сорил**

Д/д	Бодомж	Үгүй, тийм биш	Бараг л тийм	Тийм	Яг үнэн
1	Миний сэтгэл өндөр талдаа байдаг	4	3	2	1
2	Би их амархан ядардаг	1	2	3	4
3	Би амархан уйлдаг	1	2	3	4
4	Би бусадтай адилхан аз хийморьтой байхыг хүсдэг	1	2	3	4
5	Би тааламжгүй зүйлийг эмзэг хүлээн авч, түүнийгээ мартаж чадахгүй их уддаг	1	2	3	4
6	Өөртөө ажиллах хүч, урам зориг орж байгааг би мэдэрдэг	4	3	2	1
7	Би тайвандуу, хөндийдүү, нямбай хүн	4	3	2	1

8	Тохиолдож болох бэрхшээл намайг урьдчилан зовоодог	1	2	3	4
9	Өчүүхэн зүйлээс ч санаа минь их зовдог	1	2	3	4
10	Би аз жаргал дүүрэн хүн	4	3	2	1
11	Би бүхий л зүйлийг зүрхэндээ их ойрхон тусгадаг	1	2	3	4
12	Өөртөө итгэлтэй байх явдал надад дутдаг	1	2	3	4
13	Би өөрийгөө хамгаалах чадваргүй гэдгээ мэдэрдэг	1	2	3	4
14	Би төвөгтэй нөхцөл бэрхшээлээс зайлсхийдэг	1	2	3	4
15	Надад унжгар шаналгаатай байдаг тал бий	1	2	3	4
16	Би сэтгэл хангалуун байдаг	4	3	2	1
17	Өчүүхэн төдий ч юм бүр л миний анхаарлыг сарниулж намайг зовоодог	1	2	3	4
18	Өөрийгөө азгүй хүн гэж тооцох үе надад байдаг	1	2	3	4
19	Би тогтвор суурьшилтай хүн	4	3	2	1
20	Өөрийн ажил хэрэг, санаа тавих зүйлийг бодохоор би тайван байдлаа алддаг	1	2	3	4
Нийт оноо					

Үнэлгээ:

- 30 хүртэл оноо Сэтгэл түгшүүрлэл бага
- 31-44 оноо Сэтгэл түгшүүрлэл дунд
- 45-аас дээш оноо Сэтгэл түгшүүрлэл өндөртэй

**Сэтгэл гутралын шалтгаан, түвшинг тодорхойлох
Цунгийн сорил**

Д/д	Асуулт	Үгүй, тийм биш	Бараг л тийм	Тийм	Яг үнэн
1	Би уйтгартай байгаагаа мэдэрч байна	1	2	3	4
2	Би өглөө сэргэлэн цовоо байдаг	4	3	2	1
3	Надад нулимс цийлэгнэх, уйлах үе ч байдаг	1	2	3	4
4	Би шөнө нойр муутай байна	1	2	3	4

5	Миний хоол идэх дур хэвийн байна	4	3	2	1
6	Сэтгэл татам хэн нэгнийг харах, түүнтэй ярих, хамт байх нь надад тааламжтай байдаг	4	3	2	1
7	Би турж байгаа нь надад мэдрэгдэж байна	1	2	3	4
8	Миний өтгөн хатдаг	1	2	3	4
9	Миний зүрх дэлсээд байна	1	2	3	4
10	Би ямар ч шалтгаангүйгээр ядардаг	1	2	3	4
11	Би урьдынхтайгаа адил оновчтой сэтгэж байна	4	3	2	1
12	Чаддаг зүйлээ хийхэд надад хялбар байдаг	4	3	2	1
13	Би тайван биш, нэг газраа тогтвортой байж чадахгүй байна	1	2	3	4
14	Надад ирээдүйдээ итгэх итгэл бий	4	3	2	1
15	Би ердийнхөөс илүү цочромтгой байна	1	2	3	4
16	Шийдвэр гаргахад надад амархан байна.	4	3	2	1
17	Би бусдад хэрэгтэй хүн гэдгээ мэдэрч байна.	4	3	2	1
18	Би хангалттай сайхан амьдарч байна.	4	3	2	1
19	Би үхчихвэл бусад хүмүүст амар байх болно.	1	2	3	4
20	Би урьд нь сэтгэл ханамж авч байсан зүйлдээ одоо ч гэсэн сэтгэл хангалуун байдаг.	4	3	2	1
Нийт оноо					

Үнэлгээ:

- | | |
|---------------------|--|
| 1. 50 хүртлэх оноо | Хэвийн, сэтгэл гутралгүй |
| 2. 50-59 оноо | Тухайн нөхцөл байдлаас, ядаргаанаас үүдэлтэй сэтгэл гутрал |
| 3. 60-69 оноо | Хөнгөн сэтгэл гутрал, далд сэтгэл гутрал |
| 4. 70-аас дээш оноо | Сэтгэл гутралтай |

Стресстэй байгаа эсэхээ өөрөө шалгах богино хэмжээний тест
Сүүлийн нэг сард дараах шинжүүдээс аль нь илүү тохирч байгааг сонгон хариулна уу.

Д/д	Асуулт	Үгүй	Хааяа	Хэд хэдэн удаа	Олон удаа	Үргэлж
		0	1	2	3	4
1	Та амархан ядарч, хангалттай унтаж амарсан ч гэсэн дандаа л амраагүй юм шиг сульданги байдаг уу?					
2	Хүмүүс өөрсдийнхөө өдөр тутмын, болох болохгүй явдлынхаа талаар ярихад танд яршигтай, үүнээс болж амархан уурлаж уцаарладаг уу?					
3	Өөрт чинь нэн тулгамдсан шийдвэрлэх боломжгүй, ичгүүргүй байдал бий болсон мэт мэдрэмж төрдөг үү?					
4	Та юунаас болоод байгаагаа өөрөө ч мэдэхгүй, уйтгар гунигт автан, хэвийн үед байдгаасаа уйламтгай болоод байна уу?					
5	Та төлөвлөсөн уулзалт, өнгөрсөн аливаа үйл явдлын сүүлийн хугацаа, амины эд зүйлээ мартдаг уу? Таны ухаан эзгүйрч хоосрон, мартамтгай болсон юм шиг байна уу?					
6	Та найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ цөөн уулзах болж, ганцаараа байх, хүмүүсээс тэр ч бүү хэл найз нөхдөөсөө ч хүртэл холдохыг хүсдэг болсон уу?					

7	Өдөр тутмынхаа ажлаа хийхэд урьдынхаасаа илүү хүч орох болсон уу?					
8	Өөрт чинь ходоод өвдөх, толгой өвдөх, хүйт даах, бие нозоорох гэх мэт ямар нэг зовиур байна уу?					
9	Өдрийн ажлаа дуусгасны дараа дэндүү ядарч тэнхээгүй болсон мэт мэдрэмж танд үүсдэг үү?					
10	Урьд нь таны сонирхолтой, дуртай байсан зүйл чинь одоо сонирхлыг чинь татахаа больсон уу?					
11	Та ажилдаа дур сонирхолгүй болж, ажил хийнэ гэхээр сэтгэлээр шаналах болсон уу?					
12	Таны төлөвлөгөө санаснаасаа бага үр дүнд хүрэх болсон уу?					
13	Та ажлаас үүссэн стрессээ тайлахын тулд хоол ундаа багасах, ихэсгэх, тамхи их татах, архи их уух байдалд орсон уу?					

Тайлбар:

0-15 оноо

Та ажил дээрх стрессээ өөрөө тайлах боломжтой

16-25 оноо

Та ажлын үүсэлтэй стресст автсан бөгөөд түүнийгээ тайлах арга хэмжээ авахад оройтоогүй байна

26-35 оноо

“Туйлдал”-ын байдалд хүрэх боломжтой

35-аас дээш бол

“Туйлдал”-ын байдалд хүрснийг заана

НАСАНД ХҮРЭГЧИД ӨӨРИЙГӨӨ ҮНЭЛЭХ ТҮРГЭВЧИЛСЭН АСУУМЖ

Асуумж /SRQ-20/

Сүүлийн 30 хоногт доорх шинжүүдээс илэрч байсан бол “Тийм” гэсэн хариултыг сонгоорой. Эсрэгээрээ бол “Үгүй”-г сонгоорой. Энд зөв, буруу хариулт гэж байхгүй бөгөөд зарим асуултанд хэрхэн хариулахаа мэдэхгүй эргэлзвэл аль өөртөө ойролцоо хариултыг сонгоно уу.

Д/д	Сүүлийн 30 хоногт	Тийм	Үгүй
		1	0
1	Таны толгой үргэлж өвддөг үү?		
2	Хоолонд дургүй байна уу?		
3	Нойронд муу байгаа юу?		
4	Амархан айж цочиж байна уу?		
5	Таны гар салгалдаг уу?		
6	Стрессдэж байна уу?		
7	Хоолны шингэц муу байна уу?		
8	Тодорхой бодож сэтгэхэд хэцүү байна уу?		
9	Аз жаргалгүй мэт санагдаж байна уу?		
10	Ердийнхөөс илүү уйлж байна уу?		
11	Өдөр тутам хийдэг зүйлдээ сэтгэл ханамжгүй байна уу?		
12	Шийдвэр гаргахад хэцүү байна уу?		
13	Өдөр тутмын ажил чинь зовлон шаналантай байна уу?		
14	Амьдралд чухал хүн байхаа больсон юм шиг санагдах уу?		
15	Идэвхи сонирхол буурсан уу?		
16	Та ямар ч үнэ цэнэгүй хүн юм шиг санагдах уу?		
17	Өөрийн амьдралаа дуусгах талаар бодож байсан уу?		
18	Үргэлж л ядраад байгаа санагдах уу?		
19	Таны ходоод эвгүйдэг үү?		
20	Амархан ядарч байна уу?		
21	Тамхийг ердийнхөөс илүү татаж байгаа юу?		
22	Ердийнхөөс илүү ууж байгаа юу?		

Үнэлгээ:

- 1-20-р асуултын нийт оноо 20. Босго оноо 7-8. Нийт оноо 7-8-аас дээш бол сэтгэцийн эрүүл мэндийн тусламж шаардлагатай гэсэн үг.
- 21, 22-р асуултууд нь нэмэлт асуултууд бөгөөд архи, тамхины хэрэглээ нэмэгдсэн эсэхийг илрүүлнэ.

Бие, сэтгэцийн ерөнхий эрүүл мэндийн асуумж /GHQ-12/

Сүүлийн 2-3 долоо хоногт таны биеийн эрүүл мэндийн байдал ямар байсныг тодруулах хэрэгтэй байна. Зөв, буруу хариулт гэж байхгүй бөгөөд өөртөө аль ойролцоо хариултыг сонгоорой.

Д/д	Та сүүлийн 2-3 долоо хоногт				
1	Хийж буй зүйлдээ анхаарал хир төвлөрч байна вэ?	Ердийнхөөс илүү сайн	Ердийнх шигээ	Ердийнхөөс муу	Ердийн үеэсээ хамаагүй муу
2	Санаа зовсоны улмаас нойр алдаж байгаа юу?	Огт үгүй	Ердийнхөөс ихгүй	Ердийнхөөс арай илүү	Ердийн үеэсээ хамаагүй илүү
3	Өөрийгөө чухал хэрэгцээтэй мэтээр мэдэрч байна уу?	Ердийнхөөс илүү	Ердийнх шигээ	Ердийнхөөс муу	Ердийн үеэсээ хамаагүй муу
4	Шийдвэр гаргах ёстой гэж /чадвартай/ мэдэрч байна уу?	Ердийнхөөс илүү	Ердийнх шигээ	Ердийнхөөс муу	Ердийн үеэсээ хамаагүй муу
5	Үргэлж их ачаалалтай байгаа юм шиг санагдах уу?	Огт үгүй	Ердийнхөөс ихгүй	Ердийнхөөс арай илүү	Ердийн үеэсээ хамаагүй илүү
6	Танд тулгараад буй хэцүү асуудлуудаа давж туулж чадахгүй мэт санагдах уу?	Огт үгүй	Ердийнхөөс ихгүй	Ердийнхөөс арай илүү	Ердийн үеэсээ хамаагүй илүү
7	Өдөр тутмын ажил үйл, амьдралдаа сэтгэл хангалуун байгаа юу?	Ердийнхөөс илүү	Ердийнх шигээ	Ердийнхөөс муу	Ердийн үеэсээ хамаагүй муу

8	Өөрийнхөө тулгамдсан асуудалтай нүүр тулахад бэлэн үү?	Ердийнхөөс илүү	Ердийнх шигээ	Ердийнхөөс муу	Ердийн үеэсээ хамаагүй муу
9	Аз жаргалгүй, гунигтай мэдрэмжтэй байна уу?	Огт үгүй	Ердийнхөөс ихгүй	Ердийнхөөс арай илүү	Ердийн үеэсээ хамаагүй илүү
10	Өөртөө итгэх итгэлээ алдаж байна уу?	Огт үгүй	Ердийнхөөс ихгүй	Ердийнхөөс арай илүү	Ердийн үеэсээ хамаагүй илүү
11	Өөрийгөө үнэ цэнэгүй хүн гэж бодож байна уу?	Огт үгүй	Ердийнхөөс ихгүй	Ердийнхөөс арай илүү	Ердийн үеэсээ хамаагүй илүү
12	Бүх юмыг утга учиртай, аз жаргалтайгаар мэдэрч байна уу?	Ердийнхөөс илүү	Ердийнх шигээ	Ердийнхөөс муу	Ердийн үеэсээ хамаагүй муу
13	Тамхи илүү их татаад байна уу?	Огт үгүй	Ердийнхөөс ихгүй	Ердийнхөөс арай илүү	Ердийн үеэсээ хамаагүй илүү
14	Архи илүү их уугаад байна уу?	Огт үгүй	Ердийнхөөс ихгүй	Ердийнхөөс арай илүү	Ердийн үеэсээ хамаагүй илүү

- 1-12-р асуулт хүртэл эхний 2 хариултыг сонгосон бол 0, сүүлийн хоёр хариултыг сонгосон бол 1 оноо өгнө. GHQ 12 бол оношлогоо биш, харин сэтгэлийн өвдөлт зовиурын түвшинг илтгэнэ. Оноо өндөр байх тусам шаналал их байна гэсэн үг. Илрүүлгийн босго оноо 3.
- 13, 14-р асуултууд нь нэмэлт асуултууд бөгөөд архи, тамхины хэрэглээ нэмэгдсэн эсэхийг илрүүлнэ.

PTSD илрүүлэх товч скрининг

Сүүлийн 1 сард таны мэдрэмж ямар байгааг харгалзан “Тийм” “Үгүй”-г сонгон хариулна уу. Зөв, буруу хариулт гэж байхгүй бөгөөд өөрийн мэдрэмжид тулгуурлан хариултыг сонгоорой.

Д/д	Сүүлийн 1 сард	Тийм	Үгүй
		1	0
1	Ямар нэгэн зүйлийг эргэн дурсахгүйн тулд тодорхой газар орон, хүмүүс, болон үйл ажиллагаанаас зайлсхийдэг үү?		
2	Урд нь таатай хөгжилтэй санагдаж байсан зүйлс одоо сонирхолгүй санагдах уу?		
3	Хүмүүсээс зай аван, тусгаарлагдаж байгаа мэт мэдрэмж төрөх үү ?		
4	Бусдад сэтгэл алдрах, хайрлаж дурлахад хэцүү болсон шиг санагдах уу?		
5	Ирээдүйгээ төлөвлөх нь ямар ч утгагүй юм шиг санагдах уу ?		
6	Энэ явдлын дараа та ердийн үеийнх шигээ унтаж чадахгүй байна уу? Унтахад хэцүү байна уу?		
7	Ердийн дуу чимээ, хэн нэгний энгийн хөдөлгөөнөөс амархан цочин давхийж байна уу?		

Үнэлгээ:

Нийт 7 асуулттай, үүнээс 5 нь зайлсхийх, мохох шинжийг, 2 нь цочрол ихсэх шинжийг илрүүлнэ. Нийт 4 болон түүнээс дээш оноотой бол тухайн хувь хүнд сэтгэл зүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг байх боломжтой гэж үзнэ.

Сэтгэл зүйн тусламж үзүүлэгчийн сэтгэл хөдлөлийн эрсдэлийг үнэлэх

Та хүнд тусалж байна гэдэг нь та тухайн хүний амьдралтай шууд холбогдоно л гэсэн үг. Таны бусдад туслах чин сэтгэл эргээд танд өөрт чинь эерэгээр болон сөргөөр нөлөөлдөг. Хүнд тусалж буй хүний хувьд, таны үзэж туулсан эерэг сөрөг байдал аль алины талаар доорх хэдэн асуултанд хариулна уу. Зөв, буруу хариулт гэж байхгүй. Сүүлийн 30 хоногт аль хир давтамжтай байгаа талаар үнэнээр нь бөглөнө үү.

Д/д	Асуултууд	Хэзээ ч үгүй	Цөөхөн	Заримдаа	Ихэнхдээ	Нилээд их	Байнга
1	Би аз жаргалтай байна	0	5	4	3	2	1
2	Би нэгээс олон хүнд үйлчлээд их ачаалалтай байна	0	1	2	3	4	5
3	Хүмүүст тусалж байгаадаа сэтгэл ханамжтай байгаа	0	1	2	3	4	5
4	Бусадтай холбоотойгоо мэдэрдэг	0	5	4	3	2	1
5	Гэнэтийн чимээнд цочин давхийдэг	0	1	2	3	4	5
6	Хүмүүст туслах ажил хийснийхээ дараа урам зориг ордог	0	1	2	3	4	5
7	Өөрийн хувийн амьдралаа бусдад туслахаас салган ойлгож чадахгүй байна	0	1	2	3	4	5
8	Тусламж үзүүлж буй хүнд маань тохиолдсон зовлонг сонсоод унтаж ч чадахгүй байна, миний ажлын бүтээмж багассан	0	1	2	3	4	5
9	Миний тусалж буй хүмүүст тохиолдсон аймшигт явдал / сэтгэл зүйн гэмтэл/ надад ч нөлөөлж байна гэж бодож байна	0	1	2	3	4	5
10	Тусламж үзүүлэх ажилд баригдчихсан юм шиг санагдана	0	1	2	3	4	5
11	Туслах ажил хийж байгаагийн улмаас олон юмны “Яг ирмэг дээр” байгаа мэт санагдана	0	1	2	3	4	5
12	Туслах ажилдаа дуртай	0	1	2	3	4	5

13	Тусламж үзүүлж буй хүнд маань тохиолдсон зовлонг сонсоод сэтгэл гутардаг	0	1	2	3	4	5
14	Тусламж үзүүлж буй хүнд маань тохиолдсон зовлон надад тохиолдох вий гэж боддог	0	1	2	3	4	5
15	Намайг “Би” болгож байдаг өөрийн гэсэн итгэл үнэмшил надад бий	0	5	4	3	2	1
16	Хүмүүст туслах арга техникээ улам сайжруулах боломжтой байгаадаа талархалтай байдаг	0	1	2	3	4	5
17	Би бол үргэлж эрэлттэй хүн	0	5	4	3	2	1
18	Ажилдаа сэтгэл хангалуун байдаг	0	1	2	3	4	5
19	Туслах ажил хийсээр байгаад ядарч цуцсан байдаг	0	1	2	3	4	5
20	Хүмүүст тусалж чадсандаа аз жаргалтай байдаг	0	1	2	3	4	5
21	Ажлын ачаалал хэрээс хэтэрсэн, хэзээ ч дуусахгүй юм шиг санагддаг	0	1	2	3	4	5
22	Ажилдаа өөрчлөлт хийж чадна гэдэгтээ итгэлтэй байна	0	1	2	3	4	5
23	Миний тусламж үзүүлж байсан хүмүүст тохиолдсон аймшигт явдлыг санагдуулах тодорхой орчин нөхцөл, үйл ажиллагаанаас би зайлсхийдэг	0	1	2	3	4	5
24	Хүмүүст тусалж чадаж байгаадаа бахархалтай байдаг	0	1	2	3	4	5
25	Туслах ажил хийснээр би аймхай болсон, яршигтай бодлууд төрдөг	0	1	2	3	4	5

26	Би энэ системийн “Намаг балчиг”-т баригдсан юм шиг санагддаг	0	1	2	3	4	5
27	Тусламж үзүүлэгчийн хувьд “Би бол амжилт”	0	1	2	3	4	5
28	Хүчирхийллийн хохирогчтой ажилласан ажлынхаа чухал хэсгийг эргэн дурдаж чадахгүй	0	1	2	3	4	5
29	Би болих анхаарал халамжтай хүн	0	5	4	3	2	1
30	Би энэ ажлыг сонгосондоо жаргалтай байдаг	0	1	2	3	4	5

Үнэлгээ:

Ажилдаа дуртай, сэтгэлтэй байгааг илэрхийлэх асуултууд: 3, 6, 12, 16, 18, 20, 22, 24, 27, 30 сонгосон хариултын дагуу оноог нэмж, нийт оноог гаргана. Халшраад байгааг илэрхийлэх асуултууд: *1, *4, 8, 10, *15, *17, 19, 21, 26, *29 /* тэмдэгтэй нь урвуу оноотой/ сонгосон хариултын дагуу оноог нэмж, нийт оноог гаргана.

Сэтгэлийн гэмтэл авсан эсвэл ядарч цуцсаныг илэрхийлэх асуултууд: 2, 5, 7, 9, 11, 13, 14, 23, 25, 28 сонгосон хариултын дагуу оноог нэмж, нийт оноог гаргана.

Ажилдаа дуртай, сэтгэлтэй байгааг илэрхийлэх нийт оноо ≤ 32 , сэтгэлийн гэмтэл авсан эсвэл ядарч цуцсаныг илэрхийлэх нийт оноо ≥ 23 , халшраад байгааг илэрхийлэх нийт оноо ≥ 18 бол субъект өндөр эрсдэлтэй байна гэж үзнэ. Бусад нь бага эрсдэл гэж тооцогдоно.

НОМ ЗҮЙ:

1. С.Бямбасүрэн, Сэтгэцийн эмгэг судлал. 2014; х.587-597, 617-622.
2. З.Хишигсүрэн, Т.Ганцэцэг. Сэтгэцийн эрүүл мэндийн дадлагын хичээлийн гарын авлага. 2014; х.36, 68-69, 135-137, 165-166.
3. З.Хишигсүрэн. Сэтгэцийн эрүүл мэндийн хичээлийн гарын авлага. 2016; х.152-153, 170-181.
4. О.Ганчулуун. Эрүүл мэндийн анхан шатны түвшин дэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ. 2014; х.61-61, 76-80, 89.
5. Н.Оюунчимэг, В.Баярмаа, Л.Насанцэнгэл. Сэтгэцийн эмчийн баримталвал зохих хууль, стандарт, удирдамж, тушаалын эмхэтгэл. 2019; х.239-241.
6. Лурдес Ладридо Игнасио, Ансельмо Т.Тронко. Нийгэм хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ. Улаанбаатар. 2013. BCI хэвлэлийн компани. х.59-75.
7. Розен, Баркинс. -5-minute emergency medicine consult Psychobehavioral Emergencies. 2007; х.83-85.
8. Clinical Management of Rape Survivors.
9. Medical Protocol/Guidelines for Management of Victims of Gender Based Violence /including sexual violence/. WHO 2014.
10. Guidelines for medico-legal care for victims of sexual violence. World Health Organization 2003.
11. Health care for women subjected to intimate partner violence or sexual violence, A clinical handbook. 2014.

IV БҮЛЭГ

ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧ ХҮҮХДЭД СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ

4.1 ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Сүүлийн жилүүдэд хүчирхийлэлд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах хөтөлбөр, арга хэмжээнүүдийг өндөр хөгжилтэй орнууд эрчимтэй хэрэгжүүлснээр хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх хүмүүсийн тоо буурч байгааг харуулсан олон судалгаанууд хэвлэгдэн гарсаар байна. Хүүхэд хүчирхийлэл үйлдэхэд хүргэж буй шалтгаануудад хүүхдийн зан чанар, тэдний гэр бүлийн хүмүүжил, найз нөхдийн харилцаа, амьдарч буй орон нутаг, нийгэм эдийн засгийн тэгш бус байдал, архи, согтууруулах ундааны хэрэглээ зэрэг нөхцлүүд нөлөөлж байна.

Хүчирхийллийг “Бусад хүн, бүлэг хүний эсрэг амь насыг нь хохироох, хэвийн хөгжилд нь саад болох, бие махбод, сэтгэл санааны гэмтэл учруулах эрсдэлтэй байдлаар биеийн хүч юмуу эрх мэдлийг санаатайгаар ашиглахаар заналхийлэх үйлдэл” гэж тодорхойлдог. Дэлхийн хэмжээнд 10-29 насны хүүхэд, залуучуудын дунд жил бүр 200,000 хүн амины хэрэг гардаг ба нас баралтын дөрөв дэх шалтгаан нь болж байна. Сургуульд түшиглэсэн сурагчдын эрүүл мэндийн судалгааг /The Global School- based Student Health survey буюу GSHS/ 100 гаруй орныг хамруулан 2003-2013 оны хооронд 13-15 насныхны дунд хийсэн. Судалгаагаар сурагчдын дунд зодолдох, нэгнийгээ дээрэлхэж дарамтлах явдал их байдаг бөгөөд манай орны хувьд эрэгтэй 63, эмэгтэй 19 сурагч судалгаа авахаас өмнөх 12 сарын хугацаанд зодоонд оролцсон гэж мэдээлжээ. Өөрөөр хэлбэл бүх л оронд эрэгтэй хоёр сурагчийн нэг, эмэгтэй дөрвөн сурагчийн нэг нь зодоонд оролцсон нь энэ төрлийн хүчирхийлэлд хүйсийн ялгаа ажиглагдахгүй байгааг харуулж байна.

Хүүхдийн хүчирхийлэл нь гэр бүлийн хүчирхийлэлд амьдардаг, эцэг эх нь архи тамхи, мансууруулах бодист донтох эмгэгээр өвдсөн, эцэг эхийн анхаарал халамж дутуу, хүүхэдтэй хатуу ширүүн аргаар харилцдаг, эцэг эх нь гэмт хэрэгт холбогдож байсан, хүүхэд өөрөө анхаарал дутмагшилхэт хөдөлгөөнтөх, зан үйлийн эмгэгтэй, архи тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг, гэмт хэрэгт холбогдсон хүмүүстэй нөхөрлөдөг зэрэг хүчин зүйлстэй холбоотой үйлдэгддэг.

Хүүхэд хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг өндөр хөгжилтэй орнуудад бага наснаас нь анхаарч эхэлж байгаа нь давуу талтай ч бага насанд үзүүлсэн үйлчилгээ, дэмжлэг нь өсөж том болохын хэрээр өсвөр болон залуу насанд хүчирхийллээс хамгаалж чадаж байгаа эсэхийг авч үзсэн урт хугацааны судалгаа цөөн байна. Гэхдээ эцэг эхийг хүүхдээ зөв хүн болгож хүмүүжүүлэх, хүүхдийг багаас нь эхэлж зүрх сэтгэлтэй иргэн болгох зорилготой хөтөлбөрүүд хэрэгждэг нь зохих үр дүнгээ өгсөөр иржээ.

Мөн хүчирхийлэл үйлдэх өндөр эрсдэлтэй-түрэмгий зан араншинтай хүүхдүүдэд чиглэсэн танин мэдэхүй, зан үйлийн эмчилгээ нь хүчирхийлэл

үйлдэгдэхээс сэргийлж чаддаг. Хот, орон нутгийн түвшинд гэмт хэрэг их гардаг цэгүүдэд чиглэсэн арга хэмжээ, сургуулийн орчинд архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээний эсрэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хар тамхины хяналт, галт зэвсгийн олдоц, буруу хэрэглээг бууруулах хөтөлбөр, орчны тохижилт, ядуурлын төвлөрлийг бууруулах арга хэмжээ нь хүүхдийг хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөхөөс хамгаалах үр нөлөө үзүүлж чадаж байгаа талаар судалгааны тайлангуудад бичигдэж байна.

Хүүхдийн дундах хүчирхийлэл нь амар шийдэлтэй энгийн асуудал биш ч урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг зохистойгоор авч, хэрэгжүүлснээр ахиц дэвшил гаргах боломж бий.

4.2 ХҮҮХЭД ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХЭД ХҮРГЭДЭГ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛС

Хүүхэд өмнө нь гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан байдал

Өмнө нь гэмт хэрэг, зөрчилд холбогдох нь хожим хүчирхийлэл үйлдэх явдалтай хамгийн хүчтэй хамааралтай байдаг.

Нийгмийн эсрэг зан үйлтэй найз нөхөдтэй харилцаатай байх

Түрэмгий буюу нийгмийн эсрэг зан үйлтэй, зан үйлийн эмгэгтэй хүүхэдтэй найзалж нөхөрлөх нь хүчирхийлэл үйлдэх, үе тэнгийнхнээ дээрэлхэх, түрэмгий зан үйл гаргах эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

Хүүхдийн архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээ

Архи, тамхи, мансууруулах бодис нь хүүхдийн танин мэдэхүй, бие махбодын үйл ажиллагаанд шууд нөлөөлж, өөрийгөө хянах, мэдээллийг боловсруулах, эрсдэлийг үнэлэх чадварыг бууруулдаг бөгөөд цочмог занг улам өдөөн даамжруулдаг тул зарим хүүхдийг хүчирхийлэл үйлдэхэд түлхэх магадлалтай. Архийг бага наснаасаа хэрэглэж эхэлсэн, тогтмол хэрэглэдэг хүүхдүүдийн хүчирхийлэл үйлдэх, түүнд өртөх эрсдэл нэмэгддэг.

Хүйсийн байдал

Хөвгүүд охидыг бодвол хүчирхийллийг үйлдэх, түүнд өртөх магадлал өндөртэй байдаг байна. Судалгаагаар хүний амь насыг хохироосон хүчирхийллийн 90 орчим хувийг эрэгтэйчүүд үйлдсэн байжээ.

Нийгэм, эдийн засгийн тааламжгүй байдал

Амьдралын нөхцөл боломж тааруу, ядуу байх нь дунд, өндөр орлоготой гэр бүлд амьдардаг хүүхдүүдтэй харьцуулахад хүчирхийлэл үйлдэх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

Эцэг, эх нь гэмт хэрэгт холбогдож байсан байдал

Эцэг эх нь гэмт хэрэгт холбогдож байсан, нийгмийн эсрэг зан үйлтэй гэр бүлийн хүрээнд амьдрах нь хүчирхийлэл үйлдэхэд нөлөөлдөг.

Түрэмгий зан араншин

Хүмүүжилгүй, дуулгаваргүй, хэрэг зөрчилд орооцолддог, бусдыг үг хэлээр доромжилдог, амьтан тамлан зовоодог зан араншин хүчирхийлэл үйлдэхтэй холбоотой байдаг байна.

Хүүхэдтэй зүй бус харилцах

Хүүхдийг үл хайхарч, тэдэнд бие махбод, бэлгийн, сэтгэл санааны дарамт үзүүлснээр хожим хүүхэд өөрөө ийм зан үйлтэй болж төлөвших магадлал ихтэй байдаг.

4.3 ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧ ХҮҮХДИЙН ЗАН АВИР

Хүүхэд болон өсвөр үеийнхэн дунд хүчирхийлэгч зан авир илэрч байгаа нь маш их анхаарал татсан асуудал бөгөөд энэхүү нийлмэл төвөгтэй байдлыг эцэг эх, багш, насанд хүрэгчид маш сайн анхааралдаа авах хэрэгтэй.

Хүүхэд, тэр байтугай сургуулийн өмнөх насны хүүхэд ч хүчирхийлэгч зан авиртай байх нь бий. Эцэг эх болон насанд хүрэгчид тэдний түрэмгий зан авирыг өөрийн нүдээр харсан ч гэлээ “За хүүхэд том болохоороо гайгүй болчихно” гэж тоохгүй өнгөрөөх асуудал элбэг байдаг. Хүүхэд насны ямар ч үед түрэмгий зан авир илэрсэн л бол үүнийг анзаарахгүй орхиж болохгүй.

Хүчирхийлэгч зан авирын цар хүрээ

Хүүхэд болон өсвөр үеийнхэн дунд тохиолдож буй хүчирхийлэгч зан авир нь нилээд өргөн хүрээний ойлголтыг өөртөө агуулдаг. Жишээлбэл: Гэнэт дүрсхийн уурлах, бие махбодын хүчирхийлэл үйлдэх, зодоон хийх, бусдыг гэмтээхээр завдах, сүрдүүлэх /бусдыг алах тухай бодох/, зэвсэг хэрэглэх, амьтан тамлах, галдан шатаах, бусдын эд зүйлийг санаатайгаар эвдэн сүйтгэх гэх мэт.

Хүчирхийлэгч зан авирын эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлүүд

Судалгаанаас харахад олон хүчин зүйлүүдийн харилцан үйлчлэлийн дүнд хүүхэд өсвөр үеийнхний хүчирхийлэгч зан авирын эрсдэл нэмэгддэг болохыг тогтоожээ. Үүнд :

- Урд өмнөх түрэмгий болон хүчирхийлэгч зан авир
- Биеийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч болох
- Гэр орондоо болон хамт олон дотроо хүчирхийлэлд өртдөг, хүчирхийлэлтэй үйл явдлыг хардаг байх
- Дээрэлхүүлдэг байх
- Генийн буюу удамшлын хүчин зүйлс
- Зурагт, кино, интернет, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийллийг үзүүлдэг байх
- Архи, мансууруулах бодис хэрэглэдэг байх
- Гэртээ галт зэвсэг хадгалдаг байх

- Гэр бүлийн болон нийгэм эдийн засгийн тааламжгүй хүчин зүйлүүд хавсрах / ядуурал, байнгын гачигдал дутагдал, гэр бүл салалт, ганц бие эцэг эх байх, ажилгүйдэл, гэр бүлдээ гадуурхагдсан байх /

- Тархины гэмтэл

Хүчирхийлэл үйлдэгч хүүхдийн зан авирын “эрт илрэх шинж тэмдэг” Хэд хэдэн эрсдэлт хүчин зүйлс хавсарсан тохиолдолд хүүхдэд доорх зан авирын шинж тэмдгүүд илэрч байвал анхаарч, зөв үнэлэх хэрэгтэй. Үүнд:

- Их ууртай
- Үе үе ухаан мэдрэлээ алддаг, дэлбэрдэг
- Туйлын цухалдуу
- Гэнэтийн огцом үйлдэл хийдэг
- Маш амархан сэтгэлээр унадаг

4.4 СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ҮЕ ТЭНГИЙНХНИЙ ДАРАМТ ШАХАЛТ

Хүүхэд насандаа дарамтлагч байсан хэн нэгэн хүчирхийлэл үйлдэгч болж төлөвших өндөр эрсдэлтэй байдаг. Норвегийн судлаачдын судалгаагаар өсвөр насандаа дарамтлагч байсан хөвгүүд 20 гаруй насандаа үе тэнгийн бусад хөвгүүдтэй харьцуулахад хүчирхийлэл үйлдэх магадлал 4 дахин их, АНУ-д хийгдсэн урт хугацааны судалгааны дүнгээр өсвөр насандаа дарамтлагч байсан хөвгүүд насанд хүрэхээрээ зодоон цохион хийх, бусдын биед халдах, дээрэмдэх гэх мэт илүү гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд хийх нь мэдэгдэхүйц их байжээ. Эхэндээ эрэгтэй хүүхдүүдийн дунд зөвхөн бие махбодын хувьд дээрэлхэгч байснаа цаашид хүчирхийлэл үйлдэгч, бүүр цаашилбал өсөрхүү, өс санагч зан төлөвтэй нэгэн болж хувирах нь даамжран давтагдаж улам цар хүрээгээ нэмсээр байгаа зүй тогтол ажиглагдаж байна. Сургуулийн орчин дах хүчирхийлэл үйлдэгч хүүхдүүд ихэвчлэн зан үйлийн өөрчлөлттэй, түргэн цочир ууртай байдаг. Хүүхэд хүчирхийлэл үйлдэхэд сургуулийн бус орчны нөлөөлөл /эцэг эхтэйгээ асуудалтай байх/, сургуулийн орчин дахь таагүй нөхцөл байдал /багш болон бусад үе тэнгийнхний шударга бус хандлага/ ихээр нөлөөлдөг. Эдгээр эрсдэлт хүчин зүйлсүүд тухайн хүүхдэд харилцан үйлчилж, уур бухимдал, түрэмгий зан авираар илэрдэг. Жишээ нь: Импульсив буюу цочир ууртай хүүхдийг сургуулийн хонгилд хэн нэгэн санаандгүй түлхлээ гэхэд тэрбээр эргээд заавал өс тайлах байдлаар хариу өгнө. Тухайн түлхсэн хүүхдийг гэмтээх ч юмуу хохироох хандлага үзүүлдэг. Ууртай хүүхдүүдийн олонхи нь ерөнхийдөө үл итгэх мэдрэмжтэй байх ба өс тайлах үйлдлээ тэд өөрийгөө хамгаалсан гэж тайлбарладаг. Жишээ нь: Ийм хүүхдүүдийг дарамтлагч биш хүүхэдтэй харьцуулахад дарамтлагч хүүхдүүд үргэлж өөрийгөө хамгаалах ямар нэг зэвсэг биедээ авч явдаг бөгөөд үүнийгээ өөрийн аюулгүй байдлын улмаас авч явдаг гэж тайлбарладаг байна.

Заримдаа тэдний өс хонзонгийн сэдэлтэй үйлдлүүд өөрийнх нь эрх мэдэл, хүчийг нь тунхаглан харуулах, өөрийн гэсэн хяналтаа тогтоох боломжийг олгодог. Эдгээр дарамтлагч, хүчирхийлэл үйлдэгч хүүхдүүд өөрийн өс хонзогносон үйлдлүүдээр үе тэнгийнхний дунд давуу байр суурьтай байгаагаар мэдэрдэг байна. Үеийнх нь хүүхдүүд ч гэсэн тэдний хариу урвал, хорон муу үйлдлүүдээс айж, давуу байр суурийг нь аялдан дагалдах нь олонтаа. Ингэж идэвхгүй буюу дарамтлагчийн чанга хатуу байдлыг аялдан дагалдах нь эргээд нийгмийн гажуудал болдог бөгөөд хүчирхийллийг үг дуугүйгээр улам даамжруулдаг билээ. Ийм учраас сургуулийн орчин болон тэнд өрнөж буй дарамт шахалт нь үе тэнгийнхний /хүчирхийлэлд өртөгч хүүхэд болон хөндлөнгөөс ажиглагч хүүхдүүдийн/ хандлагаас маш их шалтгаалдаг.

4.5 ХҮҮХДИЙН ХҮЧИРХИЙЛЭГЧ ЗАН АВИРЫН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Эцэг эх, багш, насанд хүрэгч хэн ч байлаа гэсэн хүүхдэд хүчирхийллийн зан авир илрэхийг ажигласан бол сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтэнд хандан зохих үнэлгээг хийлгэх хэрэгтэй. Мэргэжилтнүүд эрт илрүүлэн эмчилвэл үр дүнтэй байдаг. Эмчилгээний зорилго нь хүүхдэд цаг алдахгүй тусламж үзүүлэх, хэрхэн уур бухимдлаа хянах, уур бухимдал болон сөрөг сэтгэл хөдлөлөө эерэг аргаар тайлах, хийж буй үйлдэл, үр дагаварыг нь хариуцах чадвартай байх, гэр бүлийн зөрчил, будлиан, сургууль, анги хамт олон дундах асуудлыг эерэгээр даван туулахад чиглэгддэг.

Уур бухимдал, сөрөг зан үйл /эсэргүүцэх болон сүйтгэх, сөргөлдөх/ хүүхэд насанд илрэх сэтгэцийн эмгэгүүдтэй ихэнхдээ хавсарч тохиолддог. Үнэндээ, уур бухимдал бол хүүхдийн зан үйлийн эмгэг болон эсэргүүцэн сөргөлдөх эмгэгийн анхны шинж тэмдэг юм. Нийгмийн эсрэг зан үйл буюу эдийн засгийн хувьд ч их хор хохирол учруулдаг танхайрах зан авир, мансууруулах эм бодис хэрэглэх, насанд хүрсэн хойно илрэх бусад сэтгэцийн эмгэгийн эх үүсвэр нь хүүхдийн зан үйлийн эмгэг билээ. Дээрх асуудлууд хэдий бага насанд илэрнэ төдий яаралтай арга хэмжээ авахгүй бол цаашид тогтвортой даамжрах байдлаар үргэлжлэн, үр дүн муутай байх нь бий. Сургуулийн өмнөх насанд зан үйлийн эмгэгтэй гэж оношлогдсон хүүхдүүдийн тал орчим хувь нь хүүхэд насанд нь энэ байдал үргэлжлэн, өсвөр насанд нь бүр даамжирдаг.

Уур бухимдал болон зан үйлийн эмгэг нь урьдчилан сэргийлэхэд хэцүү, учир нь гэр бүл, үе тэнгийнхэн, сургууль гэх мэт олон хүчин зүйлээр тодорхойлогдож байдаг. Эдгээр олон хүчин зүйлс бүрэлдэн нас насны үечлэлд янз бүрийн эрсдэлт байдалд хүргэдэг. Мөн түүнчлэн генетикийн болон биологийн хүчин зүйлс ч нөлөөтэй. Эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн хурдацтай өсөлт хүүхдийн хөгжилд шуудаар, эцэг эхийн

сэтгэцийн байдал, эцэг эх байх чадвар нь шууд бусаар нөлөөлдөг.

Зан үйлийн эмгэгтэй хүүхдийн эцэг эх нь хүүхдийнхээ ааш аягийн учрыг олж зохицуулж чадахгүй, хүмүүжлийн тогтворгүй арга барилтай, ихэвчлэн шийтгэх, буруутгах байдлаар ханддаг. Энэ нь явсаар *coercive cycles*-албадлагын цикл болж хувирдаг. Ийнхүү хүүхдийг шийтгэсэнээр хүүхдэд сөрөг зан үйлийг та өөрөө ч анзааралгүй заадаг төдийгүй, уур бухимдлын замаар өөрийн зорилгодоо хүрч болдог юм байна гэдэг ойлголтыг суулгаж өгдөг.

Хүүхдэд тодорхой хэмжээгээр уур бухимдал илэрсэн л бол, ялангуяа нэгээр ч тогтохгүй удаа илэрсэн бол сургуульд дасан зохицох чадвар болон суралцах чадвар бууралттай байдаг. Тэд нийгмийн болон сэтгэл хөдлөлийн чадвар бууралттай байдаг нь үеийнхнээсээ тусгаарлагдахад хүргэж, багштайгаа эерэг харилцаа тогтооход хүндрэл үүсгэдэг. Эдгээр сөрөг зан үйл, дасан зохицох чадварын бууралт, үеийнхэн болон бусад хүүхдүүдийн гадуурхал, сурлага хичээлдээ муу байх бүгд ирээдүйн эрсдэл юм.

Хүчирхийлэл үйлдэхэд хүргэж буй эрсдэлт хүчин зүйлүүд багасах болон арилахад хүчирхийлэгч зан авир буурч, бүр илрэхгүй ч байх боломжтой талаар судлаачид тэмдэглэсэн байдаг. Хамгийн чухал нь, гэр бүл, хамт олон доторх хүчирхийлэл буурахад үр дүн нь илэрхий мэдэгдэхүйц сайжирдаг байна. Өөрөөр хэлбэл, хүчирхийллээс хүчирхийлэл төрдөг гэдгийг мартаж өсгүй билээ.

Дараах стратегаар хүчирхийлэгч зан авираас урьдчилан сэргийлэх боломжтой.

- Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх /эцэг эхчүүдийг хөтөлбөрт сургалтад хамруулах, гэр бүлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх/
- Өсвөр үеийнхэнд эцэг эх байх тухай хөтөлбөр болон бэлгийн боловсрол олгох
- Өсвөр үеийнхэн дунд буй хүчирхийлэгч зан төлөвийг эрт илрүүлэх, эмчилгээ хийх
- Хүүхдийн дэлгэцийн /интернэт, таблет, ухаалаг утас, зурагт, кино/ цаг болон үзэж буй зүйлд хяналт тавих

Хүчирхийлэл үйлдэгч хүүхдүүдэд танин мэдэхүй-зан үйлийн сэтгэл засал эмчилгээ хийхэд тэдний зан араншингийн цочромтгой байдал багасч, эмпатитай хандлага ихэсдэг байна. Судлаачид энэхүү танин мэдэхүй-зан үйлийн эмчилгээг аль болох бага насанд нь хийвэл төдий чинээ сэтгэл хөдлөл болон өөрийгөө хянах чадварыг нь дээшлүүлэх боломж ихэсдэгийг тогтоосон байдаг. Мөн ижил тулгамдсан асуудалтай хүүхдүүд ижил төрлийн сэтгэл зүйн тусламжинд хамрагдвал илүү үр дүнтэй байдаг. Нөгөө талаас нь авч үзвэл зан авирын хувьд өөр өөр хүүхдүүд гэмт хэргийн янз бүрийн нөхцөл байдалд өөр өөр хариу урвал үзүүлдэг учир сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хүүхэд тус бүрт тохирсон байвал илүү үр дүнгээ өгдөг.

Хүүхдийн үе тэнгийнхнээсээ суралцах боломжийг бүрдүүлэх

Ихэнх хүүхдүүд үе тэнгийнхэнтэйгээ сургууль, цэцэрлэг, гэрийнхээ ойролцоох орчинд тоглож, нийгэмшдэг. Харин зарим эцэг эхчүүд хүүхдээ гадаа үе тэнгийнхэнтэй нь тоглуулдаггүй. Гэтэл хүүхдийн нас хичнээн бага байсан ч бусадтай тоглож байх явцдаа бусдаас суралцаж, асуудал тулгарвал шийдэх, зөрчил будлианыг даван туулах гэх мэт чадваруудад суралцаж байдаг билээ. Зарим тохиолдолд хүүхдүүд нь хоорондоо тоглох үед үүссэн маргаанд эцэг эхчүүд хөндлөнгөөс оролцдог. Хүүхдийнхээ нүдэн дээр энэхүү асуудлыг эцэг эхчүүд хэрхэн шийдэж байгаа нь цаашид тэдний нийгмийн амьдралд асар их тусгал үзүүлдэг бөгөөд асуудлыг зөвөөр шийдвэрлэж сураагүй л бол, энэ чадварыг эзэмшихгүй л бол цаашид хүчирхийлэл үйлдэх гэх мэт зан үйлийн тулгамдсан олон асуудлуудтай нүүр тулдаг байна.

Эцэг эх, асран хамгаалагчид нь зааж сургах

Ойролцоогоор 5 наснаас эхэлж хүүхэд хүмүүс хоорондын харилцааны талаар эрчимтэй суралцаж эхэлдэг. Үүний тулд эцэг эх, асран хамгаалгчдад хүүхдийнхээ энэ чадварыг зөв эзэмшүүлж, зааж сургахын тулд тодорхой хуваарилалт, зарим нэг хязгаарлалтыг хайр халамжтай хослуулан өсгөх, мөн зарим нэг үйлдлийн үр дагаварыг өөрт нь үзүүлж тайлбарлан ойлгуулах, зан үйлийг нь засаж залруулья гэвэл өөрсдөө үлгэрлэн үзүүлэх хэрэгтэйг зөвлөх. Энэ насанд хүүхдэд уур хорсол, айдас үүсгэн зодож шийтгэхийн оронд ингэвэл ийм болно гэдгийг л тайлбарлаж, аль болох хариуцлагыг мэдрүүлэх нь чухал байдаг.

Сургуулийн наснаас эхлэн хүүхдэд бие даах хандлагууд үүсч эхэлдэг ба хүүхэд ихэнх цагийг гэртээ биш, сургууль, бусад газруудад үеийнхэнтэйгээ хамт өнгөрөөдөг. Цэцэрлэгийн ахлах бүлэг болон сургуулийн бага ангиудад энгийн дүрэм журам гэж ийм юм байдаг гэдгийг сайтар мэдэж авах нь зүйтэй бөгөөд энэ наснаас цаашлан шилжилтийн нас руу ороход эцэг эх-хүүхэд, хүүхэд-хүүхэд харилцаанд олон төвөгтэй асуудлууд үүсч болзошгүй байдаг тул яг энэ насанд нь дүрэм, журам, хариуцлага болон бусад асуудлуудын талаар чөлөөтэй сайтар ярилцдаг болгоход хамгийн тохиромжтой, алдаж болохгүй нас юм. Мөн аз жаргалгүй буюу будлиантай янз бүрийн нөхцөл байдалд хэрхэн яах тухай зөвлөгөөнүүд энэ насанд л үр дүнтэй байдаг.

Сургуулийн өмнөх насны хүүхэд рүү чиглэсэн урьдчилан сэргийлэх зорилготой олон судалгаануудаас харахад 5-аас доош насны хүүхдэд сэтгэл зүйн зохицуулга хийх нь байдаггүй бөгөөд харин гэр бүлийн зохицуулгыг хийдэг. Гэхдээ хүүхэд танин мэдэж, хэлж ярьж, сэтгэл хөдлөлөө илэрхийлж эхэлсэн л бол орчинтойгоо харьцаж эхэлсэн гэсэн үг бөгөөд харилцааны чадамжуудын суурь тавигдаж байдаг. Энэ суурь зөв бол уур бухимдалаас урьдчилан сэргийлнэ. Мөн хүүхдийн танин

мэдэх чадварыг нэмэгдүүлэх тусам уур бухимдал багасах нь ажиглагддаг. Хүүхдийн уур бухимдлыг багасгахын тулд тухайн хүүхдийн нийгэм, сэтгэл хөдлөлийн болон танин мэдэхүйн чадамжуудыг сайжруулах нь урьдчилан сэргийлэлтийн анхдагч зорилго байдаг.

Хүчирхийлэл үйлдэж буй хүүхдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх олон улсын хөтөлбөр, удирдамжууд байдаг. Тухайлбал,

Харьяалалтай хүүхэд-Америкийн Хүүхдийн эмч нарын Холбооноос /AAP/ хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор боловсруулсан хөтөлбөр

4 бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:

- Үндсэн хэсэг-Эмнэлзүйн удирдамж
- Сэтгэл зүйн зөвлөгөө-3 өөр өнгөтэй бичигдсэн. Ногоон-нярайгаас 5
- нас хүртэл, цэнхэр-6-12 нас, улаан –13-21 нас
- Боловсрол олгох гарын авлагууд
- Илтгэлүүд

Энэ хөтөлбөрийн үндсэн зорилго нь хүүхэд өөрийн амьдралаа баяр баясгалантай, уян хатан болгох.

Зарим эмч, судлаачдын үздэгээр ямар ч сайн хүүхэд зарим нийгэм хамт олны дунд тодорхой хэмжээний хүчирхийлэлд өртөхгүй гэсэн баталгаа байхгүй бөгөөд эцэг эхчүүдэд нь хүүхдээ хүчирхийллээс урьдчилан сэргийлэх аргуудыг зөвлөдөг.

Хүүхэд рүү чиглэсэн хөтөлбөр

Хүүхэд рүү чиглэсэн хөтөлбөрийг дангаар нь хэрэгжүүлэх нь тун ховор байдаг. Эцэг эхийг хамруулахаас гадна ангид нь эсвэл хэсэг бүлэг хүүхдүүдийн хамт хийхийн зэрэгцээ нийгэм, сэтгэл зүйн болон бусад тулгамдсан асуудлаа яаж шийдэх вэ? гэдэгт зааж сургадаг. Хамгийн түгээмэл арга бол-би асуудлыг шийдэж чадна гэдэг хөтөлбөр.

Сургуулийн өмнөх нас болон бага ангийнханд их тохиромжтой, үр дүнтэй байдаг.

Эцэг эх рүү чиглэсэн хөтөлбөр

Гэр бүлийн эрсдэлт нөхцөл байдал хүүхдийн уур бухимдлыг улам ихэсгэдэг тул эцэг эхийн чадварыг сайжруулах уламжлалт арга юм. Жижиг бүлгээр ажиллах бөгөөд энэ хөтөлбөр нь өвөрмөц онцлогтой. Жишээ нь: видео бичлэг, гараар бичсэн захиа зурвас ашиглан хүүхэд болон эцэг эхийн хоорондын харилцааг сайжруулдаг. Ээж аавд нь хүмүүжлийн эерэг аргуудыг ашиглан хүүхдийнхээ суралцах чадварыг хэрхэн дэмжих зэргийг зөвлөнө.

Олон бүрэлдэхүүнт хөтөлбөр

Нэг удаад чухал бөгөөд үр дүнтэй гэсэн нэг бай сонгож аваад ажилласан нь дээр бөгөөд эрсдэл үүсгэж буй янз бүрийн нөхцөл байдал руу төрөл бүрийн олон аргуудыг зэрэг хийх нь төдийлөн үр дүнтэй байдаггүй. Жишээ

нь: Анхны алхам-хөтөлбөр гэхэд цэцэрлэгт байхаасаа л ууртай гэдэг нь тогтоогдсон хүүхдэд ээж аавд нь сургалт, хүүхдэд нь мөн харилцаа болон танин мэдэхүйн чадамжуудыг нь сайжруулахаар ажиллахад тэр хүүхэд сургуульд ороходоо харьцангуй дасан зохицол нь сайжирсан байдаг.

Хүүхэд хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажил сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж байгаа бөгөөд баримт нотолгоонуудаас харвал хүүхэд насанд тохиолдох сэтгэцийн эмгэгийг бууруулж байна. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний ихэнх нь өсвөр насны хүүхдүүдээс илүүтэйгээр сургуулийн бага ангийн хүүхдүүд рүү чиглэх нь илүү үр дүнтэй байна. Мөн уур бухимдалтай зан үйл бүрэлдэхэд нөлөөлж буй олон бүрэлдэхүүн хэсгүүд болох орчин, гэр бүлийн нэгж рүү чиглэсэн нийгмийн шинж чанартай цогц арга хэмжээ чухал билээ.

Бий болгох, байнга тогтмолжуулах, хэрэгжүүлэх-гэсэн 3 үгээр урьдчилан сэргийлэлтийг тодорхойлдог.

Бага насны хүүхдийн уур бухимдлыг зохицуулах 7 эерэг арга

Хүүхэд уурлаж бухимдах нь тухайн хүүхдэд өөрт нь хэцүү ичгүүртэй байгаад зогсохгүй, эргэн тойронд нь байгаа хүмүүст ч хэцүү байдаг.

Аль болох эрт зааж сургах ба буруу үйлдэл хийсэн мөчид нь хэлэх хэрэгтэй байдаг.

Хяналтаа алдсан хүүхэд сэтгэл зүйн болон бие махбодын хувьд ч тухайн үйлдлийг нь таслан зогсоохгүй л бол аюултай. Хажууд нь байгаа хүүхэд өөр хүүхдийн аюултай ааш гаргаж байгааг хараад айна, дараа нь дуурайж үзнэ. Сүүлд нь хүүхэд өөрийн хяналтаа алдаж хийсэн үйлдлээсээ ичдэг.

1. Хүүхэд заримдаа өөрийнхөө зан аашийг хянаж чаддаггүй гэдэгт бэлэн байх

Хүүхдийн уураг тархи тасралтгүй хөгжиж байдаг бөгөөд насанд хүрэгчидтэй адил өөрийгөө хянаж чадахгүй гэдгийг ойлго. Аливаа зүйлийг ойлгодог болж эхэлмэгц нь зөвөөр зааж удирдаж сургах хэрэгтэй.

Хүүхэд маш мэдрэмтгий учраас “маш амархан”, “ингэх л ёстой” гэх мэт стандартуудыг ойлгохгүй байж болно.

Аливаа асуудлыг үгүйсгэх, хойшлуулахын оронд үнэн бодитоор нь хүүхдэд тайлбарлаж өгч, ууртай хүүхэд бүр муу хүүхэд, тэр хүүхдийн ээж аав тэвчээргүй гэсэн үг биш гэдгийг ойлгох хэрэгтэй.

2. Эмзэг цэгийг нь хөндөх шалтгааныг мэдэж, тодорхойлж, бууруулах

“Яаж”, “Ямар учраас” гэдгийг нь ойлговол эерэг шийдэл олж болдог. Мөн гэнэт тулгарсан асуудал биш, өмнө нь хуримтлагдсаар хүүхэд тэсэрсэн байж болзошгүй. Үүнд цаг хугацаа шаардлагатай. Тухайн үеийн авир араншинг нь баримтжуулах хэрэгтэй. Хүүхдэд тохиолддог зарим эмзэг асуудлуудаас дурдахад:

- Шилжилт-хүүхдүүд урьдчилан таамаглаж болохооргүй нөхцөлд шилжихэд хяналтаа алдан янз бүр ааш авир гаргадаг бөгөөд аль болох дуртай зүйлийг нь дэмжих хэрэгтэй. Заримдаа амьдралд байдаг эерэг өөрчлөлтүүд ч хүүхдийг бухимдуулдаг. /шинэ дүү, шинэ гэр орон, төрсөн өдөр/ Харин гэр бүл салах, ээж аав нь ажилгүй, орлогогүй болох, ойр дотны хүн нас барах гэх мэт сөрөг өөрчлөлт шилжилт хүүхдийг маш их бухимдуулдаг. Энэ тохиолдолд гэр бүлээс онцгой анхаарал шаардагдана.
- Зарим хүүхэд температурт маш мэдрэмтгий байдаг. Жаахан халуун, жаахан хүйтэнд л уурлаж бухимдах нь бий.
- Илүү их унтах хэрэгцээ
- Насанд хүрэгчидтэй илүү ойр байх хэрэгцээ
- Илүү их биеийн хүч зарцуулах, гүйх харайх, хөдлөх хэрэгцээ
- Илүү өөрийн гэсэн орон зайтай байх
- Хэт эрчимжүүлэх, хэт ихийг шаардах
- Өлсөх
- Эрүүл мэндийн болон физиологын асуудлууд

Дээрх байдлуудаар эмзэг цэгийг нь мэдэж тодорхойлсноор, уур бухимдалд хүргэхгүйгээр асуудлыг шийдэж болно.

3. Хүүхдэд сэтгэл хөдлөл, мэдрэмжээ илэрхийлж, уур бухимдалаа зохицуулах аргыг зааж өгөх

Хүүхэдтэй харилцан ярилц, ямар ч хүнд ядарсан бухимдалтай мэдрэмж төрөх нь байж болох зүйл, гагцхүү мэдрэмжээ хэрхэн зохицуулах вэ? гэдгийг ярилцаж сургах нь чухал билээ. Ийм агуулгатай ном хамт уншаад ярилцсан ч болно. Өөрт чинь бас хүнд түлхүүлэх, цохиулах үе байсан бол тэр тухайгаа ярь. Тоглоом ашиглан, хүүхэлдэйгээр дүрд тоглон харилцан ярилцах хэрэгтэй. Эерэг үр дүн гарах бүрт нь урамшуул. Хүүхдэд амжилттай, өөдрөг байх боломжийг олго. Биеэ ашиглан яаж тайвшрах талаар иога-г хөгжилтэй байдлаар зааж өгөх. Урлагийн хөтөлбөрүүдийг санал болгох нь тустай.

Хүүхэд уцааргүй тайван байгаа үед нь ХҮҮХДИЙН ХҮЧ-ний чадваруудыг танилцуул.

Тайвшрах хүч: Гунигтай үедээ амьсгалын дасгал хийх, гүнзгий амьсгалах, алгаа хавсран үрэх, нуруугаа цэхлэх гэх мэт өөртөө тохирох аргыг сонгон тайвширч чаддаг болвол баяр хүргэх.

Амаа хамхих хүч: Муухай болон тохиромжгүй үг хэллэг хэлэхгүй байх, бүдүүлэг үг аманд орж ирсэн ч гаргахгүй, хуруугаараа уруулаа дарах, чшшш, дүрд тоглон давтаж болно. Амжилттай байгааг нь урамшуулна. Бахархаж байгаагаа илэрхийл.

Гараа буулгах хүч: Бусдыг цохихоос сэргийлнэ. Нэг гараар нөгөө гараа барих, эсвэл халаасандаа хийх, мөн дүрд тоглон давтана. Гараа доош нь

гэж хэлэх үед тэр хүүхэд зааврыг гүйцэтгэнэ. Өөрийгөө сайн хянаж чадаж байгаад нь тохирсон жижигхэн урамшуулал өг.

Хөдөлгөж зайлуулах хүч: Тайвшрах хүртлээ үсрэх, харайх, дэр тэврэх, гүнзгий амьсгалах гэх этээр аль болох чөлөөтэй хөдлөх орон зайг нь бүрдүүлж өг. Бага насны хүүхдүүдэд хэрэггүй.

Холдож одох хүч: Зөрчил будлианыг тойрч холдох чадвар. Хэн нэг хүүхэд түлхэх юмуу өөр байдлаар өдөөн хатгалаа гэхэд хариу үзүүлэхгүй байх чадварыг бас дүрд тоглон давтаж дадлага хийнэ. Хүүхдэд тайван, хүндэтгэлтэй, өөртөө итгэлтэй хандлага суулгана.

4. Хаана ч хэн ч уурлаж болзошгүй учир ийм үед хэрхэн урьдчилан сэргийлэх талаар урьдчилан төлөвлөх

Хэрэв та уур бухимдлаа зохицуулах шаардлагатай хүүхэдтэй бол, эсрэг тулгарч болзошгүй асуудлуудыг төлөвлөөд ийм үед хүүхэд өөрийгөө хэрхэн тайвшруулахыг хүүхэддээ зааж эзэмшүүлвэл цаашид тэр хүүхэд насан туршдаа олон асуудлаас зайлсхийж чадна.

- Уурлан дүрсхийхээс сэргийлэх төлөвлөгөөг гэр бүлээрээ гаргах Хэн нэгэн гунигтай үед яах вэ, ядарсан бол яах вэ, тоглоомыг чинь авбал яах вэ ... гэх мэт.
- Тохиолдож болзошгүй нөхцөл байдлын алхам бүрийг ямар байгаасай гэж төсөөлж байгаагаа дүрслэх
- Яг тухайн мөчид нь дасгалжуулах
- Асуудал тулгаран ирж буйг мэдсэн даруйд хүүхдийг төлөвлөгөөгөө дагахыг заах, учир нь ихэнхдээ хүүхдүүд аливаа асуудал болоод өнгөрсөний дараа тэгэх ёстой байсан, ингэх ёстой байсан гэж төлөвлөгөөгөө санадаг. Ингэхгүйн тулд яг тулгарсан мөчид л төлөвлөсөнөө дагаж эхлэхийг сургах
- Төлөвлөгөөний хэсэг нэг бүр дээр ажиллахад цаг зарцуул, ялангуяа өөрийгөө тайвшруулах хэсэг дээр сайн ажиллах
- Захирангуй байдлыг хэрхэн давахад бэлэн байх

Хүүхэд заримдаа насанд хүрэгчидээр болон бусад хүүхдээр цагдуулах дургүй байдаг бөгөөд ийм үед их хорилгүйгээр, аливаа үйлдлийн үр дагаварыг чи өөрөө л хариуцана гэж тайлбарлах хэрэгтэй.

- Зааж сургасан эерэг чадваруудыг сэтгэл тавгүй үедээ хэрэглэн амжилтад хүрсэн жишээнүүдийг хэлж ярьж өгөх

5. Өөрийн сэтгэл хөдлөлийн эмзэг асуудлыг өөрөө хариуцана гэдгийг ойлгуул

6. Хяналтаа алддаг хүүхэдтэй ажиллаж буй насанд хүрэгч нь хүчтэй бас хүндлэлтэй байх

Хүүхэд аюултай зан авир гаргах, эвдэн сүйтгэх үед нь зогсоох шаардлагатай. Хэцүү хүүхэдтэй ажиллахад ядарна, уур хүрнэ, айна, гутарна, гэвч та эдгээр мэдрэмжээ тэр хүүхдийг ичээх, буруушаах байдлаар гаргавал

эсрэг үйлдэл улам ихсэнэ. Үүний оронд тэр хүүхдийн өөрийнх нь аюулгүй байдал танд чухал гэдгийг ойлгуул, байдал хяналтаас гарахаас өрсөж та хамгаалах, аюулгүй байх арга хэмжээнүүдээ түргэн шийд. Хариу урвалаа үзүүлэхээсээ өмнө та өөрөө тайван бай, үг яриа болон биеийн хэлэмж тань хурдан тохиромжтой байх ёстой, хашгирахын оронд “Наадхаа доош нь тавиарай”, “Цохиж болохгүй”, “Хазаж болохгүй” гэх мэт үгийг хүүхэд рүү шууд хандаж, татгалзахын аргагүйгээр хэл. Юм шидэх гэж байвал гарт нь хүрж болохоор, барьж зогсоохоор ойрхон бай. Хоёр хүүхэд муудалцвал дунд нь орж суух гэх мэт.

Хүүхдийг гэмтээж болохгүй, өөрөө гэмтэж болохгүй.

7. Асран хамгаалагч болон багш нарт: Хэрэв та бусдын хүүхдийг хариуцдаг бол төлөвлөгөө гаргаж, таниулсан зөвшөөрөл аваарай.

Хил хязгаар тогтоох зарчмын “Асуудал нууц байх ёсгүй”, “Тусламж хүртэтлээ асуусаар л байгаарай” хэсгүүдийг санаарай.

Хэцүү хүүхэдтэй ажилладаг хүн бүр харилцан адилгүй туршлагатай, иймд тухайн хүүхэдтэй ажиллаж эхлэхээс өмнө хамгийн түрүүнд аюулгүй байдлын үүднээс ямар ямар хязгаарлалт зөвшөөрөгддөг вэ гэдгийг мэдэж авах нь чухал. Тухайн сургууль болон байгууллагын дотоод дүрэм журмыг мэдэхээс гадна, яг ямар ямар урьдчилан сэргийлэх хэрэгсэл танд боломжтой, юу хийх нь зөвшөөрөгддөг, хэнийг дуудах, яаж дуудах, хэрэв дуудсан хүн байхгүй тохиолдолд яах вэ, хэрхэн тайлан мэдээгээ бичих вэ зэргийг бүгдийг урдаас тодорхойлох хэрэгтэй.

Хүүхдийн гаргаж буй сэтгэл хөдлөл мэдрэмж тэр байтугай уур бухимдал ч хэвийн гэдгийг хүүхэд ойлгох хэрэгтэй. Хүн бүр л уурладаг, заримдаа бусдыг гомдоодог. Насанд хүрэгчдийн хувиар бид хүүхдэд туслах ёстой, уурласан үедээ яах, бухимдлаа яаж давахыг хүүхдэд зааж сурга. Та бухимдсан үедээ яаж даван гарсанаа, яаж эерэгээр шийдсэнээ эргэн сана. Таны сэтгэл дотор юу ч болж байлаа гэсэн та болон таны орчин аюулгүй л байх ёстой гэсэн амьдралын гайхамшигт чадварыг эзэмшүүлээрэй.

4.6 ХЭМЖҮҮР БА ҮНЭЛГЭЭ

Хүүхэд өсвөр үеийнхний дунд хүчирхийлэлтэй холбоотой хандлага, ойлголт, зан авирыг илрүүлэх, тодорхойлох зорилготой үнэлгээнүүд байдаг. Эдгээр үнэлгээ нь хүүхэд өсвөр үеийнхэний дунд үйлдэгдэж буй хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд маш их ач холбогдолтой байсан төдийгүй, сүүлийн арваад жилийн туршид удаан хугацааны судалгаануудад ашиглагдаж, улам өргөн агуулгатай болсон. Дийлэнх асуумжууд 11-24 насныханд чиглэсэн байдаг.

1. Түрэмгий авирын тухай түгээмэл ойлголтууд

Энэ хэмжүүрээр хүүхэд, өсвөр үеийнхэн тодорхойгүй нөхцөлд болон илт өдөөн хатгасан нөхцөлд түрэмгий зан авирыг хэрхэн ойлгож хүлээн

авж байдгийг үзүүлнэ. Бүлгээр болон ганцаараа бөглөж болно. Өөрт тохиолдож байсан болон тохиолдоогүй байсан ч ийм тохиолдолд яах байснаа бодож хариултыг сонгоно уу?

Хариу үзүүлэх тухай асуултууд

Таны бодол :

Нэг хүү Бат гэдэг хүү рүү муухай үг хэллээ

1. Бат эргүүлээд түүн рүү хашгирах нь зохистой юу?
... тэгэлгүй яахав, зөв ...тийм ч буруу биш ... тийм ч зөв биш ... огт буруу
2. Бат түүнийг цохиод авах
... тэгэлгүй яахав, зөв ...тийм ч буруу биш ... тийм ч зөв биш ... огт буруу

Нэг хүү эмэгтэй хүүхэд рүү муухай үг хэллээ

3. Охин эргүүлээд түүн рүү хашгирах нь зохистой юу?
...маш буруу ...тийм ч зөв биш ... тийм ч буруу биш ... тэгэлгүй яахав, зөв
4. Охин түүнийг цохиод авах
...маш буруу ...тийм ч зөв биш ... тийм ч буруу биш ... тэгэлгүй яахав, зөв

Нэг охин Мишээл гэдэг охин руу муухай үг хэллээ

5. Мишээл эргүүлээд түүн рүү хашгирах нь зохистой юу?
... тэгэлгүй яахав, зөв ...тийм ч буруу биш ... тийм ч зөв биш ... огт буруу
6. Мишээл түүнийг цохиод авах
... тэгэлгүй яахав, зөв ...тийм ч буруу биш ... тийм ч зөв биш ... огт буруу

Нэг охин өөр хүү рүү муухай үг хэллээ

7. Хүү эргүүлээд түүн рүү хашгирах нь зохистой юу?
...маш буруу ...тийм ч зөв биш ... тийм ч буруу биш ... тэгэлгүй яахав, зөв
8. Хүү түүнийг цохиод авах
...маш буруу ...тийм ч зөв биш ... тийм ч буруу биш ... тэгэлгүй яахав, зөв

Нэг хүү Бат хэмээх хүүг цохиод авлаа

9. Бат түүнийг эргүүлээд цохиж авах нь зөв үү?
...маш буруу ... тийм ч зөв биш ... тийм ч буруу биш ...тэгэлгүй яахав, зөв

Нэг хүү эмэгтэй хүүхдийг цохиод авлаа

10. Охин түүнийг эргүүлээд цохиж авах нь зөв үү?
... тэгэлгүй яахав, зөв ...тийм ч буруу биш ... тийм ч зөв биш ... огт буруу

Нэг охин Мишээл хэмээх өөр охиныг цохиод авлаа

11. Мишээл түүнийг эргүүлээд цохиж авах нь зөв үү?
...маш буруу ...тийм ч зөв биш ...тийм ч буруу биш ...тэгэлгүй яахав, зөв

Нэг охин өөр хүүг цохиод авлаа

12. Хүү түүнийг эргүүлээд цохиж авах нь зөв үү?
... тэгэлгүй яахав, зөв ...тийм ч буруу биш ... тийм ч зөв биш ... огт буруу

Ерөнхий ойлголтын тухай асуултууд

13. Ерөнхийдөө, хэн нэгнийг цохино гэдэг нь буруу үйлдэл
...маш буруу ...тийм ч зөв биш ...тийм ч буруу биш ...тэгэлгүй яахав, зөв
14. Хэрэв та үнэхээр уур чинь хүрээд байгаа бол хэн нэгэнд муухай үг хэлж болно
... тэгэлгүй яахав, зөв ...тийм ч буруу биш ... тийм ч зөв биш ... огт буруу
15. Ерөнхийдөө, хэн нэгэн рүү хашгирах, муухай үг хэлэх нь зүгээр үү?
... тэгэлгүй яахав, зөв ...тийм ч буруу биш ... тийм ч зөв биш ... огт буруу
16. Хэрэв та ууртай байгаа бол хэн нэгнийг түлхэх эсвэл мөрлөх нь хэвийн үзэгдэл үү?
... тэгэлгүй яахав, зөв ...тийм ч буруу биш ... тийм ч зөв биш ... огт буруу
17. Бусдад халдах нь буруу
...маш буруу ...тийм ч зөв биш ...тийм ч буруу биш ...тэгэлгүй яахав, зөв
18. Бухимдлаа хэн нэгэнд муухайгаар гаргах нь буруу
...маш буруу ...тийм ч зөв биш ...тийм ч буруу биш ...тэгэлгүй яахав, зөв
19. Хэн нэгэнтэй биеийн хүчээр тулалдах нь ерөнхийдөө буруу
...маш буруу ...тийм ч зөв биш ...тийм ч буруу биш ...тэгэлгүй яахав, зөв
20. Бухимдсан үедээ хэн нэгэнд биеийн хүчээр уураа гаргах нь ерөнхийдөө зүгээр
...тэгэлгүй яахав, зөв ...тийм ч буруу биш ...тийм ч зөв биш ...огт буруу

Үнэлгээ:

Энэ асуумж нь тэгэлгүй яахав, зөв-4, тийм ч буруу биш-3, тийм ч зөв биш-2, огт буруу-1 оноогоор тус тус тооцно.

Нийт онооны дундажаар доорх 3 хэмжүүр илэрхийлэгдэнэ.

- Түрэмгий зан авирыг ерөнхийдөө хүлээн зөвшөөрөх хэмжүүр: 13-20-р асуултуудын нийт оноог нэмээд дундажийг нь олоход 4 /дээд тал нь/ бол бусдын эсрэг түрэмгий авирлахыг ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөг. 1 /доод тал нь/ бол бусдын эсрэг түрэмгий авирлахыг хүлээн зөвшөөрдөггүй.
- Түрэмгий авирт хариу үзүүлэхийг хүлээн зөвшөөрөх хэмжүүр: 1-12-р асуултуудын нийт онооны дундажийг тооцно. 4 /дээд тал нь/ бол бусдын өдөөн хатгалгын эсрэг түрэмгий авирлахыг ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөг. 1 /доод тал нь/ бол бусдын өдөөн хатгалгын эсрэг түрэмгий авирлахыг хүлээн зөвшөөрдөггүй.
- Түрэмгий зан авирыг хүлээн зөвшөөрөх хэмжүүр: 1-20-р асуултуудын нийт онооны дундажийг тооцно. Энэ хэмжүүрээр хүүхэд, өсвөр үеийнхэн тодорхойгүй нөхцөлд болон илт өдөөн хатгасан нөхцөлд аль алинд нь түрэмгий зан авирыг хэрхэн ойлгож хүлээн авч байдгийг үзүүлнэ.

2. Түрэмгий зан авирыг дэмжих тухай түгээмэл ойлголтууд

Энэ асуумжаар түрэмгий зан авирын тухай нийтлэг ойлголтыг илрүүлнэ. Өөрт зөв гэж үзсэн 1 хариултаа сонгоно уу.

1. Хажуудаа буй хэн нэгнийг түлхэх гэх мэт үйлдэл нь таныг бусдаас том /атаман/, чанга хатуу гэдгийг харуулдаг
...яг тийм ...тийм ...үгүй ...огт үгүй
2. Хэрэв та зодолдох тулалдахаас ухарвал бүгд чамайг хулчгар амьтан гэх болно
...яг тийм ...тийм ...үгүй ...огт үгүй
3. Зарим тохиолдолд танд нөгөө хүүхдээс өрсөж цохих эсвэл өөрөө цохиулах гэсэн хоёрхон сонголт л байдаг
...яг тийм ...тийм ...үгүй ...огт үгүй
4. Галзууртлаа уурласан үедээ бусдыг цохиод авах нь байдаг л зүйл
...яг тийм ...тийм ...үгүй ...огт үгүй
5. Хэн нэгэн өөрийг нь түлхээд авахад хариу үзүүлдэггүй хүүхдийг бусад хүүхдүүд хүндлэхээ больдог
...яг тийм ...тийм ...үгүй ...огт үгүй
6. Найз охиноо үнэхээр хайрладаг залуу л юм бол бусад залуус охиныг шоолж байгаа бол найз охиноо хамгаалан заавал тулалдах ёстой
...яг тийм ...тийм ...үгүй ...огт үгүй

Үнэлгээ:

Энэ асуумж нь яг тийм-4, тийм-3, үгүй-2, огт үгүй-1 оноогоор тооцно.

Нийт асуултуудын онооны дундажийг гаргана. Оноо өндөр байх тусам түрэмгий зан авирыг дэмжинэ гэсэн үг.

3. Цохиод авах тухай ойлголт

Хамт байдаг насанд хүрэгчид нь зодоон цохионыг хэрхэн хүлээн авч байгааг илрүүлнэ.

Чамтай хамт байдаг насанд хүрэгчдээс доорх төрлийн зөвлөгөөг чамд хэлдэг үү?

Д/д	Бодомж	Бүгд	Ихэнх	Зарим	Хэн ч үгүй
1	Хүүхэд чамайг цохисон л бол хариуг нь өг, зодолд	1	2	3	4
2	Чамайг зодолдохоор өдөөд байвал, зодолдохын оронд ярилцахаар оролдоорой	4	3	2	1
3	Хэрэв чамайг зодолдохоор өдөөд байвал багшдаа юмуу том хүнд хэлээрэй	4	3	2	1
4	Зодоон хийх явч зөв биш, асуудлыг шийдэх өөр олон арга байна	4	3	2	1

Үнэлгээ:

Оноог доош нь нэмж дүгнэхэд 4-16 гарна. Оноо өндөр байх тусам хүүхдэд үлгэр жишээ болдог эцэг эх, асран хамгаалагч, насанд хүрэгч нь хүчирхийллийг дэмжихгүй байгааг илтгэнэ.

4. Хүчирхийллийн талаарх хандлага

Энэ асуумжаар хүчирхийллийн талаарх хандлагыг хэрхэн хүлээж авч байгаа эсэх, ялангуяа зодоон цохионы асуудалд хэрхэн хандаж байгааг илрүүлнэ. Санал нийлж буй түвшингээ дугуйлна уу.

Д/д	Бодомж	Явц авсан санал нийлнэ	Санал нийлнэ	Аль нь ч ялгаагүй	Санал нийлэхгүй	Огт санал нийлэхгүй
1	Зодолдохоос татгалзвал аймхай амьтан болно	5	4	3	2	1
2	Би заавал зодолдох албагүй, учир нь бухимдлаа зохицуулах олон арга бий	1	2	3	4	5
3	Хэрэв тэр эхлээд цохисон бол буцааж хариуг нь өгнө	5	4	3	2	1
4	Хүүхэд намайг шоолоод байгаа үед би түүнийг цохихоос өөрөөр зогсоож чаддаггүй	5	4	3	2	1

5	Би хүүхдүүдтэй зодолдохоос илүү ярилцаж учраа ололцож чаддаг байх юмсан гэж үнэхээр их боддог	1	2	3	4	5
6	Хэрэв би зодолдохоос татгалзах юм бол найзууд маань намайг хулчгар гэж бодно шүү дээ	5	4	3	2	1

Үнэлгээ:

Нийт оноо хамгийн дээд тал нь 30 бөгөөд оноо өндөр байх тусам хүчирхийлэх байдлаар асуудлыг шийдэх хандлагатай байна гэж үнэлнэ. Бага оноотой байх тусам хүчирхийллээр асуудлыг шийдэхгүй гэсэн үг.

5. Телевизийн нэвтрүүлэгт хандах хандлага

Энэ асуумж нь телевизээр үзүүлж буй хүчирхийллийн агуулгатай зүйлд ямар хандлагатай байгааг үнэлнэ. Оролцогч өөрт тохирох хариултаа сонгоно.

- Телевизээр үзүүлж буй зүйлс хир зэрэг худлаа гэж боддог вэ?
... бараг бүгд худал ...ихэнх нь худал ...зарим нь худал
...багахан хэсэг нь худал ...бүгд үнэн
- Их зодоон буудалцаантай телевизийн шоуунууд хүүхдэд хортой юу?
...маш их хортой ...тодорхой хэмжээнд хортой ...магадгүй
...тодорхой хэмжээнд хоргүй ... огт хоргүй
- Телевизийн шоуунууд амьдралыг бодит байдлаар хэр их үнэн үзүүлдэг гэж боддог вэ?
...бүгд ...ихэнх нь ... зарим нь ... багахан нь ... аль нь үгүй
- Телевизээр хүчирхийлэлтэй зүйл үзэх нь хүүхдэд сөргөөр нөлөөлж байна уу?
... яг тийм ... тийм ... магадгүй ...үгүй байхаа ... огт үгүй
- Хүүхэд чөлөөт цагийнхаа хэр их хувийг телевизийн өмнө өнгөрөөх нь зүйтэй гэж та боддог вэ?
.... бараг бүгд ... ихэнх нь ...зарим нь ... багахан нь ... огт хэрэггүй
- Хүүхэд бүхий л цагаа телевизийн өмнө өнгөрөөх нь хэр хортой вэ?
...маш хортой ... хортой ...ямар 1 хэмжээгээр хортой ... багахан хортой .. огт хоргүй

2, 3, 5-р асуултуудад

- 1-р хариулт сонгосон бол 1 оноо
- 2-р хариулт сонгосон бол 2 оноо
- 3-р хариулт сонгосон бол 3 оноо
- 4-р хариулт сонгосон бол 4 оноо
- 5-р хариулт сонгосон бол 5 оноо

1, 4, 6-р асуултуудыг үүний урвуугаар оноо өгнө. Эцэст нь бүх оноог нэмээд дунжийг гаргахад оноо өндөр тусмаа телевизээр үзүүлж буй хүчирхийлэл үнэн бодитой мөн хүүхдэд төдийлөн хор нөлөөгүй гэж ташаа ойлгож байгааг илтгэнэ.

6.Танхайрагчид хандах-Питсбург залуусын судалгаа

Танхай зан авирыг хэрхэн хүлээн авч байгааг илрүүлнэ. Оролцогч хэр зэрэг буруу гэж бодож байгааг сонгон дугуйлна.

Чиний насны хүүхэд доорх үйлдлүүдийг хийж байвал аль хир буруу вэ?

Д/д	Бодомж	Маш буруу	Жаахан буруу	Буруу	Огт буруу биш
1	Шалтгаангүй хичээл таслах	3	2	1	0
2	Худал хэлэх, эцэг эх, багш бусад өөрөөс ахмад насны хүний өөдөөс сөргөх	3	2	1	0
3	Өөрийн биш зүйлийг санаатайгаар эвдэн сүйтгэх	3	2	1	0
4	5.000₮-өөс хямд ямар нэгэн зүйл хулгайлах	3	2	1	0
5	50.000₮-ний зүйл хулгайлах	3	2	1	0
6	100.000₮-ний зүйл хулгайлах	3	2	1	0
7	Хулгай хийх зорилгоор байшин барилгад нэвтрэх	3	2	1	0
8	Бусдын эзэмшлийн машин дугуй гэх мэт зүйлсийг эзнийх нь зөвшөөрөлгүй жолоодох	3	2	1	0
9	Бусдыг гэмтээх зорилгоор зодох	3	2	1	0
10	Бусдыг хүнд гэмтээхээр зэвсэглэн халдах	3	2	1	0
11	Мөнгө, бусад эд зүйлийг нь авах зорилгоор зэвсэг, хүч хэрэглэх	3	2	1	0

Үнэлгээ:

Доош нэмж, нийт оноог гаргана. Оноо бага байх тусам танхайрлыг дэмжихийг илтгэнэ.

НОМ ЗҮЙ

1. J. Juvonen, in Encyclopedia of Stress /Second Edition/, 2007
2. Celene E. Domitrovich, Mark T. Greenberg. Preventive Interventions that Reduce Aggression in Young Children.
3. Krug E, Dahlberg L, Mercy J, Zwi A, Lozano R. World report on violence and health. Geneva: World Health Organization; 2002.
4. Global status report on violence prevention 2014. Geneva: World Health Organization; 2014.
5. Handbook for Guideline Development. 2 ed. Geneva: World Health Organization; 2014.
6. Mercy JA, Butchart A, Farrington D, Cerdb M. In: World report on violence and health 2002. Geneva: World Health Organization; 2002:23–56.
7. Smith PK, Shu S. What good schools can do about bullying: findings from a survey in English schools after a decade of research and action. Childhood. 2000;7/2/:193–212.
8. Sivarajasingam V, Page N, Morgan P, Matthews K, Moore S, Shepherd J. Trends in community violence in England and Wales 2005–2009. Injury- International Journal of the Care of the Injured. 2014;45/3/:592–8.

V БҮЛЭГ

ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧ НАСАНД ХҮРЭГЧДЭД СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ

5.1 ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАЙЛБАРЛАХ ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛУУД

Хүчирхийллийг тайлбарласан сэтгэл судлалын онолд, хүүхэд насанд нь тохиолдсон таагүй үйл явдлууд, тухайлбал, хүүхэд насандаа хүчирхийлэлд өртөж байсан түүхтэй холбоотой, хувь хүний сэтгэл зүйн онцлог чанартай холбоотой, мөн бусдаас зугтаах эсвэл бусадтай сөргөлдөх зэрэг зан үйлийн өөрчлөлттэй, сэтгэцийн эмгэгтэй, тухайлбал гэмтлийн дараах дасан зохицохуйн эмгэг, тархины гэмтэл, өөрийгөө хянах чадвар муу, өөрийн үнэлэмж доогуур, хорт зуршил, мансууруулах бодист донтсон зэрэг шалтгаануудтай холбосон байна.

Психодинамик чиг хандлагыг баримтлагчид хүүхэд насанд нь үүсээд тайлагдалгүй үлдсэн зөрчил, будлиан нь насанд хүрсэн хойно нь зан байдлын эмгэг байдлаар илэрдэг гэж үздэг. Янз бүрийн зөрчлийн улмаас төрөл бүрийн эмгэг шинжүүд хүнд бий болдог. Гэхдээ эдгээр зөрчлүүд нь ухамсарлагддаггүй бөгөөд яагаад ийм шинж тэмдгүүд илэрч байна вэ? гэдгийг хүн өөрөө мэддэггүй. Иймээс эмгэг нь улам даамжран тухайн хүн хэлмэгдсээр л байдаг гэж сэтгэц задлан шинжлэлийн онолын үүднээс үздэг.

Харин бихевиорист чиг хандлага нь үүний эсрэгээр зан үйлийг өөрийг нь асуудал болгон авч үздэг. Иймэрхүү байр суурийг баримталдаг эрдэмтэд нь хүний зан үйлийн эмгэгийг тодорхойлохын тулд ажиглаж боломгүй, сэтгэцийн гүн дэх зүйлийг судлах шаардлагагүй гэж үздэг. Харин үүнийхээ оронд зан үйлийн гажилтанд яаж дасч дадав? Орчны ямар нөлөөнөөс болоод энэ онцлог өнөөг хүртэл ийнхүү хадгалагдаж ирэв гэдгийг л тайлбарлах хэрэгтэй гэж үздэг ажээ.

Зарим онолчид нь хүний эмгэг ба эрүүл зан үйл нь гэр бүл, нийгмийн орчин болон соёл иргэншлийн ул мөрийг агуулсан байдаг гэж үздэг. Ийм ч учраас сэтгэцийн эмгэгийг тайлбарлах нийгэм-соёлын чиг хандлагыг баримтлагчид нь өдөр тутмын амьдралын явцад хүмүүст учирч буй түгшүүр, зөрчил нь зан үйлийн эмгэгийг үүсгэх, хадгалах хүчин зүйл болж байдаг гэж үздэг.

Гэр бүлийн хүчирхийллийг тайлбарласан социологийн онолуудад нийгмээс суралцахуйн онол, солилцооны онол, нөөцийн онол, зөрчилдөөний онол, системийн онол тус тус багтана. Мөн феминист онол, патриархал онол, экологийн онолын тайлбарлалуудыг авч үзэх болно.

Нийгмээс суралцахуйн онол \Social learning theory\-ыг анх үндэслэсэн хүн бол Габриел Тард \Gabriel Tarde 1843-1904\ юм. Тэрээр-Нийгэмшил гэдэг ухагдахууныг 19-р зууны сүүлчээр Францын социологич Г.Тард анх гаргасан. Тэрээр социологи, нийгмийн сэтгэл зүйн асуудлыг судлахад хувь нэмрээ оруулсан. Г.Тард энэхүү ухагдахууныг хувь хүний хөгжлийн

асуудлыг судлахад хэрэглэсэн. Түүний үзлээр-дууриах-гэдэг нь зөвхөн хүний асуудлаар зогсохгүй байгалийн болон нийгмийн хууль хэмээн үзэж байжээ.

Габриел Тардын дараагаар энэ онолыг баяжуулан авч үзсэн хүн бол Жулиан Роттер /Julian Potter 1954/ бөгөөд сүүлд хэлбэржүүлэн авч үзсэн эрдэмтэн бол Канад-Америкийн социологич Алберт Бандура /Albert Bandura 1977/ юм.

А.Бандура нь хүний суралцахуйн болон хөгжлийн талаар хамгийн чухал тайлбарыг нийгмээс суралцахуйн онолдоо дэвшүүлсэн байдаг юм. Хүчирхийллийг тайлбарлах нилээн бэхжиж тогтсон энэ онолын үндсэн үзэл баримтлалууд нь хүний суралцахуйн бүх хэлбэрийг тооцож, батлан илтгэж чадахгүй байна гэж тэрээр үзсэн юм.

Нийгмээс суралцахуйн онолын хүрээнд дээрх загвар нь шинэ зан төлвүүдийг судлах болон зан төлвийн өөрчлөлтөнд хүрэх чухал суурь нь болдог. А.Бандура Нийгмээс суралцахуйн онолын гол асуудал нь хүчин зүйлс хоорондын шууд хамаарлыг гаргасан явдал юм. Энэ ойлголт нь тухайн хүний бие даасан зан үйл нь хүрээлэн буй орчин болон бусад хүний шинж чанарын нөлөөнд автдаг. Өөрөөр хэлбэл хүний зан үйл, хүрээлэн буй орчин болон хувь хүний шаардлагууд нь хоорондоо харилцан хамааралтайгаар бие биенийхээ нөлөөнд автдаг. Энэ нийгмээс суралцахуйн онолоор хүчирхийллийг тайлбарладаг. Энэ онолоор хүмүүс бусдын хийж буй үйлдлийг харж, даган дуурайх замаар тэр шинэ зан үйлийг сурна. Хэрэв тухайн зан үйлийг дэмжсэн орчин бүрдвэл тэр зан үйл дахин давтагдана гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хүчирхийллийг харсан хүмүүс хүчирхийллийг өөрсдийн харилцаандаа хэрэглэнэ. Хэрэв сөрөг үр дагаваргүйгээр /жишээ нь хууль эрх зүйн арга хэмжээ авагдаагүй тохиолдолд/ хүссэн үр дүндээ хүрвэл /хүчирхийллийг зөвшөөрөх ба хариу арга хэмжээ аваагүй тохиолдолд/ тэрхүү үйлдэл нь дахин давтагдах магадлал ихтэй гэж үздэг байна. Мөн зарим судлаачид энэ онолоор үе дамжин үйлдэгдэх гэр бүлийн хүчирхийллийг тайлбарладаг. Гэр бүлийн хүчирхийллийг өөрийн төрсөн гэртээ харж байсан түүх нь хожим гэр бүлийн харилцаанд ороод хүчирхийллийн хохирогч болох эсвэл өөрөө хүчирхийлэл үйлдэгч болох магадлалтай шууд хамааралтай хэмээн үзсэн байдаг.

Нийгмийн солилцооны /Social exchange theory/ онол нь нэг талаас сэтгэл судлалын онолоос эхтэй боловч нөгөө талаас үнэ цэнэ ба үр ашгийн солилцоог тодорхойлсон социологийн онол гэж үздэг. Энэ онолыг анх социологич Жорж Хоманс боловсруулсан бөгөөд нийгмийн бүхий л харилцааг тайлбарлахыг зорьж байжээ. Ямар ч харилцаанд байх харилцан солилцох зарчмын дагуу амраг хосууд мөн бие биедээ үйлчлэх эсвэл тухайн харилцаанаасаа ямар нэг үр шим хүртэх байдлаар дотно

харилцаанд байдаг. Солилцооны онолоор хүний зан үйл нь бусдын магтаал ба шийтгэлийн нөлөөнд өөрчлөгдөн өөрийн хэв маягаа олдог гэж үздэг. Энэхүү солилцооны онолд тайлбарласнаар, хүмүүс хүссэн зүйлээ авах, хүсээгүй үр дүнгээс зайлсхийхийн тулд өөрийн биеэ авч яваа байдалдаа анхааралтай ханддаг. Нөгөө талаас, хэрэв сөрөг үр дагавартай тулгарахгүйгээр хүчирхийллээр хүссэн зүйлээ авбал хүчирхийлэл үйлдэгч хүчирхийллийг дахин үйлдэх магадлал их гэж үздэг. Нөөцийн /Resource theory/ онол нь эрх мэдэл, шийдвэр гаргах боломжийг нөөц баялагтай холбон тайлбарласан. Баялаг ихтэй, тухайлбал хөрөнгө мөнгө орлого ихтэй, нийгмийн харилцаа холбоо сайтай, эрх мэдэлтэй хүмүүс хүч чадалтай, шийдвэр гаргах эрх мэдэл нь илүү байдаг. Ихэнх нийгэмд эрэгтэй хүмүүс эдийн засгийн нөөц баялагтай байх давуу тал их байдаг бөгөөд энэ нь эмэгтэйчүүд эдийн засгийн хувьд тэднээс хараат, эмзэг байдалд ороход хүргэдэг гэж энэ онолоор тайлбарладаг. Нөгөө талаас, эдийн засаг болон нийгмийн нөөц баялаг багатай зарим хүмүүс хүчирхийлэл хэрэглэн бусдыг дарамтлах, хүмүүсийг өөрийн хяналтанд оруулах замыг эцсийн арга болгон ашигладаг гэж үздэг.

Нийгмийн зөрчилдөөний /Social conflict/ онолоор хүчирхийлэл бол энэ онолын салшгүй ойлголт, хаяг, өөрөөр хэлбэл хүн төрөлхтөн болон гэр бүлд наалдсан цавуу гэж үздэг. Заналхийлэл сүрдүүлэг болоход хүмүүс өөрийн үйлдэл, зан үйлээ хамгаалахад хүрдэг хэмээн үздэг.

Системийн /Systems theory/ онол нь гэр бүлийн бүх гишүүд хүчирхийллийг гэр бүлд бий болгох ба түүнийг тогтоон барих үйл явцад тодорхой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэр зан үйл нь нэг үеэс нөгөө үед дамждаг гэж үздэг.

Феминист /Feminist theory/ онолоор хүчирхийлэл үйлдэгч гэр бүлийн харилцаанд байгаа эмэгтэйгээ хяналтандаа байлгахын тулд хүчирхийллийг хэрхэн ашигладаг талаар анхааран судалдаг. Хүчирхийлэл гэдэг ухагдахууны хүрээнд эмэгтэй хүний бие даасан байдлыг няцааж, гэр бүлийн хамтын амьдралд түүний эрх мэдэлтэй байх бололцоог хязгаарласан аливаа үйлдлүүдийг тухайлбал, бие махбодын хүчирхийлэл, сэтгэл санааны дарамт, бэлгийн хүчирхийлэл, нийгмээс тусгаарлалт, эдийн засгийн хавчлага зэрэг үйлдлүүдийг багтаана. Феминист онолоор мөн нийгмийн бүтэц зохион байгуулалт нь эрэгтэй хүний нийгэмд давамгайлах байр суурийг, нийгмийн тэгш бус байдлыг дэмждэг гэж үздэг.

Патриархаль /Эцгийн эрхт ёс давамгайлсан/ нийгэмд эрэгтэй эмэгтэй хүний эрх мэдлийн харилцаа тэнцвэртэй биш, тэдний нийгэмд гүйцэтгэх үүрэг өөр өөр, нийгмийн хүлээлт ч ялгаатай гэж ойлгодог.

Энэхүү уламжлалт хүйсийн тэгш биш хандлага, нийгмийн хүлээлтийг феминистүүд мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй холбон тайлбарласан.

Экологийн /Ecological theory/ онолоор хүмүүс өөр хоорондоо болон гадаад орчинтойгоо харилцах явцад тэдэнд тулгарах хэрэгцээ, бэрхшээлтэй

асуудлууд нь ил тодорхой болдог. Тухайн асуудалд нөлөөлөх хүчин зүйлс нь хувь хүний онцлог чанар, гэр бүл, орон нутаг, нийгэм соёлын өргөн хүрээг тусгасан орчинтой холбоотой гэж тэд тайлбарлажээ. Тиймээс экологийн онолыг баримтлагчид хүчирхийллийн нөхцөл байдал нь хувь хүн, орон нутаг, нийгэм, улс төр, соёлын гэх мэт хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийн дүнд бий болсон байж болох юм хэмээн үздэг. Лори Хайзе гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр хийсэн өргөн хүрээтэй судалгааныхаа үр дүнд гэр бүлийн хүчирхийллийг экологийн загвараар тайлбарлахад хувь хүний түүх, микросистем, экосистем, макросистем гэсэн дөрвөн түвшинд авч үзэхийг санал болгосон. Хайзе хүүхэд насандаа гэр бүлийн хүчирхийллийн гэрч болсон, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан, эцэггүй өссөн гэх хүүхэд насны гурван өөр түүхийг гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой байж болох хувь хүний эрсдлийн хүчин зүйлс гэж тодорхойлжээ. Харин микросистемд багтах орчны эрсдлийн хүчин зүйлсийн тоонд нийгмийн харилцаанд эрчүүд давамгайлан шийдвэр гаргах, эрэгтэйчүүд илүү эдийн засгийн эрх мэдэлтэй байж хяналт тогтоох боломжтой байх, гэр бүлийн зөрчилдөөн, архи их хэрэглэх зэрэг хүчин зүйлсийг багтаажээ. Экосистемийн хүчин зүйлсийн тоонд нөхцөл байдалд нөлөөлөх албан ба албан бус нийгмийн бүтэц, байгууллагуудыг багтаажээ. Макросистем нь өмнөх гурван түвшинд нөлөөлөх өргөн хүрээтэй нийгэм соёлын хүчин зүйлс, тухайлбал хүмүүсийн хоорондын маргаан зөрчлийг шийдэхэд хүчирхийлэл хэрэглэхийг дэмжсэн итгэл үнэмшил, үнэт зүйлс, уламжлалт хандлага зэргийг багтаадаг байна. Гэхдээ бид дээрх бүх хүчин зүйлүүдийг хүчирхийллийн шалтгаан болдог гэж үзэж болохгүй юм. Өөрөөр хэлбэл хүчирхийлэлд өртөж байсан хүүхэд бүр насанд хүрээд хүчирхийлэл үйлдэгч болдоггүй, нийгэм эдийн засгийн боломж муу айл бүрт гэр бүлийн хүчирхийлэл байдаггүйг бид мэднэ. Тиймээс экологийн янз бүрийн түвшний эрсдлийн хүчин зүйлсийн нөлөөллийг дангаар судлахын оронд тэдгээр хүчин зүйлсийн харилцан үйлчлэл гэр бүлийн хүчирхийлэлд хэрхэн нөлөөлөх талаар судлах нь үр дүнтэй гэж зарим судлаачид үзэж байна.

Танин мэдэхүйн онолд хүмүүсийн сөрөг хандлага бодлоос үүдэлтэй зан үйл нь тэднийг нөхцөл байдлыг бодитоор харж ойлгоход саад болдог. Хүмүүсийн итгэл үнэмшил, бодол санаа, өөрийнх нь тухай яриа нь бодит биш, бодол санаа нь сөрөг, бие махбод дахь физиологийн, мэдрэлийн, эд эрхтний өөрчлөлтөөс үүдэлтэй сэтгэл хөдлөлийн тогтворгүй байдал зэрэг нь тэдний сэтгэл хөдлөл зан үйлийг хэвийн биш болгодог. Мөн хэвийн биш үйлдлийг хэвийн гэж ойлгож, түүнийг үйлддэг зэрэг нь нийгмийн болон бусдын эсрэг зан үйл гаргахад нөлөөлдөг гэж үздэг.

Гэр бүлийн хүчирхийллийг тайлбарласан сэтгэл судлалын онолуудад гол төлөв хувь хүний амьдралын түүхтэй холбоотой, хувь хүний онцлог

чанартай холбоотой, сэтгэцийн эмгэг өөрчлөлт зэрэг шалтгаануудтай холбон тайлбарласан байдаг.

Дээрх шинжлэх ухааны тайлбаруудын аль аль нь хүчирхийлэл хэмээх энэ ойлголтыг онолын үндэстэй тайлбарлаж, уг үзэгдлийн мөн чанар, шалтгааныг илрүүлж байдаг.

Жендэрт суурилсан хүчирхийллийн шалтгаан

Хүчирхийлэл нь эрх мэдэлтэй холбоотой жендэржсэн үзэгдэл юм. Хүчирхийллийг зогсооё гэвэл түүнийг үүсгэж байгаа үндэстэй нь ажиллах шаардлагатай.

Хүчирхийллийн илрэл болон үр дагаврууд нүдэнд илт харагддаг учраас эдгээрийг хүчирхийллийн суурь шалтгаанд тооцогдож, төөрөлдөл үүсгэдэг.

Бид ихэвчлэн хүчирхийллийн хэлбэрүүд болон үр дагаврын талаар л ярилцдаг. Харин “Яагаад хүчирхийлэл үйлдэгдээд байна” гэж бараг асуудаггүй.

Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хооронд, хүмүүсийн харилцаанд эрх мэдлийн тэнцвэргүй байдал оршиж, түүнээс шалтгаалан хүчирхийлэл үйлдэгдэж байдаг.

Эрх мэдлийн тэнцвэргүй байдал нь жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгаан юм. Эрх мэдлийн тэгш бус байдал нь зөрчил, айдас, түгшүүр, хонзогнол, түрэмгийлэл, хүчирхийллийг төрүүлж байдаг. Хүчирхийлэл нь эрх мэдлээ сөргөөр ашиглаж, бусдыг хянаж, дарамтлан, хамааралд оруулж байгаатай холбоотой. Эрх мэдэл хүн бүрт байдаг ч бусдыг хянаж, дарамтлахад ашиглаж, хүчирхийлэл үйлдэж байгаа нь эрх мэдлийн сөрөг хэрэглээ юм.

Архидалт, ядуурал, ажилгүйдэл, боловсролын түвшин зэрэг нь жендэрт суурилсан хүчирхийлэлд нөлөөлөгч хүчин зүйлс болно. Жишээ нь, архи уудаг хүн бүр хүчирхийлэл үйлдэхгүй байхад архи огт амсдаггүй атлаа хүчирхийлэл үйлддэг хүн байдаг. Энэ нь дээрх хүчин зүйлс нь суурь шалтгаан биш болохыг харуулж байна.

Хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоо

Гэр бүлийн хүчирхийлэл нь зөрчил, гэмт хэрэг болсонтой холбогдуулан хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлага нь Зөрчлийн ба Эрүүгийн хуулинд тусгагдсан. 2015 оны Эрүүгийн хуулиар гэр бүлийн хүчирхийллийг анх удаа гэмт хэрэгт тооцож, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг тодорхойлсон. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн онцлог, гэр бүлийн хамаарал бүхий харилцааг харгалзсан доорхи зохицуулалтууд тусгагдсан:

Бие даасан гэмт хэрэг	<ul style="list-style-type: none"> Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх
Тусгай зүйлүүд	<ul style="list-style-type: none"> Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүнийг алах Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах Заналхийлэх Хууль бусаар мөрдөж мөшгих Хувь хүний нууцыг задруулах
Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> Аргагүй хамгаалалт Албадлага, эрхшээлд автах
Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> Хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн Байнгын хүчирхийлэл, дарамтад өртсөний улмаас өөрийгөө хамгаалах зорилгоор хохирогчид халдаж гэмт хэрэг үйлдсэн
Зарим гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдал	<ul style="list-style-type: none"> Хүнийг алах Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах Хүчиндэх
Ял, албадлагын арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> Хорих Зорчих эрхийг хязгаарлах Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ

“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг

11.7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх

- Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга:
 - зодсон;
 - харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан;
 - хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- Энэ гэмт хэргийг:
 - хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн;

- 2.2. асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн;
2.3. таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг ба зөрчлийн ялгаа

1. Үйлдлээрээ ялгаатай
2. Үйлдлийн давтамжаараа ялгаатай /гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийг 1-2 удаа үйлдвэл зөрчлийн тухай хуулиар шийтгэнэ, 3 буюу түүнээс дээш удаа үйлдвэл эрүүгийн хуулиар шийтгэнэ./
3. Оногдуулах ял, шийтгэлийн төрлөөрөө ялгаатай.

Зөрчил	Гэмт хэрэг
Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг: - зодсон; - хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; - бусадтай харилцахыг хязгаарласан; - хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга: - зодсон; - харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; - хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан Энэ гэмт хэргийг: - хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн; - асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн; - таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн бол
Албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна	Зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

Эрүүгийн хариуцлага

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн тэлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх зорилготой. Эрүүгийн хариуцлага нь доорхи ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ.

Эрүүгийн хариуцлага



Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал

Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдлыг харгалзан үзэх нь шүүхээс гэм буруутай этгээдэд ногдуулах ялыг хөнгөрүүлэх, эсхүл хүндрүүлэх зайлшгүй шаардлагатай эсэхийг дүгнэх үндэс болдог. Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх дор дурдсан нөхцөл байдлыг Эрүүгийн хуулиар тогтоосон:

- Тохиолдлын шинжтэй нөхцөл байдлын улмаас анх удаа гэмт хэрэг үйлдсэн;
- Гэмт хэрэг үйлдсэний дараа хохирогчид шууд эмнэлгийн, бусад туслалцаа үзүүлсэн, учруулсан хохирлыг төлсөн;
- Бие махбодын, сэтгэл санааны албадлагын, эд хөрөнгийн, албан тушаалын, бусад байдлаар эрхшээлд орсны улмаас гэмт хэрэг үйлдсэн;
- Хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн;
- Өөрийгөө илчилсэн, бусдын үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг олоход тусалсан;
- Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн;
- Байнгын хүчирхийлэл, дарамтад өртсөний улмаас өөрийгөө хамгаалах зорилгоор хохирогчид халдаж гэмт хэрэг үйлдсэн.

Шүүх дээр дурьдсанаас бусад онцгой нөхцөл байдлыг харгалзан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж болно.

Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэх нөхцөл байдлын жагсаалтыг Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлд дараахь байдлаар тогтоосон:

- Бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж онц харгис хэрцгий аргаар, тохуурхан доромжилж үйлдсэн;
- Санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн, эсхүл гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн;
- Нийтэд аюултай аргаар үйлдсэн;

- Өөр гэмт хэргийг нуун далдлах, хялбарчлах зорилгоор үйлдсэн;
- Албан үүргээ гүйцэтгэх, олон нийтийн үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хохирогч, түүний ойр дотны хүний эсрэг үйлдсэн;
- Хохирогчийн биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн;
- Онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан үйлдсэн;
- Гэм буруугаа хүлээж хохирлоо төлөх үүрэг хүлээсэн хүн шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй.

Дээр дурьдсанд заагаагүй нөхцөлөөр эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхийг хориглоно.

Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх

Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа зөвшөөрч гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлөхөө илэрхийлсэн бол гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан хорих ял оногдуулахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар тэнсэж болно.

Шүүх ял оногдуулахгүйгээр тэнссэн хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, хувийн байдлыг харгалзан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.

Тэнссэн хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн, эсхүл санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх тэнссэн шийдвэрээ хүчингүй болгож, ял оногдуулна. Харин тэнссэн хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хугацаанаас нь өмнө ялаас чөлөөлж болно.

Албадлагын арга хэмжээ

Шүүх гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх зорилгоор гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нь нэмж оногдуулдаг хүмүүжлийн болон нөлөөллийн шинжтэй арга хэмжээ юм.

Албадлагын арга хэмжээ нь дараах төрөлтэй:

1. Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ;
2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ;
3. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.

Үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ	
1. Үүрэг хүлээлгэх	2. Эрх хязгаарлах
<ul style="list-style-type: none"> • гэмт хэргийн хор уршгийг арилгах • зан үйлээ засах сургалтад хамрагдах • тодорхой ажил үүрэг гүйцэтгэх • оршин суух газраа өөрчлөх, зорчихдоо эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах 	<ul style="list-style-type: none"> • тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах • галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хорилох • согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох • тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглох

Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хэд хэдэн үүрэг хүлээлгэж, эрхийн хязгаарлалт тогтоож болно.

Шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн, албадлагын арга хэмжээ авагдсан хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх уг шийдвэрийг хүчингүй болгож ял оногдуулна.

Харин үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлж эрхийн хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хугацаанаас нь өмнө ялаас чөлөөлж болно.

Албадлагын арга хэмжээний хугацаа дууссаны дараа тухайн хүнд ял оногдуулах эсэхийг прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ

Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана. Хэрэг хариуцах чадваргүй байсан гэдэгт хүн өөрийн үйлдлийг хариуцаж буюу жолоодож чадахгүй болсныг ойлгоно. Тухайлбал, сэтгэл мэдрэлийн архаг өвчин /шизофрени, давших саа, эпилепси/, сэтгэл санааны хүнд дарамтаас болж сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, оюуны хомсдол, хүнд дэмийрэл г.м сэтгэцийн бусад сааталд орсон байх-ыг хэлнэ. Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүнд сэтгэл заслын, донтох зуршлын эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох эсэхийг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх шийдвэрлэнэ.

Хүчирхийлэл үйлдэгч гэж хэн бэ?

Хүчирхийлэгч дараах стратегийг ашигладаг

- Сэтгэл хөдлөлийн эмзэг байдал, ур чадварын дутмаг байдлаа нуух
- Өөрийгөө хамгаалах зорилгоор хуурамч дүрийг бүтээх
- Өөрийнх нь үнэн дүр төрх, сул дорой байдал нь илчлэгдэхээс сэргийлэх

Хүчирхийлэгчийн онцлог шинжүүд

- Өөрчлөлт хийхэд хүлээцгүй ханддаг
- Өөртөө итгэлгүй
- Хил хязгаар байхгүй
- Өв тэгш бус гэр бүл
- Бодит байдлаас зугтах хандлагатай
- Бусдаас илүү/ялгаатай байхыг эрмэлзэх
- Дотно харилцаа эсвэл хяналтаа тогтоохын тулд уур омгоо ашигладаг
- Сэтгэл хөдлөлөө илэрхийлж чаддаггүй
- Гэр бүлээ өмч хөрөнгө шиг авч үздэг
- Үүрэг хариуцлагаас зайлсхийдэг
- Эмпати үзүүлэх чадваргүй
- Нийгмээс тусгаарлагдмал
- Хуучинсаг
- Хартай
- Хохирогчийг буруутгадаг
- Дээд зэргийн арга зальтай
- Өмнө нь хүчирхийлэл үйлдэж байсан
- Үерхэл нөхөрлөлөө хяналтандаа байлгахыг эрмэлздэг
- Өөрийнхөө зан үйл, биеэ авч яваа байдлаа хэвийн/зөв гэж үнэлдэг.

Хариуцлагаас зайлсхийдэг нийтлэг шинж:

1. Үгүйсгэл Ийм зүйл болоогүй!
2. Багасгаж ярихХүчирхийллийн агуулгыг багасгаж ярих
3. Гадаад шалтгаанБусад хүмүүс ингэсэн учраас ийм үйлдэл хийсэн!
4. Оюунжуулах.....Өөрийгөө зөвтгөх зан үйл!

Бодол санаа ба зан үйлийн хэв маяг:

- Буруутгах-Үүрэг хариуцлагаа бусад руу шилжүүлэх
- Сэтгэл ханамжийг яг одоо авах гэх-Одоо цагт анхаардаг
- Маадгар-Өөрийгөө их чухал гэх дүр үзүүлэх
- Магтаал-Өөрийгөө бусдаас илүү гэж үнэлэх
- Цор ганц/хосгүй-Бусдаас өөр байхыг эрхэмлэх
- Худал хэлэх-Мэдээллийг хянах, төөрөгдөл үүсгэх эсвэл давуу тал олж авах зорилгоор

- Хил хязгаарын мэдрэмж сул-“Би юу хүсч байна, түүнийгээ хийнэ”
- Чи минийх-Бусдыг өмч хөрөнгө шиг өмчлөх гэх

Хүчирхийлэгч дараах тактикийг ашигладаг:

- Эрх мэдэл давуу
- Дарангуйлал
- Хяналт

Тактик

5.2 ХҮЧИРХИЙЛЭЛ БА СЭТГЭЦИЙН ЭМГЭГИЙН УЯЛДАА ХОЛБОО

Ямар ч төрлийн сэтгэцийн эмгэгтэй хүн хүчирхийлэл үйлдэж болно. Гэвч сэтгэцийн эмгэгтэй хүмүүс бүгд хүчирхийлэл үйлдэх хандлагатай байдаггүй. Хүчирхийлэл үйлдэх өндөртэй эрсдэлтэй сэтгэцийн эмгэгт бие хүний эмгэг, донтох эмгэгүүд ордог. Хүчирхийлэл үйлдэхэд түгээмэл илэрдэг сэтгэл хөдлөл бол уур бухимдал юм.

Сэтгэл хөдлөлийн талаас уур бухимдал гэдэг бол хамгаалах механизм юм. Сэтгэл зүйн дотоод асуудлаа уур бухимдлаар илэрхийлэх тохиолдол байдаг хэдий энэ нь зэрэг, сөрөг хоёр талтай үздэг.

БИЕ ХҮНИЙ ЭМГЭГҮҮД

F60-Бие хүний өвөрмөц эмгэгүүд нь дараах эмнэлзүйн хэлбэрүүдтэй.

- F60.0 Бие хүний паранойд эмгэг
- F60.1 Бие хүний шизоид эмгэг
- F60.2 Бие хүний нийгмийн эсрэг эмгэг
- F60.3 Бие хүний сэтгэлийн хөдөлгөөний тогтворгүй эмгэг
- F60.4 Бие хүний истерийн эмгэг
- F60.5 Бие хүний улигт албадмал эмгэг
- F60.6 Бие хүний сэтгэл түгших эмгэг
- F60.7 Бие хүний хараат эмгэг
- F60.8 Бие хүний бусад өвөрмөц эмгэг
- F60.9 Бие хүний тодорхой бус эмгэг

Хүчирхийлэл үйлдэх эрсдэл бүхий бие хүний эмгэгүүдийг дэлгэрүүлж үзэе.

F60.0–Бие хүний паранойд эмгэг

Паранойд хэвшинжтэй бие хүнийг илэрхийлдэг өвөрмөц шинж чанаруудыг тодорхойлвол:

- Хэт үнэлсэн одол санаанд автах хандлагатай, өөрийнхөө авьяас чадвар, бодит боломжийг хэт үнэлнэ.
- Хардамтгай, сэжиглэмтгий, мэдрэмтгий, эмзэг, бусдад итгэдэггүй, хэрүүлч, заргач, биедээ хэт найдсан, зөрүүд, шуналтай, үнэнч биш, нууц далд хийгээд зөвхөн хувиа хичээсэн зан төлөвтэй.
- Сэтгэлдээ хурсан хардах мэтийн муу сэтгэлээ мартаж, өөрөөсөө зайлуулж чадалгүй түүнд шигдэж, түүндээ хөтлөгддөг.

- Хүмүүстэй харилцахдаа өөрийн эрх ашигт хохирол учруулах нууц далд санаа бодолтой хүн мөн эсхийг тандах, сонжих хэлбэрээр сонор сэрэмжтэй хандана.
- Ямар нэг асуудал хэлэлцэх явцад санал зөрөхөд өөрийнхөө санал бодлыг хайхраагүй тэр хүнд хэт эмзэглэж түүнд гомдож өшөө өвөрлөнө. Тэрчлэн санал зөрөлдөөний ач холбогдлыг өсгөж, асуудлыг өөрийнхөөрөө шийдвэрлэхийн төлөө тэмцэнэ.
- Зөрчил будлианы улмаас үүссэн тааламжгүй сэтгэл хөдлөлийг олон жилээр сэтгэлдээ хадгална. Сэтгэлдээ хурсан мэдрэмжиндээ хөтлөгдөн тэдгээр муу сэтгэлийг төрүүлсэн хүнээс өшөөгөө авахаар тэмцэнэ. Ямар нэг аргаар өшөөгөө авч байж сэтгэлд хурсан муу сэтгэл нь тайлагдана.
- Өөрийнхөө хийсэн, зохион бүтээсэн, гар бие оролцсон буюу ухаан бодлоо шингээсэн ямар нэг зүйлийг бодит байдлаас нь хэтрүүлэн үнэлж, шинэ бүтээл зохиосон хэмээн түүнийг албан ёсоор баталгаажуулсан үнэмлэх, гэрчилгээ, зэрэг бичиг баримт олж авахын төлөө, бас зохих шагнал урамшуулал хүртэхийн төлөө махруун хөөцөлдөнө.

F60.1–Бие хүний шизойд эмгэг

Эмнэлзүйн шинжүүд:

- Шизойд бол олноос тасархай, зожиг хүн юм.
- Хүүхэд насанд үеийн хүүхдүүдтэй хамт тоглохгүй, ганцаараа тоглоно. Насанд хүрсэн хүмүүстэй хамт байж, тэдний яриаг удтал дуугүй сонсоно.
- Өсвөр насанд зожиг зан ааш нь хүн бүрийн нүдэнд улам ил тод болж хэнтэй ч чин сэтгэлээсээ нээлттэй тод харилцахгүй.
- Зөвхөн өөрийн дотоод ертөнц рүү чиглэсэн түгжигдмэл, далд, нууц харилцаатай.
- Шизойдуудын дотоод ертөнц нь хүсэл мөрөөдлөөр, зохиомол хийгээд хийсвэр бодлоор, ер бусын сонирхлоор дүүрэн байдаг.
- Шизойдууд амьдралаас тасархай, хэт хийсвэр агуулагтай, хөндлөнгийн хүмүүст ойлгогдохгүй хийгээд хачин сэтгэдэл төрүүлсэн ямар нэг зүйлийг сонирхоно.
- Өөр нэг онцлог шинж чанар бол хүйтэн сэтгэл, хайхрамжгүй хандлага, донгио байдал юм.
- Юу ч шизойдуудын сэтгэлийг хөдөлгөхгүй, шүүмжлэл магтаал хоёрын аль алинд сул хариу урвал өгнө.
- Бусдын зовлонг мэдрэх мэдрэмжгүйгээсээ болж шизойдууд харгис хэрцгий хэрэг үйлдэж мэднэ.
- Зожиг зангаасаа, этгээд араншингаасаа болж шизойдууд ганцаар амьдрах амьдралыг эрхэмлэнэ, ганцаар ажиллахыг шаарддаг мэргэжлийг сонгоно.

F60.2–Бие хүний нийгмийн эсрэг эмгэг

Бие хүний нийгмийн эсрэг эмгэгтэй хүмүүс нийтээр хүлээн зөвшөөрсөн

нийгмийн хэм хэмжээнүүдийг тухайлбал, олон нийтийн, хэв журмын, сахилга батын, ёс заншлын, ёс зүйн болон эрх зүйн хэм хэмжээнүүдийг үл баримтлан зүйл зүйлийн зөрчил гаргах буюу гэмт хэрэг үйлдэнэ. Тэд байн байн танхайрна, ажил таслана, хууран мэхлэнэ, луйвардана, худлаа ярина, хулгай хийнэ, хүчирхийлэл үйлдэнэ, гэмт хэрэг үйлдэнэ.

Бие хүний нийгмийн эсрэг эмгэгтэй хүмүүс бол:

- Энэрэх сэтгэлгүй
- Хатуу сэтгэлтэй
- Гэмших сэтгэлгүй
- Бусдын сэтгэлийн зовлонг хайхардаггүй
- Гаргасан зөрчил хийгээд үйлдсэн гэмт хэргээ хүлээн зөвшөөрдөггүй
- Гэм буруугаа хүлээн зөвшөөрхийн оронд түүнийг бусад руу түлхэх хандлагатай
- Гэм буруутай үйлдлээсээ сургамж авах чадваргүй
- Өөрий эрхгүй гэнэт хөдөлж нийгэмд харш үйлдэл үйлдэх хандлагатай
- Харгис хэрцгий зан төлөвтэй
- Үл бүтэх этгээдүүд байдаг

F60.3–Бие хүний сэтгэлийн хөдөлгөөний тогтворгүй эмгэг

Хоёр хувилбартай:

1. Бие хүний сэтгэлийн хөдөлгөөний тогтворгүй эмгэг
2. Бие хүний огцом уурлах эмгэг

Бие хүний сэтгэлийн хөдөлгөөний тогтворгүй эмгэг: Ийм эмгэгтэй хүмүүс сэтгэцийн хувьд маш тогтворгүй хүмүүс байдаг. Тэдний үзэл бодол, итгэл үнэмшил, хэрэгцээ сонирхол, дур хүсэл маш тогтворгүй хийгээд хувьсамтгүй байдаг. Тогтворгүй зан аашнаасаа болж авгай олныг солино, олон албан газар дамжин ажиллана, сургууль буюу мэргэжлээ байн байн солино.

Эмнэлзүй:

- Сэтгэлийн хөдөлгөөн маш тогтворгүй, хувьсамтгай байдаг. Жишээ нь: Гуниглах, уцаарлах, гомдох, түгших, үе үе огцом уурлаж, түрэмгий авир гаргана
- Огцом уурлаж, бухимдсан үедээ биеийнхээ энд тэнд хутгаар сийчих, судсаа ханах, амиа хорлох оролдлого хийх зэрэг зан үйлийг гаргаж болно.
- Аливаа асуудлыг болол ухаарлаар биш, зөвхөн дур хүсэл буюу сэтгэл хөдлөлдөө хөтлөгдөн шийдвэрлэнэ.
- Өөрийгөө захирч чадахгүй, өөрийн мэдэлгүй гэнэтийн зан үйлдлийг олонтаа үйлдэнэ. Жишээ нь: ямар ч бодлогогүй мөнгөө дэмий үрнэ, өөртөө хяналтгүй садар самуун явдалд татагдах гэх мэт.
- Биеэ даан сэтгэх чадвар султай, биеэ даасан бодлогогүй байдаг. Бусдын ятгалганд амархан автана.

- Үл бүтэх этгээдүүдийн нийгэмд харш зан үйлийг амархан даган дууриана, эвсэлдэн нэгдэж ч мэднэ. Үл бүтэх этгээтүүдийн гар, хөл болж, тэдний санаачилсан “хам хэргийг” халуун гараараа үйлдэж хариуцлагыг хүлээх нь олонтаа тохиолдоно.
- Сэтгэл нь цочирдсон үед өөрийгөө шийтгэх хариу урвал өгч мэднэ.

Бие хүний огцом уурлах эмгэг:

- Ийм эмгэгтэй психопат өөрийг нь зэмлэж буруушаахад өөрийгөө хянаж, сэтгэлээ барьж чадахгүй огцом уурлаж зэмлэн буруушаагчийг хэл амаар доромжлох, зодож бэртээх хэлбэрээр байн байн хүчирхийлэл үйлдэнэ.
- Уурандаа бусдыг шийтгэх хариу урвал өгнө.

Ү60.5–Бие хүний улигт албадмал эмгэг

Эмнэлзүйн шинжүүд:

- Аливаа ажлыг хэтэрхий ёсоор нь хийх гэж мэрийнэ.
- Тэд дэг журмыг, дүрэм зааврыг, ёс зүйг, бас хууль ёсыг мөрдөх гэж өөрсдийгөө албадна, тэдгээрийг ёсчлон биелүүлнэ, ягштал хэрэгжүүлнэ, ингэхгүй байж хэрхэвч чадахгүй.
- Дүрэм журам баримтлахыг, ёс дэглэм сахихыг, даалгавар биелүүлэхийг бусдад тулган шаардана.
- Хэрэв ямар нэг хэрэг хийх буюу зөрчил гаргавал түүндээ гэмшихийн ихээр гэмшинэ.
- Өөрсдөө алдаа гаргахаас үргэлж айна. Аймхайгаасаа болж шийдвэр гаргахдаа дандаа эргэлзэнэ. Шийдвэр гаргахын өмнө олон удаа эргэцүүлэн бодно. Гаргасан шийдвэрийнхээ зөв эсэхт байнга эргэлзэж сэтгэл түгшинэ.
- Жижиг сажиг юманд хэт санаа зовно. Мөн аар саар юмаар хөөцөлдөх олхиогүй зан гаргана. Тэд үзэл баримтлалаа тууштай хамгаална.
- Ямар нэг зөрчил будлианд өртвөл түүнийг сэтгэл дотроо хадгалан далд шанална. Энэхүү далд шаналгаа бухимдал, түгжигдмэл байдал нь улигт бодлоор, албадмал үйлдлээр буюу ямар нэг хэлбэрийн хүчирхийлэл үйлдэх явдлаар илэрч болно.

АРХИНЫ ШАЛТГААНТ БИЕ ХҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Хүний нийгэм-сэтгэл зүйн шинжүүд болох зан төлөв, авир араншин, авъяас чадвар, зорилго чиглэлийг бие хүний хувийн онцлог чанар гэж тооцдог. Архины архаг хордлогын нөлөөгөөр бие хүний хувийн онцлог шинж чанарууд тодрон илрэх эсвэл тэдгээр нь хувиран өөр шинж чанаруудаар солигдох хэлбэрээр өөрчлөгддөг. Үүнийг харгалзан бие хүний өөрчлөлтийг дотор нь:

1. Бие хүний хувийн онцлог шинж чанар хурцдан тодрох өөрчлөлт
2. Бие хүний бууралт буюу доройтол гэж хуваана.

Бие хүний хувийн онцлог шинж чанар хурцдан тодрох өөрчлөлт:

Архинд донтох эмгэгийн нэг ба хоёр дугаар үе шатанд ажиглагддаг. Архаг архидалтын нөлөөгөөр бие хүний онцлог шинж чанарууд янз бүрийн хэлбэр маягийн зан төлөвөөр хурцдан илэрнэ. Зонхилон ажиглагдах зан төлвүүдийг тодруулбал:

Тогтворгүй зан төлөв:

- Хүсэл, сонирхол, хэрэгцээ, төлөвлөгөө маш тогтворгүй, үргэлж солигдоно.
- Нэг албан байгууллагад буюу нэг ажилд тогтвор суурьшилтай ажиллаж чадалгүй, түүнийг байн байн өөрчилнө.
- Хэнтэй ч хамаагүй амархан танилцана, гэвч бусадтай удаан хугацаагаар тогтвортой үерхэж чаддаггүй.
- Бусдын муу нөлөөнд амархан автагддаг.
- Зугаа цэнгээг эрхэмлэх хандлагатай.
- Архи болон мөрийтэй тоглоомд амархан автагддаг хувийн онцлогтой.

Истериин зан төлөв:

- Өөрсдийгөө хүрээлэн байгаа хүмүүсийн анхаарлын төвд байхыг эрмэлзэнэ.
- Өөртөө халамж анхаарал тавихыг шаардана.
- Бусдын анхаарлыг татах, элдвээр маяглах хандлага гаргадаг.
- Өөртөө тохиолдсон хэрүүл маргаан, зөрчил будлианд ээрэх, унах, татах, үхнэ гэж ярих, амиа хорлох оролдлого хийх зэрэг элдэв янзын байдлаар бусдад үзүүлэх хэлбэрийн хариу урвал өгнө.
- Гар хөл, цээж болон биеийн бусад хэсэгт элдэв янзын дүрстэй хээ, янз бүрийн үсэг шивэх хандлагатай.

Цочромтгой догшин зан төлөв:

- Ялимгүй зүйлд бие сэтгэлээ барьж чадахгүй уурлах, хилэгнэх, бухимдах, хэрэлдэх зан үйл гаргана.
- Бусдаас өө сөв эрэнэ, сэтгэл дундуур байх хандлага ихтэй.
- Агсам тавьж дошгироно, зодолдоно.
- Түрэмгий авирын улмаас хэрэг үйлдэнэ.

Архины архаг хордлогын нөлөөгөөр тодрон гарч байгаа бие хүний хувийн онцлог чанарууд согтсон үед улам тод ажиглагддаг.

Архинд донтох эмгэгийн хоёрдугаар үе шатанд шилжсэн архины хамааралтай хүнд илэрдэг шинж тэмдэг юм. Бие хүний бууралтын илрэлүүдэд хүний зан харьцаа, ёс суртахуун, дотоод сэтгэлийн мэдрэмжүүдийн өөрчлөлтүүд ордог. Дараах шинжүүд илэрнэ.

- Бие хүний нийгэмд дасан зохицох чадвар эхлээд буурч, сүүлдээ алдагддаг. Үүнээс болж архаг архичид нь хамт олон, гэр бүлийнхээ хүмүүст хандах өдөр тутмын харицлаанд зөрчил будлиан, хэрүүл маргаан гаргадаг.

- Бие хүний нийгэм-ёс суртахууны мэдрэмжүүд алдагддаг. Үүнтэй холбоотойгоор архаг архичид нь албан байгууллага болон гэр бүлийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх чадваргүй байдалд шилждэг.
- Нийтээр баримталдаг ёс суртхууны хэм хэмжээг баримтлан, хамт олны дунд биеэ авч явах чадвараа алддаг.
- Хамт олноос тавьж байгаа нийгэм-ёс суртахууны шаардлагыг биелүүлэх чадваргүй болж байн байн ёс зүйн болон эрх зүйн зөрчил гаргана.
- Хүний хамгийн нандин чанар болох нинжин сэтгэлд бүр ч илүүтэйгээр хортой нөлөө үзүүлж, нинжин сэтгэл алдагдсанаас ичих, зовох, харамсах, гэмших зэргээр бие хүн өөрөө өөрийгөө шүүх, зэмлэх, шийтгэх чадвараа алдан ёс суртахууны хувьд доголдолтой хүн болно.
- Архины архаг хордлогын нөлөөгөөр танхай балмад, ууртай, догшин, бүдүүлэг, хөнгөн хийсвэр, худалч, зальтай, хэнэггүй авир араншинтай хүмүүс болон хувирдаг.
- Архинд донтох эмгэг даамжрахын хирээр архидах эмгэг хэрэгцээ, дур шунал төрдөг.
- Архи олж уухын тулд эд хөрөнгөө зарах, таних танихгүй хүнээс мөнгө гуйх, бусдыг хууран мэхлэх, худлаа ярих, хулгай дээрэм хийх зэрэг зүйл зүйлийн хэлбэрээр шившигтэй хэрэг үйлддэг гэмт хэрэгтэн болж хувирдаг.
- Эдгээрийн эцэст архаг архичид нь ажил таслах, худал хэлэх, хууран мэхлэх, залилах, гэр бүлээсээ салах, нийгмийн хэв журам зөрчих, танхайрах, гэмт хэрэг үйлдэх зэрэг янз бүрийн хэлбэрээр ёс зүйн болон эрх зүйн зөрчил гаргах байдлаар ёс суртахууны хувьд доройтон зохисгүй муухай, гутамшигтай, нэр төргүй, хүний ёсноос гадуур хэрэг үйлдэж хөлчүүрхдэг бэртэгчин амьдралтай хүмүүс болж хувирдаг.

5.3 ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИД ҮЗҮҮЛЭХ СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ

Хүчирхийлэл үйлдэгчид сэтгэл зүйн тусламж үзүүлэх дийлэнх хөтөлбөр нь дараах гурван хандлага дээр суурилсан байдаг. Үүнд:

- I. **Феминист хандлага** нь эцгийн эрхт зан заншил, түүний гэр бүл, нийгэмд үзүүлж буй үр нөлөө, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн суурь хүчин зүйлс, эрэгтэй ба эмэгтэй хүмүүс хоорондын эрх мэдлийн эрх тэгш харилцаа; жендэрийн талаарх стереотипийг даган мөрдөж байгаа байдал; болон нийгэмд оршиж буй хүчирхийлэл дагуулсан нийтлэг уламжлал, сол зэрэгт хийсэн дүн шинжилгээнд суурилдаг. Гол зорилго нь хүчирхийлэлгүй/ялгаварлан гадуурхалгүй нийгмийн стандартууд, эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд хоорондын эрх тэгш харилцааг дэмжих, түгээн дэлгэрүүлэхэд оршдог.
- II. **Танин мэдэхүй-зан үйлийн хандлага** нь хувь хүнд түрэмгий зан авирын үйл хөдлөлийн саатал ба үйлдлийн талаар ойлгуулахад

чиглэдэг. Үүнд түрэмгий үйлдлийг зогсоох стратегиудыг таньж мэдэх, зан үйлийг бүтцээр нь салгах болон дахин эвлүүлэх арга хэрэгслийг ашиглан уур уцаар, хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах өвөрмөц арга техникууд багтдаг /жишээ нь: Хамгаалах дохиоллыг таньж мэдэх; өөрийн бурууг хүлээлгэх; хугацаа дуусах гэх мэт/.

III. **Сэтгэл зүйн боловсролын хандлага** нь дарангуйлах зан үйлийн төлөөх хариуцлагын таамаглалд анхаардаг. Үүнд сэтгэл санааны сөрөг байдлаа удирдах, цаашид гарч болох хүчирхийллээс урьдчилан сэргийлэх стратегиудыг боловсруулах, зан үйлийн шинэ дадалтай болох, эцэг эхийн хүмүүжлийн хэв маягт нөлөөлж зан үйлийг засах/засах, бусдыг ойлгож санаа зовох ур чадварыг хөгжүүлэх, болон эр хүн эрэлхэг зоригтой байх гэсэн итгэл үнэмшил, үнэт зүйлсийг өөрчлөх дасгалууд орно.

Сэтгэл зүйн тусламжийг үзүүлэхдээ зайлшгүй тодруулах асуултууд:

- Өмнө нь хүчирхийлэл үйлдэж байсан уу?
- Хэн нэгнийг хохироож байсан уу?
- Ямар нөхцөл, ямар зорилгоор хүчирхийлэл үйлдсэн болон мэдэх хэрэглэсэн эсэх бүгдийг мэдэх нь чухал.
- Хүчирхийллийн дарамтанд өртөж байсан эсэх?
- Бага насны зан байдлыг тодруулах?
- Түр саатуулахад орж байсан эсэх, зугтах оролдлого хийж байсан эсэх?
- Бэлгийн этгээд зан үйл, хүсэл бий эсэхийг тодорхойлох?
- Үйлдсэн хүчирхийллийн үйлдэлдээ өөрийнх нь хандаж буй байдал, хандлагыг тодорхойлох нь маш чухал. Тиймээс үүнийг тодруулж асууна. “Байх л зүйл, гайгүй ш тээ” гэх мэтээр хандах нь эрсдлийг нэмэгдүүлж байдаг.
- Өмнө нь сэтгэл зүйн тусламж, эмчилгээнд хамрагдаж байсан эсэх, хийгдсэн эмчилгээний үр дүн ямар байсан?
- Ирээдүйн төлөвлөгөө болон амьдралын төлөвлөгөө бий эсэх?
- Нэмэлт судлах асуултууд, /гадаад нөлөөлөх хүчин зүйл/:
- Гэрт нь зэвсэг хадгалагдсан байна уу? /Зэвсэгтэй байх нь хүчирхийлэл үйлдэх эрсдлийг нэмэгдүүлж байдаг/
- Хэн нэгнийг үзэн ядаж байна уу? Түүнийг олж хайх гэсэн эрсдэл бий эсэх.
- Хохирч болзошгүй хүмүүс нь биеэ хамгаалах чадваргүй байх нь эрсдлийг бүр ихэсгэнэ.
- Нийгмээс авч буй дэмжлэгийг судлах. Дэмжлэг ихтэй байх нь дахин хүчирхийлэл үйлдэх эрсдлийг бууруулдаг.
- Амьдралынх нь стресс бүхий үйл явдлыг судлах /өртэй байх, хэн нэгэнтэй үргэлж тааламжгүй харилцаатай байх гэх мэт/.

Сэтгэл зүйн тусламж үзүүлэх дараалал:

Эмчилгээний хэлбэр нь:

1. Бүлгээр
2. Хосын болон гэр бүлийн
3. Хувьчилсан буюу ганцаарчилсан байж болно.

Хэрвээ хүчирхийлэл үйлдэгч нь мансууруулах бодис хэрэглэдэг, хэл яриа, юмыг удаан ойлгодог эсвэл сэтгэцийн эмгэгтэй бол нэмэлтээр дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд илгээх эсвэл мэргэжлийн эмчээс зөвлөгөө авах шаардлага гарч болно.

Бүлгийн эмчилгээг голдуу эмэгтэй ба эрэгтэй 2 чиглүүлэгч удирдана. Эрэгтэй-эмэгтэй чиглүүлэгчийн хослол нь эрэгтэй ба эмэгтэйчүүдийн хоорондын хүчирхийлэлгүй харилцааны жишээ болдог. Бүлгийн эмчилгээний үеэр голдуу өөр хүний түүхийг сонсох замаар тусгах, асуудлыг бүрэн дүүрэн ойлгуулах, түүнчлэн нийгэмших, жендертэй холбоотой хэвшмэл ойлголтыг өөрчлөх боломжийг бүрдүүлдэг.

Бүлгээр ажиллах хөтөлбөр нь эрчүүд хоорондын харилцааны онцлог байдлын талаар туршилт хийх, өрсөлдөөнөөс илүүтэй хувь хүний өөрчлөлтөнд анхаардаг. Түүнчлэн бүлгийн дунд байснаар хүчирхийлэл үйлдэгчид ганцаардаж байгаа бус өөрийг нь ойлгож, дэмжиж байгаа мэдрэмж төрдөг байна. Бүлэгт 8-10 хүртэлх тооны, хамгийн дээд нь 12-15 оролцогтой байна. Бүлгийн уулзалт нь хаалттай эсвэл нээлттэй байж болно.

Хосын болон гэр бүлийн эмчилгээг өвөрмөц нөхцөл бүрдсэн тохиолдолд явуулна. Эмэгтэйн хувьд аюулгүй байдалдаа итгэл төгс, эрэгтэйн хувьд хөтөлбөрөө заавал дуусгах, бие махбодын хүчирхийлэл эсвэл хяналтандаа байнга байлгахыг больсон, мөн тодорхой хугацааны туршид ямар нэгэн хүчирхийлэл үйлдээгүй байх ёстой. Бусад нөхцөлд хосын эмчилгээ нь тохиромжгүй.

Хувьчилсан буюу ганцаарчилсан эмчилгээ нь тэр бүр стандартын дагуу байж чаддаггүй. Зарим хөтөлбөрт ганцаарчилсан эмчилгээг ямар нэгэн чухал хэрэгцээ гарсан эсвэл өвөрмөц тохиолдолд /хэрвээ оролцох бүлгийн хичээлд оролцох боломжгүй болсон гэх мэт/ дангаар нь, бусад үед бүлгийн эмчилгээтэй хамт үзүүлдэг. Ганцаарчилсан эмчилгээг хувийн асууудал, хүчирхийллийн төрөл бүрийн хэлбэрийн дүн шинжилгээ, хүчирхийллийн суурь болж буй хүчин мөхөс байдлын мэдрэмжийг ойлгох, эсвэл харилцааны явцыг ойлгох зэрэгт хандуулж болно.

Сэтгэл зүйн тусламж үзүүлэх хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа:

Үйлчлүүлэгчийн шалгуурт нийцэх байдлыг нэгээс таван удаагийн ирэлтийн /үнэлгээ хийх/ байдлаар үнэлнэ. Ганцаарчилсан уулзалтууд зургаагаас арван сарын хооронд үргэлжилж болох бөгөөд багадаа 1-5 хоногийн давтамжтай байна. Хугацаа нь үйлчлүүлэгчийн өвөрмөц хэрэгцээнээс

хамаардаг. Бүлгийн уулзалт нь 7-14 хоногийн хооронд дор хаяж нэг удаа, долоо хоногт гурван удаагаас хэтрэхгүй байх нь зүйтэй. Интервенцийг ядахдаа 20 долоо хоногийн туршид үргэлжлүүлэх, ер нь нэгээс 1.5 жил үргэлжилдэг. Ерөнхийдөө, нэг удаагийн уулзалтыг 2-2.5 цагт багтаах нь зүйтэй.

Сэтгэл зүйн тусламж үзүүлэх хөтөлбөрийн агуулга

Хөтөлбөрийн хүрээнд бүлгийн хэлэлцүүлэг, хосоор ажиллах зэрэг бүлгээр хийх үйл ажиллагаанаас гадна видео, аудио материал эсвэл зураг зурах, психодрам, дүрд тоглох болон тэмдэглэл хөтлөх зэрэг бусад бүтээлч үйл ажиллагаа багтдаг.

Бүлгийн үйл ажиллагааны үеэр хамрах сэдвүүдэд:

- Бие махбодын хүчирхийллийг эцэслэх асуудлыг анхаарах,
- Сүрдүүлэг болон хянах зан үйл,
- Хүчирхийлэл дахин давтагдаж буй байдлыг ойлгох зэрэг багтдаг.

Бүлгийн хэлэлцүүлгээр өөрийн зан үйлд хариуцлага хүлээхийг дэмжих, хүчээр удирдаж буй байдлыг, түрэмгийлэх тактик, үгүйсгэх болон доош оруулах зэргийг шинжлэн судалж болох юм. Түүнчлэн бүлгийн ажлыг жендэрт суурилсан хүчирхийлэл болон жендэрийн тухай хэвшмэл ойлголт, соёлын болоод нийгмийн бүтцийн нөлөөллийн асуудлаар зохион байгуулж болно. Эрэгтэй хүний хувьд, нийгмийн бүтэц хэрхэн бүрэлддэг, хувь хүн, гэр бүл, олон нийт болон соёлын байдалд эрх мэдлийн нөлөөг ойлгох талаар эрэгцүүлэн бодох зэрэг нь эхний үр дүнтэй алхам байж болох талтай. Цаашлаад жендэрийн талаарх хэвшмэл ойлголтод дүн шинжилгээ хийх, өөр өөр ёс заншил, шашин болон бэлгийн чиг баримжааг хүндэтгэн үзэх сэтгэлтэй болох; эрх тэгш болоод бие биенээ хүндэлсэн харилцааны загвар бий болгох, хамтын харилцаатай байхад хүчирхийллээс бусад аргыг дэмжихийн төлөө ажиллах нь гол зорилго юм.

Хувь хүний түвшинд, өөрийгөө-таньж мэдэх, итгэлтэй байх, сэтгэл зовох, хардалт, эцэг хүн байх болон хүүхдийн хэрэгцээнд чиглүүлж ажиллах хэрэгтэй. Эрэгтэйчүүдэд өөрийгөө илэрхийлэх, өөрийгөө илүү өргөн хүрээнд таньж мэдэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн уур уцаар, утга учиргүй итгэл үнэмшил болон уур хүргэдэг үйл явдлыг /жишээ нь: өмнө болсон үйл явдлууд, итгэл үнэмшил, сэтгэл санааны байдлын үр дагавар болон таагүй сэтгэл хөдлөл гэх мэт/ шинжлэн дүгнэхэд бас чиглэнэ. Гол зорилго нь түрэмгий зан үйлийн шалтгаан болж буй сэтгэл хөдлөлд анхаарал хандуулж, хүчирхийлэл үйлдэхийн өмнөх бодит шинж тэмдгийг таньж мэдэх, хохирогч болж буй хүмүүсийг ойлгох, өрөвдөж энэрэх сэтгэлээр хандахыг сурах, мөн өөрийгөө хянах ур чадвар, стратегийг эзэмшихэд анхаарлыг хандуулахад оршино.

Өвөрмөц үйл ажиллагаа

Дан хүчирхийлэл үйлдэгч нараас гадна тэдэнтэй ажиллаж буй дэмжих

үйлчилгээний, олон нийтийн хүрч очих ажилтнууд, болон бодлогын болон системийн интервенцийн хэрэгжилтийг хариуцаж буй мэргэжилтнүүдийг сургах хэрэгтэй юм. Ялангуяа хүчирхийлэл үйлдэгч нарт үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүд, мөн зайн-эрүүл мэндийн /жишээ нь: утсаар зөвлөгөө өгөх, туслах шугам гэх мэт/ үйлчилгээ үзүүлэгч нарыг сайтар сургах нь зүйтэй.

Хүчирхийлэгч нарт хандсан дэмжих үйлчилгээ нь хамтарсан баг руу илгээхээс эхлээд эрэгтэйчүүдэд зориулсан хямралаас сэргийлэх интервенц /жишээ нь: гэр бүл салалт, ажилгүй болох гэх мэт/, болон бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан хөтөлбөр хүртэл өргөн хүрээтэй.

Хүчирхийллийн хохирогч нарт хандсан дэмжих үйлчилгээ нь хамтарсан багт илгээх, дэмжих, хүчирхийллийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон хохирогч нарт туслах, эрэгтэйг эмчилгээнд хамрагдах хугацаанд нь гэр бүлийг нь дэмжих төслүүдэд хамруулах, болон эмэгтэйчүүд болон гэр бүлийн аюулгүй байдлыг төлөвлөх зэрэг хүрээг хамарсан байдаг.

Заавал хүчирхийлэгч нарт зориулагдаагүй, харилцан туслах бүлгүүд, эцэг-хүү хоорондоо чөлөөтэй ярьж болох онлайн үйлчилгээг санал болгох зэрэг дэмжих үйлчилгээг бас ашиглаж болно.

Хүрч очих болон ойлголтыг сайжруулах үйл ажиллагаанууд нь өөрт-үйлчлэх/идэвхгүй болон интерактив хэлбэртэй байж болно. Өөрт-үйлчлэх үйл ажиллагааны хувьд олон тооны хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан вебсайтуудаас эрчүүд жендэр болон хүчирхийллийн асуудлын талаар ойлголт авч, өөртөө тусгах; эмчилгээний хөтөлбөрийн талаарх судалгаа, дүн шинжилгээний тухай мэдээлэл бүхий цахим эсвэл хэвлэмэл сонин тараах; өөртөө-туслах туршлагауд, жишээ нь: бусад эрчүүдийн гарсан өөрчлөлт, аав хүн болоход анхаарах зүйлсийн талаарх туршлага бүхий хэвлэгдсэн ном, хамгийн наад захын стандартууд, болон удирдамж гарын авлага зэрэг олон эх үүсвэрийг ашиглах боломжтой.

Интерактив хэлбэрийн хувьд, эдгээр асуудлыг сонирхдог ажилтнууд, судлаач болон иргэдэд зориулсан семинар, хурал болон конференцийг зохион байгуулж болно. Мөн сургууль болон олон нийтийн хурлын үеэр урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг явуулж, иргэдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах ажлыг явуулж болох юм.

Хязгаарлалт ба Хасах шалгуур

Бүх хүчирхийлэгчийг эмчилгээний хөтөлбөрт хамруулахгүй. Хөтөлбөр бүр шалгууртай байна. Ерөнхийдөө асуудалтай гэдгээ ойлгохгүй байгаа, хөтөлбөрт тууштай хамрагдах хүсэлгүй эсвэл хөтөлбөрийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй /хувийн нууцлалын хязгаарлагдмал байдал, хуулийн дагуу зэвсгийг хураах эсвэл үнэлгээ хийх гэх мэт/ эрэгтэйг эмчилгээнд оруулахгүй.

Нэгэнт хамрагдсан бол үйлчлүүлэгч нар ижил шалтгааны улмаас хөтөлбөрөөс гарч магадгүй. Зарим хөтөлбөрт, гэр бүлийн хүчирхийллээр

шийтгүүлж буй эрэгтэйг эмчилгээнд хамруулах нь зайлшгүй биш эсвэл хөөн шүүгдэх хугацаа дууссан бол хамруулдаггүй нь эмчилгээг шийтгэлийн оронд орлуулж болохгүйтэй холбоотой. Зарим тохиолдолд эрэгтэй хүн хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй эсвэл сэтгэцийн өвчтэй бол эмчилгээнд оруулдаггүй. Мансууруулах бодис хэрэглэдэг эрэгтэйн хувьд, эмчилгээний хугацаанд мансууруулах бодис хэрэглэхээ болино гэсэн нөхцөлд эмчилгээнд хамруулахыг зөвшөөрдөг.

Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ, эмчилгээний үнэлгээ

Үнэлгээнд хэрэглээний үнэлгээ, ололт дэвшлийн үнэлгээ болон кейсийн хаалтын үнэлгээ орно. Эдгээр үнэлгээнд тоон болон чанарын аргаар мэдээлэл цуглуулах бөгөөд тусгайлан бэлтгэсэн бүтцийн дагуу ярилцлага авах арга үүнд багтана. Түүнчлэн эмэгтэйчүүд, хүүхдүүд, чиглүүлэгч нар, цагдаа, шүүхийн тайлан, нийгмийн үйлчилгээ, эмэгтэйчүүдэд зориулсан үйлчилгээ болон насанд хүрээгүй хүүхдийн шүүх зэрэг олон оролцогч талаас хэрэглээний мэдээлэл, сэтгэгдэл зэргийг цуглуулна.

Бүтцийн ярилцлагад хүн ам зүйн мэдээлэл, гэр бүлийн байдал, мансууруулах бодис эсвэл архинд донтсон эсэх, сэтгэцийн өвчин, ажил эрхлэлтийн байдал, гэмт хэргийн шийтгэл, мөн хохирогч/хамтрагчаас авсан мэдээллийг хамруулж болно. Эмэгтэйчүүд ба хүүхдүүдээс эрэгтэйн зан байдал бүлгийн хичээлд орохын өмнө, явж байх хугацаанд болон хичээл дууссанаас хойш зургаан сарын дараа хэрхэн өөрчлөгдсөн талаар асуух аргыг бас хэрэглэдэг.

Эрэгтэйчүүдээр өөрийн-үнэлгээний маяг бөглүүлэх бөгөөд үүнд зургаан удаагийн хичээл бүрийн дараа гарсан өөрчлөлтийг /зарим үед долоо хоног бүр өөрийн-тайлан бичүүлдэг/ эргэн санаж бичихийг хүсдэг. Зарим тохиолдолд, хувь хүний үнэлгээний дараа эрэгтэй, эмэгтэй хоёрыг хамт байлган ярилцлага хийдэг.

Эрэгтэй нь бие махбодын хүчирхийлэл үйлдэхээ больж, хамтрагч/хүүхдүүдээ хяналтандаа байлгадаг дадлаасаа салж, өмнө нь гэм хор учруулж байсан хүмүүсээс уучлал гуйсан тохиолдлуудад хөтөлбөр амжилттай болсон гэж үздэг.

Хяналт ба сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийн дараах тусламж үйлчилгээ

Бүлгийг орхихын өмнө, ажилтан/мэргэжилтнүүд гарах-төлөвлөгөөг үйлчлүүлэгчтэй хамтран боловсруулахын тулд юунд хүрсэн, тулгарч байсан бэрхшээлүүд, тэднийг хэрхэн даван туулсан талаар нь эрэгцүүлэн бодохыг хүсэж энэ талаар ярилцана. Зарим хөтөлбөрт, бүлгийн гишүүд “нээлттэй” буюу эмчилгээний төгсгөлд ч үргэлжлүүлэн оролцсоор байх, эсвэл сардаа нэг удаа уулзаж хяналтыг тусгайлан үргэлжлүүлэхээр оруулсан байдаг. Гарах-хөтөлбөрийн дараагаар эргэн хянах үүднээс оролцогчидтой холбоо барьж ярилцлага хийж болно. Хамтрагчид дэмжлэг үзүүлэх нь хяналтын үйл явцын нэгэн хэсэг юм.

5.4 ХАВСРАЛТУУД

Сэтгэл гутралын түвшинг тодорхойлох Бекийн сорил /Beck depression inventory, 1961/

II бүлгийн хавсралтаас харна уу.

Стрессорын улмаас үүссэн сэтгэл түгшилтийг тодорхойлох Спилберг-Ханины сорил

III бүлгийн хавсралтаас харна уу.

Сэтгэл түгшилтийн төрөлхийн байдлыг тодорхойлох Спилберг-Ханины сорил

III бүлгийн хавсралтаас харна уу.

Сэтгэл гутралын шалтгаан, түвшинг тодорхойлох Цунгийн сорил

III бүлгийн хавсралтаас харна уу.

Стресстэй байгаа эсэхээ өөрөө шалгах богино хэмжээний тест

III бүлгийн хавсралтаас харна уу.

AUDIT СОРИЛ

Доорхи сорилын бүлэг бүрээс зөвхөн ганц хариултыг сонгох ба хариултын өмнөх хаалтанд байгаа тоо нь уг асуултын оноо болно.

Д/д	
1	Та согтууруулах ундааг хэр давтамжтай хэрэглэдэг вэ? /0/ Огт хэрэглэдэггүй /1/ Сард 1 удаа ба түүнээс дээш /2/ Сард 2-4 удаа /3/ Долоо хоногт 2-3 удаа /4/ Долоо хоногт дор хаяж 4 удаа
2	Та жирийн өдөрт согтууруулах ундааг хэдэн стандарт уултаар хэрэглэдэг вэ? /0/ 1 эсвэл 2 /1/ 3 эсвэл 4 /2/ 5 эсвэл 6 /3/ 7, 8 эсвэл 9 /4/ 10 эсвэл түүнээс дээш
3	Нэг удаагийн уултаар 6 болон түүнээс дээш стандарт хэмжээгээр ууж байсан удаа бий юу? /0/ Үгүй /1/ Сар болгон биш /2/ Сардаа /3/ Долоо хоногтоо /4/ Өдөр болгон

4	Өнгөрсөн 1 жилийн дотор та согтууруулах ундааг ууж эхэлсэн тохиолдолд зогсоож чадахгүй байсан удаа бий юу? /0/ Үгүй /1/ Сар болгон биш /2/ Сардаа /3/ Долоо хоногтоо /4/ Өдөр болгон
5	Өнгөрсөн 1 жилийн дотор та согтууруулах ундааг хэрэглэснээс болж өөрийн хийх ёстой юмыг хийж чадахгүй байсан удаа бий юу? /0/ Үгүй /1/ Сар болгон биш /2/ Сардаа /3/ Долоо хоногтоо /4/ Өдөр болгон
6	Өнгөрсөн 1 жилийн дотор та урьд өдөр нь уусан тохиолдолд маргааш нь хэвийн байдалд орохын тулд архи хэрэглэж байсан удаа бий юу? /0/ Үгүй /1/ Сар болгон биш /2/ Сардаа /3/ Долоо хоногтоо /4/ Өдөр болгон
7	Өнгөрсөн 1 жилийн дотор танд архи уусны дараа гэмшил төрж байсан удаа бий юу? /0/ Үгүй /1/ Сар болгон биш /2/ Сардаа /3/ Долоо хоногтоо /4/ Өдөр болгон
8	Өнгөрсөн 1 жилийн дотор та урьд өдөр нь согтуудаа болсон юмыг санахгүй тохиолдол байсан уу /0/ Үгүй /1/ Сар болгон биш /2/ Сардаа /3/ Долоо хоногтоо /4/ Өдөр болгон

9	Та согтууруулах ундааг хэрэглэснээс болж бусад хүмүүст эсвэл өөртөө хохирол учруулж байсан удаа бий юу? /0/ Үгүй /2/ Тийм гэхдээ өнгөрсөн жилд биш /4/ Тийм, өнгөрсөн жилд
10	Таны гэр бүл, хамаатнууд, найзууд эсвэл эмч таны архины хэрэглээний талаар санаа зовж архиныхаа хэрэглээг зогсоох шаардлагатай гэж хэлж байсан уу? /0/ Үгүй /2/ Тийм гэхдээ өнгөрсөн жилд биш /4/ Тийм, өнгөрсөн жилд

Үнэлгээ:

- | | |
|---------------|------------------------------------|
| 1. 0 оноо | Огт хэрэглэдэггүй |
| 2. 1-7 оноо | Эрсдэл багатай архины хэрэглээ |
| 3. 8-15 оноо | Аюултай хэрэглээ |
| 4. 16-19 оноо | Хортой үр дагавар өгөхүйц хэрэглээ |
| 5. 20-40 оноо | Архины хамааралтай |

AUDIT сорилын онооноос хамаарч эрсдэлийн түвшинг үнэлэх ба эрсдэлийн түвшингээс шалтгаалан архины хэрэглээний асуудлыг шийдвэрлэнэ.

Эрсдэлийн түвшинг үнэлэх ба авах арга хэмжээ

AUDIT оноо	Эрсдэлийн түвшин	Архины хэрэглээний асуудлыг шийдвэрлэх арга хэлбэр
0-7	Түвшин I	Архины хэрэглээний боловсрол
8-15	Түвшин II	Энгийн зөвлөгөө
16-19	Түвшин III	<ul style="list-style-type: none"> Энгийн зөвлөгөө Архины хэрэглээний асуудлыг шийдвэрлэх аргыг хэрэглэх Үргэлжилсэн ажиглалт
20-40	Түвшин IV	<ul style="list-style-type: none"> Нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх Эмчилгээ хийлгэхээр явуулах

Архинд донтох өвчтэй эсэхийг илрүүлэх CAGE асуумж

№	Асуултууд	Тийм	Үгүй
1	C Согтуудаа болсон зарим үйл явдлыг эрүүлжсэн хойноо санахгүй байх тохиолдол бий юу?		
2	A Таны архидан согтуурч байгааг хүмүүс шүүмжлэхэд уур, уцаар төрдөг үү?		
3	G Та архидан согтуурдаг явдалдаа гэмшдэг үү?		
4	E Та өглөө бүр шараа архиар тайлдаг уу?		

Үнэлгээ:

- Дээрх 4 асуултын 2 эсвэл 3 асуултанд “Тийм” гэж хариулсан бол архины хараат байдалтай байх магадлалтай.
- Бүх асуултанд “Тийм” гэж хариулсан бол архины хараат байдалтай гэж оношлоно.

/Эх сурвалж: Ewing. The American psychiatric press textbook of psychiatry. 1994/

“Мичиган” оношлогооны тест

№	Асуултууд	Тийм	Үгүй
1	Та өөрийгөө хэвийн хэмжээгээр уудаг гэж боддог уу? /Хэвийн хэмжээ гэдэг ойр тойрны хүмүүсийн тань уудаг хэмжээнээс их биш хэмжээ/	0	2
2	Архи уусны маргааш өглөө, урьд орой нь юу хийснээ санахгүй байх тохиолдол байсан уу?	2	0
3	Таныг архи уулаа гэж ойр дотны хүмүүс, гэр бүлийхэн чинь зэмлэж байсан уу?	1	0
4	Та нэг буюу хоёр хундаг уугаад биеэ албадалгүйгээр больж чадах уу?	0	2
5	Та архи уугаад байна даа гэж өөрийгөө буруутган боддог уу?	1	0
6	Таны архи уудаг хэмжээг ойр дотныхон, найз нөхөд чинь хэвийн гэж үздэг үү?	0	2
7	Та хэрвээ хүсвэл архи уухаа бүрмөсөн больж чадах уу?	0	2
8	Архичдын /AA/ цуглаанд оролцож байсан уу?	5	0
9	Согтуугаар зодоон цохионд оролцож байсан уу?	1	0
10	Архидалт тань таны хувьд эхнэр, /нөхөр/ ойрын хамаатантайгаа хэрэлдэх маргалдах шалтаг болж байсан уу?	2	0
11	Таныг архи уугаад байна гэж таны ойрын хүмүүсээс чинь хэн нэгнээс тусламж гуйж байсан уу?	2	0
12	Архидалтаас болоод хань ижил, найз нөхдөөсөө салж байсан уу?	2	0
13	Архитай холбоотой ямар нэг асуудал ажил дээр тань гарч байсан уу?	2	0
14	Архинаас шалтгаанлан ажил солигдох эсвэл ажлаасаа халагдаж байсан уу?	2	0

15	Архи ууснаас болж алба, амины ажлаа хоёроос дээш хоног орхиж байсан уу?	2	0
16	Та үдээс өмнө архи ууж байсан уу?	1	0
17	Таны элэг муудаж байгаа тухай мэргэжлийн эмч анхааруулж байсан уу?	2	0
18	Олон хоног архи уусны дараа салгалж чичрэх, нүдэнд хий юм харагдах, чихэнд хий юм сонсогдож байсан уу?	2	0
19	Та архинаас гарах талаар хэн нэгэнд хандаж байсан уу?	5	0
20	Архи ууснаас болоод эмнэлэгт хэвтэж эмчлүүлж байсан уу?	5	0
21	Архи байнга хэрэглэснээс болж сэтгэцийн өөрчлөлт илэрч эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байсан уу?	2	0
22	Архи байнга ууснаас болж зан ааш тань хувирч, янз бүрийн бэрхшээл учирснаас болж сэтгэцийн эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, лам бөөд хандаж байсан уу?	2	0
23	Согтуугаар машин жолоодсоноос саатуулагдаж байсан уу?	2	0
24	Согтуугаар хууль дүрэм зөрчиж, баривчлагдаж саатуулагдаж, эрүүлжүүлэгдэж байсан уу?	2	0
Бүх онооны нийлбэр			

Тестийг шинжлүүлэгч өөрөө бөглөнө. Бас шинжлүүлэгчийн гэр бүл, дотны хүмүүс ч бөглөж болно. Энэ тохиолдолд сорилын хариуг 90%-ийн найдвартай гэж тооцно.

Үнэлгээ:

- 0-5 оноо Архины хараат байдал илрээгүй
- 5-7 оноо Хараат байдалтай байж магадгүй
- 7-15 оноо Архины хараат байдлын I үе
- 15-25 оноо Архины хараат байдлын II үе
- 25-ба түүнээс дээш оноо Архины хараат байдлын III үе

/Эх сурвалж: Richard J.Prances., John E.Franklin J., The American psychiatric press textbook of psychiatry. 1994/

НОМ ЗҮЙ:

- С.Бямбасүрэн, Сэтгэцийн эмгэг судлал. 2014;
- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц /CEDAW/, Ерөнхий зөвлөмж №19.
- НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал.
- SASA “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд нийгэм, хамт олны хүчийг дайчлан, үр дүнтэй ажиллахад чиглэгдсэн аргачлал”, МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ, 2011.
- Д.Энхжаргал, “Амьдрах ухааны чадвар” цуврал гарын авлага: “Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх” НҮБ-ын ХАС, 2016.
- С.Нарантуяа. “Хүүхдийн нийгэмшилд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлэх нөлөөлөл” /Докторын эрдэм шинжилгээний бүтээл/ 2014 он.
- “Treatment Programs for Perpetrators of Domestic Violence”, New male studies: an international journal ~ issn 1839-7816 ~ vol. 4, issue 3, 2015 pp. 5-22 © 2015 australian institute of male health and studies.

**НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВҮҮД БОЛОН
ХАМГААЛАХ БАЙРНЫ УТАСНЫ ЖАГСААЛТ**

1. Дорнод аймаг НЦҮТ-70584455
 2. Хэнтий аймаг НЦҮТ-70563433
 3. Говь-Алтай аймаг НЦҮТ-98299111
 4. Завхан аймаг НЦҮТ-80740740
 5. Баянхонгор аймаг НЦҮТ-70442122
 6. Дархан-Уул аймаг НЦҮТ-70378737
 7. Өмнөговь аймаг НЦҮТ-70532005
 8. Хөвсгөл аймаг НЦҮТ-70382121
 9. Баян-Өлгий аймаг НЦҮТ-7042102, 94442902
 10. Хан-Уул дүүргийн НЦҮТ-88127821, 88049073, 89893773
 11. Баянзүрх дүүргийн НЦҮТ-70150183
 12. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн НЦҮТ /жижүүрийн цагдаагийн утас/-93070949
 13. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дэргэдэх НЦҮ: 70180139
 14. Сүхбаатар дүүргийн НЦҮТ
 15. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв: 96490505
 16. Хүүхдийн хамгааллын утас: 108
 17. Нийслэлийн цагдаагийн хамгаалах байр: 107
-

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ